

Бямба гарагийн өглөөний хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Бид Чуулгандаа дахин цуглалаа

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Та нарын итгэл болоод сайн мэдээнд үнэнч байдагт тань мөн бие биедээ үзүүлдэг хайр, үйлчлэлд тань талархал илэрхийлье.

Бид энэ барилгыг барихаар төлөвлөж байхдаа үүнийг хэзээ ч дүүргэж чадахгүй гэж бодож билээ. Харин одоо хар.

Хайрт ах эгч нар аа, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн жил тутмын 181-р ерөнхий чуулганыг эхлэн та бид дахин хамтдаа байгаа нь ямар сайхан хэрэг вэ.

Олон үүрэг хариуцлагаа гүйцэтгэн завгүй байснаас өнгөрсөн зургаан сар нүд эрмэх зуур өнгөрсөн мэт санагдаж байна. Энэ хугацаан дахь хамгийн агуу адислалуудын нэг нь ойролцоогоор 2 жилийн турш их засвар хийсэн Хавайн Лайе дахь гайхамшигтай Ариун Сүмийг дахин онцгойлон адисалсан үйл явдал байлаа. Би Ерөнхийлөгч Хенри Б.Айринг болон Айринг эгч, Ахлагч Квинтен Л.Кук болон Кук эгч, Ахлагч Виллям Р.Уокер болон Уокер эгч нартай хамт явсан юм.

Арваннэгдүгээр сард болсон дахин онцгойлон адислалтын өмнөх өдөр 2000 залуус Хавай дахь Бригам Янг Их Сургуулийн Каннон Үйл ажиллагааны төвийг дүүргэж, бидэнд зориулан тоглолт хийснийг бид үзсэн. Тэдний хөтөлбөр “Цуглах газар” гэсэн нэртэй байсан бөгөөд тэд орон нутгийнхаа сүмийн түүх болон ариун сүмийн түүхэн дэх онцгой үйл явдлуудыг урлагийн чадварлаг тоглолтоор үзүүлсэн. Үнэхээр гайхамшигтай үдэш байлаа.

Дараагийнх нь өдөр ариун сүмийг гурван удаагийн цуглаанаар дахин онцгойлон адисалсан нь сүнслэг байдлын охь манлай болсон юм. Их Эзэний Ариун Сүнснийг бид агуу ихээр мэдэрч билээ.

Бид ариун сүмүүдийг барьсаар байна. Өнөө өглөө надад ирэх сар, жилүүдэд баригдах гурван ариун сүмийг зарлах онцгой боломж олдсон юм. Тэдгээр ариун сүмүүд нь Колорадо мужийн Форт Коллинс, Айдахо мужийн Меридиан, Канадын Манитоба мужийн Виннипегт тус тус баригдах гэж байна. Эдгээр нь баригдах газар бүрийнхээ гишүүдэд адислал байх болно.

Жил бүр Ариун сүмүүдэд сая сая ёслолыг гүйцэтгэдэг. Зөвхөн өөрсдийнхөө төлөө төдийгүй өөрсдийнхөө төлөө ариун сүмийн ёслолуудыг хийж чадахгүй нас барсан хайртай хүмүүсийнхээ төлөө ёслолуудыг гүйцэтгэхээ итгэлтэйгээр үргэлжлүүлцгээе.

Сүм байгалийн гамшиг сүйрлийн үеэр хүмүүнлэгийн тусламжаа үзүүлсээр байна. Саяхан болсон гамшигт газар хөдлөлт, цунами болон үүнээс үүдсэн атомын

цахилгаан станцад гарсан цөмийн бэрхшээлтэй үед бид Япон улсад сэтгэл санааны дэмжлэг, материаллаг тусламжаа үзүүлээд байна. Бид хүнс, ус, хөнжил, цагаан хэрэглэл, ариун цэврийн багц, хувцас болон шатахуун зэрэг 70 гаруй тонн хангамжийн барааг хүргүүлээд байна. Залуу гишүүд маань интернет, мэдээллийн болон орчин үеийн харилцаа холбооны төхөөрөмжийг ашиглан олдохгүй байгаа гишүүдийг олоход нь сайн дураараа тусалж байна. Гишүүд машинаар очиход хэцүү газруудад моторт дугуйгаар тусламжийг хүргэж байна. Токио, Нагоя, Осака дахь тойрог, гадсууд ариун цэврийн болон цэвэрлэгээний материалуудыг цуглуулан бэлтгэх үйлчлэлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Одоогийн байдлаар 4000 гаруй сайн дурынхан 40,000 гаруй цагийг үйлчлэлд зориулаад байна. Бид Япон болон шаардлагатай бусад бүсүүдэд цаашид тусалсаар байх болно.

Ах эгч нар аа, та нарын итгэл болоод сайн мэдээнд үнэнч байдгийн тань төлөө, бусдад үзүүлдэг та нарын хайр халамж болон тойрог, салбар, гадас дүүргүүддээ хийдэг та бүхний үйлчлэлийн төлөө бид талархаж байна. Мөн аравны нэг болон мацгийн өргөлөө итгэлтэйгээр төлж, Сүмийн санд өгөөмрөөр хандив өргөдөгт тань би та бүхэнд талархлаа илэрхийлж байна.

2010 оны сүүлчээр дэлхий даяар 340 номлолд 52,225 номлогч үйлчилж байлаа. Номлолын ажил нь хаант улсын амьдралын эх булаг юм. Боломжтой бол Номлогчийн Ерөнхий Санд хандив өргөхийг би санал болгож байна.

Ах эгч нар аа, эдүгээ бид өнөөдөр болон маргааш бидэнд хандсан захиасуудыг сонсохоор сэтгэл догдолж байна. Бидэнд хандан үг хэлэх эдгээр хүмүүс тэнгэрийн тусламж, удирдамжтайгаар захиасуудаа бэлтгэсэн юм. Бид тэднийг сонсохдоо Их Эзэний Ариун Сүнсээр дүүрч, өсч хөгжин, урам зориг нэмэх болтугай хэмээн би залбирч байна. Есүс Христийн нэрээр, амен.

Лиахона

2011 оны 5-р сар

Бямба гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Хүндэтгэлийн өдөр болон ариун ёслол

Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Л.Том Перри

Дэлхийн өнцөг булан бүр дэх ах эгч нар минь, бид өнөө өглөө бошиглогчийн үгийг сонсохоор ирсэн билээ. Бидний саяхан сонссон дуу хоолой бол өнөөдөр дэлхийд байгаа Бурханы амьд бошиглогч Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн дуу хоолой болохыг би гэрчилж байна. Бидэнд түүний захиас болон үлгэр жишээ байгаа болохоор бид үнэхээр адислагдсан билээ!

Энэ жил бид бүгд Шинэ Гэрээн дэх бошиглогчдын үгсийг Ням гарагийн хичээлээр суралцах боломжтой байгаа билээ. Хуучин Гэрээ нь бошиглогч болон ард түмний талаар байдаг бол Шинэ гэрээ нь мөнх бус амьдралд ирэхдээ дэлхий болон тэнгэрт хоёуланд нь харьяалалтай байсан цорын ганц Хүн болох бидний Аврагч, Гэтэлгэгч, Есүс Христийн амьдрал болон нөлөөг илүү ихээр харуулдаг.

Хүмүүний сургаал өнөөдрийн дэлхийд давамгайлж байгаа болохоор Шинэ Гэрээ болох Аврагчийн амьдрал, сургаалын маш чухал цэдгийг мартаж, итгэлээ алдах нь амархан болоод байна. Аврагч Өөрөө бидний амьдралын гол цөм байдаг шиг энэхүү ариун товхимол нь сударт бичигдсэн түүхийн гол цөм нь билээ. Бид үүнээс суралцаж, үнэт эрдэнэс мэт эрхэмлэн нандигнах хэрэгтэй!

Бид Шинэ Гэрээнээс суралцсанаараа үнэлж баршгүй эрхэм мэргэн үгсийг олох болно. Паул аялж, Аврагчийн Сүмийг байгуулсан тухай цэдгийг, ялангуяа Тимотод заасан түүний заавруудын талаар уншихдаа би үргэлж дуртай байдаг. Паулын Тимотид хандсан захиасын дөрөвдүгээр бүлгээс бид ийн уншдаг: “Эдгээр зүйлийг тушаа, мөн сургагтун. Чи итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариун байдлаараа үлгэр дуурайл бол”¹. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихаас өөр итгэгчийн үлгэр жишээ болох илүү арга замыг би бодож олж чадахгүй байна.

Дэлхийн бүтээлтээс эхлээд нэг өдрийг бусдаас ялган онцолсон. “Бурхан долоо дахь өдрийг ерөөж, ариун болгов.”². Бурхан хүртэл энэ өдөр Өөрийн хөдөлмөрөөс амарсан юм. Тэрээр хүүхдүүдээ мөн адил үйлдээсэй гэж хүсдэг. Израилын хүүхдүүдэд Тэрбээр энэхүү зарлигийг өгчээ:

“Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун.
Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий.
Харин долоо дахь өдөр бол чиний Бурхан Эзэний амралт тул . . .

Тиймээс Эзэн Амралтын өдрийг ерөөн, тэр өдрийг ариун болгосон юм.”³

Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих хэв маяг нь хүндэтгэл бишрэлийг үргэлж багтаасан байх ёстой. Адам Ева хоёр мөнх бус биетэй болсны дараа тэдэнд “өөрсдийн Бурхан Их Эзэнийг шүтэх ёстой, мөн мал сүргийнхээ ууган төлүүдийг Их Эзэнд барих өргөлийн тул өргөж байх ёстой . . . энэ нь Эцэгийн Төрсөн Ганцын золиослолтой төстэй бөлгөө”⁴ хэмээн зарлигласан билээ. Малаар тахил өргөх нь нэгэн өдөр Бурханы Хурга, Есүс Христ амиа бидний төлөө золиослол болгон өргөхийг Адамын үр удамд сануулсан.

Аврагч амьдралынхаа туршид тэрхүү золиослолын талаар ярьдаг байсан.⁵ Цовдлогдохынх нь өмнөх орой, Түүний үгс гүйцэлдэж эхэлсэн юм. Тэрбээр дэлхийн уруу таталтаас хол, дагалдагчдаа дээд ерөөнд цуглуулан, Их Эзэний Оройн зоогийн ариун ёслолыг танилцуулсан юм.

“Тэднийг зооглон байх үед Есүс хэсэг талх аваад ерөөсний дараа, хуваан шавь нартаа өгөөд, Май ид. Энэ бол Миний бие гэлээ.

Тэгээд Тэр аяга авч, талархлаа өргөөд, тэдэнд өгөнгөө Үүнээс та нар бүгдээрээ ууцгаа.

Учир нь энэ бол нүглүүдийн уучлалын тулд олны төлөө урсгах гэрээний Миний цус”⁶ гэжээ.

Тэр цагаас хойш Аврагчийн Цагаатгал агуу их болоод эцсийн золиослол болсон. Тэрээр амилсныхаа дараа Америк тивд ирээд Өөрийн санваарыг дагалдагч нартаа шилжүүлж, ариун ёслолыг танилцуулахдаа ийнхүү хэлжээ:

“Мөн үүнийг та нар хийхээр . . . бүр яг би талхыг хувааж мөн үүнийг адисалж мөн үүнийг та нарт өгсний адилаар үргэлж чармайх болно.

Мөн энэ нь Эцэгт та нар намайг үргэлж дурсан санаж байгаагийн гэрчлэл байх болно. Мөн хэрэв та нар намайг үргэлж санах аваас, миний Сүнс та нартай хамт байх болно”⁷.

Урвалтын харанхуй үед ч Хүндэтгэлийн өдрийг шүтэх нь мөн Ариун ёслолын хэв маяг олон янзаар үргэлжлэн явагдсаар ирсэн нь гайхамшигтай юм.

Мөн сайн мэдээ сэргээгдэх үед Аврагчаас анх ариун ёслолыг хүртсэн Дагалдагчдын гурав нь болох Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит, Оливер Каудери хоёрт үзэгдсэн билээ. Есүс Христийн сүмийн гишүүдэд Ариун ёслолыг түгээхэд шаардагдах санваарын эрх мэдэл тэдний удирдлагын дор сэргээгдсэн⁸.

Аврагчаас Өөрийн бошиглогч дагалдагч нарт, тэднээс бидэнд дамжин өгөгдсөн тэрхүү санваарын эрх мэдэл нь дэлхий дээр өнөөдөр ч оршиж байгаа билээ. Дэлхий даяарх залуу санваар атгагчид сайн мэдээний жишгийн дагуу амьдарч, зарлигуудыг хичээнгүйлэн сахиснаар санваарын хүчийг эдлэх эрхтэй болдог. Эдгээр залуу эрэгтэйчүүд сүнслэг

байдлын хувьд сэвгүй зүрх сэтгэл, цэвэр ариун гартай байснаар Аврагчийн замаар – 2000 жилийн өмнө Түүний танилцуулсан тэр арга замаар ариун ёслолыг бэлтгэн, адисалж, түгээдэг билээ.

Ариун ёслолоос хүртэх нь Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихын голт зүрх нь юм. Сургаал ба Гэрээнд, Их Эзэн бид бүгдэд ийн зарлигладаг:

“Мөн чи өөрийгөө дэлхийгээс илүү бүрэн дүүрэн толбогүй байлгаж болгохын тулд, чи залбирлын өргөөнд очиж мөн миний ариун өдөрт ариун ёслолуудаа өргөх ёстой.

Учир нь үнэнээр энэ бол хөдөлмөрүүдээсээ амрахаар, мөн Бүхний Дээдэд чи бүхнээ зориулахаар чамд өгөгдсөн өдөр юм.

Мөн . . . энэ өдөр чи . . . өөр юу ч хийх ёсгүй”⁹.

Хүндэтгэлийн өдрийн болоод ариун ёслолын энэхүү хэв маягийг бид амьдралдаа хэрэгжүүлэхэд Их Эзэн биднээс гурван зүйлийг шаарддаг. Нэгдүгээрт, өөрсдийгөө дэлхийгээс илүү толбогүй байлгах; хоёрдугаарт, залбирлын өргөөнд очиж, ариун ёслолоо өргөх; гуравдугаарт, ажил хөдөлмөрөөсөө амрах явдал юм.

Христэд итгэгч байж, Христийн үнэнч шавь болон амьдрах нь хэчнээн бахархуштай сайхан зүйл билээ. Тэрбээр “Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх биш”¹⁰ хэмээн бидний талаар хэлсэн юм. Өөрсдийгөө дэлхийгээс илүү толбогүй байлгахын тулд Тэрбээр биднийг Хүндэтгэлийн өдөр ажил хийхгүй, зугаа цэнгэлээс хол байж, дэлхийн уруу таталтаас зайлсхийхийг хүсдэг.

Тэр бас биднийг зөв зохистой хувцаслахыг хүсдэг гэдэгт би итгэдэг. Хуучны “Бүтэн сайн өдрийн сайн хувцас” хэмээх хэллэг хоцрогдсон гэж залуу үеийнхэн бодож магадгүй. Хэрэв өдөр тутмын өмсдөг хувцсаа Хүндэтгэлийн өдөр өмсөх юм бол бидний үйлдэл, төрх байдал тийнхүү илрэх болно гэдгийг бид мэддэг шүү дээ. Хүүхдүүд Хүндэтгэлийн өдрийн хувцсыг нар жаргатал өмсөх хэрэггүй ч байж болох юм. Гэсэн хэдий ч тэдэнд өмсгөх хувцас болон тэднийг хийхээр дэмжсэн үйл ажиллагаагаар дамжуулан бид тэднийг Ариун ёслолд бэлтгэж, өдөржингөө түүний адислалуудыг хүртэхэд тусалж байдаг.

Их Эзэнд өөрсдийн ариун ёслолыг өргөнө гэдэг нь юу гэсэн утгатай юм бэ? Бид бүгдээрээ алдаа гаргадгаа мэддэг. Бид бүгд Тэнгэрлэг Эцэгт болон өөрсдийн гомдоосон байж мэдэх хүмүүст хандан алдаа нүглээ хүлээж, үүнийг давтахгүй байх хэрэгтэй. Хүндэтгэлийн өдөр нь ариун ёслолоо Их Эзэнд өргөх үнэт боломжийг бидэнд олгодог билээ. Тэрбээр, “Энэхүү, Их Эзэний өдөр, чи нүглүүдээ ахан дүүстээ, мөн Их Эзэний өмнө хүлээж, өөрийнхөө өргөлүүд хийгээд өөрийнхөө ариун ёслолуудыг Бүхний Дээдэд өргөх ёстой гэдгийг санагтун”¹¹ гэжээ.

Ахлагч Мелвин Ж.Баллард, “Бид Хожмын Үеийн Гэгээнтэн болгоныг ариун ёслолын ширээнд ирэхийг хүсдэг, учир нь энэ нь өөрсдийгөө Сүмийн заадаг зүйлс болон ах эгч нартайгаа нэгдэх болгож, амьдралаа зөв зүйтэй болгож, замаа засч сурахад тусалдаг өөрсдөдөө хяналт тавих газар юм”¹² гэж хэлжээ.

Бид ариун ёслолоос зохистойгоор хүртсэнээр, Түүний Сүнснийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд өөрсдөдөө Аврагчийн нэрийг авч, мөн үргэлж Түүнийг санаж, мөн Түүний зарлигуудыг дагахад бэлэн гэдгээ гэрчилдэг. Ийм замаар бидний баптисмын гэрээ шинэчлэгддэг. Их Эзэн Өөрийн дагалдагчдад, “Та нар үүнийг хийх бүрдээ Миний та нартай байсан энэ цагийг санах болно”¹³ хэмээн батлан хэлжээ.

Заримдаа бид ажил хөдөлмөрөөсөө амарна гэдгийг талбай дахь өвс хураагч машинаа ажиллуулахгүй байхыг эсвэл дэлгүүр, үйлчилгээний газрынхаа үүдэн дээр “Хаалттай” гэсэн тэмдэг тавих гэж боддог. Гэсэн хэдий ч өнөөдрийн дэлхийд хөдөлмөр гэдэг нь бидний өдөр тутам хийдэг ажил хөдөлмөрийг багтаадаг. Үүнд бидний гэрээсээ хийж болох бизнесийн үйл ажиллагаа, спортын тоглолт тэмцээн мөн биднийг Хүндэтгэлийн өдрийн шүтлэг болон бусдад туслах боломжоос холдуулдаг бусад зүйлүүд багтаж болно.

“Ариун нандин зүйлүүдэд бүү хөнгөн хуумгай ханд”¹⁴ хэмээн Их Эзэн Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд илчилсэн бөгөөд энэ нь дагалдагчиддаа хандаж хэлсэн дараах үгсийг бидэнд сануулж байдаг: “Хүн Хүндэтгэлийн өдрийн төлөө бус, Хүндэтгэлийн өдөр нь хүний төлөө бий болсон.”¹⁵

Ах эгч нар аа, эдгээр хожмын өдрүүдэд бид Аврагчид бие сэтгэлээ зориулахаа больж, Шинэ Гэрээ болон бусад судрууд дахь Түүний сургаалуудыг үл ойшоон, Түүнийг дагахаа болих юм бол дайсан ялж байгаа нь тэр. Эцэг эхчүүд ээ, Ариун ёслолын цуглаанд оролцсоноор итгэгчдийн үлгэр жишээ байхыг хүүхдүүддээ заах цаг нь одоо шүү. Хүндэтгэлийн өдрийн өглөө болоход, тэднийг сайн амарч, зөв хувцаслаж, Ариун ёслолын бэлгэдлийг хүртэхэд сүнслэг байдлын хувьд бэлтгэж, Ариун Сүнсний гэгээрүүлэх, сэнхрүүлэх болон хөгжүүлэх хүчийг хүлээж авахад нь туслаарай. Та бүхэн Хүндэтгэлийн өдрийг бүтэн өдрийн турш хүндэтгэж мөн үүний сүнслэг адислалыг долоо хоногийн туршид хүртсэнээр гэр бүлээ хайраар дүүргээрэй. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахиснаар хөвгүүд, охиддоо “тэдний гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч мөн урагш гэрэлтүүлэхийг”¹⁶ уриалаарай.

Он жилүүд өнгөрөх тусам би хүүхэд насныхаа болон залуу үеийнхээ Хүндэтгэлийн өдрүүдийн талаар эргэн боддог. Би дикон болоод ариун ёслолыг түгээсэн анхны өдрөө мөн тойргийнхоо гишүүдэд түгээсэн жижигхэн шилэн аягануудыг одоо ч санаж байна. Хэдэн жилийн өмнө миний өссөн хотын Сүмийн байр шинэчлэгдэн засагдахад индэр дээрх нэг шургуулга хаагдан хадагдсан байлаа. Түүнийг буцааж онгойлгоход нөгөөх жижигхэн шилэн аяганууд дотор нь байж байлаа. Аягануудын нэгийг надад дурсгал болгон өгсөн юм.

Мөн би Нэгдсэн Улсын Тэнгисийн Цэргийн Хүчинд алба хааж байхдаа үргэлж биедээ авч явдаг байсан ногоон хайрцгийг бас санаж байна. Дайны цаг, сорилт бэрхшээлийн үед ч Их Эзэний Зоогийн найдвар болон амар амгалангаар бид адислагдаж болохын тулд тэр хайрцган дотор модон тосгуур, ариун ёслолын ууттай аяганууд байдаг байлаа.

Залуу үеийнхээ ариун ёслолын аяганууд болон энх тунх өсч торнисон хүүхэд ахуй үеийн гэр орныхоо тухай түүнчлэн мянга мянган км-ийн чанад дахь Номхон далайд эр цэргийн алба хашиж байхдаа ус уудаг байсан аягануудыг санах үед дэлхийн Аврагч миний төлөө “гашуун аяганаас”¹⁷ уухад бэлэн байсны төлөө зүрх сэтгэл минь талархлаар дүүрдэг билээ. Мөн Тэрээр тийн үйлдсэн учраас л Түүний үүрд мөнхийн хэмжээлшгүй Цагаатгалын адислалаар “аяга маань дүүрэн бялхдаг”¹⁸ гэж би Дууллын зохиогчтой дуу хоолой нийлүүлэн хэлж чадна.

Хүндэтгэлийн өдрийн өмнөх энэ өдөр энэхүү агуу чуулганыг эхлэх агшинд салбар, тойргууддаа долоо хоног бүр ариун ёслолын цуглаанд оролцсоноор бидэнд ирдэг боломжууд болон адислалуудыг бүгдээрээ санацгаая. Бидэнд болон бидний гэр бүлүүдэд амлагдсан адислалуудыг хүртэхүйц байдлаар Хүндэтгэлийн өдөрт бэлтгэхийн сацуу биеэ мөн тийм байдлаар авч явцгаая. Энэ амьдрал дахь хамгийн агуу баяр баясал нь зөвхөн Аврагчийг дагаснаар ирдэг гэсэн онцгой гэрчлэлийг би хуваалцаж байна. Бид бүхэн Түүний ариун өдрийг ариунаар нь хадгалж, Түүний зарлигуудыг сахихын төлөө би залбирч байна, Есүс Христийн нэрээр, амен.

Эшлэл

1. 1 Тимот 4:11–12

2. Эхлэл 2:3

3. Египетээс Гарсан нь 20:8–11

4. Мосе 5:5, 7

5. Жишээ нь, Марк 10:32–34, Иохан 2:19, 10:17, 12:32-ыг үз.

6. Матай 26:26–28

7. 3 Нифай 18:6–7

8. Иосеф Смит---Түүх 1:68-69, 72; Сургаал ба Гэрээ 27:12–13-ыг үз.

9. Сургаал ба Гэрээ 59:9–10, 13

10. Иохан 17:16

11. Сургаал ба Гэрээ Г 59:12

12. Брайнт С.Хинкли, *Sermons and Missionary Services of Melvin Joseph Ballard* (1949), 150.

13. Иосеф Смитийн орчуулга, Марк 14:21, Bible appendix.

14. Сургаал ба Гэрээ 6:12

15. Марк 2:27

16. Сургаал ба Гэрээ 115:5

17. 3 Нифай 11:11

18. Дуулал 23:5

Бямба гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Бяцхан хүүхэд лугаа адил бологтун

Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Жийн А.Стивинс

Тэнгэр дэх бидний Эцэг агуу мэргэн ухаан болон хайраараа Өөрийн сүнсэн охид хөвгүүдийг энэ дэлхийд хүүхдүүд болгон илгээдэг юм. Тэд гэр бүлүүдэд бурханлиг зан чанар, хувь заяатай эрхэм ариун бэлэг болон ирдэг. Хүүхдүүд биднийг Өөртэй нь адил болоход туслах түлхүүр юм гэдгийг Тэнгэрлэг Эцэг маань мэддэг. Бидэнд хүүхдүүдээс сурч болох олон зүйл байдаг.

Энэхүү чухал үнэн нь Далын Зөвлөлийн нэгэн гишүүнийг хэдэн жилийн өмнө Хонг Конгд томилолтоор очсон байх үед харагдсан юм. Тэрээр олон талаар хүнд байдалд байгаа, хэрэгцээгээ хангах боломжгүй болсон маш ядуу нэгэн тойрогт очжээ. Бишоп нөхцөл байдлаа дүрсэлж ярихад гишүүдээр нь аравны нэгийг төлүүлэх хэрэгтэй гэсэн сэтгэгдэл Ерөнхий эрх мэдэлтэнд төрсөн гэнэ. Бишоп тэдний туйлын хүнд нөхцөл байдлыг мэдэж байсан учраас энэ зөвлөгөөг хэрэгжүүлэх тухайд санаа нь ихэд зовжээ. Тэрээр энэ талаар эргэцүүлэн бодсоныхоо дараа тойргийнхоо хамгийн итгэлтэй зарим гишүүдэд хандаж, аравны нэгийг төлөхийг тэднээс хүсэхээр шийдсэн аж. Дараагийнх нь ням гарагт тэрээр Хүүхдийн Хэсэгт очжээ. Тэр хүүхдүүдэд Их Эзэний аравны нэгийн хуулийн талаар зааж, олсон мөнгөнийхөө аравны нэгийг төлөх хүсэлтэй байгаа эсэхийг тэднээс асуужээ. Хүүхдүүд тэгнэ гэж хэлсэн гэнэ. Тэд үнэхээр төлсөн ажээ.

Дараа нь бишоп тойргийнхоо насанд хүрэгчид дээр очиж, итгэлтэй хүүхдүүд нь аравны нэгээ сүүлийн зургаан сарын турш төлсөн гэдгийг хэлжээ. Тэрээр тэднээс хүүхдүүдийнхээ жишээг дагаж, тэдэнтэй адил аравны нэгээ төлөх үү гэж асуусан гэнэ. Хүмүүс хүүхдүүд золиослол гаргах өрнүүн хүсэлтэй байсанд сэтгэл нь хөдөлж, аравны нэгээ төлөхийн тулд шаардлагатай бүхнийг хийжээ. Тийнхүү тэнгэрийн цонх нээгдсэн гэнэ. Итгэлтэй хүүхдүүдийн жишээний улмаас тойрог нь дуулгавартай байдал болон гэрчлэлээрээ өсчээ.

Есүс Христ Өөрөө хүүхдүүдийн жишээг харахыг бидэнд заасан билээ. Тэнгэрийн хаант улсад хэн хамгийн агуу байх талаар дагалдагчид маргах үед Түүний өгсөн хариултыг Шинэ Гэрээнд өгүүлсэн байдаг. Тэрээр тэдний асуултанд жижигхэн

мөртлөө хүчтэй жишээгээр хариулав. Тэрээр бяцхан хүүхдийг дуудан, дунд нь суулгаад ийн ярьсан юм:

“Та нар өөрчлөгдөж, хүүхдүүдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй.

Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь байх болно” (Матай 18:3–4).

Бид хүүхдүүдээс юу сурах ёстой вэ? Бидний сүнслэг байдлын өсөлт хөгжилтөд туслахаар ямар жишээг тэд үзүүлдэг вэ? Ямар зан чанар тэдэнд байдаг вэ?

Бурханы эдгээр ариухан үрс итгэлийн зүрхтэйгээр бидэнд ирдэг билээ. Тэд итгэлээр дүүрэн байдаг бөгөөд Ариун Сүнсийг мэдрэмтгий хүлээн авдаг. Хүүхдүүд бол даруу зан, дуулгавартай байдал, хайрын агуу жишээ юм. Тэд ихэвчлэн хамгийн түрүүнд хайрладаг бас уучилдаг.

Хүүхдүүд цайлган цагаан Христийнхтэй адил зан чанарын хүчтэй үлгэр жишээгээрээ бидний амьдралыг хэрхэн адисалж чадах тухай хэдэн жишээг хуваалцъя.

Хоёрхон настай бяцхан хөвгүүн Тодд саяхан Аврагчийн гайхамшигтай зургуудыг дэлгэн үзүүлсэн урлагийн музейд ээжтэйгээ очжээ. Тэднийг ариун зургуудын хажуугаар өнгөрөх үед хүү нь, “Есүс” нэрийг чимээгүйхэн хэлэхийг ээж нь сонсжээ. Түүнийг эргэж хартал хүү нь зураг уруу ширтэн, гараа зөрүүлэн толгойгоо бөхийлгөж байв. Бид Тоддоос даруу байдал, сүсэг бишрэл, Их Эзэнийг хайрлах хайрын талаар ямар нэгэн зүйлийг сурч болох уу?

Өнгөрсөн намар би Арменд арван настай нэгэн хөвгүүний үлгэр жишээг харсан. Бид бүгд ариун ёслолын цуглаан эхлэхийг хүлээж байтал тэр хүү салбарын хамгийн өндөр настай гишүүн ирэхийг ажиглав. Хөвгүүн тэр даруй түүний хажууд очиж, гараа өгөн, тохойноос нь түшиж, танхим уруу оруулан өндөр настай эмэгтэйд үг хэлэгчдийн яриа хамгийн сайн сонсогдох, цуглааны байрын нүүрэн талын эгнээнд очиж суухад нь туслав. Их Эзэний хаант улс дахь хамгийн агуу хүмүүс бол бусдад үйлчлэхэд бэлэн байдаг хүмүүс мөн гэдгийг түүний сайхан сэтгэлийн өчүүхэн үйлдэл бидэнд зааж чадах бус уу?

Хүүхдийн Хэсгийн насны нэгэн охин Кейти гэрийнхэндээ хэрхэн нөлөөлснийг харсан нь бидэнд сургамж болсон. Тэрээр Хүүхдийн хэсэгт явснаар сайн мэдээний сургаалд дуртай болсон юм. Итгэл, гэрчлэлээрээ өсөж буй Кейти аав ээжийнхээ дэрэн дээр бичиг үлдээсэн байв. Тэр сайн мэдээний үнэнүүд зүрх сэтгэлийг нь эзэмдсэн гэж бичсэн байв. Тэрээр Тэнгэрлэг Эцэгтэй ойрхон, Түүний зарлигуудад дуулгавартай байж, гэр бүлээрээ ариун сүмд лацдан холбуулахыг маш их хүсдэг тухайгаа хуваалцжээ. Хайртай охиныхоо энгийн гэрчлэлд аав ээжийнх нь сэтгэл нэн их хөдөлжээ. Кейти болон түүний гэр бүл тэднийг үүрд мөнхөд холбосон ариун сүмийн онцгой ёслолуудыг хүлээн авсан ажээ. Кейтигийн гүн бишрэлтэй зүрх сэтгэл, итгэлийнх нь үлгэр жишээ гэр бүлдээ мөнхийн адислал ирэхэд нь тусалсан юм. Түүний чин сэтгэлийн гэрчлэл болон Их Эзэний төлөвлөгөөг дагах хүсэл нь амьдралд хамгийн чухал зүйл юу болохыг илүү тод томруун харахад биднийг хөтөлж чадах уу?

Манай гэр бүл ойрын хамаатан зургаан настай Лиямаас сурч байна. Өнгөрсөн жил тэр тархины хорт хавдраар өвчилсөн юм. Хоёр удаагийн хүнд мэс заслын дараа эмч нар түүнийг цацраг идэвхт туяагаар эмчлэх шаардлагатай гэж үзжээ. Энэхүү цацраг идэвхт туяаны эмчилгээний үед тэр ганцаараа, хөдөлгөөнгүй байх шаардлагатай байв. Эвгүй санагддаг учраас тэр тайвшруулах тариа хийлгэхийг хүсээгүй гэнэ. Лиям аавынхаа дууг дотоод радиогоор сонсох юм бол тариагүйгээр хөдөлгөөнгүй хэвтэж чадна гэж шийдсэн байв.

Тийм түгшүүртэй үед аав нь түүнд хайр болон урмын үгсээр ярьж байв. “Лиям, чи намайг харж чадахгүй ч гэсэн аав нь энд байна. Чамайг тэвчээртэй байж чадна гэдгийг аав нь мэдэж байна. Охиндоо хайртай шүү” гэж аав нь түүнд урам хайрлаж байлаа. Нас нь балчир түүнд тайвшруулах тариа хийхгүй бол болохгүй гэж эмч нар нь бодож байсан ч, Лиям огт хөдөлсөнгүй, 33 удаагийн цацраг идэвхт туяаны эмчилгээг амжилттай дуусгажээ. Өчнөөн сар хүнд хэцүү, сэтгэл санааны зовлон туулах үед Лиямын өөдрөг үзэл нь хүнд сорилт бэрхшээл учирсан үед найдвартай, бүр аз жаргалтай байхад тусалдаг ажээ. Түүний эрэлхэг зориг эмч, сувилагч болон өөр олон хүмүүсийг зоригжуулсан юм.

Бид Лиямаас итгэхээр сонгох, Их Эзэнд найдвар тавих тухай чухал сургамжуудыг сурч байна. Бид Лиямын адил Тэнгэрлэг Эцэгийг харж чадахгүй ч гэсэн амьдралын саад бэрхшээлийг даван туулахад хэрэгтэй хүч чадлыг өгдөг Түүний дуу хоолойг сонсохыг хичээж чадна.

Хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн хүүхэд шиг болох тухай Хаан Бенжамины үгсийг улам сайн ойлгоход Лиямын жишээ бидэнд тусалж чадах уу? (Мозая 3:19-ийг үз)

Тэнгэрийн хаант улсад орохын тулд бидний хөгжүүлэх эсвэл өөрсөддөө байгааг дахин олж мэдэх хэрэгтэй, хүүхэд шиг тэрхүү зан чанарын жишээнүүдийг эдгээр хүүхдүүд бидэнд өгч байна. Тэд дэлхийгээс өнгө алдаж гундаагүй, зааж сургахад амар, итгэлээр дүүрэн цэвэр ариун сүнснүүд юм. Аврагч жаахан хүүхдүүдэд онцгой хайртай, тэднийг анхаарч халамжилдаг нь гайхах зүйл биш.

Аврагчийн Америк дахь айлчалын үеэрх гайхамшигтай үйл явдлуудаас хүүхдүүдэд үйлчилсэн Түүний үйлчлэл онцгой юм. Тэрээр чин сэтгэлээсээ хүүхэд бүрд хандаж чадсан.

“Мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав.

Мөн тэрээр үүнийг хийгээд тэрээр дахин уйлав.

Мөн тэр олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв.” (3Нифай 17:21-23).

Ахлагч М.Рассел Баллард бяцхан үрсээ анхаарах тухай Аврагчийн тушаалын чухлыг бидэнд заахдаа: “Аврагч ‘тэднийг халыт хар эсвэл тоомсоргүйгээр ажигла эсвэл хааяа л нэг тэднийг анхаар’ гэж хэлээгүйг сайтар бод. Тэднийг болгоогтун гэж Тэрбээр хэлсэн юм. Энэ нь бид тэднийг харцаараа болон зүрх сэтгэлээрээ тэвэрч, Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн үрс болох тэнгэрлэг зан чанартай тэднийг байгаагаар нь харж, анхаарч халамжлан, талархах хэрэгтэй гэсэн үг” гэжээ. (“Behold Your Little Ones,” *Tambuli*, 1994 оны 10-р сар, 40; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Гэр бүлүүдээс илүүгээр “бяцхан үрсээ болгоох” газар гэж үгүй. Гэр бүл бол бид бүгд хамтдаа сурч, өсч хөгжих газар юм. Хүүхдийн Хэсгийн сайхан дуунуудын нэг нь бидэнд энэ үнэнийг заадаг:

Бурхан бидэнд гэр бүлийг өгсөн нь

Түүний хүссэн хүн болоход туслахын тулд юм

Тэрээр Өөрийн хайрыг ийнхүү хуваалцдаг

Гэр бүл нь Бурханых билээ.

(“The Family Is of God,” *Friend*, 2008 оны 10-р сар, 28–29)

Хайрын орчин болох энэхүү гэр бүлүүддээ л бид Түүний сүнсэн хүүхдүүдийн бурханлиг чанаруудыг илүү тод томруунаар олж хараад баярлан талархдаг. Гэр бүлд л бидний зүрх сэтгэл зөөлөрч, бид хүүхэд лүгээ адил болж, өөрчлөгдөхийг даруухнаар хүсдэг билээ. Энэ бол бид Христтэй илүү адил болж чадах үйл явц юм.

Амьдралын зарим туршлага та нарын итгэл бишрэлтэй зүрх сэтгэлийг болон хүүхдийнх шиг цагаан цайлган сэтгэлийг алга болгосон уу? Хэрэв тэгсэн бол өөрсдийнхөө амьдрал дахь хүүхдүүдийг хар. Бүр дахиад хар. Тэд танай гэр бүлд эсвэл нөгөө талын гудамжинд амьдардаг эсвэл тойргийн чинь Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд байж болно. Хэрэв бид хүүхдүүдийн жишээг дагах хүсэлтэй, тэднээс суралцах сэтгэлтэй байвал тэдний бурханлиг чанарууд бидний өөрсдийн сүнслэг хөгжлийг нээх түлхүүр байж чадна.

Хүүхдүүдээс маань ирсэн адислалд би үргэлж талархаж явах болно. Тэдний нэг бүрийн жишээ нь надад хэрэгтэй сургамж болсон. Намайг илүү сайн хүн болоход тэд надад тусалсан.

Есүс бол Христ мөн гэсэн даруухан ч бат бөх гэрчлэлээ хуваалцъя. Тэрээр хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн цорын ганц төгс төгөлдөр Хүү юм. Бидний хүн нэг бүр тэнгэр дэх гэртээ эргэн очихын тулд Түүний жишээг дагаж, хүүхэд лүгээ адил болох болтугай. Есүс Христийн нэрээр залбирлаа, амен.

Бямба гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Христийн дагалдагчид

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн

Ахлагч Уолтер Ф.Гонзалес

Өнгөрсөн 10-р сард эхнэр бид хоёр Ахлагч Нийл Л.Андерсен, Андерсен эгч хоёрыг дагалдан Аргентины Кордова хотод шинэ ариун сүмийн газар хөндөх ёслолд оролцохоор явсан. Ёслолын дараа, тогтсон журмын дагуу хэвлэлийн бага хурал болсон юм. Сүмийн гишүүн биш нэгэн сэтгүүлч, эрэгтэй хүмүүс эхнэрүүддээ хэрхэн сайнаар хандаж байгааг харснаа хэлж билээ. Тэгээд тэр эмэгтэй гэнэтхэн энэ нь үнэн бодитой юу эсвэл хуурамч байдал уу? хэмээн асуужээ. Тэр манай сүмийн гишүүд ямар нэгэн байдлаар өөр байгааг харж мэдэрсэн гэдэгт би итгэлтэй байна. Тэр манай Сүмийн гишүүдийн Христийг дагах хүслийг нь ойлгож мэдэрсэн байхаа. Дэлхий даяарх Сүмийн гишүүд ийм хүсэлтэй байдаг юм. Түүний хамт Сүмийн гишүүн бус олон хүмүүс ч гэсэн Түүнийг дагах хүсэлтэй байдаг.

Саяхан, Гана болон Нигерид уулзсан хүмүүс эхнэр бид хоёрт онцгой сэтгэгдэл төрүүлж билээ. Ихэнх нь Сүмийн гишүүн биш байсан. Христийг дагах хүсэл эрмэлзлэл нь тэдний олон ярианд илэрч, гэр оронд нь, машин дээр нь, байшин барилгын хана, зарлал мэдээллийн самбар дээр бичээстэй байгааг хараад бид баяртай байлаа. Бид урьд нь Христийн ийм олон сүм нэг нэгэнтэйгээ зэрэгцэн оршиж байсныг хараагүй.

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд, ийм олон сая хүмүүст, тэдэнд аль хэдийн байгаа тэр сайн зүйлүүд дээр нь манай Сүм юуг нэмж чадахыг харуулах нь бидний үүрэг хариуцлага юм. Ямар ч тивээс, ямар ч цаг агаартай орноос, эсвэл соёл заншлаас ирсэн хэн ч гэсэн Бошиглогч Иосеф Смит Эцэг Хүү хоёрыг үзэгдэлдээ харсан гэдгийг өөрсдөө мэдэж чадна. Тэд тэнгэрлэг элчүүд санваарыг сэргээсэн мөн Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ гэдгийг мэдэж чадна. Енохын үгсэд, "...зөв шударга ёс[] тэнгэрээс доош илгээ[гдэ]х болно; мөн миний Төрсөн Ганцы тухай гэрчлэхээр дэлхийгээс үнэн[] илгээ[гдэ]х болно." ¹

Аврагч: "...намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно." хэмээн амласан байдаг. ² Христийн дагалдагчид гэрэлд алхан, амьдралдаа Түүний хэв маягийг дагадаг. Хоёр төрлийн зан төрх нь бид ямар хэмжээгээр Түүнийг дагах вэ гэдгийг мэдэхэд тусалдаг. Нэгдүгээрт, Христийн дагалдагчид бусдыг хайрладаг хүмүүс юм. Хоёрдугаарт, Христийн дагалдагчид гэрээнүүд хийж, түүнийгээ сахьдаг.

Кордова дахь сайхь сэтгүүлч манай Сүмийн гишүүдийн дундаас ажиглан харсан зан төрхийн анхдагч үйл нь бусдыг хайрлах хайр байсан байж магадгүй. Бид Христэд хайртай

учраас Түүнийг дагадаг. Бид хайрын улмаас Гэтэлгэгчийг дагаснаар Түүний үлгэр жишээг дагаж байгаа хэрэг. Аврагч хайраар дамжуулан, ямар ч нөхцөл байдалд Эцэгийн хүсэлд дуулгавартай байсан. Бидний Аврагч махбодын болон сэтгэл санааны зүйрлэшгүй их өвдөлтийг биеэр амссан ч; ташуурдуулж, шоолуулсан ч; найзууд нь Түүнийг орхисон үед дайснууд нь Түүнийг зовоон тарчлаасан тийм үед Тэрбээр дуулгавартай байсан билээ. Аврагчийн үйлчлэлийн нэгэн онцлог болох цагаатгагч золиослол нь хамгийн агуу хайрын илрэл юм “...бидний амар амгалангийн төлөө Түүн дээр гэсгээлт бууж, Түүний шархаар бид эдгэрсэн юм.”³ Христ Эцэгийг ямар ч нөхцөлд дагасантай адил, бид Түүний Хүүг дагах ёстой. Хэрвээ бид ингэвэл, ямар ч хавчлага шахалт, гай зовлон, сорилт бэрхшээл, “махан биеийн өргөстэй”⁴ тулгарах нь хамаагүй, бид ганцаараа биш. Христ биднийг дэмжин туслах болно. Түүний нигүүлсэл биднийг ямар ч нөхцөл байдалд хүчирхэг болгож чадна.⁵

Христийг дагана гэдэг нь Моабийн Руттэй адил хайрладаг, эрхэм нандин зүйлсээ орхин явах гэсэн утгатай байж болно. Тэр шинэ хөрвөгчийн хувьд, Бурхан болон Наомид хайртай байсан учраас, итгэл бишрэлийнхээ дагуу амьдрахын тулд тэрээр бүх зүйлсээ орхин явсан юм.⁶

Энэ нь мөн сорилт бэрхшээл, уруу таталтын эсрэг тэмцэх гэсэн үг. Иосеф өсвөр насандаа боол болон зарагдсан билээ. Тэрээр хайртай бүх зүйлээсээ салсан. Хожим нь тэрээр ариун явдлын хуулийг ноцтойгоор зөрчих уруу таталттай тулгарсан. Тэр уруу таталтыг эсэргүүцэн, “...Би яаж ийм их муухай хэрэг үйлдэж, Бурхандаа нүгэл үйлдэх билээ” гэж хэлсэн байдаг.⁷ Түүний Бурханд зориулсан хайр ямар ч сорилт бэрхшээл, уруу таталтаас илүү хүчтэй байлаа.

Өнөөдөр орчин үеийн Рутчүүд болон Иосефчууд дэлхий даяар газар сайгүй байна. Эквадорын Гуаяаквилийн Жимми Олвера ах номлолынхоо дуудлагыг хүлээн авах үед гэр бүл нь хүнд сорилт бэрхшээлийг даван туулахын төлөө байдаг хүчээрээ чармайн тэмцэж байлаа. Түүнийг номлолд явдаг өдөр, хэрвээ тэр гэр бүлээ орхин явах юм бол, номлолоосоо буцаж ирэхэд нь гэр бүл нь түүнийг орхин явах болно гэжээ. Зүрх сэтгэл нь шархиран өвдөж байсан ч тэрбээр гэр бүлээ орхин явсан юм. Түүнийг номлолд байхад ээж нь номлолынхоо талбарт дахиад арай удаан үлдээрэй гэж гуйсан гэнэ. Учир нь тэд маш олон адислал хүлээн авсан ажээ. Өнөөдөр Олвера ах гадасын патриархаар үйлчилж байна.

Биднийг хайрладаг Христ Түүнийг дагахад шаардагдах тэрхүү хүчин чадлыг бидэнд өгдөг. Үүнийг Их Эзэн өөрөө “Чи намайг хайрладаг уу?” хэмээн Петрээс гурван удаа асуухдаа бидэнд харуулсан юм. Петр Их Эзэнд хайртай гэдгээ чангаар дахин батлан хэлсний дараа Их Эзэн Петрт тохиолдох бэрхшээлүүдийн талаар хэлээд: “Намайг дага” гэж урьсан билээ. Петр тавьсан Аврагчийн дараах асуулт бидэнд хамааралтай юм: “Чи намайг хайрладаг уу,” гэдэг нь “Намайг дага”⁸ гэсэн уриалгаар дамжин үйлдэл буюу үйл ажиллагаа болох ёстой.

Хайр нь дуулгавартай байх хүчин чармайлт гаргахад бидний зүрх сэтгэлд хүчтэй нөлөө үзүүлдэг. Аврагчийг хайрлах бидний хайр Түүний зарлигуудыг дагахад бидэнд хүчтэй урам дэм өгдөг. Мөн ээж, аав, гэр бүлийнхээ бусад гишүүдийг хайрлах хайр нь сайн мэдээний зарчмуудыг дуулгавартай дагахад биднийг урамшуулан дэмждэг билээ.⁹ Бид бие биенээ хайрладаг тэр хэмжээгээр бас бусдад хэрхэн ханддаг байдлаар Аврагчаа хэрхэн дагадагаа харуулдаг.¹⁰ Бид хийж байгаа зүйлээ орхин бусдад туслахад, бүх зүйлд бүрэн

дүүрнээр илэн далангүй, зөв шударга байхад, мөн гэрээнүүд хийж, сахиснаар хайр талархлаа Түүнд харуулдаг билээ.

Гэрээнүүд хийж, тэдгээрийг чанд сахих нь Христийн дагалдагчдад байдаг хоёр дахь зан чанар юм.

“...Өөрсдийг тань нүглийн ангижралд хүргэх, Эцэгийн гэрээн дэх Христийн цус урсалтаар ариусгагдсан билээ, тиймээс та нар ариун, толбогүй болно” гэж Моронай онцлон тэмдэглэсэн байдаг.¹¹

Бошиглогч Иосеф Смит энэ дэлхий зохион байгуулагдахаас өмнө тэнгэрт гэрээнүүд үндэслэгдэн бий болсон тухай заасан юм.¹² Эртний бошиглогчид болон патриархууд гэрээнүүд хийдэг байжээ.

Аврагч Өөрөө үлгэр жишээ үзүүлсэн юм. Тэрбээр бүх зөв шударгыг гүйцэлдүүлэхийн тулд эрх мэдэлтэй нэгнээр баптисм хийлгэсэн билээ. Аврагч баптисмаараа дамжуулан, Эцэгийн бүх зарлигийг дагахад дуулгавартай байх болно гэдгээ Эцэгт гэрчилсэн юм.¹³ Эрт үеийнхтэй адил, бид ч бас Христийг дагахын тулд санваарын ёслолуудаар дамжуулан гэрээнүүд хийдэг. Гэрээнүүдийг хийх нь манай Сүмийн гишүүн биш олон сая хүний хувьд зан чанарынхаа сайн тал дээр улам сайжрахад нь туслах зүйл юм. Гэрээнүүд хийх нь хайрын илэрхийлэл мөн. Энэ нь чухамдаа, Би таныг дагана хэмээн Түүнд хэлж байгаа хэрэг юм.

Гэрээнүүд нь амлалтуудыг, ...”бүр мөнх амьдралын амлалтыг” багтаадаг.¹⁴ Хэрвээ бид тэрхүү гэрээг санах аваас, бидний сайн сайхны тулд бүх зүйл хамтдаа ажиллах болно.¹⁵ Гэрээнүүдээр өгөгддөг амлалтуудыг бүрэн дүүрнээр хүлээн авахын тулд бид гэрээнүүд хийж, тэдгээрийг *сахьдаг* байх ёстой. Аврагчийг хайрлаж, гэрээнүүдээ байнга санаж явах нь тэдгээрийг сахихад бидэнд туслах болно. Ариун ёслолоос хүртэх нь гэрээнүүдээ санах нэг арга зам мөн.¹⁶ Ариун сүмд тогтмол явах нь өөр нэг арга зам юм. Хоорондоо таарч тохирохоо болиод, салж сарних дээрээ тулсан, Өмнөд Америкийн нэг залуу гэр бүлийн хосыг би санаж байна. Санваартан удирдагч нь ариун сүмд явж, тэнд хийсэн гэрээнүүдийнхээ амлалт болон гэрээний үгсэд онцгой анхаарал тавь хэмээн зөвлөжээ. Тэд түүний зөвлөлгөөг дагаснаар гэрлэлтээ аварч чадсан аж. Гэрээнүүдийн хүч нь бидэнд тохиолдох сорилтуудаас илүү юм.

Сайн мэдээнд идэвхгүй байгаа Сүмийн гишүүд ээ, эргэж ирээч. Ариун ёслолд оролцон, ариун сүмд явснаар гэрээнүүдээ санан, шинэчилдэг адислалаа мэдэрнэ үү. Ингэх нь хайрын илрэл бөгөөд Христийн үнэнч дагалдагч байх хүсэл эрмэлзлийг харуулдаг. Энэ нь амлагдсан адислалуудаа хүлээн авахад та нарыг бэлтгэх болно.

Манай Сүмийн гишүүн биш хүмүүст, би та бүхнийг итгэлээ бодитой болгон, наманчилж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисмын гэрээг хүлээн авахад бэлтгэ хэмээн урьж байна. Ингэснээр, та бүхэн хайраа, түүнчлэн Христийг дагах хүсэл эрмэлзлээ Тэнгэрлэг Эцэгтээ харуулах болно.

Бид Есүс Христийн сайн мэдээний сургаалуудыг дагаснаар илүү их аз жаргалтай байдгийг би гэрчилж байна. Түүнийг дагахыг хичээвэл тэнгэрийн адислалууд бидэнд ирэх болно. Бид гэрээнүүд хийж, тэдгээрийг сахиснаар, мөн Христийн үнэнч дагалдагч байснаар Түүний амлалтууд биелэгдэх болно гэдгийг би мэднэ. Бидний хүн нэг бүрийг хайрладаг Түүний хайрыг би гэрчилж байна. Энэ бүхнийг Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

Эшлэл

1. Мосе 7:62.

2. Иохан 8:12.

3. Исаиа 53:5.

4. 2Коринт 12:7

5. 1Нифай 1:20-ийг үз.

6. Рут 1:16-г үз.

7. Эхлэл 39:7-9-ийг үз.

8. Иохан 21:15-19-ийг үз.

9. Иохан 13:35-ыг үз.

10. Алма 27:27.

11. Моронай 10:33.

12. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 42; мөн Спенсер В.Кимбалл, “Be Ye Therefore Perfect” (онцгой цугларалт дээр хэлсэн үг, Солт Лейк дэх Шашны Институт, 1975 оны 1-р сарын 10): “Бид энэхүү мөнх бус амьдралд ирэхээсээ өмнө тэнгэрт андгай тангараг, ариун андгай тангараг тавьсан юм, ... Бид тэрхүү андгай тангаргийг дэлхий дээрх байр сууриа хүлээн зөвшөөрөхөөс өмнө хийсэн билээ.”

13. 2Нифай 31:5-7-г үз.

14. Абрахам 2:11. Жон А. Видзөү, “Temple Worship” (lecture, Assembly Hall, Солт Лейк хот, 1920 оны 10-р сарын 20), 10: (“Гэрээ нь үнэнийг амьдруулдаг бөгөөд мэдлэгийг зохих ёсоор ашигладаг бүх хүмүүсийг адислалуудыг хүлээн авах боломжтой болгодог ...”)

15. Сургаал ба Гэрээ 90:24-ийг үз.

16. Жишээ нь, 3Нифай 18:7-11-ийг үз.

Бямба гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Цагаатгал бүх өвчнийг эдгээдэг

Далын Ахлагч

Кент Ф.Ричардс

Би мэс засалчийн хувьд ажил мэргэжлийнхээ маш олон цагийг өвчин эмгэгтэй хүмүүстэй хамт өнгөрүүлсэн. Ажлын шаардлагаар би өдөр бүр өвчин эмгэгтэй нүүр тулж, улмаар түүнийг эдгээж илааршуулахын төлөө чадах бүхнээ хийдэг байлаа.

Өвчин эмгэг гэж чухам юу юм бэ? гэдгийг би олон удаа тунгаан бодсон. Бид бүгдэд өвчин эмгэг тохиолддог. Хүмүүс өвчин эмгэгийг янз бүрээр ялж гарахыг

үзсэн. Зарим нь уурлан бухимдаж Бурханаас холддог байхад зарим хүмүүс өвчин зовлонгоос болж Бурхантай илүү ойртдог.

Та нарын адил би ч бас өвчин эмгэгийг үзсэн хүн. Зовиур бол эдгэх үйл явцын хэмжүүр юм. Энэ нь бидэнд ихэнхдээ тэвчээр хатуужил суулгадаг.

Ахлагч Орсон Ф. Витни “Бидэнд тохиолдохгүй өвчин зовлон, сорилт бэрхшээл гэж байхгүй. Сорилт бэрхшээлийн үр дүнд бид мэдлэг, туршлага, тэвчээр хатуужилтай болж, бидний итгэл, даруу байдал өсч хөгждөг ... Бид уй гашуу, зовлон зүдгүүр, хүнд хөдөлмөр болон гамшгаар дамжуулан энд суралцах гэж ирсэн мэдлэгээ олж авдаг”¹ гэж бичсэн байдаг.

Мөн үүнтэй төстэйгөөр Ахлагч Роберт Д.Хейлс “Зовиур та нарыг бодож тунгаахад хүргэдэг даруу зан уруу хөтөлдөг. Би өөрөө үүнийг даван туулсандаа баяртай байдаг юм. Нэг удаа хүнд мэс заслын дараа бие махбодын зовиур болон эдгэрэх явц нь нүглээ наманчлахад сүнсний зовиур эдгэрэхтэй нэн ойролцоо болохыг би олж мэдсэн”² гэж хэлжээ.

Бидэнд тохиолддог зовлон зүдгүүрийн олонх нь бидний буруугаас болоогүй байдаг. Гэнэтийн үйл явдлууд, зөрчил болон сэтгэл санаанд таагүйгээр нөлөөлсөн нөхцөл байдал, зүрх шимшрүүсэн өвчин тэр байтугай үхэл хүртэл биднийг тойрдоггүй бөгөөд бидний мөнх бусын амьдралын жам ийм юм. Үүнээс гадна бусдын үйлдлээс болоод бидэнд зовлон зүдгүүр тохиолдож болно.³ Лихай Иаковыг “ах нарынхаа балмадын учир их харамсал мөн зовлон үзсэн юм”⁴ гэжээ. Сөрөг тал бол Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Эцэгийн хайр болон Аврагчийн тусламжийн талаар бидэнд илүү ихээр ойлгуулах хангалттай сөрөг зүйлүүдтэй бид учирдаг билээ.

Аврагч бол чимээгүй ажиглагч биш. Тэрээр бидэнд тохиолдох өвчин зовлон, сорилт бэрхшээлийг сайн мэддэг. “Тэрээр бүх хүмүүний шаналлыг тэвчинэ, тийм ээ, амьдрагч бүхний шаналалыг... эр, эм, мөн хүүхэд аль алиныхыг нь болой.”⁵ “Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын

тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очицгооё”⁶ Заримдаа бид хүнд зовлон зүдгүүртэй учирсан үед “Гилейдад ямар ч гавар байхгүй гэж үү? Тэнд ямар ч эмч байхгүй гэж үү?”⁷ гэж асуумаар санагддаг. Үүний хариуд би тийм ээ, эмч байдаг гэж гэрчилж байна. Есүс Христийн Цагаатгал нь мөнх бус байдлын эдгээр бүх зорилго болон нөхцөл байдлыг хамардаг.

Бид өөрсдөө үүрэг хүлээх ёстой өөр нэгэн зовиур байдаг. Сүнсний зовиур нь Алмагийн хэлснээр, “илэрхийлэхийн аргагүй” “тарчилгахаар”⁸ бидний оюун санаанд гүн оршиж, эцэс төгсгөлгүй мэт санагддаг билээ. Энэ нь бидний нүгэлт үйлдэл болон нүглээ наманчлаагүйгээс улбаатай байдаг. Сүнсний зовиурыг ч гэсэн бүрэн эдгээж болно. Энэхүү эдгээлт Эцэгээс Хүүгээр нь дамжин ирдэг бөгөөд хэрэв бид нүглээ наманчлахад шаардлагатай бүхнийг хийхэд бэлэн байх юм бид бүгдийн төлөө байдаг юм. “Би та нарыг эдгээж болохын тулд та нар надад ир[эхгүй]... гэж үү?”⁹ гэж үү хэмээн Христ хэлжээ.

“Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд, би загалмай дээр өргөгдсөний дараа, би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд... Эцэг минь намайг илгээсэн бөлгөө...”

Тиймийн тул Эцэгийн хүчний дагуу би бүх хүмүүнийг өөртөө татах болно”¹⁰ гэж Христ Өөрөө заасан билээ.

Магадгүй Түүний хамгийн чухал ажил нь бидний хүн нэг бүрийг өргөж, адислан, итгэлийг нь бэхжүүлж, дэмжиж туслан, удирдах болон уучлах одоогийн хийгдэж байгаа ажил байж болно.

Нифай үзэгдэлд харснаар, Христийн мөнх бус амьдрал дахь үйлчлэлийн ихэнх нь бие махбодын болон оюун санаа, сүнслэг байдлаараа өвчтэй олон янзын өвчтөн хүмүүсийг адисалж эдгээхэд зориулагдсан юм. “Мөн өвчилсөн, бас олон зүйл өвчний улмаас... зовж шаналсан олныг би болгоов... мөнхүү тэнгэр элч... эдгээр бүх зүйлийг надад үзүүлсэн авай. Мөн тэд Бурханы Хурганы хүчээр эдгээгдэв.”¹¹

Алма мөн ийнхүү бошигложээ: “Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ ав[ч] түүний зүрх сэтгэл бие махбодийн дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд бөлгөө.”¹²

Нэг орой би эмчийн хувьд биш харин өвчтөн болж эмнэлгийн орон дээр хэвтэж байхдаа дээрх шүлгүүдийг дахин дахин уншиж билээ. “Яаж ийм болох вэ? Хэний төлөө? Үүнд тэнцэхийн тулд юу шаардлагатай вэ? Энэ нь нүгэл нь өршөөгдөхтэй адил юм болов уу? Түүний хайр болон тусламжийг хөдөлмөрлөж байж олох ёстой юу?” гэдгийг би тунгаан бодсон. Ийнхүү тунгаан бодох явцдаа, Христ мөнх бус амьдралынхаа туршид биднийг ойлгохын тулд зовлон шаналлыг туулахаар *сонгосныг* би ойгосон юм. Магадгүй бид ч мөн Түүний болон өөрсдийн мөнхийн зорилгыг ойлгохын тулд мөнх бус байдлын хамгийн хүнд хэцүүг туулах хэрэгтэй байх.¹³

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, “Хүнд хэцүү үед Аврагчийн амласан тусламжийг хүлээх хэрэгтэй байвал, Аврагч биднийг хэрхэн эдгээж, бидэнд хэрхэн туслахыг Өөрийн туршлагаас мэддэг учир биднийг тайвшруулдаг. Мөн тусламжийн төлөө гуйн залбирч, хөдөлмөрлөн, хүлээх зуур энэхүү хүчинд итгэх итгэл нь бидэнд

тэвчээр хатуужлыг суулгана. Тэрээр бидэнд хэрхэн туслахыг илчлэлтээр мэдэж болох л байсан, гэвч тэрээр *өөрийн туршилагаар сурахаар сонгосон билээ.*¹⁴

Би тэр үдэш “хайрын мутарт тэвр[үүлснээ]”¹⁵ мэдэрсэн юм. Баярлаж, сэтгэл догдолсондоо дэрээ нулимсаараа норгож билээ. Дараа нь Матайн номноос Христийн мөнх бус үйлчлэлийн талаар өөр нэгэн судрыг үзэв: “...Олон хүнийг Түүн уруу авчрахад...өвдсөн *бүгдийг* эдгээжээ.”¹⁶Тэрээр Өөр уруу нь ирсэн *бүгдийг* эдгээсэн. Нэгийг нь ч буцаагаагүй юм.

Ахлагч Даллин Х.Өүкс ингэж заажээ: “Эдгээх адислалууд олон янзаар ирдэг, биднийг хамгийн их хайрладаг Түүний мэдлэгийн дагуу бидний хүн нэг бүрийн хэрэгцээнд тохирсон байдаг. Заримдаа ‘эдгээлт’ нь бидний өвчнийг эдгээж, зовлонг нимгэлдэг. Гэвч заримдаа тохиолдсон зовлон зүдгүүрийг даван туулах тэвчээр, ойлголт, хүч чадлыг хүлээн авснаар бид эдгээгддэг.” Тэрбээр бүх хүмүүст хариу өгдгийн адилаар бидэнд хариу өгдөг. Ирсэн бүхэн “Есүсийн мутарт тэврэгдэх”¹⁸ болно. Бүх сүнснүүд Түүний хүчээр эдгээгдэж чадна. Бүх зовлонг Тэрбээр нимгэлэх болно. Түүгээр бид “сэтгэл санааны амралтыг олж”¹⁹ чадна. Бидний мөнх бус байдлын ын нөхцөл байдал тэр даруй өөрчлөгдөхгүй байж болно. Гэвч бидний өвчин, сэтгэлийн зовиур, шаналал, айдас Түүний амар тайван болон эдгээлтийн гаварт дарагдах болно.

Хүүхдүүд ихэнхдээ өвчин эмгэгт илүү хүлээцтэй хандаж, тэвчиж чаддагийг би олж мэдсэн. Тэд чимээгүйхэн, даруу төлөв, номхон дөлгөөн зангаар тэсвэрлэдэг. Бяцхан хүүхдүүдийн амьдралаас би гайхамшигтай сайхан мэдрэмжийг мэдэрдэг.

14 настай Шери нугасны хавдар авахуулахаар арван дөрвөн цаг үргэлжлэх мэс засалд орсон юм. Тэр эрчимт эмчилгээний тасагт мэдээ орж эхлэх үедээ, “Аав аа, Шерил эгч энд байна. Бас Норман өвөө, Браун эмээ хоёр ч энд байна. Аав аа, таны хажууд зогсож байгаа хэн бэ? Тэр танаас өндөр л болохоос тантай адилхан харагдаж байна. Тэр өөрийгөө таны ах Жимми гэлээ” гэжээ. Авга ах Жимми нь 13 настайдаа мэдрэлийн судлын цочмог үрэвслээр нас барсан ажээ. Шери бараг бүтэн цаг өөр дээр нь ирсэн хүмүүсийг тодорхойлж хэлсэн бөгөөд тэд бүгдээрээ нас барсан хамаатнууд нь байжээ. Тэгээд тэр ядарсандаа унтаад өгсөн гэнэ. Дараа нь тэр аавдаа, “Аав аа, энд эрчимт эмчилгээний тасагт байгаа бүх хүүхдүүдэд тэнгэр элчүүд тусалж байна”²⁰ гэж хэлжээ.

Христ бид бүгдэд хандан, “Болгоогтун, та нар бяцхан хүүхдүүд, мөн эдүгээ та нар бүх зүйлийг даах нь үгүй болой; та нар ач ивээл хийгээд үнэний мэдлэгт өсөх ёстой.

Иймийн тул, бибээр та нарын дунд байна, мөн бибээр сайн хоньчин”²¹ гэж хэлсэн билээ.

Бяцхан хүүхдүүд бүү эмээ, учир нь та нар минийх болой. . .

“Христийн цагаатгалаар гэгээнтэн”²² болох нь мөнх бус амьдралд бидэнд тохиолддог яггүй хэцүү бэрхшээл юм. Та нарт болон надад учрах зовлон зүргүүр нь энэхүү үйл явцын хамгийн том хэмжүүр байж мэднэ. Эцэст нь бид зүрх сэтгэлээрээ хүүхдүүд болж, өөрсдийгөө даруусган, “залбирч, хөдөлмөрлөн, бие болоод сүнсээ эдгэрэхийг тэвчээртэйгээр хүлээж”²³ чадна. Бид Иовын адилаар зовлон зүдгүүрээрээ цэвэршсэний дараа, “алт мэт урагш гарч ирэх”²⁴ болно.

Тэрээр бидний Гэтэлгэгч, бидний Найз, бидний Өмгөөлөгч, агуу эмч, агуу эдгээгч мөн гэдгийг би гэрчилж байна. Хэрэв бид Түүгээр дамжуулан, Түүн уруу даруухан зүрх сэтгэлтэйгээр ирэх юм бол, амар тайван, зовлон зүдгүүр, нүглээс тайтгарлыг олж чадна. Түүний “ач ивээл хангалттай.”²⁵

Есүс Христийн нэрээр, амен.

Эшлэл

1. Оорсон Ф.Витни, Spencer W. Kimball, *Faith Precedes the Miracle* (1972), 98.
2. Роберт Д.Хейлс, “Healing Soul and Body,” *Ensign*, 1998 оны 11-р сар, 14.
3. Алма 31:31, 33-ыг үз.
4. 2Нифай 2:1.
5. 2Нифай 9:21.
6. Еврей 4:16. “[Бид] сэтгэлээр унахгүй байж, тэнхээгээ шавхахгүйн тулд, [бидний] эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцэл” (Еврей 12:3)-тэй тулгарахдаа Аврагчийн үлгэр жишээнд найдвар тавь хэмээн Паул заажээ.
7. Иеремиа 8:22.
8. Алма 36:14.
9. 3Нифай 9:13.
10. 3Нифай 27:14-15; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн
11. 1Нифай 11:31.
12. Алма 7:11-12; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
13. Жон Тейлор, *Mediation and Atonement*, 1882, . 97-г үз. Хүн төрөлхтний цагаатгагч гэтэлгэлийг гүйцэлдүүлэхийн төлөө мөнх бус байдлын өмнөх зөвлөл дээр Эцэг, Хүү хоёрын хооронд хийсэн гэрээний тухай бичжээ. Христ амьд ахуй үедээ зовлон тарчлалыг сайн дураараа эдэлсэн нь цэцэрлэгт болон загалмай дээр үзсэн зовлон дээр нэмэгдсэн юм. Мөн Мозая 3:5–8-ыг үз.
14. Хенри Б.Айринг, “Adversity,” *Liahona* ба *Ensign*, 2009 оны 5-р сар, 23–27; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
15. Сургаал ба Гэрээ 6:20-ийг үз.
16. Матай 8:16; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.

17. Даллин Х.Өүкс, “He Heals the Heavy Laden,” *Liahona* ба *Ensign*, 2006 оны 11-р сар, 7–8.

18. Мормон 5:11.

19. Матай 11:29.

20. Майкл Моррис, “Sherrie’s Shield of Faith,” *Ensign*, 1995 оны 6-р сар, 44.

21. Сургаал ба Гэрээ 50:40–41, 44.

22. Мозая 3:19.

23. Хенри Б.Айринг, *Liahona* ба *Ensign*, 2009 оны 5-р сар, 24.

24. Иов 23:10.

25. 2Коринт 12:9, мөн Ифер 12:26-27, Сургаал ба Гэрээ 18:31-ийг үз.

Бямба гарагийн өглөөний хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүд үнэхээр гайхалтай юм!

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Квинтин Л.Кук

Солт Лейкийн хөндий уруу Мормончуудын шилжин суурьших нүүдэл болон цугларалтын талаар зохиолч, түүхч Уоллас Стегнер бичсэн байдаг. Тэр хэдийгээр бидний итгэлд шүүмжлэлтэй хандаж, хүлээн зөвшөөрөөгүй ч, манай Сүмийн эхэн үеийн гишүүдийн, ялангуяа эмэгтэйчүүдийн баатарлаг зориг, хичээл зүтгэл түүнд өндөр сэтгэгдэл төрүүлжээ. Тэрбээр, “Эмэгтэйчүүд нь тун гайхалтай” хэмээн дурсчээ.¹ Би өнөөдөр энэхүү мэдэгдлийг давтан хэлье. Манай Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүд үнэхээр гайхалтай!

Хүч чадал, ариун журам, хайрыг мөн Түүний сүнсэн хүүхдүүдийн хойч үеийг өсгөн хүмүүжүүлэхэд золиослол гаргахад бэлэн байх тэнгэрлэг чанаруудыг Бурхан эмэгтэйчүүдэд хайрласан юм.

Нэгдсэн Улсын өөр өөр шашны эмэгтэйчүүдийг хамарсан саяхны нэгэн судалгаагаар эмэгтэйчүүд нь “Бурханд гүн гүнзгий итгэж,” шашны үйлчлэл цуглаанд эрэгтэйчүүдээс илүү оролцож, “бүх талаараа илүү итгэл бишрэлтэй юм”² гэсэн дүгнэлт өгсөн байна.

Энэ дүгнэлт нь миний гайхлыг төрүүлээгүй ээ, ялангуяа гэр бүлүүд болон эмэгтэйчүүд манай итгэлд ямар эрхэм байр суурь эзэлдэг тухай эргэцүүлэн бодохоор үүнд гайхах зүйл үгүй юм. Эмэгтэйчүүд бол тэдэнд хайртай Тэнгэрлэг Эцэгийн охид юм гэсэн манай сургаал тод томруун билээ. Эхнэр нөхөр адил тэгш эрхтэй. Гэрлэлт нь эхнэр нөхөр хоёулаа гэр бүлийнхээ хэрэгцээг хангахын тулд хамтран ажиллах хоёргүй сэтгэлийг шаарддаг.³

Эмэгтэйчүүдэд олон сорилт, түүний дотор, сайн мэдээгээр амьдрахыг хичээн чармайхад нь сорилт бэрхшээл тулгардгийг бид мэднэ.

Анхдагч эгч нарын өв

Манай анхдагчдын амьдрал дахь хамгийн чухал шинж чанарын нэг нь эгч нарын итгэл байсан юм. Тэнгэрлэг мөн чанартай эмэгтэйчүүд маань гэр орондоо болон эргэн тойрондоо бусдыг мөн үр хүүхдээ хайрлан халамжлах агуу авъяас чадвартай, илүү хариуцлага хүлээсэн байдаг. Ийм зан чанарын сацуу, хээр талыг туулаад тодорхой бус ирээдүйн төлөө гэр орноо орхин явахад бэлэн байсан эгч нарын итгэл нь үнэхээр бидэнд урам дэм хайрладаг билээ. Хэрвээ хэн нэгэн нь тэдний хамгийн чухал шинж чанарыг тодорхойлох хэрэгтэй болбол, энэ нь Их Эзэн Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнд итгэх тэдний нугаршгүй, бат бөх итгэл байх болно.

Уудам хээр талыг туулахдаа эдгээр анхдагч эмэгтэйчүүдийн золиослол гарган хийж бүтээсэн зүйлсийн тухай баримтууд нь Сүмийн үнэлж баршгүй өв юм. Мартины гар тэрэгтэй бүлгийн хамт Платте голыг гаталсны дараа нөхөр Айрон нь нас барсан

Элизабет Жексоны дурсамж миний сэтгэлийг үнэхээр догдлуулсан. Тэрээр бичихдээ:

“Ийм хүнд нөхцөл байдалд гурван хүүхэдтэй бэлэвсэрсэн миний сэтгэл санаа ямар байсныг дүрслэн өгүүлэх зорилго тавьсангүй ... Сайн мэдээгээр амьдрахыг хичээн тэмцсэний улмаас надад тохиолдсон зовлон зүдгүүр миний сайн сайхны төлөө гэдэгт би итгэлтэй байлаа...

“Бэлэвсэн эмэгтэйд нөхөр нь, эцэггүй нэгэнд эцэг нь болохыг амласан Их Эзэнд би хандаж, тэрээр надад туслахаар ирсэн юм”⁴ гэжээ.

Элизабет өөртэй нь адил амьдралын хатуу бэрхшээлийг даван туулсан хүмүүст зориулж энэ түүхийг бичихдээ, үр удам нь Бурханы Хаант улсын төлөө бүхнээ золиосолж, зовлон зүдгүүрийг даван туулахад бэлэн байгаасай гэсэн итгэл найдвар өвөрлөж явжээ.⁵

Сүмийн эмэгтэйчүүд өнөөдөр бат бөх итгэлтэй, зоригтой байна

Сүмийн эмэгтэйчүүд өнөөдөр тулгарсан сорилтыг даван туулах бат бөх итгэлтэй, хүч чадалтай хэвээр байгаа гэдэгт би итгэдэг. Энэ сүмийн санваартны бүх шатны удирдагчид бид эгч нарынхаа үйлчлэл, золиослол, итгэл үнэмшил, хувь нэмрийн төлөө гүн талархал илэрхийлж байна.

Энэ Сүм өдий зэрэгтэй байгаан ач гавъяа бол эмэгтэйчүүдийн бие хайргүй үйлчлэлийн үр дүнд билээ. Гэрт ч бай сүмд ч бай, санваартнуудын болон Нийгмийн Халамжийн Бүлгийнхэн төгс зохицон ажилдагийг харах нь сайхан байдаг. Ийм харилцаа нь хөг ая нийлсэн найрал хөгжимчид биднийг урамшуулах яруу сайхан симфони тоглохтой адил байдаг.

Саяхан би Калифорний Мишшен Виехо Гадасны чуулганд томиллолтоор очоод, тэдний дөрвөн гадасны залуучуудын шинэ жилийн өмнөх оройн бүжгийн тухай нэгэн түүхийг сонсоод миний сэтгэл ихэд догдолж билээ. Бүжгийн дараа хэнийх болох нь мэдэгдэхгүй нэг цүнх олдсон гэнэ. Би та нартай Лагуна Нигэл гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч Моника Седвик эгчийн энэ талаар бичсэн зүйлийг хуваалцъя:

“Бид бусдын зүйлийг зөвшөөрөлгүй оролдохыг хүсээгүй, яагаад гэвэл энэ нь хэн нэгний хувийн зүйлс байв. Тэгээд бид энэ цүнхийг дөнгөж нээж хараад хамгийн дээд талд байгаа юм нь цүнхний эзэн хэн болохыг мэдэх юм байж магадгүй гэж бодоод гаргаж ирэв.. Гэтэл цүнхэн дотор Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол байв... Ямар гайхалтай вэ! Энэ нь цүнхний эзний талаар ямар нэг зүйлийг бидэнд хэлэв. Тэгээд, бид дараагийн зүйлийг гаргаж ирсэн нь, жижигхэн тэмдэглэлийн дэвтэр... байв. Одоо л цүнх хэнийх болох нь мэдэгдэх болов уу гэж бодтол мөн л бидний бодсоноор болсонгүй. Эхний хуудас нь... дуртай судруудынх нь жагсаалт байлаа... Дараа нь бас нямбайлан бичсэн өөр таван хуудас судрууд болон хувийн тэмдэглэл байв.”

Эгч нар энэхүү гуйвшгүй итгэлт залуу эмэгтэйтэй даруйхан уулзахыг хүссэн гэнэ. Тэгээд цүнх хэнийх болохыг мэдэхийн тулд дотор нь байсан юмсыг гаргаж үзтэл хэдэн ширхэг гаа, саван, гарын тос, нэг сам байлаа. “Аа ингэхлээр, түүний ам сайхан үнэртэй; цэвэрхэн, зөөлөн гартай, өөртөө анхаарал тавьдаг хүн байх нь” гэж бичсэн нь надад таалагдсан.

Тэд одоо юу гарч ирэх бол гэж тэсч ядан хүлээж байсан гэнэ. Цахилгаан товчлууртай кармаанд нь хэсэг мөнгө хийсэн ундааны цаасан хайрцгаар ухаан зарж хийсэн задгай мөнгөний гар хийцийн, жижигхэн түрийвч гарч ирсэн гэнэ. Эгч нар аа, энэ хүн аливаад бүтээлчээр ханддаг, амьдралд бэлтгэгдсэн хүн байх нь!” хэмээн дуу алдсан гэнэ. Тэд Христийн Мэндэлсний Баярын өглөөг угтаж буй бяцхан хүүхдүүд шиг л байв. Цүнхнээс гаргаж ирсэн дараагийн зүйл тэднийг бүр ихээр гайхахад хүргэсэн аж. Хар Ой хэмээх шоколадан бялууны жор, мөн энэ бялууг найзынхаа төрсөн өдөрт зориулан хийх тэмдэглэл байх нь тэр! “Тэр чинь ГЭРИЙН АЖИЛД гарамгай! Анхаарал халамжтай, үйлчлэх хүсэлтэй хүн байх нь!” гэж тэд бараг л хашгирах шахсан гэнэ. Тэгээд дараа нь, цүнхний эзэн хэн болохыг хэлж өгөх зүйл эцэст нь гарч иржээ. Залуучуудын удирдагчид “сайн мэдээгээр амьдардаг залуу эмэгтэйн даруухан жишээг” хараад агуу ихээр адислагдсанаа мэдэрсэн юм хэмээн хэлж билээ.⁶

Энэ түүх залуу эмэгтэйчүүд Сүмийн жишгүүдэд тууштай үнэнч байдгийг харуулж байна.⁷ Энэ нь бас дэлхий даяарх энэрэнгүй үйлст, анхаарал халамжтай, бие сэтгэл бүхнээ сайн мэдээнд зориулдаг Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдын хувьд үлгэр жишээ болох зүйл юм. Тэд үнэхээр гайхалтай хүмүүс!

Эгч нар Сүмд, гэр бүлдээ болон хувийн амьдралдаа маш чухал үүрэгтэй мөн Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд нэн чухал байр суурь эзэлдэг. Эдгээр үүрэг хариуцлагаас олныг нь цалин мөнгөөр биелүүлдэггүй, харин сэтгэлийн баяр баясгалангаар хангадаг бөгөөд эдгээр нь мөнхийн ач холбогдолтой юм. Саяхан, нэгэн сонины редакцийн зөвлөлд ажилладаг, сэтгэл булаам, чадварлаг нэгэн эмэгтэй манай Сүм дэх эмэгтэйчүүдийн үүргийг тодорхойлохыг хүссэн аж. Манай Сүмийн бүх удирдагчид *цалингүй* ажилладгийг түүнд тайлбарлажээ. Сурвалжлагч эмэгтэй тэр даруй яриаг таслан, “Миний бодлоор эмэгтэйчүүдэд цалингүй ажил хэрэггүй” ярилцлага хийх сонирхол нь үлэмж буурлаа гэжээ.

Дэлхий дээрх хамгийн чухал байгууллага бол гэр бүл бөгөөд үүнд “эцэг эхчүүд нь... адил тэгш хамтрагчид”⁸ байдаг гэдгийг бид онцлон тэмдэглэсэн. Энэ хоёрын аль нь ч үүнийхээ төлөө цалин авдаггүй, харин үүнээс ирдэг адислал нь төсөөлөхийн аргагүй их юм. Бид, мэдээжийн хэрэг, эмэгтэй ерөнхийлөгчдөөр удирдагддаг Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, мөн Хүүхдийн Хэсгийн байгууллагуудын талаар түүнд ярьсан. Манай Сүмийн эхэн үеийн түүхээс л эрэгтэй, эмэгтэйчүүд аль аль нь манай хамгийн ариун цуглаан болох ариун ёслолын цуглаанд залбирч, хөгжим тоглож, үг хэлж, найрал дуунд дуулдаг гэдгийг тэмдэглэн хэлсэн.

Сүүлийн үеийн, өндрөөр үнэлэгдсэн *American Grace* (*Америкийн ач ивээл*) хэмээх номонд олон шашны эмэгтэйчүүдийн тухай өгүүлсэн байдаг. Энэ номонд Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүд Сүмийн удирдлагын үүрэгтээ маш ихээр сэтгэл хангалуун байдгаараа онцгой ялгаатай гэж бичжээ.⁹ Түүнчлэн, Хожмын Үеийн Гэгээнтнүүд нь бүхэлдээ, эрэгтэйчүүд мөн эмэгтэйчүүд нь, судалгаанд хамрагдсан бусад шашнуудтай харьцуулахад сүмтэйгээ хамгийн баг бөх холбоотой байдаг гэжээ.¹⁰

Манай эмэгтэйчүүд амьдралын бэрхшээлээс зайлсхийж чаддагаараа бусдаас ялгаатай байдаггүй---харин ч үүний эсрэг юм. Тэд амьдралын хүнд сорилтуудад хандах арга замаараа бусдаас онцгой ялгаатай юм. Гэрлэлт нь бүтэлгүйтсэн буюу гэрлээгүйгээс, хүүхдүүдийнхээ сонголтоос, сул дорой эрүүл мэндээсээ эсвэл

боломж олдоогүйгээс, түүнчлэн бусад асуудлууд тулгарсан ч тэд итгэл бишрэлдээ гайхалтай үнэнч, бат бөх хэвээр үлддэг. Сүмийн эгч нар маань сул доройчуудад итгэлтэйгээр тусалж, доош унжсан гарнуудыг өргөж мөн сул дорой өвдөгнүүдийг хүчирхэг болгож байдаг.¹¹ Энэхүү ер бусын үйлчлэлийн төлөө баярлаж, талархснаа илэрхийлсэн нэгэн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч, “Эгч нар үйлчилж байхдаа ч ‘би үүнээс бүр илүүг хийсэн ч болоосой’ хэмээн боддог” гэж хэлжээ. Хэдийгээр тэд төгс төгөлдөр бус мөн бүгд хувийн сорилтуудаа давах шаардлагатай ч, хайрт Тэнгэрлэг Эцэгтээ итгэх итгэл болон Аврагчийн цагаатгагч золиослолын найдвар тэдний амьдралыг гэрэлтүүлдэг.

Сүм дэх эгч нарын үүрэг

Сүүлийн гурван жилийн турш Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд санваартны болон туслах байгууллагын удирдагч нартай зөвлөлдөн *Сүмийн шинэ гарын авлагууд* дээр ажиллахдаа удирдамж, бурханлиг нөлөө, илчлэлтүүдийг эрэлхийлсэн юм. Энэхүү үйл явцад эгч нар туйлын чухал үүрэг гүйцэтгэж байгааг өндрөөр үнэлж, надад талархлын гүн мэдрэмж төрж билээ. Манай эгч нар гэр бүлтэй ч бай, ганц бие ч бай, гэр бүлд болон Сүмд, үргэлж асар их үүрэг гүйцэтгэсээр ирлээ.

Есүс Христийн Сүмийн бүх гишүүд “Хүмүүний бодгалиудыг аврахын төлөө түүний талбайд хөдөлмөрлөх”¹² ёстой. “Авралын ажилд гишүүний номлолын ажил, хөрвөгчдийг идэвхтэй хэвээр үлдээх, идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил, ... сайн мэдээг заах,”¹³ болон ядуучууд, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах зэрэг нь орно.¹⁴ Авралын ажлыг ихэвчлэн тойргийн зөвлөл хийдэг.¹⁵

Бишопууд хүмүүсийн ажил үүргийн хэмжээг харгалзан, илүү их үүрэг хариуцлагыг бусдад хариуцуулан хийлгэх талаар шинэ *Гарын авлагуудад* тодорхой заасан юм. Гишүүд тэдний зөвлөгөөг дагаснаар тэдэнд тусалж, дэмжлэг үзүүлдэг. Энэ нь залуучууд, залуу насанд хүрэгчид, гэр бүлтэйтэйгээ илүү их цагийг хамт өнгөрүүлэх боломжийг олгох болно. Тэрбээр бусад чухал үүрэг хариуцлагуудыг санваартны удирдагчид, туслах байгууллагуудын ерөнхийлөгч нарт түүнчлэн гишүүдэд хариуцуулан даалгаж болно. Сүм гэр бүлд гүйцэтгэдэг эмэгтэйчүүдийн үүрэгт хүндэтгэлтэй ханддаг билээ.¹⁶ Эхнэр нь их цаг хугацаа шаарддаг Сүмийн дуудлага авсан бол, нөхөрт нь цаг хугацаа бага шаарддаг дуудлага өгч болно.

Хэдэн жилийн өмнө би Тонгад нэг гадасны чуулганд оролцож билээ. Ням гарагийн өглөө цуглааны байрны эхний гурван эгнээ 26--35 насны эрэгтэйчүүдээр дүүрсэн байв. Би тэднийг эрэгтэйчүүдийн найрал дуучид байна гэж бодсон. Гэвч чуулганы ажил хэргийг явуулах үед, эдгээр 63 эрэгтэйн нэрийг дуудахад тэднийг Мелкизедек санваарт томилохоор нэр дэвшүүлж байгааг мэдэв. Би гайхахын сацуу бас баярлаж билээ. Хуралдааны дараа би гадасны ерөнхийлөгч Матейакигаас ийм гайхамшиг яаж тохиов гэж асуув. Тэрээр гадасны зөвлөлийн хуралд идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх талаар ярилцсан тухайгаа яриу. Гадасных нь Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Лиената Ва’энуку эгч үг хэлж болох уу гэж асуужээ. Тэр эгчийг үг хэлж байхад түүний санал болгож байгаа зүйл үнэн гэдгийг сүнс ерөнхийлөгчид баталсан гэнэ. Тэдний гадсанд номлолд үйлчлээгүй, 20--30 насны олон гайхамшигтай залуу эрэгтэйчүүд байгааг тэр хэллээ. Тэднээс олон нь номлолд үйлчил гэж ихэд дэмжиж байсан бишоп болон санваартны бусад удирдагч нарынхаа урмыг хугалсан гэдгийг мэдээд, одоо тэд сүмийн хоёрдугаар зэргийн гишүүд мэт санагддаг болжээ гээд эдгээр залуу эрэгтэйчүүд бүрэн цагийн номлолд

үйлчлэх насанд хүрснийг тэрээр хэлжээ. Тэр бас тэднийг хайрладгаа болон тэдний төлөө санаа зовж байгаагаа илэрхийлсэн аж. Авралын бүх ёслол тэдэнд боломжтой байгаа, тэдний анхаарал санваарын томилолт дээр болон ариун сүмийн ёслолууд дээр төвлөрдөг бол сайнсан гэж хэлжээ. Мөн эдгээр залуу эрэгтэйчүүдийн зарим нь ганц бие, зарим нь идэвхтэй, зарим нь идэвх султай, зарим нь сүмийн гишүүн биш эмэгтэйчүүдтэй гэр бүл болсныг тэр дурджээ.

Гадасны зөвлөлийн хурлаар хэлэлцээний дараа бишопууд цаг завьнхаа ихээхэн хэсгийг залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдэд зориулж, санваартан эрэгтэйчүүд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар дээрх эрэгтэйчүүд болон тэдний эхнэрүүдэд туслахаар шийдсэн ажээ. Авралын энэхүү ажилд оролцсон хүмүүс тэднийг санваар, мөнхийн гэрлэлт, ариун сүмийн авралын ёслолуудад бэлтгэхэд ихэвчлэн анхаарч байлаа. Миний оролцсон чуулганаар Мелкизедэкийн санваарт томилогдсон 63 эрэгтэй бараг бүгдээрээ дараагийн хоёр жил ариун сүмд хишгийг хүлээн авч, эхнэрүүд нь тэдэнтэй лацдан холбуулсан байлаа. Энэ явдал нь манай тойрог, гадсууд дахь авралын ажилд эгч нар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдгийн, ялангуяа гэр бүлд болон Сүмийн зөвлөлд илчлэлт хүлээн авахад хэрхэн тус дөхөм үзүүлдгийн тодорхой жишээ юм.¹⁷

Гэр бүл дэх эгч нарын үүрэг

Эмэгтэйчүүд болон гэр бүлийн эсрэг ямар их хүчээр дайрч давшилж байгааг бид мэддэг. Сүүлийн үеийн судалгаанууд гэрлэлтэндээ үнэнч байх нь багассаны хамт насанд хүрсэн хүмүүсийн гэрлэлтийн тоо буурсныг харуулсан байна.¹⁸ Зарим хүмүүсийн хувьд, гэрлэлт болон гэр бүл нь “нийгмийн үндсэн гол зохион байгуулалтын зарчим байхаасаа илүүгээр зүгээр л сонгож болох зүйлсийн нэг” болоод байна.¹⁹ Эмэгтэйчүүд олон сонголттой тулгарч байгаа бөгөөд хийсэн сонголтнууд нь гэр бүлд нь яаж нөлөөлж байна вэ гэдгийг залбирч, тунгаан бодох хэрэгтэй.

Өнгөрсөн жил Шинэ Зеландад байхдаа би эдгээр асуудлуудтэй тэмцэж, даван туулахыг хичээж буй гишүүн биш эмэгтэйчүүдийн тухай Аукландын сониноос уншиж билээ. Нэгэн ээж түүний хувьд, гэртээ байх уу эсвэл ажилд орох уу гэдэг сонголт нь түүнд зайлшгүй шаардлагатай биш шинэ хивс, хоёр дахь машин авах тухай асуудал байсан гэдгийг ойлгосноо ярьж билээ. Гэтэл өөр нэг эмэгтэй, “аз жаргалтай гэр бүлийн хамгийн том дайсан бол цалин авч байгаа ажил биш, харин зурагт” гэж боддог аж. Зурагт үзэхэд олон цаг зарцуулдаг гэр бүл маш бага цагийг бие биетэйгээ хамт өнгөрүүлдэг гэжээ.²⁰

Эдгээр нь зөвхөн хувь хүний шинжтэй, сэтгэл зүрхний шийдвэр юм. Гэвч бид хоёр зарчмыг үргэлж санаж явах ёстой. Нэгдүгээрт, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд гол хүч чармайлтаа зориулдаг эмэгтэй өөрийн хувь нэмрийг ач холбогдол багатай байна, эсвэл үүнийхээ төлөө уучлал гуйх хэрэгтэй хэмээн бодох ёсгүй ээ. Бидний Тэнгэр дэх Эцэгийн төлөвлөгөөнд эмэгтэйчүүдийн үүргээс илүү ач холбогдолтой зүйл байхгүй. Хоёрдугаарт, бид бүгдээрээ бусдыг шүүмжлэхээс, гэрээсээ гадуур ажиллах шийдвэр гаргасан эгч нарыг итгэл багатай гэж бодохоос болгоомжлох ёстой. Бид хүмүүсийн ахуй амьдралыг бүрэн ойлгож ухаарах нь ховор байдаг. Гаргасан шийдвэрүүдийнхээ төлөө Бурханы өмнө хариуцлага хүлээнэ гэдгээ ойлгосны үндсэн дээр эхнэр нөхрүүд хамт залбирч, зөвлөлдөх хэрэгтэй.

Ямар шалтгааны улмаас ганц бие болсон нь хамаагүй, ганц бие итгэлтэй эхчүүд ээ, бид та нарт хайртай бөгөөд талархдаг билээ. Та нарт бүхий л мөнхийн адислал

боломжтой байдаг гэдгийг бид баталж байна. “Олон гар та нарт туслахаар та нарын зүг сунгаастай байгаа. Бурхан та нарт хайхрамжгүй хандаагүй. Мөн Түүний Сүм ч бас адил” гэж бошиглогчид тод томруунаар мэдэгдсэн юм.²¹ Эцэг эхийн үүргээ биелүүлэх тохиромжтой уур амьсгалыг ажлын байрандаа бий болгоход Хожмын Үеийн Гэгээнтнүүд манлайлан тэргүүлэх болно гэдэгт би найдаж байна.

Бат бөх итгэлтэй ганц бие эгч нар аа, бид та нарт хайртай мөн та нарт чин сэтгэлээсээ талархалтай ханддаг гэдгийг санаарай. Үүрд мөнхийн олон адислал та нарт өгөгдөнө гэдгийг та нарт амлаж байна.

Гайхамшигтай анхдагч эмэгтэй Эмили Х.Вудмайнси, “Сионы эгч нартаа” гэдэг сүмийн дууллын үгсийг зохиосон юм. Тэрээр, “тэнгэр элчийн үүрэг эмэгтэйчүүдэд өгөгдсөн” гэж үнэн зөвөөр өгүүлсэн. Тэрхүү үүрэг нь “Тэнгэр дэх Эцэгийн зарлигласныг тэр дор нь, шуурхай биелүүлэх явдал бөгөөд ‘энэ нь эгч нарын авч болох... бэлэг’” хэмээн дүрсэлсэн ажээ.²²

Хайрт эгч нар аа, бид та нарт хайртай, та нараар бахархан биширдэг. Их Эзэний хаант улс дахь та бүхний үйлчлэлд бид баяр талархалтай байдаг. Та нар бол гайхамшигтай хүмүүс! Ялангуяа бүх таньдаг эмэгтэйчүүддээ чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Би Цагаатгалын үнэн бодит байдал, Аврагчийн бурханлиг байдал болон Түүний Сүмийн Сэргээлтийг гэрчилж байна. Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

Эшлэл

1. Валлас Стегнер, : *The Story of the Mormon Trail* (1971), 13.
2. Роберт Д.Путнам, Давид Э.Сампбелл нар, *American Grace: How Religion Divides and Unites Us*, Саямон, Шустер нар, х. 233.
3. *Гарын Авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), Хэсэг 1.3.1, Мосе 5:1,4 12, 27–г мөн үз.
4. Andrew D. Olsen, *The Price We Paid: The Extraordinary Story of the Willie and Martin Handcart Pioneers* (2006), 445
5. “Leaves from the Life of Elizabeth Horrocks Jackson Kingsford,” Utah State Historical Society, Manuscript A 719.¹ “Remembering the Rescue,” *Ensign*, 1997 оны 8-р сар, 38-ыг үз.
6. Цүнхний түүх, Шинэ жилийн өмнөх оройн Бүжиг, Мишшон Виехо Гадас, Лагуна Нигэл гадас, Сан Клемент Гадас, Ранчо Маргарита Гадас, бүгдээрээ Калифорнид байдаг, Лагуна Нигэл гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч Моника Седвик эгчийн и-мэйлээс товчлон авсан байна, Мишен Виехо Гадасны Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхийлөгч Лэсли Мортэнсэний ярианаас товчлон авсан,
7. “Бид яагаад тэднийг тэгж хувцаслахыг зөвшөөрдөг вэ?” гэсэн өгүүлэлд *The Wall Street Journal*, 2011 оны 3-р сарын 19-20, С3, энэрэнгүй Еврей ээж Мормон эмэгтэйн хувцаслалтын жишиг болон ёс суртахууныг олж харсан ажээ.

8. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”. *Лиэхона, 2010 оны 11-р сар, 129.*

9. Putnam and Campbell, *American Grace*, 244-245-ыг үз.

10. Putnam and Campbell, *American Grace*, 504.

11. Сургаал ба Гэрээ 81:5, мөн Мозая 4:26-г үз.

12. Сургаал ба Гэрээ 138:56.

13. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь*, 2010, 22-р хуудас

|v13

14. Мөн *Гарын авлага 2*, 6-р бүлэг “Халамжийн зарчмууд ба удирдлага”-ыг үз.

15. Мөн *Гарын авлага 2*, 5-р бүлэг, “Тойрог болон гадсан дахь авралын ажил”-ыг үз

16. Эмили Матчер, “Why I Can’t Stop Reading Mormon Housewife Blogs,” salon.com/life/feature/2011/01/15/ Энэ феминист болоод шашингүй үзэлтэн Mormon housewife blogs-уудыг унших туйлын дуртай бөгөөд хүндэлдэг гэдгээ хүлээн зөвшөөрчээ.

17. Тонгагийн Ха’акамэ Гадас. Гадасны ерөнхийлөгч Лихонита Матеаки, (хожим нь Папуа Шинэ Гвинейн Порт Морсбай Номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн); Гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Лиената Ва’инуки нартай ярилцсан ярианаас.

18. “Д’ Вера Кон, Ричард Фрай нар, Women, Men, and the New Economics of Marriage,”¹ and Demographic Trends, pewsocialtrends.org. Олон оронд шинээр төрсөн хүүхдийн тоо тодорхой хэмжээгээр буурсныг хүн амзүйн өвөл хэмээн нэрлэсэн аж.

19. “A Troubling Marriage Trend,” *Deseret News*, 2010 оны 11-р сарын 22, Хуудас A14, msnbc.com-ын илтгэлд эш татжээ.

20. Симон Коллинз, “Put Family before Money-making Is Message from Festival,” *New Zealand Herald*, 2010 оны 2-р сарын 1, A2.

21. Гордон Б. Хинкли, “Women of the Church,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 69; мөн Спенсер В.Кимбалл, “Our Sisters in the Church,” *Ensign*, 1979 оны 11-р сар, 48–49-ийг үз.

22. “As Sisters in Zion,” *Hymns*, no. 309.

23. Карен Линн Давидсон, *Our Latter-day Hymns: The Stories and The Messages*, (2009), 338–339.

Бямба гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Сайныг үйлдэх боломжууд

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг

Материаллаг хэрэгцээтэй хүмүүст туслах Их Эзэний арга зам нь хайрын үндсэн дээр бие сэтгэлээ болон байгаа бүхнээ Бурханд болоод Түүний үйлсэд зориулахыг хүмүүсээс шаарддаг.

Хайрт ах эгч нар минь, дэлхий дээрх Өөрийн хүүхдүүдийн дунд байгаа ядуу болон тусламж хэрэгтэй хүмүүст үйлчлэхийн тулд бидний Их Эзэн юу хийснийг мөн юу хийсээр байгааг хүндэтгэн тэмдэглэх нь миний хэлэх үгийн гол зорилго билээ. Тэр тусламж хэрэгтэй хүмүүст болон бусдад туслахыг хүсдэг хүүхдүүддээ хайртай. Тусламж хэрэгтэй хүмүүс болон тэдэнд туслах хүсэлтэй хүмүүс аль алиныг нь адислах арга замуудыг Тэрбээр бий болгосон юм.

Идэх хоол, өмсөх хувцас, бие даан амьдрах чадвартай байхаас ирдэг сэтгэл ханамжийг гуйдаг, дэлхий даяарх хүүхдүүдийнхээ залбирлыг Тэнгэрлэг Эцэг сонсдог. Тэрбээр эрэгтэй эмэгтэй хүмүүсийг дэлхий дээр байрлуулснаас эхлэн тийм гуйлтуудыг сонссоор ирсэн юм.

Та нар амьдарч байгаа газраасаа болон дэлхий даяар тэрхүү хэрэгцээний тухай сонсож мэддэг. Та нарын зүрх өрөвдөх сэтгэлээр олонтаа дүүрдэг билээ. Ажил олохоор хичээж байгаа нэгэнтэй уулзаад, бэлэвсэн нэгний гэрт ороод хоолгүй байхыг нь хараад, байгалийн гамшигаас болж утсан гэрийнхээ үлдэгдэл дээр суугаад уйлж байгаа хүүхдүүдийн зургийг хараад та нарт туслах хүсэл төрдөг.

Их Эзэн тэдний гуйлтыг сонсож мөн тэдний төлөөх та нарын энэрэнгүй сэтгэлийг мэдэрдэг учраас, Тэрбээр цаг хугацааны эхлэлээс дагалдагч нартаа туслах арга замуудыг бэлдэж өгсөн юм. Тэрбээр Өөрийн хүүхдүүдийг цаг зав, эд зүйлээ болон өөрсдийгөө бусдад үйлчлэхэд зориулахад, Өөртэйгөө нэгдэхийг урьдаг.

Түүний туслах арга замыг нэг үе “Өргөлийн хууль,” дараа нь “Нэгдсэн журам” гэж нэрлэж байлаа. Бид өнөө үед “Сүмийн халамжийн хөтөлбөр” гэж нэрлэдэг.

Уг хөтөлбөрийн нэр болон хэвшин тогтсон үйл ажиллагаа нь хүмүүсийн хэрэгцээ, нөхцөл байдалд зохицон өөрчлөгдсөөр ирлээ. Гэхдээ материаллаг хэрэгцээтэй хүмүүст туслах Их Эзэний арга зам нь хайрын үндсэн дээр бие сэтгэлээ болон байгаа бүхнээ Бурханд, Түүний үйлсэд зориулахыг хүмүүсээс шаарддаг.

Тусламж хэрэгтэй хүмүүсийг өргөж дэмжих үйлсдээ оролцохыг Тэрээр бидэнд зарлиг болгосны хамт урьсан юм. Бид үүнийг хийнэ хэмээн баптисмын усанд болон Бурханы ариун сүмүүдэд гэрээ хийдэг билээ. Хүндэтгэлийн өдөр, ариун ёслолоос хүртэх үедээ бид гэрээгээ шинэчилдэг.

Тусламж хэрэгтэй хүмүүст туслахад, Түүний бий болгож өгсөн боломжуудын заримынх нь тухай ярих нь миний өнөөдрийн зорилго юм. Энд бүх боломжуудын талаар ярьж амжихгүй ч та нарын хичээх хүсэл шинэчлэгдэж, бэхжинэ гэдэгт би найдаж байна.

Энэхүү үйлсэд Их Эзэний биднийг урьсан талаар миний жаахан хөвгүүн байхаасаа хойш дуулсан, нэг дуулал байдаг. Би хүүхэд байхдаа энэ дууны хүчирхэг үгсээс илүү яруу сайхан аянд нь их анхаарал тавьдаг байжээ. Өнөөдөр энэ дууллын үгс та нарын зүрх сэтгэлд хүрэхийн төлөө би залбирч байна. Энэ дууны үгийг дахиад сонсоцгооё:

Би өнөөдөр дэлхий дээр ямар нэгэн сайныг үйлдсэн үү?

Би хэрэгцээтэй нэгэнд тусалсан уу?

Би гунигтайг баярлуулж мөн хэн нэгнийг хөгжөөсөн үү?

Би, хэрэв тэгээгүй бол, үнэхээр чадаагүй гэсэн үг.

Би хуваалцахад бэлэн байснаас

Өнөөдөр хэн нэгний ачаа хөнгөрсөн үү?

Өвчтэй, сульдсан нэгэнд тусалсан уу?

Миний тусламж хэрэгтэй болоход би тэнд байсан уу?

Тэгвэл, сэрээд мөн илүү ихийг хий,

Тэнгэр дэх орд харшаа зүүдлэхээс өөрийг хий.

Сайныг үйлдэх нь таашаал, хэмжээлшгүй баясал,

Хайр болон хариуцлагын адислал ¹.

Их Эзэн бидэнд сэрэмжлүүлгийг үргэлж илгээж байдаг. Заримдаа, гачигдалтай нэгний төлөө өрөвдөх сэтгэлийг гэнэт мэдэрч болно. Эцэг хүн үүнийг, нэгэн хүүхэд унаад, өвдгөө шалбалахыг хараад мэдэрч болно. Эх хүн үүнийг, шөнө дунд хүүхдийнхээ цочин уйлахыг сонсоод мэдэрч болно. Охид, хөвгүүд сургууль дээрээ гунигтай эсвэл айсан нэгнийг хараад өрөвдөх сэтгэлийг мэдэрч болно.

Бид нар бүгдээрээ, таньж мэдэхгүй бусдын төлөө хүртэл өрөвдөх сэтгэлийг мэдэрч байсан. Жишээлбэл, Японд болсон газар хөдлөлтөөс үүдэлтэй Номхон Далай дахь цунамийн тухай мэдээг сонсох үедээ, гэмтэж болох тэдний төлөө та нар санаа зовж байсан.

Австрали улсын Квинсландад болсон үерийн талаар олж мэдээд та нар мянга мянгаараа өрөвдөн энэрсэн. Мэдээгээр ихэнхдээ тусламж хэрэгтэй хүмүүсийн тоог мэдээлж байлаа. Гэхдээ та нарын олон нь тэр хүмүүст учирсан гай зовлонг мэдэрч байсан. Австрали дахь Сүмийн 1500 гаруй гишүүд дуудлагад хариулан, сайн дураараа туслан, тайтгаруулахаар ирсэн.

Тэд өрөвдөх сэтгэлээ, гэрээнийхээ дагуу үйл ажиллагаа болгохоор шийдсэн юм. Тусламжийг хүлээн авч байгаа гачигдалт нэгэнд болон тусламж үзүүлэх боломжийг ашиглаж байгаа хүнд аль алинд нь адислал ирэхийг би харсан.

Ухаалаг эцэг эхчүүд бусдад тусалснаар адислал авах боломжийг үр хүүхдүүдээ олгодог. Саяхан гурван хүүхэд амттай хоол хийсэн сав барин манай хаалгыг тогшсон билээ. Эцэг эх нь бидэнд тусламж хэрэгтэй байгааг мэдсэнээс мөн бидэнд үйлчлэх боломжийг хүүхдүүдээ олгосон байна.

Эцэг эх нь манай гэр бүлийг өгөөмөр үйлчлэлээрээ адисалсан юм. Туслахдаа хүүхдүүдээ оролцуулахыг сонгосноор, тэд ач зээ нараа адисалсан юм. Манайхаас явахдаа тэр хүүхдүүд инээмсэглэж байсан нь энэ уламжлал давтагдах юм байна гэж надад бодогдсон. Их Эзэний найрсаг үйлчлэлийг үзүүлснээр мэдэрсэн баяр баяслынхаа талаар тэд хүүхдүүддээ хэлэх болно. Би бага байхдаа аавынхаа хүссэнээр хөршийнхөө ногооны талбайн зэрлэгийг зулгааж өгч байхдаа сэтгэл ихэд ханамжтай байснаа санаж байна. Туслах боломж гарах болгонд би “Үйлс нь сайхан билээ, миний Бурхан, миний Хаан”² гэсэн дууллын үгсийг санадаг мөн түүнд итгэдэг.

Хүндэтгэлийн өдөр Их Эзэнийг шүтэн биширснээс ирэх баяр баяслыг энэ дууны үгс яруу сайхан дүрсэлдгийг би мэднэ. Гэхдээ нэгэн ажлын өдрийн орой эдгээр хүүхдүүд бидэнд хоол авчирч, Их Эзэний ажлыг хийсэндээ баяр баяслыг мэдэрч байсан. Мөн тэдний эцэг эх нь сайныг үйлдэх, мөн үр удам нь энэхүү баяр баяслыг эдлэх боломжийг олж харсан байна.

Тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах Их Эзэний арга зам нь эцэг эхчүүдэд хүүхдүүдээ адислах өөр нэгэн боломжийг олгодог. Би нэгэн бүтэн сайнд үүнийг цуглааны байранд харсан юм. Нэг бяцхан хүүхэд ариун ёслолын цуглааны өмнө сүмд ирээд бишопдоо гэр бүлийнхээ өргөлийн дугтуйг өглөө.

Би тэр гэр бүл болон тэдний хөвгүүнийг таньдаг юм. Тэднийх, тусламж хэрэгтэй байгаа тойргийнхоо нэг хүний талаар олж мэджээ. Аав нь, жирийн үед өгдгөөсөө илүү мацгийн өргөлийг хийсэн дугтуйг хүүдээ өгөөд;

“Бид өнөөдөр тусламж хэрэгтэй хүмүүсийн төлөө мацаг барьж, залбирсан. Энэ дугтуйг бишопт өгөөрэй. Тэр үүнийг биднээс илүү тусламж хэрэгтэй байгаа хүмүүст туслахаар өгнө” гэж хэлсэн байх.

Хөвгүүн тэр ням гараг өлссөнөө биш харин сайхнаар дурсан санах болно. Тэр инээмсэглэн дугтуйгаа чангаар атгасныг нь хараад би, гэр бүлийнхээ өргөлийг ядуучуудад зориулан өгч байгаа аавынхаа өөрт нь итгэж найддагийг тэр хөвгүүн мэдэрснийг би харсан. Тэр энэ явдлыг дикон болсон хойноо, бүр магадгүй үүрд санах болно.

Олон жилийн өмнө би Айдаход, Их Эзэний төлөө хүмүүст тусалсан хүмүүсийн яг тийм баяр хөөрийг бас харсан билээ. 1976 оны 6 сарын 5-нд Тетон далан эвдэрч, 11 хүн нас барсан юм. Олон мянган хүн хэдхэн цагийн дотор гэр орноо орхин явах ёстой болж зарим хүмүүсийн гэр нь үерт урсан эвдэрч сүйрсэн. Олон зуун байшин эздүүд нь төлж дийлэхгүй их мөнгөөр засвар хийх шаардлагтай болсон билээ.

Энэхүү эмгэнэлт явдлын талаар сонссон хүмүүс өрөвдөж, сайныг үйлдэх хүслийг мэдэрсэн юм. Хөршүүд, бишопууд, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчид, чуулгын удирдагчид, гэрийн болон айлчлагч багш нар гэр орон, ажил төрлөө орхин, үерт автсан бусдын гэр орныг цэвэрлэж байлаа.

Нэгэн гэр бүлийн хос амралтанд явчихаад, үерийн дараахан Рэксбургт буцаж ирсэн. Тэд байшингаа очиж харахаар яваагүй. Оронд нь, тэд хаана очиж тусалж болохыг мэдэхээр бишоптойгоо очиж уулзсан аж. Бишоп нь тэднийг тусламж хэрэгтэй байгаа нэг айл уруу явуулжээ.

Хэд хоногийн дараа тэд байшингаа үзэхээр явсан гэнэ. Гэр нь үерт урсан оргүй болсон байлаа. Тэд бишоп дээрээ буцаж очоод, “биднээр туслуулах ажил байна уу?” гэж асуужээ.

Та хаана ч амьдардаг байлаа гэсэн, хүмүүсийн өрөвдөх сэтгэл нь амин хувиа үл хичээх үйлс болон хувирахын гайхамшгийг харсан байх. Энэ нь байгалийн гамшиг тохиохоос өөр үед ч илэрч болно. Өөрсдийгөө болон гэр бүлээ тэтгэхээр ажил хайж буй ах эгчийн хэрэгцээг санваарын чуулгад нэгэн ах тайлбарлах үед би үүнийг харсан. Тэнд байсан хүмүүс өрөвч нинжин сэтгэлээр амьсгалж байсныг би мэдэрсэн, зарим нь ажил хэрэгтэй байгаа тэр хүнийг ажилд авах боломжтой хүмүүсийн нэрийг санал болгож байлаа.

Тэрхүү санваарын чуулгад, мөн Айдахо мужийн үерт автагдсан айлуудад тохиолдсон явдлууд нь, тусламж ихээхэн хэрэгтэй байгаа хүмүүст, дахин бие даахад нь туслах Их Эзэний арга зам юм. Бид өрөвч энэрэнгүй байж, Их Эзэний замаар хэрхэн туслахыг мэддэг.

Бид энэ жил Сүмийн халамжийн хөтөлбөрийн 75 жилийн ойг тэмдэглэж байна. “Эдийн засгийн их уналт” хэмээн нэрлэгддэг тэр үед ажил амьдрал, гэр орноо алдсан хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд уг хөтөлбөрийг анх санаачилсан.

Энэ үед, Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд юм юмаар дутагдан гачигдаж байлаа. Ийм үе өмнө нь ч тохиолдож байсан, хойшид ч тохиох болно. Сүмийн Халамжийн хөтөлбөрийн үндсэн зарчмууд нь аль нэг цаг үед, аль нэг газарт зориулсан төдий биш. Халамжийн хөтөлбөр бүх цаг үед, бүх газарт зориулагдсан юм.

Тэдгээр зарчмууд сүнслэг, үүрд мөнхийн мөн чанартай. Тийм учраас, эдгээр зарчмуудыг ойлгож, зүрх сэтгэлдээ шингээснээр, Их Эзэн биднийг хаана, хэзээ урина, тэнд бид туслах боломжуудыг олж харан ашиглаж чаддаг болно.

Би өөрөө Их Эзэний арга замаар туслахыг хүссэн үед мөн надад бусад хүмүүс туслах үед намайг дараах зарчмууд удирддаг.

Нэгдүгээрт, хүмүүс өөрсдийгөө болон гэр бүлээ тэтгэж чадаж байгаа үед мөн тэгээд бусдад туслах үед хүн бүр илүү баяр хөөртэй болж, өөрөөрөө бахархдаг. Миний хэрэгцээг хангаж өгөхөөр тусалсан хүмүүст би талархдаг. Мөн он жилүүд өнгөрөх тусам, намайг бие даах чадвартай болоход, өөртөө илүү байгаа зүйлийг бусдад туслахын тулд яаж ашиглахыг зааж өгсөн хүмүүст би хамгийн ихээр талархдаг.

Олж байгаагаасаа багыг зарцуулснаар илүү нөөцтэй байдаг юм байна гэдгийг би мэдсэн. Бусдаас авахын оронд, өөртөө илүү байгаа зүйлийг бусдад өгөх нь үнэхээр чухал юм байна гэдгийг би өөрийнхөө туршлагаар баталж чадсан. Учир нь гэвэл, бид Их Эзэний арга замаар бусдад тусалсан үед, Тэр биднийг адисалдаг.

Халамжийн ажлын талаар Ерөнхийлөгч Марион Г.Ромни, “Та нар өөрсдөө ядуу болтлоо бусдад өгнө гэж хэзээ ч байхгүй” гэж хэлсэн. Тэгээд тэрээр өөрийнх нь номлолын ерөнхийлөгч байсан Мелвин Ж. Баллардын үгсээс эш татан, “Хүмүүн нь, Их Эзэнд талхны зах өгөөд оронд нь бүтэн талх хүлээн авахгүй байна гэж байхгүй”³ гэжээ.

Би үүнийг үнэн болохыг харсан. Тэнгэрлэг Эцэгийн тусламж хэрэгтэй байгаа хүүхдүүдэд би өгөөмрөөр хандвал, Тэр надад өгөөмрөөр ханддаг.

Халамжийн ажилд намайг удирддаг байсан сайн мэдээний хоёр дахь зарчим нь, эв нэгдлийн адислал болон хүч юм. Ерөнхийлөгч Ж.Рюбен Кларк ийн хэлжээ:

“Халамжийн ногооны талбайд эсвэл өөр төсөл дээр мөр зэрэгцэн ажилласан янз бүрийн мэргэжилтэй эрчүүд, ахан дүүсийн барилдлагыг бусдад тусалснаар мэдэрдэг”⁴.

Өгч байгаа болон авч байгаа хүний хувьд ахан дүүсийн барилдлага зузаардаг нь үнэн юм. Рексбург дэх үерт автсан байшинд надтай мөр зэрэгцэн шавар хүрээдсэн нэгэн ахтай би өнөөг хүртэл ойр дотно байдаг. Тэр өөрийнхөө төлөө, гэр бүлийнхээ төлөө чадах бүхнээ хийсэн болохоор сэтгэл хангалуун байдаг. Хэрвээ бид тусдаа, ганц ганцаараа ажилласан бол хоёулаа сүнсний адислалыг авч чадахгүй байсан.

Энэ нь халамжийн ажлын гурав дахь зарчим уруу намайг хөтөлж байна: Гэр бүлтэйгээ хамт ажилла, тэгснээр гэр бүлийн гишүүд чинь бусдыг халамжилдаг шиг бие биеэ халамжилж сурна. Тусламж хэрэгтэй хүмүүст үйлчлэхээр та нартай мөр зэрэгцэн ажиллаж байгаа охид хөвгүүд чинь шаардлага гарсан үед өөрсдөө бие биедээ илүү ихээр туслах болно.

Сүмийн халамжийн дөрөв дэх чухал зарчимд би бишоп байхдаа суралцсан билээ. Ядуусыг эрж олох ёстой гэсэн судар дахь зарлигаас энэ нь ирсэн юм. Гэр бүлүүдийнхээ хамт чадах бүхнээ хийсний дараа тусламж хэрэгтэй хүмүүсийг олж, тусламж үзүүлэх нь бишопын үүрэг юм. Үнэнийг олохтой адил, ядуучуудыг халамжлахад ч гэсэн “эрэлхийл, тэгвэл та нар олох”⁵ боломжтой болгохын тулд Их Эзэн, Ариун Сүнснийг илгээдгийг би олж мэдсэн билээ. Мөн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг энэхүү эрэлдээ оролцуулах хэрэгтэй бөгөөд тэрээр танаас өмнө илчлэлт хүлээн авах боломжтой гэдгийг би ойлгосон.

Ирэх саруудад, та нарын заримд нь тэрхүү удирдамж хэрэг болж магад. Сүмийн Халамжийн Хөтөлбөрийн 75 жилийн ойг тэмдэглэхээр, дэлхий даяарх Сүмийн гишүүдийг “Үйлчлэлийн өдөр”-т оролцохыг урих болно. Удирдагчид болон гишүүд төлөвлөгөөгөө гаргахдаа удирдамж эрэлхийлэх болно.

Үйлчлэх төлөвлөгөө гаргах талаар би та нарт гурван санал хэлье.

Нэгдүгээрт, өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэ. Аврагчийн Цагаатгалаар та нарын зүрх сэтгэл уярсан үед хаант улс болон нийгэмд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн амьдралыг сүнсний болон материаллаг хэрэгцээгээр нь адислах төлөвлөгөөнийхөө зорилгыг тод томруунаар харж чадна.

Миний хоёр дахь санал бол зүрх сэтгэлд нь нөлөөлөх үйлчлэл хэрэгтэй хүмүүсийг, үйлчлэлийнхээ хүлээн авагчаар сонгоорой. Тэдний үйлчлэх хүмүүс хайрыг нь мэдрэх болно. Дуунд амласнаар, тэдний мэдрэх хайр нь, зөвхөн материаллаг хэрэгцээг нь хангаж өгснөөс илүүгээр тэднийг ихээр баярлуулах болно.

Миний хамгийн сүүлийн санал бол гэр бүл, чуулгууд, туслах байгууллагууд болон нийгэм, хамт олны доторх таньдаг хүмүүсийнхээ эв нэгдлийн хүчийг ашиглахаар төлөвлөөрэй. Эв нэгдлийн мэдрэмж та нарын өгөх үйлчлэлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх болно. Мөн төсөл дууссаны дараа ч гэр бүл, Сүм, нийгэм дэх эв нэгдэл өсөн бэхжиж, үүрдийн өвийг үлдээх болно.

Та бүхэнд хэрхэн талархаж явдгаа хэлэх боломж надад тохиож байна. Дэлхий даяарх хүмүүстэй уулзах үед Их Эзэний төлөө та нарын өгсөн халамжийн үйлчлэлийн төлөөх талархлыг би хүлээн авдаг.

Их Эзэний арга замаар туслахдаа та нар хүмүүсийн санаа сэтгэлийг өргөх арга замыг олсон байгаа. Та нар болон та нарын адил Аврагчийн даруухан дагалдагчид, үйлчлэхдээ зүсэм талхыг усанд хаяхад, та нарын тусалсан хүмүүс хариуд нь талархлын бүтэн талхыг надад өгөхийг хичээдэг.

Та нартай хамт ажилладаг хүмүүс ч талархлыг мөн надад илэрхийлдэг билээ. Би нэг удаа Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсонтой хамт зогсож байснаа санаж байна. Бид Их Эзэний Сүмд үйлчлэх талаар ярилцсан юм. Тэрээр, “Би энэ ажилд хайртай, энэ бол үнэхээр чухал ажил” гэж залуу хүний эрч хүчээр, гараа атган хэлэхэд надад үнэнхүү бахархал төрж билээ

Эзэний өмнөөс, Тэнгэрлэг Эцэгийнхээ хүүхдүүдэд үйлчлэхээр хийдэг ажил үйлсийн тань төлөө талархал илэрхийлье. Тэр та нарыг мэддэг, та нарын хичээл зүтгэл, гаршуу хөдөлмөр болон золиослолыг харж байдаг. Их Эзэний төлөө та нарын тусалсан хүмүүсийн аз жаргалаас, хөдөлмөрийнхөө үр шимийг харахад тань Их Эзэн та нарыг адислах болтугай хэмээн би залбирч байна.

Бурхан Эцэг амьд бөгөөд бидний залбирлыг сонсдогийг, Есүс бол Христ гэдгийг би мэднэ. Түүнд үйлчилж, зарлигуудыг нь дагаснаар та нар болон та нарын үйлчилдэг хүмүүс ариусч, хүч чадал чинь өсөн нэмэгдэх болно. Миний мэддэгийн адилаар та нар ч бас, Ариун Сүнсний хүчээр Иосеф Смит бол үнэн бөгөөд амьд энэ Сүмийг сэргээсэн Бурханы бошиглогч гэдгийг мэдэж чадна. Ерөнхийлөгч Томас С.Монсон бол Бурханы амьд бошиглогч гэдгийг би гэрчилж байна. Тэр бол Их Эзэн ямархуу хүн байсны, эсвээс Тэрбээр сайныг үйлдэж явсны агуу үлгэр жишээ мөн. Бид “доош унжсан гарнуудыг өргөж, сул дорой өвдөгнүүдийг хүчирхэг болгоход”⁶ бүх боломжоо дайчлан ажиллахын төлөө би залбирч байна. Есүс Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

Эшлэл

1. “Have I Done Any Good?,” *Hymns*, 223.

2. “Sweet Is the Work,” *Hymns*, 147-г үз.

3. Марион Г.Ромни, “Welfare Services: The Savior’s Program,” *Ensign*, 1980 оны 11-р сар, 93..

4. Бага Ж.Рюбен Кларк, Conference Report, 1943 оны 10-р сар, 13.

5. Матай 7:7–8; Лук 11:9–10; 3 Нифай 14:7–8-ыг үз.

6. Сургаал ба Гэрээ 81:5.

Бямба гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Ариун Сүнсээр удирдагдахуй

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ерөнхийлөгч Бойд К.Пакер

Бид бүгд илчлэлтийн сүнс болон Ариун Сүнсний бэлгээр удирдагдаж чадна.

Агуу баатар хэмээн миний дээдлэн хүндэлдэг Виллям Тиндейлийн асар их хичээл зүтгэл гарган орчуулсан Библийн Хаан Жеймсийн хувилбар хэвлэгдэн гарснаас хойш эдүгээ 400 жил улиран оджээ.

Сайхь үйлчлэгч Библийг жирийн англи хэлээр нийтлэхийг хүсээгүй ажээ. Эрх баригчид Тиндейлийг хавчин дарлаж, нэг газраас нөгөөд хөөн цөлдөг байв. Тэрбээр тэдэнд “Хэрэв Бурхан миний амийг авардаг юм бол би анжисаар газар хагалж яваа хөвгүүнийг та нараас илүү Судрыг мэддэг болгоно доо”¹ гэж хэлсэн гэдэг.

Тиндейл мэхлэгдэж, Брюссельд жил гаруй харанхуй, хүйтэн гянданд хоригджээ. Хувцас нь ноорч, салбайн урагдсан байлаа. Тэр харгалзагчаасаа миний хүрэм, малгай бас лаа өгнө үү гэж гуйгаад: “Харанхуйд ганцаараа сууна гэдэг ч үнэхээр залхмаар юм байна шүү”² гэжээ. Гэтэл гуйсан юмсыг нь өгөхөөс татгалзсан гэдэг. Эцэстээ түүнийг гяндангаас авчран, цугласан олны өмнө шонгийн модонд хүлэн шатаажээ. Гэвч Виллям Тиндейлийн хүч хөдөлмөр, итгэл бишрэлээсээ болж амиа алдсан нь талаар болоогүй.

Хожмын Үеийн Гэгээнтэн хүүхдүүдэд судруудыг багаас нь заадаг учраас тэд дөрвөн зууны тэртээх Виллям Тиндейлийн бошиглолыг зарим талаар биелүүлж байгаа хэрэг юм.

|v5

Библи, Есүс Христийн бас нэгэн гэрээ болох Мормоны Ном, Агуу Үнэт Сувд, Сургаал ба Гэрээ бол бидний өнөө үеийн судрууд.

Мормоны Номын улмаас манай Сүмийг Мормоны Сүм гэж нэрлэх нь олонтаа тохиолддог. Энэ нэрэнд бид дургүйцдэггүй ч энэ нь оновчтой нэр биш юм.

Мормоны Номонд нифайчууд Эцэгт хандан нэрээр нь залбирсан учир Их Эзэн тэдэн дээр эргэн очсон. Тэр үед Их Эзэн:

“Та нарт намайг юу өгөөсэй хэмээн та нар хүснэв?” гэж асуужээ.

“Мөн тэд Түүнд хэлэв: Их Эзэн, энэ сүмийг ямар нэрээр нэрлэхийг бидэнд хэлээсэй хэмээн бид танаас хүсч байна; учир нь энэ хэргийн талаар хүмүүсийн дунд арцалдаан байна.

“Мөн Их Эзэн тэдэнд хэлэв . . . , хүмүүс яагаад энэ хэргийн учир бувтналдан мөн арцалдах болов?

Миний нэр болох Христийн нэрийг та нар өөрсдийн дээр авах ёстой хэмээсэн судруудыг тэд уншаагүй гэж үү? . . . Учир нь энэ нэрээр та нар эцсийн өдөр дуудагдах болно. . . .

Тиймийн тул та нар юуг ч үйлдсэн, үүнийгээ миний нэрээр үйлдэх болно; тиймийн тул та нар сүмийг миний нэрээр нэрлэх болно; мөн тэрбээр миний тусын тулд сүмийг адислахын тулд та нар миний нэрээр Эцэгт хандах болно.

Мөн энэ нь миний нэрээр нэрлэгдэхгүй аваас яахан миний сүм байх билээ? Учир нь хэрэв сүм Мосегийн нэрээр нэрлэгдсэн байвал энэ нь Мосегийн сүм; эсвэл хэрэв энэ нь хүмүүний нэрээр нэрлэгдсэн байвал уг сүм нь хүмүүний сүм байна; харин энэ нь миний нэрээр нэрлэгдвэл, хэрэв тэд миний сайн мэдээн дээр тулгуурлах аваас, тэгвэл энэ нь миний сүм мөн.”³

Бид дээрх илчлэлтэнд дуулгавартай байдаг учраас өөрсдийгөө Мормоны Сүм гэдэггүй харин Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэдэг. Бусад хүмүүс манай

Сүмийг Мормоны Сүм эсвэл биднийг мормончууд гэх нь тэдний хэрэг, харин бидний хувьд бол энэ нь огт өөр юм.

“Илчлэгдсэн нэр буюу Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэдэг нэрийг хэрэглэх нь Аврагчийн нэрийг бүх дэлхий даяар тунхаглах бидний үүрэг хариуцлагад нэн чухал. Тиймээс бид Сүмийн тухай ярихдаа боломжтой л бол бүтэн нэрийг нь хэлж байхыг хүсч байна. . . . Сүмийн гишүүдийг нэрлэхдээ ‘Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд’ гэж байхыг зөвлөж байна.’ Харин товчилсон нэрээр, ‘Хожмын Үеийн Гэгээнтнүүд’⁴ гэх нь зүйтэйг Тэргүүн Зөвлөл мэдэгдсэн билээ.

“[Хожмын Үеийн Гэгээнтнүүд] бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглолуудынхаа дагуу бичдэг болой.”⁵

Дэлхий биднийг юу гэх нь тэдний хэрэг харин бид үг яриандаа өөрсдийгөө *Есүс Христийн* Сүмд харьяалагддаг гэдгээ үргэлж санаж явах ёстой.

Зарим хүмүүс биднийг Христэд итгэгчид биш гэдэг. Тэд нэг бол биднийг огт мэдэхгүй байгаа хэрэг эсвэл биднийг буруу ойлгож байгаа хэрэг.

Сүмд ёслол бүрийг Есүс Христийн эрх мэдэл болон нэрээр гүйцэтгэдэг.⁶ Төлөөлөгчид, бошиглогчидтой байсан анхны Сүмийн зохион байгуулалт өнөө үед бидэнд байдаг.⁷

Эрт үед Их Эзэн Арванхоёр төлөөлөгчийг сонгон дуудсан. Түүнээс хүмүүс урван тэрсэлж, улмаар Тэрбээр цовдлогдсон билээ. Аврагч Амилалтынхаа дараа шавь нартаа 40 өдрийн турш номлож, тэгээд тэнгэр өөдөө одсон.⁸

Гэвч төлөөлөгчдөд нэг зүйл дутагдаж байлаа. Хэд хоногийн дараа Арванхоёр нэг байшинд цуглаад байтал “гэнэт тэнгэрээс хүчит хуй салхи мэт дуу чимээ гаран, тэдний сууцгааж байсан байр бүхэлдээ тэрхүү дуунд автагджээ. . . . Тэгтэл гал хаялах мэт . . . хэлүүд,

тэдний хүн нэг бүрийн дээр тогтлоо. Ийнхүү тэд . . . Ариун Сүнсээр дүүрчээ.”⁹ Түүний Төлөөлөгчид ийнхүү тэнгэрийн хүч буюу эрх мэдэлтэй болсон юм. Түүний Сүмийг үндэслэн байгуулахад шаардлагатай эрх мэдэл нь Аврагчаар болон Ариун Сүнсний бэлгээр өгөгдсөнийг тэд ойлгож байлаа. Баптисм хүртээж, Ариун Сүнсний бэлэг олгохыг тэдэнд зарлиглажээ.¹⁰

Эцэстээ Төлөөлөгчид болон тэдний санваар авагдсан. Тэргүүлэх эрх мэдэл болон хүчийг сэргээх шаардлагатай байлаа. Хүмүүс тэрхүү эрх мэдлийг сэргэж, Их Эзэний Сүм байгуулагдахыг олон зууны туршид хүсэн хүлээсэн юм.

1829 онд Иохан Баптист, Төлөөлөгч Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит болон Оливер Каудери хоёрт санваарыг сэргээн олгосон билээ. Эдүгээ Сүмийн зохистой, эрэгтэй гишүүд санваарт томилогдож байна. Баптисмын дараа Сүмийн бүх гишүүдэд олгодог энэхүү эрх мэдэл болон Ариун Сүнсний бэлэг нь бидний бусад сүмүүдээс ялгарах онцлог болдог.

“Хүн болгон Их Эзэн Бурханы, бүр дэлхийн Аврагчийн нэрээр ярьж болохыг”¹¹ эртний нэгэн илчлэлт чиглүүлдэг. Өнөөдөр тэргүүлэх, заах, удирдан зохион байгуулахаар дуудагдсан жирийн эрэгтэй, эмэгтэйчүүд Сүмийн ажлыг гүйцэтгэж байна. Дуудагдсан хүмүүс Их Эзэний хүслийг мэдэхийн тулд илчлэлтийн хүч болон Ариун Сүнсний бэлгээр удирдагддаг. Бусад хүмүүс бошиглол, илчлэлт, Ариун Сүнсний бэлгийг хүлээн зөвшөөрөхгүй байж болох юм. Гэвч тэд биднийг ойлгох болно, бид дээрх зүйлсийг хүлээн зөвшөөрдгийг тэд ойлгох ёстой.

Эрүүл мэндийн хууль буюу Мэргэн Ухааны Үгийг хортой бодисуудын аюул дэлхийд нүүрлэхээс бүр өмнө Их Эзэн Иосеф Смитэд илчилсэн. Манай залуусын өмнө хаана л бол хаана үргэлж байдаг цай, кофе, хар тамхи, тамхи мөн төрөл бүрийн мансууруулах болон донтуулагч бодисуудаас татгалзахыг бид заадаг. Энэхүү илчлэлтэнд дуулгавартай байдаг хүмүүс эрүүл мэндийг хүлээн авч, “эрүүл энхийг хийгээд яснууддаа чөмөг хүлээн авах болно”¹² хэмээн амлагдсан юм.

Мөн мэргэн ухаан хийгээд мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг;

Мөн гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй байх болно.”¹²

Амьдралыг бүтээгч ариун нандин хүчийг зөвхөн эхнэр, нөхөр болсон эмэгтэй, эрэгтэй хоёр л ашиглах ёстойг зарлиг болгосон Их Эзэний ёс суртахууны жишиг өөр нэг илчлэлд байдаг.¹³ Энэ хүчийг буруу ашиглах нь ноцтой байдлаараа гэмгүй цусыг урсгах эсвээс Ариун Сүнсийг үгүйсгэхийн дараа ордог. Хэрэв хүн тэрхүү хуулийг зөрчсөн бол ирэх үр дагаврыг нь хэрхэн арилгахыг наманчлалын сургаал заадаг.

Хүн болгон соригддог. Бусад хүмүүст тохиолдоогүй уруу таталт өөрт нь тохиолдож байгааг шударга бус хэрэг гэж хүн бодож болох юм. Гэвч соригдох нь мөнх бус амьдралын зорилго юм. Хариу нь бүх хүнд адил. Бид бүхий л уруу таталтыг эсэргүүцэх ёстой, эсэргүүцэж ч чадна.

“Аз жаргалын агуу төлөвлөгөө”¹⁵ гэр бүл дээр суурилдаг. Нөхөр нь өрх гэрийнхээ тэргүүн, эхнэр нь гэр орондоо хайрын уур амьсгалыг бүрдүүлэгч байснаар, тэд гэр бүлийнхээ амьдралд эрх тэгш хамтрагчид болдог. Хожмын Үеийн Гэгээнтэн эр хүн өрх гэрээ авч явах үүргээ ухамсарласан бөгөөд сайн мэдээнд итгэлтэй байх ёстой. Тэрбээр гэр бүлдээ анхаарал халамж тавьдаг, хоёргүй сэтгэлт эцэг, эмэгтэй хүнийг хүндэлдэг эр хүн юм. Эхнэр нь нөхрөө дэмждэг бөгөөд эцэг эх хоёул үр хүүхдээ сүнслэг байдлын хувьд өсгөн торниулдаг.

Бие биеэ хайрлаж, бусдын гэм бурууг уужуу сэтгэлээр уучилдаг байх ёстойг Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд заадаг.

Миний амьдралыг зөв шударга нэг патриарх өөрчилсөн. Тэр залуу насандаа хайр сэтгэлтэй бүсгүйтэйгээ гэрлэсэн юм. Тэр хоёр бие биедээ ухаангүй хайртай, эхнэр нь удахгүй анхныхаа үрийн зулайг үнэрлэх гэж байв.

Эхнэрийг нь төрөх шөнө орон нутгийн цорын ганц эмч өвчтөнүүдийг эмчлэхээр хаа нэгтээ явчихсан байж. Олон цагийн дараа эхийн биеийн байдал сайнгүй болоод байтал эмч хүрч ирсэн гэнэ. Эмч яаралтай арга хэмжээ авсны үр дүнд хүүхэд төрж асуудал шийдэгдсэн ч тэр шөнө эмчийн өөр айлд өвчтөн эмчилж байхдаа авсан халдвараас болж залуу эх нас баржээ.

Залуу эрийн амьдрал сүйрэв. Хоног хугацаа өнгөрсөн ч уй гашуу нь улам нэмэгдсээр байв. Тэр өөр юуны ч тухай бодохоо болиод, хорсол нь буцалж, хүмүүст хор хүргэхээр заналхийлэх болсон гэнэ. Хэрэв энэ явдал өнөө үед болсон бол, мөнгө бүхнийг шийддэг юм шиг, эмчийг мэргэжлийн ажилдаа алдаа гаргасных нь төлөө шүүхэд өгч заргалд гэж тэр залууд дарамт шахалт үзүүлэх байсан нь эргэлзээгүй.

Нэг шөнө хаалгыг нь жаахан охин тогшин энгийнээр “Аав таныг манайд хүрээд ир гэж байна. Тантай ярилцахыг хүсч байна” гэжээ.

“Аав нь” гадасны ерөнхийлөгч байж. Ухаалаг тэр удирдагчийн өгсөн зөвлөгөө тун энгийн байлаа. “Жон, энэ асуудлыг одоо орхи. Чи юу ч хийсэн түүнийг эргүүлэн авчирч чадахгүй. Ямар нэг юм хийлээ гэхэд байдлыг улам л дордуулна. Энэ асуудлыг ингээд орхи” гэжээ.

Энэ бол миний найзад тохиолдсон хүнд сорилт байлаа. Тэр энэ асуудлыг хэрхэн орхиж чадсан гээч? Түүнд үнэхээр хэцүү байсан. Найз минь биеэ барих гэж их зовсон доо. Тэгээд эцэст нь гадасны ухаалаг ерөнхийлөгчийн зөвлөгөөг дуулгавартай дагахаар шийдэж, нөгөөх гайтай асуудлыг орхисон.

“Хөдөө нутгийн тэр хөөрхий эмч хоёр нарны хооронд нэг өвчтөнөөс нөгөө уруу гүйж, эм хэрэгсэл нь хүрэлцээгүй, өвчтөнөө хэвтүүлчих эмнэлэггүй, цалин тааруухан атлаа эрдэнэт хүмүүний амийг аврахын төлөө чадах бүхнээ хийж, ихэнх тохиолдолд эмчилгээ нь амжилттай болдог байсныг би нас ахиж өтөлсөн хойноо л ойлгосон юм даа. Хоёр хүний амь хутганы ирэн дээр байсан эгзэгтэй үед эмч ирж, тэр дороо шуурхай арга хэмжээ авсан. Сүүлдээ л би энэ бүхнийг ойлгосон! Хэрэв би тэр асуудлыг орхиогүй бол өөрийн амьдралыг ч өрөөлийн амьдралыг ч сүйтгэж мэдэх байсан шүү” гэж найз минь ярьж билээ.

“Жон, энэ асуудлыг одоо орхи” хэмээн энгийн зөвлөгөө өгсөн санваартны ухаалаг удирдагчийн төлөө тэрбээр Их Эзэнд олон удаа талархал өргөсөн юм.

Хохирч гомдсон Сүмийн гишүүд бидний дунд зөндөө л байдаг. Зарим нь бусдын өнгөрсөн алдаа дутагдлыг уучлах чадваргүйгээсээ болоод, Сүмийн зарим удирдагчид

гомдлоо орхиогүйгээс насан туршдаа зовлон үзэж хохирсныг Сүмийн түүхэн дэх хэрэг явдлууд харуулдаг. Тэд гомдлоо орхиж чадаагүйгээс Сүмд идэвхгүй болсон.

Ийм зан төлөв нь хүн бороохойгоор өөрийгөө балбахтай адилхан. Тэр хүн гомдсондоо бороохой шүүрч аваад насан туршдаа толгой уруугаа цохьж явдаг. Хэчнээн ухаангүй, гунигтай хэрэг вэ! Ийм байдлаар өс хонзон санах нь зөвхөн өөрийгөө л хөнөөнө. Хэрэв таныг хэн нэгэн нь гомдоосон бол уучил, март, тэгээд асуудлыг орхи.

Мормоны Номонд ийм нэг сэрэмжлүүлэг байдаг: “Мөн эдүгээ, хэрэв буруу буй бөгөөс тэдгээр нь хүмүүний алдаа бөлгөө; иймийн тул, та нар Христийн шүүлтийн суудлын өмнө толбогүй байж болохын тулд, Бурханы зүйлүүдийг бүү буруушаа.”¹⁶

Хожмын Үеийн Гэгээнтнүүд бол жирийн л хүмүүс. Эдүгээ 14 сая болтлоо өсч, дэлхийд хаа сайгүй амьдарч байна. Энэ бол зөвхөн эхлэл. Дэлхийд бай, харин дэлхийнх биш бай гэж бидэнд заадаг.¹⁷ Тиймээс, бид жирийн гэр бүлүүдэд жирийн амьдралаар амьдардаг.

Худал хэлэхгүй, хулгай хийхгүй, хуурч мэхлэхгүй байхыг бидэнд заадаг.¹⁸ Бид бүдүүлэг үг хэрэглэдэггүй. Бид өөдрөг санаа бодолтой, аз жаргалтай хүмүүс, амьдралаас айж цэрвэдэггүй.

Бид “гашуудах тэдний хамт гашуудахад . . . тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд Бурханыг гэрчлэгч болж зогсоход бэлэн”¹⁹ байдаг.

Хэрэв хэн нэг нь маш бага зүйл шаарддаг сүмийг хайж байгаа бол энэ сүм тийм сүм биш юм. Хожмын Үеийн Гэгээнтэн байна гэдэг амаргүй ч цорын ганц зөв зам.

Эсэргүүцэл тэмцэл эсвээс “дайнууд, дайны цуурхлууд, мөн хаа сайгүй газар хөдлөлтүүд”²⁰ тохиолдсон ч энэ ажлыг зогсоож чадах ямар ч хүч, ямар ч нөлөө байхгүй билээ. Бид бүгд илчлэлтийн сүнсээр, Ариун Сүнсний бэлгээр удирдагдаж чадна. “Түүнчлэн Миссури мөрний жам ёсны урсгалыг хүмүүн өчүүхэн гараа урагш сунган зогсоох буюу эсвээс үүний урсгалыг эргүүлэх лугаа адил Хожмын Үеийн

Гэгээнтнүүдийн тэргүүн дээр тэнгэрээс доош юүлэгдэх Бүхнийг Чадагчийн мэдлэгт саад учруулж чадна гэж үү?”²¹

Хэрэв танд сэтгэл санааны дарамт учирсан бол үүнийг март, зүгээр л зөнд нь орхичих. Уужуу сэтгэл гарган уучилж, наманчилсан тохиолдолд Ариун Сүнс танд зочилж, өмнө нь мэдэхгүй байсан гэрчлэлээр энэ нь батлагдах болно. Танд болон гэр бүлийн гишүүдэд тань анхаарал халамж тавьж, адислах болно. Энэ бол Түүнд ирэх урилга мөн. Энэ сүм---эсвээс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Түүний Өөрийнх нь мэдэгдсэнээр “бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” мөн.²² Бид энэ сүмээс “аз жаргалын агуу төлөвлөгөөг”²³ олсон юм. Энэ тухай би Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

Эшлэл

1. David Danielle, introduction to Tyndale’s New Testament, Btrans. Виллям Тиндейлийн орчуулга [1989], viii.
2. David Danielle, introduction to Tyndale’s New Testament, ix.
3. 3 Нифай 27:2–5, 7–8.
4. Тэргүүн Зөвлөлийн захиас, 2001 оны 2-р сарын 23.
5. 2 Нифай 25:26.
6. Мосе 5:8; баптисм: 2 Нифай 31:12; 3 Нифай 11:27; 18:16; өвчтөнүүдийг адисал: Сургаал ба Гэрээ 42:44; Ариун Сүнсийг хүртгээх: Моронай 2:2; санваарын томилолт: Моронай 3:1–3; ариун ёслол: Моронай 4:1–3; гайхамшгууд: Сургаал ба Гэрээ 84:66–69-ийг үз.
7. Итгэлийн Тунхаг 1:6-г үз.
8. Үйлс 1:3–11-ийг үз.
9. Үйлс 2:2–4.
10. Үйлс 2:38.
11. Сургаал ба Гэрээ 1:20.
12. Сургаал ба Гэрээ 89:18-20.
13. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2004 оны 10-р сар, 49; *Ensign*, 1995 оны 11-р сар, 102.
14. Алма 39:4–6-г үз.

15. Алма 42:8.

16. Мормоны Номын эхний хуудас.

17. Иохан 17:14–19-ийг үз.

18. Египетээс Гарсан нь 20:15-16-г үз.

19. Мозая 18:9.

20. Мормон 8:30.

21. Сургаал ба Гэрээ 121:33.

22. Сургаал ба Гэрээ 1:30

23. Алма 42:8.

Лиахона

2011 оны 5-р сар

Бямба гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Ирээдүйг итгэлээр угт

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Рассел М.Нелсон

Хайрт ах, эгч нар аа, бид та бүхнийг биднийг гар өргөн дэмждэгт мөн гэр орондоо, Сүм дээр болон нийгэм хамт олныхоо дунд хийдэг үйлчлэлд тань талархал илэрхийлье. Бид та нартай хамт байх дуртай мөн та нарыг гэр бүл, найз нөхдийнхөө дунд байхыг харах дуртай. Энэ дэлхийг илүү сайхан болгохын төлөө та нарын гаргадаг хүч чармайлтыг бид газар бүрт хардаг билээ. Бид та нарыг дэмжин туслах болно! Бид та нарт хайртай! Та нар бидний төлөө залбирдаг шиг бид ч бас та нарын төлөө залбирдаг юм шүү!

Энэхүү чуулганыг зурагтаар эсвэл интернетээр үзэхээр цугласан гэр бүлүүдийг бид төсөөлөн харж байна. Нэгэн аав, ээж хоёр чуулганы үеэр гэртээ авсан гэрэл зургийн нэг хувийг надад ирүүлсэн юм. Чуулганы үйл ажиллагааг болон үг хэлэгчийн дууг таньсан ой хагастай хүүгийнхээ үйлдлийг эцэг эх хоёр нь ажиглажээ. Бяцхан хүү зурагт уруу харан хий үнсэж эхэлсэн гэнэ. Тэр бүр ойртож суухыг хүсэхэд эгч нь бяцхан дүүгээ мөрөн дээрээ суулгаж, зурагт уруу ойртож очжээ. Тэр зураг нь энэ байна.

Тийм ээ, зурагтаар гарсан хүн бол би. Тэр хоёр хүүхэд миний ач нар. Хэдэн жилийн дараа энэ хөвгүүн ахлагч болж, ариун сүмд хувийн хишгээ хүртэн, номлолдоо гарахад бэлэн болно. Хожим нь тэр өөрийн сонгосон мөнхийн хамтрагчтайгаа лацдан холбуулна. Та нар түүнийг нэгэн цагт өөрийн үр хүүхэдтэй нөхөр, эцэг болсон байхыг төсөөлж чадах уу? Нэг өдөр тэр өвөг эцгүүдтэйгээ салах ёс гүйцэтгэхдээ, үхэл гэдэг бол амьдралын нэг хэсэг гэдэг баттай мэдлэгтэй болсон байх болно.

Энэ бол үнэн зүйл. Бид төрсний дараа үхэж, дахин амьдрахын төлөө үхдэг билээ. Үүрд мөнхийн үзэл баримтлалаар жинхэнэ цаг бусын үхэл бол Бурхантай уулзахаар бэлтгэгдээгүй хүний үхэл мөн.

Төлөөлөгчид, бошиглогчид бид зөвхөн өөрсдийн хүүхдүүд, ач зээ нарын төлөө төдийгүй бас та нарын үр хүүхэд, ач зээ нарын төлөө, бүр Бурханы хүүхэд нэг бүрийн төлөө санаа

тавьдаг. Бурханы ариун хүүхэд бүрийн ирээдүйд тохиолдох бүхний эх суурийг эцэг эхчүүд, гэр бүл, найз, багш нар тавьж, төлөвшүүлдэг билээ. Тийнхүү *одоогийн* бидний итгэл хойч үеийнхний итгэлийн нэгэн хэсэг болно.

Байнга хувьсан өөрчлөгдөж, үзэл суртлаараа өрсөлдөж байгаа дэлхийд хувь хүн бүр амьдралдаа өөрийн гэсэн арга замыг бий болгодог. Сайн муу хүчнүүд үргэлж тэмцэлдэх болно. Сатан биднийг өөртөө татах гэж, өөрийнхөө замаар замнуулах гэж байнга хичээдэг.¹ Иймээс өвчин эмгэг, гэмтэл бэртэлт, аваар осол зэрэг ердийн эрсдэлүүд амьдралд үргэлж байх болно.

Бид самуун цаг үед аж төрж байна. Энд тэндгүй болж байгаа газар хөдлөлтүүд болон цунами эвдрэл сүйтгэл учруулж, засгийн газрууд унан, эдийн засгийн хямрал ужигарч, гэр бүлийн үүрэгт аюул занал учирч, гэр бүл салалтын хувь хэмжээ өсч байна. Бидний санаа зовох олон учир шалтгаан байна. Гэвч бидний итгэлийг айдас орлох учиргүй. Бид итгэлээ бэхжүүлснээр айдсыг ялж чадна.

Хүүхдүүдээсээ эхэл. Эцэг эх та нар хүүхдүүдийнхээ итгэлийг бэхжүүлэхэд үндсэн үүрэг хариуцлага хүлээдэг. Хүнд сорилт бэрхшээл та нарт тулгарсан үед ч хүүхдүүддээ итгэлээ харуул. Итгэл тань хайр энэрлээр дүүрэн Тэнгэрлэг Эцэг, Түүний Хайртай Хүү, Их Эзэн Есүс Христ дээр төвлөрөх болтугай. Ийм итгэлийг гүнзгий итгэл үнэмшилтэйгээр заагтун. Энхрий хайртай хөвгүүн, охиндоо тэд бол Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, ариун зорилго, агуу хэтийн төлөвтэй, Түүний хүү буюу охин гэдгийг нь ойлгуулагтун. Хүн бүр даван туулах сорилтуудтай, хөгжүүлэх ёстой итгэл бишрэлтэй төрдөг.²

Бурханы авралын төлөвлөгөөнд итгэх итгэлийн тухай заа. Энэ дэлхийн амьдрал бол сорилтын үе, Их Эзэн бидэнд зарлиг болгосон юуг боловч бид хийж чадах эсэхийг харах сорилтын үе юм гэдгийг заагтун.³

Бурханы *бүх* зарлигууд нь Түүний хүүхдүүдийг адисалж, тэдэнд баяр баясгаланг авчрах болно гэдгийг мэдсэний үндсэн дээр зарлигуудыг сахих итгэлийн тухай заагтун.⁴ Ямар зарлигуудыг сахих, ямар зарлигуудыг сахихгүй байхыг сонгож болно гэж хэлэх хүмүүстэй тааралдах болно гэдгийг хүүхдүүддээ анхааруул. Үүнийг би зоогийн газарт хоол сонгохтой адилаар дуулгавартай байдалд хандаж байгаа хэрэг гэж боддог.

Зарлигуудыг сонгон сахих нь явуургүй бөгөөд зөвхөн зовлон уруу хөтөлнө. Бурхантай уулзахаар бэлтгэхийн тулд хүн Түүний бүх зарлигуудыг сахих ёстой. Түүний зарлигуудыг сахихад итгэл хэрэгтэй харин зарлигуудыг сахиснаар тэрхүү итгэл бэхэждэг.

Дуулгавартай байдал нь Бурханы адислалууд аливаа саад тотгоргүйгээр ирэх боломжийг олгодог. Тэрбээр дуулгавартай хүүхдүүдээ боолчлол, гай зовлонгоос ангид байхаар адислах болно. Мөн Тэрбээр тэднийг илүү их гэрлээр адисална. Жишээ нь: Мэргэн Ухааны Үгээр амьдардаг хүн Мэргэн ухааны үгэнд дуулгавартай байх нь зөвхөн донтолтоос хамгаалах төдийгүй бас мэргэн ухааны болон мэдлэгийн сан хөмрөгийн адислалуудыг авчирдаг гэдгийг мэддэг.⁵

Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь бие махбодын болон сүнсний хамгаалалт болдгийг мэдэх итгэлийн тухай заа. Бурханы ариун тэнгэр элчүүд бидэнд туслахад үргэлж бэлэн байдгийг санагтун. Чухам иймээс Их Эзэн “Би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно”⁶ хэмээн мэдэгдсэн. Энэ бол агуу амлалт юм. Биднийг итгэлтэй байсан цагт Тэр болон Түүний тэнгэр элчүүд бидэнд туслах болно.

Гуйвшгүй итгэл залбирлаар дамжин улам бат бөх болдог. Та нарын чин сэтгэлийн гуйлт Түүнд чухал юм. Бошиглогч Иосиф Смитийн Либерти шоронд хоригдож байхдаа хэлсэн оргилуун, эрч хүчтэй залбирлуудын тухай бодоод үз. Бошиглогчийн байдал өөрчлөгдөнө гэж Их Эзэн хариулжээ. “Эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно гэдгийг чи мэдэгтүн, хүү минь”⁷ хэмээн Тэрбээр хэлсэн.

Хэрэв бид үүрд мөнхийн ирээдүйгээ бодож залбирах юм бол бидний чин сэтгэлийн гуйлтуудыг сонсох болно гэдэгт эргэлзэх хэрэггүй. Их Эзэний энэхүү амлалтыг Сургаал ба Гэрээний 98-р хэсэгт ийн цэдэглэсэн байдаг: “Залбирлууд чинь Их Эзэний сонорт ирсэн болой . . . мөн энэхүү лац хийгээд гэрээний хамт цэдэглэгдсэн авай—тэдгээр нь соёрхогдохоор Их Эзэн андгайлж мөн тогтоосон билээ.

Тиймийн тул, тэдгээр нь биелэгдэх болно хэмээх энэ амлалтыг өөрчлөгдөшгүй гэрээний хамт тэрээр та нарт өгч байна мөн та нарын зовж зүдэрсэн бүх зүйл мөн миний нэрний

алдар суутай нийлээд та нарын сайн сайхны төлөө ажиллах болно хэмээн Их Эзэн хэлж байна.”⁸

Их Эзэн бидэнд итгэл төрүүлэхийн тулд *Лац! Гэрээ! Андгайлсан! Тогтоосон!*
Өөрчлөгдөшгүй гэрээ! гэхчлэн хамгийн хүчирхэг үгсийг сонгосон байна. Ах, эгч нар аа, Түүнд итгэгтүн! Бурхан та нарын чин сэтгэлийн залбирлыг анхааралдаа авч, улмаар итгэл тань бэхжих болно.

Аравны нэгийг бүрэн төлөгч байх бат бөх итгэл, чанд тууштай байдлыг хөгжүүлэх нь нэн чухал юм. Эхлээд аравны нэгийг төлөх итгэлтэй байх хэрэгтэй. Дараа нь аравны нэгийг төлдөг хүн аравны нэг бол үнэ цэнэтэй онцгой боломж гэдэгт итгэх илүү их итгэлийг хөгжүүлдэг. Аравны нэг нь эрт дээр үеэс Бурханы хууль байсаар ирсэн юм.⁹ Тэрбээр хүүхдүүддээ “тэнгэрийн цонхнуудыг нээж, . . . хүлээн авах хангалттай зай байхгүй болтол адислалыг цутгана”¹⁰ хэмээн амласан. Зөвхөн түүгээр ч зогсохгүй аравны нэг нь таны нэрийг Бурханы хүмүүсийн дунд тоолуулж, “хилэгнэл хийгээд шатаалтын өдөр”¹¹ таныг хамгаалах болно.

Бидэнд яагаад тийм бат бөх итгэл хэрэгтэй вэ? Яагаад гэвэл ирээдүйд хүнд хэцүү цаг ирэх болно. Ирээдүйд, итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтэн байх нь хэцүү байх бөгөөд ихийг шаардах болно. Бид бүгд соригдох болно. Хожмын өдрүүдэд Их Эзэнийг хичээнгүйлэн дагасан хүмүүс “хавчигдах болно”¹² гэдгийг Төлөөлөгч Паул анхааруулсан. Тэрхүү хавчлага нь нэг бол таныг сул дорой байдалд чимээгүйхэн дагуулна эсвэл таныг өдөр тутмын амьдралдаа илүү сайн үлгэр жишээ болж, зоригтой байхад нөлөөлнө.

Амьдралын хүнд сорилтуудыг хэрхэн шийдвэрлэхээс таны итгэлийн өсөлт дэвшилт хамаарна. Өөрт чинь бурханлиг мөн чанар, хэмжээлшгүй үнэ цэнэтэй өв бий гэдгийг санасан үед хүч чадал ирдэг. Та нар бол хууль ёсны өв залгамжлагчид гэдгийг, та нар онцгой цаг үед хэрэгтэй газарт төрсөн, Түүний тугийг өндөрт өргөн авч явах гэрээт хүмүүс болгон тэнгэрт хадгалсныг Их Эзэн та нарт, та нарын хүүхдүүд, ач зээ нарт сануулсан юм. Та нар Их Эзэний зөв шударга замаар амьдрах юм бол Түүний нигүүлслээр үргэлж адислагдан, Түүний хүмүүст гэрэл бөгөөд аврагч нь байх болно.¹³

Ах, эгч нар аа, ариун Мелкизедек санваарын хүчээр дамжин ирдэг адислалууд та бүгдэд нээлттэй байдаг билээ. Эдгээр адислалууд эрүүл мэнд, Ариун Сүнсний нөхөрлөл, хувийн харилцаа, ирээдүйн боломжууд зэрэг та нарын амьдралын нөхцөлийг өөрчилж болно. Энэ санваарын хүч болон эрх мэдэл нь Сүм дэх сүнсний бүх адислалуудын түлхүүрүүдийг эзэмшдэг.¹⁴ Мөн хамгийн гайхамшигтай нь Их Эзэн Өөрийн хүслийн дагуу эдгээр адислалуудаа үргэлжлүүлэх болно гэдгээ мэдэгдсэн юм.¹⁵

Санваарын бүх адислалуудаас хамгийн агуу нь Их Эзэний ариун сүмүүдэд хүртээгддэг. Тэнд хийсэн гэрээнүүддээ чин үнэнч байх нь таныг болон гэр бүлийг тань мөнх амьдралын адислалуудыг хүртэхүйц болгоно.¹⁶

Та нарын шагнал зөвхөн дараагийн амьдралд ирэх биш харин энэ амьдралд та нарт болоод үр хүүхэд, ач зээ нарт тань ирэх болно. Итгэлтэй Гэгээнтнүүд та нар амьдралын төлөөх тулалдаанд ганцаараа биш. Энэ тухай бодоод үз! “Чамтай тэрслэгч түүнтэй би ч бас тэрслэх болно, мөн би хөвгүүдийг чинь аврах болно”¹⁷ гэж Их Эзэн хэлсэн билээ. Дараах амлалт хожим нь Түүний итгэлтэй хүмүүст ирсэн юм. “Их Эзэн бибээр тэдний тулалдаануудад мөн тэдний хүүхдүүдийн тулалдаануудад, мөн тэдний хүүхдүүдийн хүүхдүүдийнхэд ч мөн адил, гурав дахь мөн дөрөв дэх үед . . . байлдах болно.”¹⁸

Бидний хайрт Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Бидэнд амлагдсан адислалууд хэмжээлшгүй их юм гэдгийг би та бүхэнд гэрчилж байна. Олон хэцүү сорилт, бэрхшээл бидэн дээр шил дараалан ирж байгаа ч бид зөв шударгаар амьдарч, зарлигуудыг сахих юм бол сайн мэдээний тухай, Тэнгэрлэг Эцэг болон Аврагчийн тухай мэдлэг маань биднийг тайтгаруулж, дэмжин тулж, бидний зүрх сэтгэлд баяр баясгаланг авчрах болно” хэмээн гэрчилсэн билээ.

Тэрээр цааш нь: “Хайрт ах эгч нар минь, бүү ай. Зоригтой бай. Ирээдүй та нарын итгэл лүгээ адил гэрэл гэгээтэй байна”¹⁹ хэмээсэн (эшлэл төгсөв).

Ерөнхийлөгч Монсоны хүчирхэг үгс дээр би өөрийнхөө гэрчлэлийг нэмье. Бурхан бол бидний Эцэг. Есүс бол Христ. Түүний Сүм дэлхий дээр сэргээгдсэн. Түүний үнэн, Түүний гэрээнүүд болон ёслолууд айдсыг ялж, ирээдүйг итгэлээр угтах боломжийг бидэнд олгодог билээ! Үүнийг би Есүс Христийн ариун нэрээр гэрчилж байна, амен.

ЭШЛЭЛ

1. 2 Нифай 2:27-г үз.

2. Петр "та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлиг мөн чанарын хуваалцагч болох юм" (2 Петр 1:4) гэсэн найдварыг илэрхийлэх үедээ энэ үзэл баримтлалыг заажээ.

3. Абрахам 3:25-ыг үз.

4.2 Нифай 2:25-ыг үз.

5. Сургаал ба Гэрээ 89:19; Исаиа 45:3-ыг үз.

6. Сургаал ба Гэрээ 84:88.

7. Сургаал ба Гэрээ 122:7. Дуулалд цэдэглэсэн зан төлөвийг өөрчлөх өөр нэг жишээ бол: "Сэтгэлийг минь хамгаалаач; . . . миний Бурхан, Та Өөрт тань итгэдэг Өөрийн зарцыг авраач. Өө Эзэн, намайг нигүүлсээч. Учир нь Тан уруу хандан би өдөржин хашхирдаг. . . . Миний Бурхан Эзэн, би бүх зүрхээрээ Танд талархаж, Таны нэрийг мөнхөд алдаршуулна" гэсэн үгс юм (Дуулал 86:2–3, 12).

8. Сургаал ба Гэрээ 98:2–3

9. Аравны нэгийг Хуучин Гэрээний Эхлэл, Левит, Тооллого, Дэд Хууль, Шастирын Дэд, Нехемиа, Амос, Малахи зэрэг найман номонд дурдсан байдаг.

10. Малахи 3:10.

11. Сургаал ба Гэрээ 85:3.

12. 2 Тимот 3:12.

13. Сургаал ба Гэрээ 86:8-11-ийг үз.

14. Сургаал ба Гэрээ 107:18-ыг үз.

15. Сургаал ба Гэрээ 132:47, 59-ийг үз.

7

16. Абрахам 2:11-ийг үз.

17. Исаиа 49:25; мөн Сургаал ба Гэрээ 105:14-ийг үз.

18.Сургаал ба Гэрээ 98:37.

19. Томас С.Монсон “Be of Good Cheer,” Liahona.

Бямба гарагийн үдээс хойших хуралдаан
2011 оны 4-р сарын 2
Христ дээр төвлөрсөн гэр бүлийг төлөвшүүлэх нь

Далын Чуулгын

Ахлагч Ричард Ж.Мэйнз

Би Уругвай, Парагвайд номлолд үйлчилж байхдаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн тухай хүмүүсийн маш ихээр мэдэхийг хүсэж, сонирхож байгаа зүйл нь гэр бүлтэй холбоотой сургаал болохыг олж мэдсэн юм. Есүс Христийн сайн мэдээ сэргээгдсэнээс хойш үнэнийг эрэлхийлж буй сонирхогчид нь гэр бүлүүд мөнхөд хамтдаа байх талаар заасан сургаалд татагдсан байдаг.

Мөнхийн гэр бүлийн зарчим нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүддээ өгсөн агуу төлөвлөгөөн дэх чухал хэсэг юм. Төлөвлөгөөний гол үндэс нь бидэнд *тэнгэрлэг* гэр бүл төдийгүй *дэлхий дээрх* гэр бүл байдаг гэдгээ ойлгох явдал. Төлөөлөгч Паул бидэнд Тэнгэрлэг Эцэг бол бидний сүнсний эцэг гэдгийг ийн заасан билээ:

“Хүн Бурханыг эрж хайж . . . Түүнийг олох ёстой...”

Бид бас Түүний үр удам гэж хэлсэнчлэн, бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтдог.”¹

Хайрт Тэнгэрлэг Эцэгийн үр удам гэдэг нь Есүс Христийн сайн мэдээний үндсэн гол зарчим мөн. Бүр хүүхдүүд маань Хүүхдийн Хэсгийн “Би Бурханы хүүхэд” дуундаа энэхүү үнэнийг тунхагладаг, та нар үгсийг нь санаж байна уу?

*Би Бурханы хүүхэд тул
Энэ эх дэлхийд намайг,
Их Энэрэнгүй эх эцгийг
Дэлхийн хамт заяав Тэр,*

*Надад замаа олоход туслан
Хөглөн удирдаач
Түүнтэй амьдрахын тул би
Юу хийх ёстойг заагаач.*²

Бид *тэнгэрлэг* гэр бүлтэй гэдгээ ухаарах нь *дэлхийн* гэр бүлийнхээ мөнхийн мөн чанарыг ойлгоход бидэнд тусалдаг. Гэр бүл нь тэнгэрийн тогтсон журамд гол зүйл гэдгийг Сургаал ба Гэрээ бидэнд заадаг: “Энд бидний дунд байгаа тэрхүү харилцаа тэнд бидний дунд байх болно, гагцхүү энэ нь эдүгээ бидний эдэлдэггүй тийм алдар суу болох мөнхийн алдар суугаар хоёр дахин ихсэх болно.”³

Гэр бүлийн мөнхийн мөн чанарын тухай ойлголт нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүддээ өгсөн төлөвлөгөөг ойлгоход агуу ач холбогдолтой. Нөгөө талд дайсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг устгахын тулд юу ч хийхээс буцахгүй байна. Тэр Бурханы төлөвлөгөөг сүйрүүлэхийн тулд гэр бүл уруу янз бүрийн аргаар дайрч давшилж байна. Түүний хамгийн хүчтэй зэвсэг нь аминч үзэл, эдийн шунал ба порнограф юм.

Бидний мөнхийн аз жаргал Сатаны зорилго *биш*. Хүмүүсийг өөр шигээ золгүй амьтан болгох аргыг тэр мэддэг. Түүний зорилго бол *үүрд мөнх* оргилох гэр бүлийн харилцаанаас биднийг салгах явдал юм. Энэ амьдрал болон мөнхийн амьдралын жинхэнэ аз жаргал нь гэр бүлийн хүрээнд байдаг гэдгийг Сатан мэддэг учраас үүнийг устгахын төлөө чадах бүхнээ хийдэг.

Эртний бошиглогч Алма, Бурханы хүүхдүүддээ өгсөн төлөвлөгөөг “аз жаргалын агуу төлөвлөгөө”⁴ хэмээн нэрлэсэн. Бидний бошиглогч, үзмэрч, илчлэгчид хэмээн дэмждэг Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ах нар бидэнд аз жаргал ба гэр бүлийн амьдралын талаар дараах сүнслэг зөвлөгөөг өгсөн юм:

“Гэр бүл Бурханаас томилогддог. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй. Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно.”⁵

Бошиглогч Алма болон Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын хэлсэн энэхүү аз жаргалыг Христ дээр төвлөрсөн гэр бүлүүдээс харж болно. Ийм гэр бүлийг төлөвшүүлэхийн төлөө чадах бүхнээ хийвэл бид тэрхүү аз жаргалыг хамгийн агуу хэмжээгээр эдлэх болно.

Мэйнз эгч бид хоёр гэрлэсэн цагаасаа хойш Христэд төвлөрсөн гэр бүлийг төлөвшүүлэхийг хичээн, өсч хөгжих явцдаа хэдэн чухал зарчмыг ойлгож мэдсэн юм. Бид Сүмийн удирдагчдынхаа зөвлөгөөг дагаж, хүүхдүүдийнхээ хамт долоо хоног бүр гэр бүлийн үдшийг хийж, өдөр бүр хамт залбирч, судар судалдаг байлаа. Энэ нь амар хялбар, амжилттай байгаагүй ч цаг хугацаа өнгөрөх тусам бидний иймэрхүү энгийн үйл ажиллагаанууд гэр бүлийн үнэ цэнэтэй дадал зуршил болсон.

Хүүхдүүд маань гэр бүлийн үдшийн хичээлийг долоо хоногийн эцсээр нэг бүрчлэн санахгүй ч *бид үүнийг хийсэн* гэдгийг санах болно гэдгийг бид хожим нь мэдсэн. Тэд судруудын эсвэл залбирлын үг бүрийг санахгүй ч бид судраас *уншсан, залбирал* хийсэн гэдгийг санах болно. Ах эгч нар аа бидэнд гэр бүлдээ ариун дадал зуршлыг хэвшүүлэх агуу хүч болон хамгаалалт бий.

Есүс Христийн сайн мэдээний зарчмуудаас гэр бүлдээ суралцаж, зааж, хэрэгжүүлэх нь Сүнс орших амьдралын хэв маягийг бий болгоход тусалдаг. Бид эдгээр эрхэм дадал зуршлуудыг орон гэртээ бий болгосноор дэлхийн хуурамч уламжлалуудыг даван туулж, бусдын хэрэгцээ болон асуудлуудыг нэгдүгээрт тавих чадвартай болно.

Христ дээр төвлөрсөн гэр бүлийг төлөвшүүлэх үүрэг хариуцлага эцэг эх, үр хүүхэд аль алинд нь бий. Эцэг эх хүүхдүүддээ хайр ба зөв шударга үлгэр жишээгээр заах үүрэгтэй. Ариун үүрэг хариуцлагуудаа хэрхэн гүйцэтгэж байгаагаа эцэг эхчүүд Их Эзэний өмнө тайлагнах болно. Эцэг эх хүүхдүүддээ *үг хэл, үлгэр жишээгээрээ* заадаг. С.С. Миллерийн “Цуурай” хэмээх шүлгэнд эцэг эхчүүд хүүхдүүддээ нөлөөлөхийн чухлыг дурдсан байдаг:

*Есүсийн ярьсан сургаалт зүйрлэлд
Ерэн есөөсөө төөрсөн тэр хонь,
Давжаа бяцхан хурга байгаагүй юм.
Давилуун том хонь байсан юм.*

*Замаа алдаж төөрсөн хонийг
Залбирч, найдвар тавин юуны учир хайдаг вэ?
Хонь буруу замаар орж төөрвөл
Хурга тэднийг дагах болно.
Хонь хэрвээ замаа алдаж төөрвөл
Хурга тэднийг дагаж замаа алдана.
Хонь хэрвээ буруу замаар явбал
Хурга бас тэднийг дагана.*

*Өнөөдөр хурганууд байгаа тэдний төлөө
Өр зүрхээрээ бид хоньтой хамт залбирна
Хонь тийн төөрч алдагдахад
Хохирол гарз нь тоолшгүй их
Хөөрхий хурганууд л тэр гарзыг төлнө.⁶*

Хүүхдүүдээ замаа алдахад хөтөлж байгаа эцэг эхийн балгийг Их Эзэн Сургаал ба Гэрээнд тайлбарласан юм:

“Мөн дахин, Сионд ... эцэг эхчүүд хүүхдүүдтэй байхын хэрээр, тэдэнд наманчлалын сургаал амьд Бурханы Хүү Христэд итгэх итгэл хийгээд баптисм хүртээх мөн гар тавилтаар ирдэг Ариун Сүнсний бэлгийг ойлгохыг тэд *заадаггүй* бол уг нүгэл эцэг эхчүүдийнх нь тэргүүн дээр байх болно.”⁷

Эцэг эхчүүд ариун дадал зуршлуудыг хүүхдүүддээ үг яриа, үлгэр жишээгээрээ заахын чухлыг үгээр илэрхийлэх аргагүй юм. Христ дээр төвлөрсөн гэр бүлийг төлөвшүүлэхэд

хүүхдүүд маш чухал үүрэгтэй байдаг. Саяхан манай найман настай ач хүү Виллигийн энэ зарчмыг тусгасан бяцхан яриаг та нартай хуваалцъя:

“Би морь унаж, аавтайгаа хамт адуу, үхэр бугуйлдах дуртай. Олс янз бүрийн сүлжээстэй байдаг ба тэдгээр нь бүгд нийлээд бат бөх болдог. Хэрэв олсыг ганц сүлжээсээр сүлжих юм бол сайн бугуйл болж чадахгүй. Олон сүлжээс нийлээд бат бөх болдог тул бид тэдгээрийг янз бүрийн юманд ашиглах боломжтой. Үнэхээр бөх шүү.

Гэр бүлүүд яг эрчилсэн олс шиг байж чадна. Зөвхөн ганцаараа зүтгэж, зөвийг хийгээд, харин бусад гэр бүлийн гишүүд нь бие биедээ тусалж, хичээл зүтгэл гаргахгүй бол гэр бүл бат бөх, хүчирхэг байж чадахгүй.

Би зөв зүйлийг хийснээрээ гэр бүлдээ тусалдаг гэдгийг мэднэ. Намайг дүүгээ харж, хоёулаа эвтэй байх үед аав ээж хоёр баяртай байдаг. Ээжийг ажилтай үед би бяцхан дүү Жоеитай тоглож, өрөөгөө цэвэрхэн байлгаж, ээждээ тусалж чадна. Би айлын том нь болохоор сайн үлгэр жишээ болох нь маш чухал. Би зөвийг сонгож, зарлигуудыг дагахын төлөө хичээх болно.

Хүүхдүүд гэр бүлээ бат бөх олстой адил байхад тусалж чадна гэдгийг би мэднэ. Хүн бүр өөрийнхөө чадах зүйлээ хийж, хамтдаа ажиллавал гэр бүлүүд аз жаргалтай, бат бөх байж чадна.”

Эцэг эх гэр бүлээ энэрэл хайр, зөв шударгаар тэргүүлэн, хүүхдүүддээ Есүс Христийн сайн мэдээг *үгээрээ* мөн *үлгэр жишээгээрээ* зааж мөн хүүхдүүд эцэг эхийнхээ заасан зарчмуудыг суралцан, хэрэгжүүлж, эцэг эхээ хайрлан, дэмжсэний үр дүнд Христэд төвлөрсөн орон гэр бий болох болно.

Ах эгч нар аа, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бид гэр бүлийн мөнхийн мөн чанарыг ойлгож, үүнд итгэдэг. Энэ ойлголт, итгэл нь биднийг Христэд төвлөрсөн гэр бүлийг төлөвшүүлэхийн төлөө чадах бүхнээ хийхэд урамшуулан өдөөх ёстой. Хэрэв үүнийг хийхийг хичээвэл бид Аврагч Есүс Христийн амьдрал, цагаатгалаар үлгэр жишээ болсон хайр болон үйлчлэлийг бүрнээр нь хэрэгжүүлж чадах бөгөөд гэр орноо дэлхий дээрх жинхэнэ диваажин болгож чадна хэмээх өөрийн гэрчлэлийг Есүс Христийн нэрээр үлдээж байна, амен.

Эшлэл

1. Үйлс 17:27-28.
2. “Би Бурханы хүүхэд” Дуулал, 58

3. С ба Г 130:2, Роберт Д.Хейлс, “The Eternal Family,” *Liahona*, 1996 оны 11-р сар, 64-г үз.

4. Алма 42:8

5. "Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг", *Liahona*, 2010 оны 11-р сар, 129.

6. С. С. Миллер “The Echo,” in *Best-Loved Poems of the LDS People*, ed. Jack Lyon, et.al. (Солт Лейк: Deseret Book, 1996), 312–313.

7. С ба Г 68:25.

Бямба гарагийн үдээс хойших хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Гэрчлэл

Далын Ахлагч

Бага Сесил О.Самуелсон

Сүмийн залуусаар хүрээлүүлэн хамтран ажиллах боломжтой байсан маань олон жилийн турш миний амьдралыг адисалсаар ирсэн юм. Энэхүү нөхөрлөлөө би амьдралынхаа хамгийн сайхан, үнэ цэнэтэй зүйлд тооцдог. Энэ нь дэлхийн хүн төрөлхтний болон Сүмийн сайн сайхан, гэрэлт ирээдүйн үндэс суурь юм.

Тэдэнтэй ажиллаж байхдаа би гэрчлэлийн хувьд эргэлзэж тээнэгэлзсэн, асуудалтай олон залуустай ярилцдаг байлаа. Тэд янз бүрийн асуудалтай байдаг ч энэхүү эргэлзээг үүсгэдэг асуулт болон шалтгаан нь адил төстэй аливаа анги давхарга болон насны бүлгээс хамааралгүй байдаг байлаа. Хэдэн үеэрээ Сүмийн гишүүн байсан хүмүүс, шинэхэн гишүүд болон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмтэй дөнгөж танилцаж буй хүмүүст ч эргэлзээ төрж болох юм. Тэдний асуултууд ихэвчлэн аливааг олж мэдэх хүсэл, сонирхлоос нь үүдэлтэй байдаг. Хүн тус бүрийн хувьд үр дагавар нь маш чухал, онцгой учир холбогдолтой байдаг учир гэрчлэлийнхээ талаар дахин нэг бодож үзэх хэрэгтэй мэт санагдана. Хожмын Үеийн Гэгээнтнүүд бидний гэрчлэл Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлын талаарх хөдөлшгүй гэрч бөгөөд энэ нь Ариун Сүнсээр дамжин ирдэг.

Энэхүү тодорхойлолт нь хэдийгээр энгийн, тодорхой боловч үүнээс хэд хэдэн асуулт урган гарч болох юм. Тухайлбал: Хэн гэрчлэлийг хүлээн авдаг вэ? Шаардлагатай гэрчлэлээ хүн хэрхэн олж авдаг вэ? Гэрчлэл олж авах ямар үе шатууд байдаг вэ? Гэрчлэлтэй байх нь маш ховор тохиодог зүйл үү эсвэл үргэлж байдаг үйл явц уу? Эдгээр болон бусад асуултууд нь тус бүрдээ хариулттай боловч Есүс Христийн сайн мэдээний талаар гэрчлэл олж авах болон үүнийгээ хадгалан үлдэх үндсэн зарчмууд нь энгийн бөгөөд тодорхой учир хүн бүрд боломжтой юм.

Би эргэлзээтэй асуултуудад хариулахаас гадна гэрчлэлээ хэрхэн олж авсан туршлагаасаа хуваалцсан залуу насанд хүрэгч найз нарынхаа туршлагаас товчхон ярья. Мөн тэд итгэл, үнэмшлийнхээ тал дээр аливаа асуудал бэрхшээлтэй хүмүүст номлох боломжтой байсан.

Нэгдүгээрт: Хэн гэрчлэлийг хүлээн авдаг вэ? Төлөөсийг төлөхөд бэлэн хүн, өөрөөр хэлбэл тушаалуудыг сахиж буй хэн ч гэрчлэлийг хүлээн авж чадна. “Иймийн тул Их Эзэний дуу хоолой дэлхийн өнцөг булангуудад, сонсох бүгд нь сонсож болохын тулд хандсан авай” (С ба Г 1:11). Сайн мэдээний Сэргээлтийн үндсэн гол шалтгаан нь “хүн

болгон Их Эзэн Бурханы, бүр дэлхийн Аврагчийн нэрээр ярьж болохын тулд юм; Тэрхүү итгэл бас дэлхий дээр өсч болохын тулд юм” (С ба Г 1:20-21).

Хоёрдугаарт: Шаардлагатай гэрчлэлээ хүн хэрхэн олж авдаг вэ, мөн гэрчлэл олж авах ямар үе шатууд байдаг вэ? Хариулт нь түүхийн туршид энгийн бөгөөд тогтвортой байсан юм. Мормоны Номын талаар гэрчлэл олж авах амлалт нь бусад үнэнүүдийн талаарх гэрчлэлийг мөн багтаадаг. “Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, [та нар сонсож, уншиж, суралцаж, мөн өөрсдөдөө байгаа асуултынхаа талаар тунгаан бодоод] ... Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуульа би; [залбирлынхаа хариуг дагана хэмээн чанд амлалттайгаар тунгаан бодож, тодорхой мөн даруухнаар залбирвал] мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно.

“Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” (Моронай 10:4-5).

Гуравдугаарт: Гэрчлэл олж авах нь маш ховор тохиодог зүйл үү эсвэл үргэлжлэх үйл явц уу? Гэрчлэл нь зөв арчилж тордсон тохиолдолд ургаж, өсч хөгждөг амьд биеттэй төстэй юм. Амьд биетийг ургуулж, өсгөж үржүүлэхийн тулд байнгын халамж, арчилгаа, хамгаалалт шаардлагатай. Үүний адилаар бид гэрчлэлээ үл хайхран, хүчирхэгжүүлэх шаардлагатай зүйлсийг хийгээгүйгээс болж гэрчлэл маань алга болох буюу сулардаг. Гэм нүгэл үйлдэн, Бурханы тушаалуудыг зөрчсөнөөр Сүнсийг алдан, бүр хүн өөрт байсан гэрчлэлээ хүртэл үгүйсгэхэд хүрдэг талаар сударт сэрэмжлүүлсэн байдаг. (С ба Г 42:23-ыг үз).

Эрхэм хүндэт, итгэл бишрэлтэй залуу найзууддаа хандаж захих 10 зөвлөгөө байна. Тэд бодол санаа, туршлагынхаа тал дээр адил төстэй зан чанартай байдаг. Харамсалтай нь бидэнд асуудлууд тулгарах үед бид эдгээр асуудлаас гарах гарцуудаа хэсэг зуур умартсан байдаг.

Нэгдүгээрт: Бид Бурханы хүүхдүүд учир хүн бүр үнэ цэнэтэй. Тэр биднийг мэддэг, хайрладаг мөн Түүн уруу амжилттайгаар эргэн очихыг биднээс хүсдэг. Бид Түүний хайранд итгэж сурахаас гадна тэвчээргүй, эгэл хүслүүдээсээ илүүгээр Түүнд итгэхэд суралцах ёстой.

Хоёрдугаарт: Бид судруудад гардагчлан “зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт”-д бүрнээр итгэн (Мозая 5:2; Алма 5:12-14, 26-г үз), зүрх сэтгэлийн энэхүү өөрчлөлт нь гэнэт тохиодог бус харин тодорхой асуулт, туршлага, эргэлзээгээ тайлахын тулд суралцаж залбирсны үндсэн дээр аажмаар явагддаг гэдгийг ойлгох ёстой.

Гуравдугаарт: Соригдож, шалгууруудыг даван туулах нь бидний амьдралын үндсэн зорилго учир бид сорилт бэрхшээлүүдээсээ суралцах ёстой бөгөөд амар хялбар замаар олох боломжгүй хичээл, туршлагуудыг олж авсандаа талархалтай байх хэрэгтэй.

Дөрөвдүгээрт: Итгэдэг зүйлүүддээ хийгээд эргэлзээтэй, зовж зүдэрсэн үед биднийг дэмжин тусалдаг зүйлст итгэж сурах учиртай.

Тавдугаарт: Алмагийн зааснаар гэрчлэл олж авах нь найдвар тавин итгэснээр эцэст нь тодорхой зарчим, сургаал болон сайн мэдээний талаарх үнэнийг олж мэдэх байнгын үйл явц юм (Алма 32-ыг үз).

Зургадугаарт: Мэддэг зүйлсээ хэн нэгэнд заах нь бидний гэрчлэлийг хүчирхэгжүүлэхээс гадна бусдын гэрчлэлийг ч нэмэгдүүлдэг. Чи хэн нэгэнд мөнгө эсвэл хоол өгөхөд чинийхээс хорогддог. Харин та нар гэрчлэлээ хуваалцахад номлодог мөн хүлээн авдаг аль алиных нь гэрчлэл хүчирхэгжиж, өсөн нэмэгддэг.

Долдугаарт: Бид жижиг боловч чухал шаардлагатай зүйлсийг өдөр бүр тогтмол хийж сурах ёстой. Залбирал, судрууд болон сайн мэдээнээс суралцах, Сүмийн цуглаануудад оролцох, ариун сүмд орох, айлчлагч болон гэрийн багшлалтыг хийх зэрэг бусад үүрэг даалгавруудаа гүйцэлдүүлэх нь итгэлийг маань өсгөж, бидний амьдралд Сүнснийг урьдаг. Бид эдгээр боломжуудыг анхаарахгүй өнгөрснөөр гэрчлэлээ алдахад хүрдэг.

Наймдугаарт: Бид өөрсдөдөө тавьдаг шаардлагаасаа илүү шаардлагыг бусдад тавих ёсгүй. Заримдаа бид бусдын алдааг ялангуяа удирдагчид эсвэл Сүмийн гишүүдийн алдааг өөрсдөдөө болон өөрсдийн гэрчлэлдээ хандах хандлагад маань ямар нэгэн байдлаар нөлөөлөхийг зөвшөөрдөг. Бусад хүмүүст тохиолдож буй хүнд хэцүү зүйлс нь бидний алдаа гаргах шалтаг биш юм.

Есдүгээрт: Бид алдаа гаргасан үедээ өөртөө хэтэрхий хатуу хандах нь жинхэнэ наманчлал хэрэгтэй үед хайхрахгүй өнгөрөхтэй адил сөрөг нөлөөг үзүүлдэг.

Аравдугаарт: Бид өөрсдөө хүлээн зөвшөөрсөн үед Христийн цагаатгал нь бүрэн дүүрнээр, байнга үйлчилдгийг мэдэх ёстой. Хэрэв ингэж чадвал бид үргэлжлүүлэн муу зуршлуудтайгаа тэмцэж, итгэл маань сулрах үед ч бүх зүйл зөвөөр шийдэгддэг.

Би үлгэр жишээч залуу найзууд болон хамтран ажиллагсдынхаа санаа бодол, хүч чадал, гэрчлэлүүдэд нь талархалтай байдаг. Би залуустай хамт байхдаа эрч хүчийг авдаг юм. Тэдний бусдын төлөө хийж байгаа сайн үйлс болон даган дуурайж, шүтэн биширдэг Эзэнийгээ төлөөлөн хийх үйлчлэлээс нь би урам зоригийг олдог.

Хүмүүс өөрт буй гэрчлэлийнхээ дагуу сайн бөгөөд чухал зүйлсийг үйлддэг. Бид түүнчлэн хийж буй зүйлээсээ гэрчлэлийг олж авдаг. Есүс, “Миний сургаал бол Минийх биш, харин Намайг Илгээгчийнх. Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсч байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ” (Иохан 7:16-17).

“Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” (Иохан 14:15) хэмээн сургасан билээ.

Эрт цагийн Нифай, Мормон нарын адилаар би “бүх зүйлүүдийн утгыг мэдэх нь үгүй” ч (1 Нифай 11:17; Мормоны Үгс 1:7) мэддэг зүйлээ та нартай хуваалцъя.

Бидний Тэнгэрлэг Эцэг Бурхан амьд бөгөөд бидэнд хайртай гэдгийг би мэднэ. Түүний бүхнээс онцгой Хүү Есүс Христ бол бидний Аврагч, Гэтэлгэгч бөгөөд өөрийн нэрээр нэрлэгдсэн Сүмийн тэргүүн нь гэдгийг мэднэ. Иосеф Смит өөртөө тулгарсан бүхнийг биеэр туулсан бөгөөд манай өнөө үед сэргээгдсэн сайн мэдээг хүндэтгэлтэйгээр заасан гэдгийг би мэднэ. Өнөө үед бид төлөөлөгч болон бошиглогчдоор удирдагддаг бөгөөд Ерөнхийлөгч Томас С.Монсон бидний амьдралыг адислах болон Их Эзэний ажлыг гүйцэлдүүлэх санваарын бүх түлхүүрүүдийг атгадгийг би мэднэ. Надад буй энэхүү мэдлэгийг олж авах эрх хүн бүрт байдаг бөгөөд хэрвээ танд аливаа асуудал байгаа бол энэхүү чуулганы индэр дээрээс сонсож буй гэрчлэлүүд бүгд үнэн гэдэгт итгээрэй. Энэ бүгдийг би мэдэх бөгөөд өөрийн гэрчлэлийг Есүс Христийн нэрээр үлдээж байна, амен.

Бямба гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Дур хүсэл

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Даллин Х.Өүкс

Дур хүсэл гэгч хэчнээн чухал болох талаар ярихаар би сонголоо. Бидний хүн нэг бүр өөрсдийгөө юунд дуртай болохыг тодорхойлж, дур хүслээ ач холбогдлоор нь зэрэглэхийн тулд зүрх сэтгэлээ шинжин судална гэдэгт би найдаж байна.

Дур хүсэл бидний эн тэргүүнд эрхэмлэдэг зүйлсийг, эн тэргүүнд эрхэмлэдэг зүйлс маань бидний сонголтуудыг тодорхойлдог бол сонголтууд нь бидний үйлдлийг төлөвшүүлдэг. Бид хэрхэн өөрчлөгдөж байгааг, хэр их амжилтанд хүрч байгааг болон ямархуу хүмүүс болж байгааг бидний дур хүсэл тодорхойлдог.

Эхлээд би нийтлэг тохиолддог зарим дур хүслийн тухай ярья. Бид сонголтууд болон зарим үйлдлийг маань тодорхойлдог бие махбодын хүсэлтэй байдаг. Бид зарим үед аль нэг хүслээ илүү чухал гэж үзсэн өөр нэг хүслээр дардагийг дараах гурван жишээнээс харж болно.

Нэгдүгээрт: Хоол хүнс. Хоолонд дурлах нь бидэнд төрөлхийн заяасан зүйл. Гэвч энэ дур хүслээ илүү хүчтэй хүсэл болох мацаг барих хүслээр дарж болно.

Хоёрдугаарт: Хоргодох байр. Би 12-той хөвгүүн байхдаа ойд шөнийг өнгөрүүлдэг Хөвгүүдийн Скаутын шаардлагыг хангах оргилуун хүсэлтэй байсан учир тохилог майханд унтах хүслээ тэвчиж чадсан юм. Би хэдэн хөвгүүдийн хамт тав тухтай майхнаа орхиод олдсон байгалийн материалуудаар толгой хоргодох оромж барьж, болхидуухан ор хийгээд хонож билээ.

Гуравдугаарт: Нойр. Байгалиас заяасан энэхүү хүслийг илүү чухал дур хүслээр түр зуур дарж болдог. Би Ютагийн Үндэсний Гвардид шинэхэн цэрэг байхдаа тулалдааны туршлагатай нэгэн офицерын үлгэр жишээнээс энэ тухай сурсан юм.

Солонгосын дайны эхний саруудад Ютагийн Үндэсний Гвардын Ричфиелд хэмээх хээрийн их бууны суман, цэргийн жинхэнэ албанд дайчлагджээ. Энэ суманг ахмад Рей Кокс командалж байсан бөгөөд 40 орчим мормон эрээс бүрдэж байв. Тэднийг бэлтгэл сургууль хийлгэж, чөлөөнд гарсан бусад цэргүүдээр хүч нэмэгдүүлж, Солонгос уруу явуулав. Тэд хамгийн ширүүн тулалдаануудад оролцсон юм. Тэд нэг тулалдаанд, жагсаалаас гаргасан дайсны хэдэн зуун явган цэргийн дайралтыг няцааж, хээрийн их бууны бусад суманг бут ниргэх ёстой болжээ.

Энэ үйл явдал унтах хүслийг даван туулахтай ямар холбоотой байв аа? Дайсны явган цэрэг тэдний эзэлсэн нутгийн ар талын фронтын шугамыг сэтлэн дайрсан нэгэн шөнө ахмад Кокс холбооны хэрэгслээ майхандаа оруулж, эргэн тойрон харуул гаргаж, байдлыг цаг тутам утсаар илтгэж байхыг тушаасан ажээ. Энэ нь тушаал авсан харуулуудыг сэрүүн байлгаж чадсан бөгөөд ахмад олон удаа сэрэх хэрэгтэй болжээ. “Та үүнийг яаж хийв ээ?” гэж би ахмадаас асуув. Түүний хариулт хүслээ даван туулах хүчийг харуулсан юм. Түүний хариултаас энд эш татъя:

“Бид гэртээ эргэж ирэхэд манай суманд байсан залуусаас хэн нэгэн нь ахмадынхаа алдаанаас болоод гэртээ эргэж ирээгүй бол хотынхоо гудамжинд эцэг эхтэй нь тааралдаад тэдний нүүрийг яаж харах юм бэ?”¹ гэж ахмад хэлсэн юм.

Илүү чухал зүйлийн төлөө хүслээ хазаарлан тэвчихийн ямар агуу жишээ вэ? Энэ бол бусдын сайн сайхан байдлын төлөө хариуцлага хүлээх үлгэр жишээ. Энэ бол эцэг эхчүүд, эмээ өвөө нар, Сүмийн удирдагчид болон багш нарын хувьд даган дуурайх жинтэй үлгэр жишээ мөн.

Шөнөжингөө нойр муутай хоносон ахмад Кокс маргааш өглөө нь эрт цэргүүдээ удирдан дайсны явган цэрэг уруу сөрөг довтолгоонд орсон юм. Тэд хоёр хүнээ шархдуулсан ч дайсны 800 гаруй цэргийг олзлон авсан. Кокс эрэлхэг зоригынхоо төлөө шагнуулж, суман нь онцгой баатарлаг гавьяаныхаа төлөө Ерөнхийлөгчийн Хүндэт Өргөмжлөл хүлээн авсан ажээ. Мөн тэд Хиламаны залуу дайчдын (Алма 57:25–26-г үз) адил бүгдээрээ гэртээ эсэн мэнд эргэж ирсэн юм. Гэвч энэ бол өөр түүх л дээ.²

Дур хүслийн ач холбогдлын талаар олон сургаал Мормоны Номонд байдаг.

Инос Их Эзэнээс олон цаг гуйсны дараа нүгэл нь уучлагдсан. Тэгээд тэр ах дүүсийнхээ аз жаргалын төлөөх “хүслийг мэдэрч эхэлжээ” (Инос 1:9). Тэрээр бичихдээ: “Мөн. . .

залбирч, мөн бүх хүчээрээ чармайн хөдөлмөрлөсний дараа Их Эзэн надад итгэлийн чинь учир, хүслийн чинь дагуу би чамд өгнө хэмээв” (шүлэг 12) гэсэн юм. Амлагдсан адислалд хүргэх 3 чухал нөхцөл болох хүсэл, хөдөлмөр, итгэлийг анхаарна уу.

Алма итгэлийн тухай номлолдоо “итгэх хүслээс илүү нь байхгүй ч гэсэн” бид “энэ хүслийг [өөрсөддөө] хөгжихийг хүссэнээр” (Алма 32:27) итгэл эхэлж болно гэдгийг заажээ.

Хүслийн тухай ялангуяа бидний хамгийн чухал хүсэл юун дээр төвлөрвөл зохих ёстойг номлогч Аароны леменчүүдийн хаанд заасан туршлагаас бид хардаг. Аароны заасан зүйлс хааны сонирхлыг татсан учраас хаан “Мөнх амьдралыг хүлээн авч болохын тулд . . . Бурханаар төрж болохын тулд би юу хийх билээ?” (Алма 22:15) гэж асуув. Аарон хариулсан нь: “Хэрэв та энэ зүйлийг хүсвэл, . . . хэрэв та бүх нүглүүдээ наманчилбал, мөн Бурханы өмнө доош бөхийвөл, мөн та хүлээн авах болно гэдэгтээ найдсаар итгэлтэйгээр түүний нэрийг дуудвал, тэгвэл та хүссэн тэрхүү найдварыг хүлээн авах болно” (шүлэг 16).

Хаан тийнхүү үйлдэж, “Би таныг мэдэхийн тулд . . . мөн эцсийн өдөр аврагдаж болохын тулд бүх нүглүүдээ орхих болно” (шүлэг. 18) хэмээн хүчирхэг залбирал өргөжээ. Тийнхүү өөрийн хүслийг илэрхийлж, амлалт өгснөөр түүний залбирал гайхамшигтайгаар хариулагдсан юм.

Бошиглогч Алма бүх хүнд наманчлалыг тунхаглах агуу хүсэлтэй байсан ч “Шударга Бурхан . . . тэдний хүслийн дагуу тэр нь үхэлд эсвэл амьдралд хүргэх байлаа ч түүнийг нь хүмүүнд зөвшөөрдөг” (Алма 29:4) гэсэн дүгнэлт хийсэн учраас албадлагын хүчийг хүсэх ёсгүй гэдгийг тэр ойлгожээ. Үүнтэй адил Их Эзэн орчин үеийн илчлэлтэнд Тэрбээр “бүх хүмүүнийг ажлуудынх нь дагуу, зүрх сэтгэлийнх нь хүслийн дагуу шүүх болно” (С ба Г 137:9) хэмээн мэдэгджээ.

Мөнхийн Шүүгч энэхүү агуу ач холбогдлыг бидний чинхүү хүсэл дээр төвлөрүүлэхэд бид жинхэнэ ёсоор бэлтгэгдсэн үү?

Олон сударт бидний хүсдэг зүйлийг бидний эрэлхийлдэг зүйлстэй уялдуулан өгүүлсэн байдаг. “Намайг шамдан эрэлхийлэх тэрээр намайг олох болно, мөн орхигдох нь үгүй” (С ба Г 88:83). “Хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийл” (С ба Г 46:8).

“Хичээнгүйлэн хайгч тэр олох болно” (1 Нифай 10:19). “Надад ойр байгтун мөн би та нарт ойр байх болно; намайг хичээнгүйлэн эрэлхийлэгтүн мөн та нар намайг олох болно;

асуу тэгвэл та нар хүлээн авах болно; тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно” (С ба Г 88:63).

Мөнхийн зүйлсийг эн тэргүүнд эрхэмлэхийн тулд дур хүслүүдээ өөрчлөх нь амаргүй юм. Бид өмч хөрөнгө, алдар нэр, бардамнал, эрх мэдэл хэмээх дэлхийн зүйлст уруу татагддаг. Бид эдгээр зүйлийг хүсч магадгүй, гэвч эдгээрийг бүх зүйлээс дээгүүрт тавих ёсгүй.

Өмч хөрөнгө олж авахыг хамгийн түрүүнд тавьдаг хүмүүс эд баялгийг шүтэх үзэлд урхидуулдаг. Тэд “баялгийг болон энэ дэлхийн хоосон зүйлсийг бүү эрэлхийл” (Алма 39:14; мөн Иаков 2:18-ыг үз) гэсэн сэрэмжлүүлгийг анхаардаггүй.

Алдар нэр, эрх мэдлийг хүсдэг хүмүүс эрэлхэг зоригт Ахмад Моронайн үлгэр жишээг дагах ёстой. Тэрбээр “захирах хүчний” төлөө эсвээс “дэлхийн нэр төрийн” (Алма 60:36) төлөө үйлчлээгүй юм.

Бид хүслээ хэрхэн хөгжүүлдэг вэ? Арон Ральстонд тохиолдсон явдал ганц нэг хүнд тохиолдож мэднэ. Энэ нь хүслийн тухай үнэтэй сургамж болдог. Ральстониыг Өмнөд Ютад алслагдсан зэлүүд хавцлаар аялж явахад нь 363 кг хүнд хад байрнаасаа гэнэт гулсаж, баруун гарыг нь даржээ. Тэр хаданд хавчуулагдсан гараа сугалж авах гэж таван өдөр ганцаараа тэмцсэн гэнэ. Тэгээд аргаа барж бууж өгөн, үхлээ хүлцэнгүйгээр хүлээх үлдээд байтал 3 настай нэг хүү түүнийг чиглэн гүйж ирэхэд тэр зүүн гар дээрээ хүүг өргөн авч яваа үзэгдлийг харжээ. Ральстон үүнийг ирээдүйн хүүгийнхээ тухай үзэгдэл гэдгийг ойлгоод, хүч тамир нь барагдахаас өмнө амиа аврахаар зориг шулуудав. Хаданд хавчуулагдсан гарынхаа хоёр ясыг хугалж, хутгаар баруун гараа тайрсан аж. Тэгээд хамаг хүчээ шавхан тусламж авахын тулд 8 км газар явган явжээ.⁴ Энэ бол сэтгэлийн зүйрлэшгүй их хүч тэнхээний үлгэр жишээ мөн!

Бидний ихэнхэд нь ийм ер бусын гай зовлон хэзээ ч тохиолдохгүй байж болох ч мөнхийн хувь тавилан өөдөө өсч хөгжихөд бидэнд саад учруулах сорилт бэрхшээл тохиолдож болно. Хэрэв бидний зөв шударга хүсэл хангалттай бат бөх байвал бид мөнхийн өсөлт хөгжилтөд саад учруулдаг донтолт болон бусад гэм нүглийн дарамтаас ангид байж, буруу юмсыг эн тэргүүний эрхэмлэх зүйл болгохоос сэрэмжилж чадна.

Зөв шударга хүсэл нь өнгөцхөн, хөнгөн хуумгай, түр зуурын шинжтэй байх ёсгүй, харин чин сэтгэлийн, гуйвшгүй, байнгын шинжтэй мөн Бошиглогч Иосефын дүрсэлснээр нүгэл үйлдэх аливаа хүслийг бүрмөсөн орхисон байх ёстойг бид санах хэрэгтэй.⁵ Энэ бол нэн хувийн шинжтэй шийдвэр юм. Энэ тухай Ахлагч Нийл А.Максвелл хэлсэн нь:

“Хүн ‘нүгэл үйлдэх хүсэлгүй’ болох гэдэг нь Бурханыг мэдэхийн тулд бүх нүглээ болон буруу хүслээ орхихоор эргэлт буцалтгүй шийдэх явдал юм. . . .

Тиймээс бидний юу хүсэх нь эцсийн эцэст бид ямар хүмүүс болох мөн мөнхийн амьдралд юуг хүлээн авахыг тодорхойлдог.”⁶

Нүгэл үйлдэх аливаа хүслээ орхих нь нэн чухал ч мөнх амьдрал үүнээс илүү ихийг шаарддаг. Бид мөнхийн хувь тавиландаа хүрэхийн төлөө мөнх хүмүүн болоход тавигддаг шаардлагуудыг хангах хүсэлтэй байж, зорилгоо биелүүлэхийн төлөө хичээх ёстой. Жишээ нь: мөнх хүмүүн тэдэнд буруу зүйл хийсэн бүх хүмүүнийг уучилдаг. Тэд бусдын аз жаргалыг өөрсдийнхөөсөө дээгүүрт тавьж, Бурханы бүх хүүхдүүдийг хайрладаг. Хэрэв эдгээр зүйлсийг хийх нь хэтэрхий хэцүү санагдвал дээрх чанаруудыг эзэмшиж, хүсэл бодолдоо Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг авахын тулд залбирах хүсэлтэй байх нь эхлэл юм. Бид “түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр түүний цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирах ёстойг” (Моронай 7:48) Мормоны Ном бидэнд заадаг билээ.

Эдүгээ гэрлэсэн болон гэрлээгүй бүх эрэгтэй, эмэгтэйчүүдэд онцгой чухал хүслийн тухай сүүлчийн жишээгээр хэлэх үгээ өндөрлөе. Бүх хүмүүс үүрд мөнхийн гэрлэлт хийлгэх хүсэлтэй байж, энэхүү гэрлэлтийн төлөө шаргуу хөдөлмөрлөх ёстой. Ариун сүмд гэрлэсэн хүмүүс энэхүү гэрлэлтээ хамгаалахын төлөө чадах бүхнээ хийх ёстой. Гэрлээгүй хүмүүс ариун сүмд гэрлэх хүсэлтэй байж, үүнийг эн тэргүүнд эрхэмлэх зүйлээ болгох хэрэгтэй. Залуучууд, ганц бие залуу хүмүүс гэрлэх болон үр хүүхэдтэй байхын ач холбогдлыг мушгин гуйвуулдаг, улс төрийн бодлогын хувьд зөв боловч үүрд мөнхийн ач холбогдлынхоо хувьд буруу үзэл баримтлалыг няцаах ёстой.⁷

Ганц бие эрчүүд ээ нэгэн эгчийн захидалдаа хөндсөн дараах асуудлыг эргэцүүлэн бодно уу, тэрээр “Бурханы зөв шударга охид зохистой ханиа зүрх сэтгэлээрээ хайдаг атал харин эрчүүд энэ тухайд харалган болж, бидний Тэнгэрлэг Эцэгийн сор болсон, гайхамшигтай охидыг хайж олон үүрдийн ханиа болгож, Их Эзэний ариун сүмд ариун гэрээнүүд хийж сахих нь тэдний үүрэг хариуцлага мөн эсэх тухайд эргэлздэг болжээ” гэж хэлсэн юм. Тэрээр захианыхаа төгсгөлд: “ХҮГ олон эрэгтэйчүүд болзож, цагийг хамтдаа хөгжилтэй өнгөрүүлэх хүсэлтэй ч эмэгтэй хүнд шийдвэртэй үгээ хэлээд гэрлэх хүсэл тэдэнд огт алга”⁸ гэжээ.

Зарим залуу эмэгтэйчүүд зохистойгоор гэрлэж, үр хүүхэдтэй болох хүслийг ажил мэргэжилтэй болох болон мөнх бус амьдралын бусад хүсэл сонирхлоос доогуурт тавьдаг

гэдгийг хэлээсэй хэмээн мөнхийн ханиа хайж байгаа зарим залуу эрчүүд надаас хүсч байгаа гэдэгт итгэлтэй байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль алинд нь мөнх амьдрал уруу хөтлөгч зөв шударга хүсэл хэрэгтэй.

Дур хүсэл бидний эн тэргүүнд эрхэмлэдэг зүйлсийг, эн тэргүүнд эрхэмлэдэг зүйлс маань бидний сонголтуудыг төлөвшүүлдэг бол сонголтууд нь бидний үйлдлийг тодорхойлдог гэдгийг санацгаая. Түүнээс гадна бид ямар хүмүүс болохыг, үнэнч найз, авьяаслаг багш эсвэл мөнх амьдралд тэнцэх хүн үү гэдгийг бидний үйлдэл, хүсэл таашаал тодорхойлдог.

Бүхнийг боломжтой болгосон Есүс Христ, Түүний хайр, сургаал болон цагаатгалын тухай би гэрчилж байна. Бид Түүнийг болон Түүний баяслын бүрэн дүүрнийг бусад бүх зүйлээс илүү ихээр хүсдэг байхын төлөө би залбирч байна. Есүс Христийн нэрээр, амен.

Эшлэл

1. Рей Кокстой Ютагийн Моунт Плезантад хийсэн ярилцлагын хувийн тэмдэглэлээс, 1985 оны 8-р сарын 1, 1953 оны орчим Ютагийн Провод түүний тэмдэглэл надад ирсэн юм.
2. Richard C. Roberts, *Legacy, The History of the Utah National Guard* (2003), 307–14-ийг үз (Ютагийн Үндэсний Гвардийн Холбоо, 2003); *The National Guardsman* (уг сэтгүүлийн 1971 оны 5-р сарын дугаарын ар талыг үз); “Miracle at Kap Yong: The Story of the 213th” (Southern Utah University уг киног гаргажээ, 2002).
3. Aron Ralston, *Between a Rock and a Hard Place* (Нью-Йорк, Atria Books, 2004)-ийг үз.
4. Арон Ральстон, *Between a Rock and a Hard Place*, 248-ыг үз.
5. *Teachings of the Presidents of the Church, Joseph Smith* (2007), 51-ийг үз.
6. Нийл А.Максвелл, “According to the Desire of Our Hearts,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 21-22
7. Жюли Б.Бек, “Teaching the Doctrine of the Family,” *Liahona and Ensign*, 2011 оны 3-р сар, 12–17-г үз.
8. 2006 оны 9-р сарын 14-ний өдрийн захидал.

Лиахона

2011 оны 5-р сар

Бямба гарагийн үдээс хойших хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Хайрын үйлчлэлээр баяр баясгаланг олох нь

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч М.Расселл Баллард

Ах эгч нар аа, Солт Лейкэд айлчилж ирсэн та бүхэн Солт Лейкийн Ариун Сүмийн Талбай дахь хаврын үзэсгэлэнт цэцэгсийн өнгө, анхилуун үнэрийг таалан баясах боломжийг алдахгүй гэдэгт би найдаж байна.

Хаврын улирал бидэнд Их Эзэн Есүс Христийн золиослол болоод Амилалт “бүх зүйл [Түүний] тухай гэрчлэхээр бэлтгэгдэж” (Моисе 6:63) буйг сануулан шинэ амьдрал, шинэ гэрлийг авчирдаг.

Энэ үзэсгэлэнт хаврын төрх, үүний илэрхийлэх найдварын бэлгэдлийн эсрэг тодорхой бус, ээдрээтэй, эмх замбараагүй ертөнц сөрөн зогсож байна. Боловсрол, ажил, хүүхдээ хүмүүжүүлэх, Сүмийн удирдлага ба дуудлагууд, ердийн үйл ажиллагаанууд зэрэг өдөр тутмын амьдралын маань хэрэгцээ, тэрчлэн өвчин эмгэг, гэнэтийн гай зовлонгоос ирэх зовиур болоод уй гашуу нь биднийг туйлдуулдаг. Бид эдгээр ээдрээтэй саад бэрхшээл болон сэтгэл санааны амар амгалан, аз жаргалыг мэдрэхэд саад болж буй эргэлзээ, итгэлгүй байдлаас өөрсдийгөө хэрхэн чөлөөлөх вэ?

Түүхэнд өгүүлдэгчлэн 1849 онд Калифорний алтны эрин үед Бостоны худалдаачин залууд тохиолдсон шиг зүйл бидэнд олон удаа тохиолддог. Залуу бүх хөрөнгөө зараад, ганц хүн даахааргүй том шижир алтаар дүүрэн байдаг гэж сонссон Калифорни уруу азаа туршихаар явжээ.

Тэсэн ядан хүлээсэн өдрийн төгсгөлд залуу эр шигшигч саваараа ус хутгаж авсан ч овоолсон бөөн чулуу л байв. Сэтгэлээр унаж, урам хугарсан эр арай гэж ганц өдрийг өнгөрөөж няцдагийн даваан дээр нэгэн туршлагатай алтны хайгуулчин түүнд “Хүү минь чи ч эндээс овоо их чулуу овоолжээ” гэжээ.

Залуу эр хариуд нь: “Энд алт алга. Би гэр уруугаа буцлаа” гэв.

Хөгшин хайгуулч овоолсон чулуу уруу нь дөхөн: “Хүүе ээ наана чинь алт байна шүү дээ. Чи зөвхөн хаанаас хайхаа л мэдэх хэрэгтэй” гэж хэллээ. Тэр хоёр чулуу аваад хооронд нь цохив. Чулууны хагархайгаас үйрмэг алт нарны туяанд гялалзсаар гарч ирлээ.

Гэтэл залуу эр хайгуулчийн бүсэлсэн түнтгэр савхин цүнхийг хараад: “Би ийм жижиг үйрмэгүүд биш харин таны цүнхэн дэх шиг цул алтыг л хайж байна даа” гэжээ.

Хөгшин хайгуулч цүнхээ залуу эр уруу сарвайхад дотор нь цул шижир алт байгаа гэж бодсон залуу яаран өнгийн хараад хөшсөн мэт болов. Цүнх үйрмэг алтаар дүүрэн байлаа.

Хөгшин хайгуулч түүнд: “Хүү минь, чи том шижир алт хайгаад завгүй байсаар үнэ цэнэтэй үйрмэг алтаар цүнхээ дүүргэхээ мартсан юм шиг байна даа. Жижиг үйрмэгүүдийг тэвчээртэй цуглуулсан минь надад агуу баялгийг авчирсан юм” гэжээ.

Энэ түүх Алма өөрийн хүү Хиламандаа: “Өчүүхэн мөн энгийн зүйлүүдээр агуу их зүйлүүд улиран авчрагддагийг мөн маш өчүүхэн аргаар Их Эзэн олон бодгалийн авралыг авчирдаг” (Алма 37: 6-7) хэмээн заасан сүнслэг үнэний жишээ юм.

Ах эгч нар аа, бид хэчнээн төвөгтэй болгох гэж хичээлээ ч Есүс Христийн сайн мэдээ энгийн билээ. Бид амьдралаа гадны нөлөөнд автуулахгүй, хамгийн чухал зүйлс дээрээ төвлөрүүлэн, энгийн байлгахыг хичээх ёстой.

Бидний амьдралд тодорхой байдал болоод зорилгыг авчрах сайн мэдээний энгийн атлаа үнэ цэнэтэй зүйлс юу вэ? Амьдралынхаа турш тэвчээртэйгээр цуглуулсан алт эцэстээ үнэт эрдэнэс болдогийн адил мөнхийн амьдралын бэлэг болон бидэнд ирэх сайн мэдээний үйрмэгүүд юу вэ?

Энгийн бөгөөд гүн утга учиртай, эрхэм ариун, Есүс Христийн сайн мэдээг бүхэлд нь хамруулсан нэг зарчим байдаг гэдэгт би итгэдэг. Хэрэв бид энэ зарчмыг бүх зүрх сэтгэлээрээ амьдралынхаа гол зарчим болгох аваас бид ариусан, цэвэршиж, Бурханы оршихуйд дахин хамтдаа амьдрах болно.

Аврагчаас нэгэн фарисай хүн “Багш аа, хууль дахь агуу тушаал нь аль вэ?” гэж асуухад:

“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн.

Удаах нь “Чи хөршөө өөрийн адил хайрла” (Матай 22:36--40) хэмээн Их Эзэн энэ зарчмын талаар хэлсэн билээ.

Хэрэв бид Бурхан болон Христийг бүх зүрх сэтгэл, оюун ухаанаараа хайрлах юм бол бид нинжин сэтгэл, үйлчлэлийн үйлдлээрээ дамжуулан өөрсдийн хөршөө Есүс Христийн хайрласны адил хайрлаж чадна.

Бид Тэнгэрлэг Эцэг болон Есүсийн адил бодож, мэдэрч, үйлдвэл Христийн цэвэр хайр болоод энэрэл нь биднийг хүрээлэн авдаг. Биднийг өдөөгч, зүрх сэтгэлийн хүсэл нь Аврагчийнхтай адил юм. Тэрбээр энэ хүслээ Цовдлуулахынхаа өмнөх өдөр Төлөөлөгчидтэйгөө хуваалцжээ:

Тэрбээр хэлсэн нь: “Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна. . .

“Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” (Иохан 13:34--35) гэжээ.

Аврагчийн өгүүлж буй хайр нь агуу хайр юм. Энэ нь том, баатарлаг үйлсээр бус харин нинжин сэтгэл ба үйлчлэлийн энгийн үйлдлүүдээр тунхаглагдсан.

Бусдад үйлчилж, бусдыг хайрлах олон янзын арга зам бий. Би та нартай цөөхөн хэдийг нь хуваалцъя.

Нэгдүгээрт: Энэрэл гэр орноос эхэлдэг. Гэр бүл бүрийн удирдамж болгох ёстой энгийн бөгөөд хамгийн чухал зарчим бол Их Эзэний “та нар хүмүүсийг өөрсдөдөө хэрхэн хандаасай гэж хүссэнээрээ л өөрсдөө ч тийнхүү тэдэнд ханд” (Матай 7:12) гэх алтан дүрмийг хэрэгжүүлэх явдал юм. Хэрэв та нар бодлогогүй эсвэл урам хугармаар үгсийг сонсдог байсан бол юу мэдрэх байснаа бод доо. Өөрсдийн үлгэр жишээгээр гэр бүлийнхээ гишүүдэд бие биеэ хайрлахыг заа.

Бусдад үйлчлэх боломжтой өөр нэгэн газар бол Сүм юм. Тойрог болон салбарууд маань бидний үг болон үйлдлүүдийг бие биеэ гэсэн сэтгэл уруу байнга дагуулдаг газар байх ёстой. Бие биедээ элэгсэг дотно хандаж, дэм ба урмын үгсийг бэлэглэж, нэг нэгнийхээ хэрэгцээг мэддэг байснаар бид тойргийн гишүүдийн дунд хайрын холбоог бий болгож чадна. Энэрэл байгаа газар хов жив буюу дэмий бүдүүлэг яриа байдаггүй.

Тойргийн гишүүд, насанд хүрэгчид болон залуучууд бусдын амьдралыг адислахын төлөө утга учиртай үйлчлэлд нэгдэх ёстой. Хоёрхон долоо хоногийн өмнө Хойд Америкийн өмнөд бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Наш “Сүнсэнд хүчтэй нэгэн нь сул доройдоо туслах” үүрэг даалгаврыг өгснөөр тэд олон зуун насанд хүрсэн болон залуу гишүүдийг аварсан. Хайр, үйлчлэлээр дамжуулан тэд нэг нэгээрээ эргэн ирж байна. Ингэх нь тусламж хүлээн авсан болон тусалсан хүмүүсийн хооронд бат бөх, мөнхийн холбоог бий болгодог. Асар олон үнэтэй дурсамжууд ийм үйлчлэлээс эхтэй байдаг.

Би Сүмийн удирдлагад үйлчилсэн 42 жилээ эргэн харахад хамгийн сэтгэлд хоногшсон дурсамжууд нь тойргийнхоо гишүүдтэй гачигдсан нэгэнд үйлчилж байсан үеүдтэй холбоотой байдаг.

Нэгэн жишээг дурдъя. Би бишопоор үйлчилж байхдаа тойргийнхоо гишүүдтэй гадасны хүмүүнлэгийн тусламжийн ферм дээр малын бордоо хадгалдаг газрыг цэвэрлэсэн юм. Энэ нь тийм ч таатай ажил биш байсан шүү! Олон жил сүмдээ ирээгүй нэгэн ахыг бид хамт үйлчлэл хийхийг хүссэн. Муухай үнэртэй дарсан бордооны зооринд бидэнтэй ярилцах үедээ мэдэрсэн хайр, нөхөрлөлийн ачаар тэр сүмдээ эргэн ирж хожим нь эхнэр, хүүхдүүдтэйгээ ариун сүмд лацдан холбогдсон. Үйлчлэлийн ачаар бидний нөхөрлөл түүний хүүхдүүд, ач зээг адисалсан төдийгүй одоо гуч нарыг нь ч адисалж байна. Тэдний олонх нь номлолд үйлчилж, ариун сүмд гэрлэн мөнхийн гэр бүлүүдийг өсгөн хүмүүжүүлж байна. Алтны жижиг үйрмэг буюу энгийн үйлдлээр агуу ажил бий болдог юм.

Үйлчилж болох гурав дахь газар бол бидний амьдарч буй орон нутаг. Бидний тусламж хэрэгтэй хүмүүст хүрч үйлчлэх нь хайр, энэрлийн тод илэрхийлэл юм. Та нарын олонх нь “тусламжийн гар” гэсэн нөмрөгийг нөмрөн, орон нутгаа хөгжүүлэхийн төлөө ядарч цуцашгүй ажилласан байгаа. Японы Сендай Гадасны залуу насанд хүрэгчид тухайн орон нутагт нүүрлэсэн аймшигт газар хөдлөлт, цунамигийн дараах нурангаас хүмүүсийг хайх үйлчлэлд үнэлж баршгүй хувь нэмэр оруулаад байна. Тоолж баршгүй олон үйлчлэх арга зам байдаг юм.

Чин сэтгэлийн энэрэл ба үйлчлэлээрээ дамжуулан бид үйлчилж байгаа хүмүүстэйгээ найз нөхөд болж чадна. Ийм нөхөрлөлүүдөөс тэд сайн мэдээнд үнэнч байдгийг маань илүү сайн ойлгодог ба Сүмийг илүү их мэдэх хүслийг олж авдаг.

Миний сайн найз Ахлагч Жозеф Вертлин энэ зарчмын хүчийн талаар дараах зүйлийг ярьсан.

"Нинжин сэтгэл нь алдар суугийн чанар юм. . .[Энэ] нь хаалгыг нээж, нөхөрлөлийг бий болгодог түлхүүр. Энэ нь зүрхийг зөөллөж, үүрд мөнхөд үргэлжлэх харилцааг бий болгодог" ("The Virtue of Kindness," *Ensign*, 2005 оны 5-р сар, 26) гэжээ.

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд үйлчлэх бас нэг арга зам бол номлол хийх юм. Бид зөвхөн бүрэн цагийн номлогч байснаар бус харин найз нөхөд, хөршийн хувьд тэдэнд номлож болно. Сүмийн ирээдүйн өсөлт зөвхөн танихгүй айлуудын хаалгыг тогшсоноор нэмэгдэх биш гишүүд бүрэн цагийн номлогчидтой хамт Бурхан болон Христийн хайраар дүүрэн байж, сүнсний энэрэнгүй үйлчлэлээр тусламж хэрэгтэй хүмүүст тусалснаар нэмэгдэх болно.

|
Ах эгч нар аа, бид үүнийг хийснээр тэд бидний чинхүү сэтгэл болоод хайрыг мэдрэх болно. Олон хүн бидний талаар мэдэхийг хүссэнээр Сүм өсөн өргөжиж, дэлхийг бүрхэх болно. Үүнд зөвхөн бүрэн цагийн номлогчид төдийгүй гишүүн бүрийн хүсэл хийгээд үйлчлэл шаардлагатай.

Бүх үйлчлэлдээ бид Ариун Сүнсний нөлөөг мэдрэх мэдрэмжтэй байх хэрэгтэй. Намуухан, зөөлөн дуу хоолой хэнд бидний тусламж хэрэгтэй бөгөөд бид тэдэнд туслахын тулд юу хийх хэрэгтэйг заах болно.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлэхдээ: “Бид хаант улсад бие биедээ үйлчлэх нь амин чухал зүйл. Тиймээс ихэвчлэн бидний үйлчлэлийн үйлдлүүд энгийн урам зориг өгөх эсвэл санаандгүй бяцхан тус байж болох юм. Энгийн үйлдлээс гайхамшигтай үр дүнгүүд урсан ирдэг!” (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* [2006], 82) гэжээ.

Мөн Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Хүн бүрд гачигдал тохиолддог. Тиймээс хүн бүр ямар нэгэн байдлаар хэн нэгэнд тусалж чадна. Бусдын төлөө үйлчлэлд өөрсдийгөө золиослохгүй аваас бидний амьдрал өчүүхэн зорилготой байх болно” (“What Have I Done for Someone Today?” *Liahona* 2009 оны 11-р сар, 85) гэж зөвлөсөн юм.

Ах эгч нар аа, өөрсдөдөө байлгахыг хүсч, эрэлхийлэх ёстой Тэнгэрлэг Эцэг ба Түүний Хайрт Хүүгийн хамгийн чухал мөн чанар бол энэрлийн бэлэг, “Христийн цэвэр хайр” (Моронай 7:47) гэдгийг би дахин тодруулж хэлэхийг хүсч байна. Энэ бэлэг нь бидний үйлчлэх чадварыг нэмэгдүүлдэг.

Бошиглогч Мормон энэ бэлгийн хамгийн чухал ач холбогдол хийгээд түүнийг хэрхэн хүлээн авахыг бидэнд заасан. Тэрээр: “Иймийн тул, хайрт ах дүүс минь, та нар Түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр Түүний цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө; та нар Бурханы хөвгүүд болж болохын тулд; Тэрбээр хүрч ирэхэд бид Түүнтэй адил байх болно, учир нь бид Түүнийг байгаагаар нь харах болно гэсний учир, бидэнд найдвар байж болохын тулд, Түүний цэврийн адил бид цэвэр болгогдож болохын тулд зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун” (Моронай 7:48) гэжээ.

Энгийн жижиг зүйлсээс агуу зүйлс улиран тохиодог юм. Олон жижиг үйрмэг алт нийлж үнэт эрдэнэс болдгийн адил бидний энэрэл ба үйлчлэлийн энгийн бөгөөд жижиг үйлдлүүд нь биднийг бие биеэ гэх тоолонд Тэнгэрлэг Эцэгээ гэсэн хайр, Их Эзэн Есүс Христийн ажилд өөрсдийгөө зориулах сэтгэл, амар амгалан, баяр баясгалангаар биднийг дүүргэх болно.

Улаан өндөгний буюу Христийн Амилалтын баяр ойртож байгаатай холбогдуулан хайр болон Аврагчийн цагаатгалын золиослолын төлөөх талархлаа орон гэртээ, сүм дээр, орон нутагтаа энгийн атлаа энэрэнгүй үйлчлэлийн үйлдлүүдээр ах эгч нартаа харуулцгаая. Энэ бүгдийн төлөө би Есүс Христийн нэрээр даруухан залбирч байна, амен.

Лиахона

2011 оны 5-р сар

Санваартны хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Дэлхийг Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх нь

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Нийл Л.Андерсен

Өнөө орой би 12-25 насны санваар атгагч ах нартаа хандан ярьж байна. Сүмийн удирдагчид бид та нарт санаа тавьж, та нарынхаа төлөө залбирдаг. Манай дөрвөн настай ач хүү дүүгээ хүчтэй түлхэж унагасан тухай түүхийг би нэгэнтээ хуваалцаж байсан. Уйлж байсан дүүг нь тайвшруулсны дараа миний гэргий ахаас нь “чи яагаад дүүгээ түлхэж байгаа юм бэ?” гэж асуухад, ач хүү маань эмээ рүүгээ хараад “эмээ уучлаарай. Би ‘Зөвийг сонго’ бөгжөө гээчихсэн учраас зөвийг сонгож чадахгүй байна” гэж хариулсан юм. Та нар зөвийг сонгохоор их хичээл зүтгэл гаргадгийг бид мэддэг. Бид та нартаа их хайртай шүү.

Та нар яагаад яг энэ цаг үед дэлхий дээр ирсэн талаараа бодож байсан уу? Та нар Адам Евагийн үед эсвэл Египетийг фараонууд захирч байсан үед аль эсвэл Мин эзэнт гүрний үед төрөөгүй. Харин Есүс Христийн эхний ирэлтээс 20 зууны дараах өнөө үед төрсөн. Энэ бол Бурханы санваар дэлхийд сэргээгдэж, Их Эзэн сүрлэгээр залран ирэхэд бэлтгэхээр Өөрийн мутрыг сунгаж дэлхийг бэлтгэж буй цаг үе билээ. Энэ бол агуу их боломж хийгээд чухал хариуцлагатай цаг үе юм. Энэ бол та нарын өдрүүд шүү.

Баптисм хүртсэнээр та бүгд Есүс Христэд итгэх итгэлээ тунхагласан. Санваарт томилогдсоноор авьяас чадвар болон сүнслэг байдал чинь нэмэгдсэн. Та нарын чухал үүргийн нэг бол Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд дэлхийг бэлтгэх явдал мөн.

Их Эзэн санваартны үйл хэргийг удирдуулахаар бошиглогч Ерөнхийлөгч Томас С.Монсонг томилсон юм. Ерөнхийлөгч Монсон та нарт хандаж “Их Эзэнд номлогчид

хэрэгтэй байна”¹ хэмээн хэлсэн. “Зохистой мөн үйлчлэх боломжтой бүх залуу эрэгтэй номлолд үйлчлэхээр бэлтгэх ёстой. Номлолын үйлчлэл бол санваарын үүрэг бөгөөд энэ бол Их Эзэний шаардлага билээ.”²

Номлолын үйлчлэл нь золиослолыг шаарддаг. Бошиглогчоос үйлчлэлийн дуудлагыг хүлээн авахын тулд та нар ямар нэг зүйлийг зайлшгүй орхих хэрэгтэй болно.

Рагби гэдэг спортыг сонирхогчид Шинэ Зеландын Оол Блакс буюу Тас хар багийг андахгүй. Уг нэр нь тэдний өмсгөлөөс нь үүдэлтэй бөгөөд рагбигийн хамгийн алдартай баг юм.³ Шинэ Зеландад “Оол Блакс” багт тоглохоор сонгогдоно гэдэг нь америк хөл бөмбөгийн аварга багт тоглох эсвэл хөл бөмбөгийн дэлхийн цомын төлөө тоглох багт тоглохтой адил юм.

Сидни Гөинг ах 1961 онд 18 настай Аароны санваартан байхдаа Шинэ Зеландын рагбигийн од болж эхэлсэн. Тэр маш чадварлаг тоглогч байсан учир олон хүн түүнийг дараа жил үндэсний “Оол Блакс” шигшээ багт сонгогдоно гэж таамаглаж байв.

Мэргэжлийн рагбигийн зиндаа ахих чухал мөчид 19 настай Сид рагбиг орхиж номлолд явна гэдгээ мэдэгсэн юм. Зарим хүн түүнийг “галзуурсан” зарим нь түүнийг “тэнэг” гэж байлаа.⁴ Тэд ийм алтан боломж ахиж хэзээ ч ирэхгүй хэмээн халаглаж байсан.

Сидийн хувьд орхих зүйл нь биш харин ирээдүйн боломж үүрэг хариуцлага нь чухал байсан юм. Тэр Их Эзэн Есүс Христийн үнэнийг тунхаглахаар амьдралынхаа хоёр жилийг зориулах санваартны үүрэгтэй байсан. Энэхүү үүргээ биелүүлэхэд нь юу ч, бүр үндэсний шигшээ багт тоглон нэр хүндтэй болох ч түүнийг зогсоогоогүй билээ.⁵

Тэрээр Канадын Баруун Номлолд үйлчлэх дуудлага хүлээн авч, одоогоос яг дөчин найман жилийн өмнө энэ сард 19 настай Ахлагч Сидни Гөинг Шинэ Зеландыг орхиж Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогч болж байлаа.

Номлолдоо тохиолдсон нэг түүхийг Сид надад ярьж билээ. Орой болж хамтрагчтайгаа гэр уруугаа харих үедээ дахиад нэг айлаар орохоор шийдэв. Гэрийн эзэн тэднийг гэртээ урихад ахлагч Гөинг болон хамтрагч нь тэдэнтэй Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцжээ. Номлогчид тэдэнд Мормоны Ном бэлэглэв. Гэрийн эзэн Мормоны Номыг шөнөжингөө уншсан бөгөөд 10 хоногийн дотор Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт

Сувдыг уншиж дуусгажээ. Хэдэн долоо хоногийн дараа гэр бүлээрээ баптимс хүртсэн гэнэ.⁶

“Оол Блакс” багийн оронд номлолыг сонголоо гэж үү? хэмээх асуултанд Сидни: “Бусдыг сургаалд авчирснаас ирэх адислал нь ямар ч золиосоос илүү байдаг” гэж хариулсан ажээ.⁷

Сид Гөингийн номлолын дараа юу болсон талаар та нар сонирхож байгаа байх л даа. Хамгийн чухал нь тэрээр хайрт Коллийнтэйгээ гэрлэж, таван сайхан хүүхэдтэй, олон ач зээ нартай болсон. Тэрээр амьдралынхаа турш Тэнгэрлэг Эцэгт итгэн найдаж, зарлигуудыг нь дагаж, бусдад үйлчилжээ.

Харин рагбигийн тухайд гэвэл номлолынхоо дараа Сид “Оол Блакс”-ийн түүхэн дэх хамгийн агуу тоглогчдын нэг болж 11 улирал тоглосон бөгөөд олон жил багийн ахлагчаар тогложээ.⁸

Сидни Гөинг хэр зэрэг сайн тоглогч байсан юм бол? Тэрээр үнэхээр сайн байсан учир түүнийг ням гарагт тоглохгүй гэхэд нь бэлтгэл болон тэмцээний хуваарийг түүний цагт тохируулан өөрчилж байжээ.⁹ Тэрээр үнэхээр сайн байсан тул Английн Хатан Хаан түүний рагбид оруулсан хувь нэмрийг нь үнэлжээ.¹⁰ Тэрээр үнэхээр гарамгай байсан болохоор түүний тухай “Супер Сид” хэмээх ном хүртэл бичигдсэн аж.

Энэхүү нэр хүнд болон амжилт Сидийн номлолын дараа ирээгүй бол яах байсан бол? Энэ Сүмийн номлолын үйлчлэлийн нэгэн гайхамшиг бол Сид болон түүнтэй адил мянга мянган номлогч “Би номлол хийснээрээ юу авах вэ?” гэх биш “Би юу өгч чадах вэ?” гэж асуудагт байгаа юм.

Та нарын номлол бол хүмүүсийг Христэд авчирч “Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд”¹⁰ бэлтгэх ариун үйлс байх болно.

Их Эзэн Хоёр дахь Ирэлтийн өмнөх бэлтгэлийн талаар эрт үеэс ярьсаар ирсэн. Енохд Тэрээр тунхаглахдаа: “Мөн зөв шударга ёсыг тэнгэрээс доош би илгээх болно; мөн ... дэлхийгээс үнэнийг би илгээх болно ... миний сонгогдсон хүмүүсийг дэлхийн дөрвөн зүгээс цуглуулахын тулд миний илгээх зөв шударга ёс хийгээд үнэн нь дэлхийг үер мэт арчих болгоно би”¹¹

Бошиглогч Даниел хожмын өдрүүдэд сайн мэдээ “хүний гар хүрэлгүйгээр уулнаас цавчигдсан чулуу” мэт өнхрөн дэлхийн өнцөг булан бүрт хүрнэ хэмээн бошиглосон.¹² Нифай хожмын үе дэх Сүм тоогоор цөөн боловч дэлхийн нутаг дэвсгэр даяар тархсан байх тухай хэлжээ.¹³ Энэ эрин үед Их Эзэн “Мөн та нар миний сонгосон хүмүүсийн цугларалтыг тохиолгон авчрахаар дуудагдсан билээ”¹⁴ гэж хэлсэн юм.

Залуу ах нар минь, та нарын номлол бол онцгой их боломж бөгөөд амлагдсан цугларалт болон та нарын мөнхийн зорилготой холбоотой үүрэг хариуцлага мөн билээ.

Сэргээлтийн эхэн үеэс ах нар сайн мэдээг тунхаглах үүргээ маш хариуцлагатай биелүүлсээр байгаа. 1837 он буюу сүм байгуулагдсанаас хойш дөнгөж долоохон жилийн дараа ядуурал болон эсэргүүцэлтэй тулгарч байсан хэцүү үед номлогч нар сургаалыг заахаар Английг зорьжээ. Дараагийн хэдхэн жилд Австри, Францын Полинез, Энэтхэг, Барбадос, Чили, Хятад зэрэг орнуудад сургаалыг тунхаглаж байв.¹⁵

Их Эзэн энэ ажлыг адисалж Сүм дэлхий даяар өргөжин тэлсээр байна. Энэ чуулган дэлхийн 92 хэл дээр орчуулагдан цацагдаж байгаа. Бид дэлхийн 150 гаруй оронд үйлчилж буй 52,225 бүрэн цагийн номлогчид баяр хүргэн талархаж байна.¹⁶ Аврагчийг гэрчилж буй дуулгавартай номлогчид дээр нар хэзээ ч жаргадаггүй. Их Эзэний сүнсээр адислагдан, “Түүгээр хүмүүний үрсэд аврал ирж чадах тэр нэгээхэн ч өөр нэр өгөгдөхгүй, басхүү нэгээхэн ч өөр зам, мөн нэгээхэн ч арга үгүй бөгөөд зөвхөн Төгс Хүчит Их Эзэн, Христийн нэрээр буюу” хэмээн тунхаглаж буй эдгээр 52,000 гаруй номлогчийн сүнсний хүч чадлыг та нар бодож үзээрэй.¹⁷ Мөн бүх чадлаараа үйлчилсэн мөн одоо ч үйлчилсээр буй мянга мянган буцаж ирсэн номлогчдод бид талархлаа илэрхийлэхийг хүсч байна. Их Эзэний номлогч нараар дамжуулан хийж буй үйлс нь дэлхийг Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Номлолын үйлчлэл бол сүнслэг ажил юм. Зохистой байдал болон бэлтгэл маш чухал. Ерөнхийлөгч Монсон хэлэхдээ: “Залуу эрэгтэйчүүд ээ, би та нарыг номлолын үйлчлэлд бэлтгэхийг уриалж байна. Өөрсдийгөө Их Эзэнийг төлөөлөхүйц цэвэр ариун бөгөөд зохистой байлгаарай”¹⁸ гэсэн юм. Номлолд гарахаас өмнө та нарт ариун үүрэг, даалгавар

байгаа гэдгийг санагтун. Номлолоос өмнө хийж байсан үйлс чинь номлолын үед байх санваарын хүч чадалд чинь ихээр нөлөөлөх болно. Өөрсдийгөө сайн бэлтгээрэй.

Ерөнхийлөгч Монсон “Зохистой, боломжтой бүх залуу эрэгтэйчүүд номлолд үйлчлэхээр бэлтгэх ёстой”¹⁹ гэж хэлсэн. Эрүүл мэнд болон бусад шалтгааны улмаас зарим хүмүүс үйлчлэх боломжгүй байж магадгүй. Эцэг эх болон бишоптойгоо ярилцсанаар үйлчилж чадах эсэхээ мэдэж болно. Хэрвээ үйлчлэх боломжгүй бол энэхүү гайхамшигт ажилд хувь нэмэр оруулж чадахгүй нь гэж бүү санаа зов. Их Эзэн өөрийг нь хайрладаг хүмүүст энэрэнгүй бөгөөд Тэр та нарт бусад боломжуудыг олгох болно.

Зарим гишүүн өөрийгөө үйлчлэхэд оройтсон гэж боддог байж болох юм. Миний нэг хятад найз 20 нэлээд гарсан хойноо Камбожид Сүмийн гишүүн болсон юм. Тэрээр номлол хийх эсэх талаар бодсон бөгөөд бишоптойгоо уулзан залбирсны дүнд Нью Йорк хотод үйлчлэхээр дуудагдсан билээ. Хэрвээ таны нас оройтсон мэт санагдаж байвал залбирч, бишоптойгоо уулзан зөвлөөрөй. Тэр таныг хөглөх болно.

Бүх номлогчийн тавин хувь нь эх орондоо үйлчилдэг. Их Эзэн: “тэрхүү өдөр хүн болгон сайн мэдээний бүрэн байдлыг төрөлх хэл дээрээ, мөн өөрийн хэлээр сонсох болно”²⁰ гэж амласан. Та нар бошиглолын суу билгээр хамгийн их хэрэгтэй байгаа газар дуудагдах болно.

Би дэлхий даяарх номлогчидтой уулзах дуртай. Саяхан би Австралийн Сидней номлолд намайг хэнтэй таарсан гэж бодож байна? Шинэ Зеландын рагбигийн домогт тамирчин – Ахлагч Сидни Гөинг. Тэр одоо 67 настай бөгөөд дахин номлогч болсон байв. Харин энэ удаа өөрийнхөө сонгосон хамтрагч буюу эхнэр Систер Коллийн Гөингтэй хамт байсан юм. Тэр бидэнд хичээл заасан гэр бүлийнхээ талаар ярив. Тэдний эцэг эх нь сүмийн гишүүн байсан боловч сүмд идэвхгүй болоод олон жил болсон байв. Гөинг ах эгч хоёр тэдний итгэлийг эргэн бадраахад нь тусалсан юм. Баптисмын усан сангийн дэргэд эцэг нь ууган хүүдээ баптисм хүртээхэд нь мөн тэр ууган хүү нь санваарыг хүртэж, дүүдээ баптисм хүртээн, гэр бүлээрээ хамтдаа мөнх амьдралын төлөө урагшилж байгааг нь хараад ямар их баяр баяслыг мэдэрч байгаагаа Гөинг ах хуваалцсан.²¹

Та нарт хандан Тэргүүн зөвлөлөөс хэлэхдээ: “Та нар бол хариуцлага, боломж түүнчлэн уруу таталтын энэхүү агуу цаг үед төрөхөөр сонгогдсон сүнснүүд юм. Бид та нарын төлөө, ... Өмнөө байгаа агуу ажлыг хийхийн тулд [мөн] Бурханы хаант улсыг барих үүрэг хариуцлагуудаа үргэлжлүүлэн биелүүлж Аврагчийн Хоёр дахь Ирэлтэнд дэлхийг бэлтгэхэд зохистой байгаасай гэж бид залбирч байна” гэсэн билээ.²²

Би зураач Харри Андерсоны Аврагчийн Хоёр дахь Ирэлтийг дүрсэлсэн зурагт дуртай. Энэ нь Түүнийг хүч чадал хийгээд алдар сууд залран ирэхийг надад сануулдаг. Дэлхий дээр болон тэнгэрт гайхамшигт үйл явдлууд тохиох болно.²³

Аврагчийн ирэлтийг хүлээж буй хүмүүс “Түүнийг эрэх” болно. Тэр “Бибээр ирэх болно” гэж амласан. Зохистой хүмүүс Түүнийг “тэнгэрийн үүлэн дотор сүр хүч хийгээд агуу алдар суунд, бүх ариун тэнгэр элчүүдийн хамт үзэх болно.”²⁴ “Тэнгэр элч бүрээгээ үлээх болно ... мөн дэлхий дээрх гэгээнтнүүд [дэлхийн дөрвөн зүгээс]²⁵ түүнийг угтахаар дээш аваачигдах болно.”²⁶ “Мөн нойрсон гэгээнтнүүд” буюу зохистой амьдарч нас барсан гэгээнтнүүд, “[Түүнийг] угтахаар урагш гарч ирэх болно.”²⁷

Сударт мөн ийн өгүүлсэн байдаг: “Их Эзэн хөлөө уулан дээр тавих болно”²⁸ мөн “[Тэр] дуу хоолойгоо илэрхийлэх болно, мөн дэлхийн бүх хязгаарууд үүнийг сонсох болно.”²⁹

Санваартан залуу ах нар аа, би энэхүү гайхамшигт Ирэлтийн алдар суу хийгээд бүхнээс илүүгээр үүний бодит байдлыг гэрчилж байна. Аврагч амьд. Тэр дэлхийд эргэн ирэх болно. Хөшигний аль ч талд байсан та бид Түүний Ирэлтэд баясаж, Түүний Ирэлтийн өмнө дэлхийг бэлтгэхэд туслахаар өнөө үед биднийг дэлхийд илгээсэн Их Эзэнд талархах болно. Есүс Христийн нэрээр, Амен.

Эшлэл

1. Томас С.Монсон, “Их Эзэнд номлогч нар хэрэгтэй,” *Лиахона*, 2011 оны 1-р сар.

2. Томас С.Монсон, “Бид дахин хамтдаа уулзахад,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 5-6.
3. stats.allblacks.com-ыг үз.
4. Боб Хеуит, “Super Sid: The story of a great All Black,” (1978), 27-г үз.
5. Шинэ Зеландын Кайкохе гадасны ерөнхийлөгч Максвелл Хорсфордтой утсаар ярьсан яриа, 2011 оны 3 сар.
6. Ахлагч Сидни Гөингтой утсаар ярьсан яриа, 2011 оны 3 сар.
7. Ахлагч Сидни Гөингтой харилцсан и-мэйлүүд, 2011 оны 3 сар.
8. stats.allblacks.com/asp/profile.asp?ABID=324-ийг үз.
9. Шинэ Зеланды Кайкохи гадасны ерөнхийлөгч Максвелл Хорсфордтой утсаар ярьсан яриа, 2011 оны 3-р сар
10. 1978 онд Сид Гөингийн рагби спортод гаргасан хувь нэмрийг нь үнэлж Британийн Эзэнт гүрний одонт гишүүн болжээ. (Ховитын “*Super Sid 265*” -г үз)
11. Моце 7:62.
12. Даниел 2:45.
13. 1 Нифай 14:12–14–ийг үз.
14. Сургаал ба Гэрээ 29:7.
15. Deseret News *2011 Church Almanac*, (2011), 430, 432, 458, 463, 487, 505.

16. 2010 оны 12 сарын 31-ний байдлаар.

17. Мозая 3:17.

.

19. Томас С.Монсон, *Лиахона*, 2010 оны 11-р сар, 5--6.

20. Сургаал ба Гэрээ 90:11.

21. Сидней Гөингтэй утсаар ярилцсан яриа, 2011 оны 3-р сар

22. “Тэргүүн Зөвлөлийн захиас,” *Залуучуудын баг бөх байдлын төлөө: Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь*, (товхимол, 2001), 2--3.

23. Сургаал ба Гэрээ ; 43:18; 45:40.

24. Сургаал ба Гэрээ 45:44.

25. Сургаал ба Гэрээ 45:45; 46.

26. Сургаал ба Гэрээ 88:96.

27. Сургаал ба Гэрээ 45:45; мөн Сургаал ба Гэрээ 29:13; 88:96—97 г үз.

28. Сургаал ба Гэрээ 45:48.

29. Сургаал ба Гэрээ 45:49.

Лиахона

2011 оны 5-р сар

Санваартны хуралдаан

2011 оны 4-р сарын 2

Найдвар

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн

Ахлагч Стивен Э.Снөү

Би Өмнөд Ютагийн өндөрлөг зэлүүд нутагт өссөн юм. Бороо бараг ордоггүй байсан болохоор зуны аагим халуунд бороо орохыг ёстой л өдрийн бодол, шөнийн зүүд болгон хүлээнэ. Би тэр үед одоогийнх шигээ бороо ороосой гэж найдан хүлээж, залбиран, цөхөрсөн үедээ мацаг барьдаг байлаа.

Тэнд 5 настай ач хүүтэйгээ хотоор зугаалахаар шийдсэн нэгэн өвгөний тухай түүхийг ярилцдаг. Тэд явсаар хийжүүлсэн хүйтэн ундаа авахаар төв гудамжны нэгэн мухлагт иржээ. Өөр мужаас яваа машинтай хүмүүс мухлагийн гадаа зогсоод, жолооч нь өвгөн уруу дөхөн ирж, тэнгэр дэх жижигхэн үүл уруу зааж, “Та юу гэж бодож байна, бороо орох болов уу?” гэхэд

“Би ч орно гэж найдаж байна шүү. Үүнийг би өөрөө хүссэн юм биш ач хүүдээ л үзүүлэх юмсан. Би ч бороо үзсэн хүн” гэж өвгөн хариулжээ.

Найдвар нь бидний өдөр тутмын амьдралыг баялаг сайхан болгодог сэтгэл хөдлөл бөгөөд энэ нь “бүгд сайхан болно гэдэг мэдрэмж”-ээр илэрдэг. Найдвар нь “хүсэл эрмэлзлэлтэйгээр, итгэх үндэслэлтэйгээр тэсэн ядан хүлээхэд биднийг хүргэдэг” хэмээн толь бичигт тайлбарласан байдаг (dictionary.reference.com/browse/hope). Тиймээс найдвар нь ирээдүйн үйл явдлуудыг итгэлтэйгээр хүсэн хүлээхэд хүргэж, бидний амьдралд тайвшруулагч нөлөөг авчирдаг.

Заримдаа бид багахан эсвэл огт боломжгүй зүйлд найдвар тавин хүлээдэг. Бид цаг агаар сайжирна, эрт хавар болно гэж найдан хүлээдэг. Бидний дэмждэг спортын баг Дэлхийн Хөл Бөмбөгийн Аваргын эсвэл Америкийн хөл бөмбөгийн болон сагсан бөмбөгийн Аварга шалгаруулах тэмцээний Цом авна гэж бид найддаг.

Ийм найдвар нь бидний амьдралыг сонирхолтой болгож, ер бусын, санаанд оромгүй зан төлөв уруу олонтаа хөтөлдөг. Жишээ нь: манай хадам аав сагсан бөмбөгийн хорхойтон. Тэр хайртай багийнхаа тоглолтыг зурагтаар үзэхгүй бол баг нь ялна гэдэгт итгэдэг хүн. Би 12-той байхдаа Америкийн Идэрчүүдийн Лигийн бэйсболын багийг дэмждэг байсан бөгөөд би оймсоо угаалгүй өмсвөл миний хайртай баг ялна гэж найддаг байж билээ. Харин ээж минь дургүйцэн оймсыг маань байшингийн арын довжоон дээр хадгалдаг байв.

Заримдаа бидэнд найдвар сүнслэгээр нөлөөлж, үйлдэл хийхэд түлхэц үзүүлж мөрөөдөл уруу минь хөтөлж болно. Хэрэв бид сурлагаа сайжирна гэдэгт найдах юм бол биеэ дайчлан суралцаж, золиослол хийснээр биелэх болно. Хэрэв бид ялагч багт тоглохыг хүсвэл байнгын дасгал сургуулилт хийж, бие сэтгэл бүхнээ зориулж, багаараа хамтарч ажиллах хэрэгтэй бөгөөд ингэснээр бид амжилтад хүрэх болно.

Рожер Баннистер бол ихийг бүтээх хүсэл эрмэлзэлтэй, Англи дахь анагаах ухааны коллежийн оюутан. Тэрбээр 1.6 километрийг дөрвөн минутад туулсан анхны хүн болохыг хүсдэг байв. 20-р зууны эхний хагаст хүмүүс хөнгөн атлетикийн спортыг ихэд сонирхох болж, 1.61 километрийг дөрвөн минутад туулж, дээд амжилтыг эвдэх өдрийг тэсч ядан хүлээж байлаа. Он жилүүд өнгөрөх тутам олон гарамгай тамирчид тэр амжилтад дөхөж очсон ч хэн ч энэ амжилтад хүрч чадсангүй. Баннистер дэлхийн шинэ дээд амжилт тогтоох зорилгоо биелүүлэх итгэл найдвараар жигүүрлэн, өндөр зорилготой дасгал сургуулилтын хуваарь гаргаж мөрдөн биеэ бүрэн дайчилж ажилласан байна. Спортын зарим хорхойтнууд дөрвөн минутын дээд амжилтыг эвдэж чадах эсэхэд эргэлзэж эхэлсэн ажээ. Мэргэжилтнүүд ийм зайг ийм хурдаар гүйх физиологийн боломж хүний биемахбодод байхгүй гэсэн таамаглал дэвшүүлэх болов. Рожер Баннистерын агуу найдвар 1954 оны 5-р сарын 6-ны үүлэрхэг тэр нэгэн өдөр биелэгдэх нь тэр! Тэрбээр 3 минут 59.4 секундэнд барианы шугамыг алхаж, дэлхийн шинэ дээд амжилт тогтоожээ. Түүний дээд амжилтыг эвдэх итгэл найдвар, хүсэл мөрөөдөл, уйгагүй дасгал сургуулилт, нөр хичээнгүй хөдөлмөр, бие сэтгэл бүхнээ зориулсны ачаар биелэгдсэн юм.

Найдвар нь бидний мөрөөдөлд сүнслэгээр нөлөөлж, тэрхүү мөрөөдлөө биелүүлэхэд урам дэм хайрладаг билээ. Гэвч найдвар дангаараа биднийг амжилтанд хүргэдэггүй. Биелэгдээгүй олон сайхан найдварыг саад тотгор, залхууралтай тулгарч сүйрсэн хөлөг онгоцтой зүйрлүүлж болно.

Эцэг эхчүүд бид хүүхдүүддээ хамгийн эрхэм нандин итгэл найдвараа хүлээлгэдэг. Хүүхдүүд маань хариуцлагатай, зөв шударга амьдрахын төлөө өсч хүмүүжнэ гэж бид найддаг. Хэрэв бид сайн үлгэр дууриал үзүүлэхгүй бол найдвар минь нурж унах болно. Бид үр хүүхдээ дан ганц итгэл найдвараар зөв шударга хүн болон өсч хүмүүжнэ гэдэгт найдаж болохгүй. Бид гэр бүлийн үдэш болон бусад үр өгөөжтэй гэр бүлийн үйл ажиллагаануудыг хүүхдүүдтэйгээ хамт хийх ёстой. Бид хүүхдүүддээ хэрхэн залбирахыг зааж, судраас уншин, сайн мэдээний зарчмуудыг заах ёстой. Ингэснээр хүүхдүүдээсээ хүсэх бидний эрхэм нандин найдвар биелэгдэх болно.

|

Итгэл найдвар цөхрөлөөр солигдохыг бид хэзээ ч хүлцэх ёсгүй. Бид “найдлага дотор газар хагалах ёстой” (1 Коринт 9:10) гэж Төлөөлөгч Паул бичсэн байдаг. Найдвартай байх нь бидний амьдралын чанарыг дээшлүүлж, ирээдүйгээ харахад тусалдаг. Хожмын Үеийн Гэгээнтнүүд бид тариа тарихын төлөө эсвэл амьдралаа авч явахын төлөө газар хагаллаа гэхэд заавал итгэл найдвартай байх нь чухал юм.

Есүс Христийн сайн мэдээн дэх найдвар нь Түүний дагалдагчид Аврагчийн Цагаатгалаар дамжуулан үүрд мөнхийн авралыг олох чин хүсэл юм.

Энэ бол үнэхээр бидэнд байх ёстой найдвар юм. Энэ бол биднийг бусдаас онцгой ялгаатай болгодог зүйл. “Та нарын доторх найдварын талаар асуух хүн бүрд хариу өгөхөд ямагт бэлэн бай” (1 Петр 3:15) гэж Петр Христийн анхны дагалдагчдад зөвлөсөн байдаг.

Цагаатгалд итгэх бидний итгэл үүрд мөнхийн хүч боломжуудыг нээж өгдөг. Ийм боломжууд нь зөвхөн энэ амьдралын төдийгүй ирэх амьдрал дахь үүрд мөнхийн үйл явдлуудыг угтан харах боломжийг бидэнд олгодог. Нийгэм байнга өөрчлөгдөж байгаа өнөө үед бид явцуу хүрээнд баригдах ёсгүй. Бид гэр бүл, хайртай хүмүүстэйгээ лацдан холбуулж, селестиел алдар сууг чөлөөтэйгөөр хүсэн хүлээх ёстой.

Сайн мэдээнд найдвар нь итгэл, энэрэлтэй үргэлж холбоотой байдаг. Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф ийн заасан юм:

“Найдвар бол гурван хөлтэй сандлын нэг хөл юм. Нөгөө хоёр хөл нь итгэл ба энэрэл мөн. Зарим үед саад бэрхшээл тохиолдож болох хэдий ч энэ гурван зүйл бидний амьдралыг тогтвортой болгодог (“The Infinite Power of Hope,” *Liahona*, 2008 оны 11-р сар, 21).

Мормоны Номын сүүлчийн бүлэгт Моронай ийн бичсэн байдаг:

“Иймийн тул, итгэл байх учиртай; мөн хэрэв итгэл байх ёстой аваас түүнчлэн найдвар байх ёстой; мөн хэрэв найдвар байх ёстой аваас, түүнчлэн энэрэл байх учиртай.

“Мөн та нар энэрэлтэй байхгүй аваас Бурханы хаант улсад та нар яавч аврагдаж чадахгүй; бас хэрэв та нар итгэлгүй аваас Бурханы хаант улсад аврагдаж чадахгүй; хэрэв та нар найдвар үгүй аваас мөн чадахгүй” (Моронай 10: 20–21).

Ахлагч М.Рассел Нелсон, “Итгэл нь Есүс Христэд суурилдаг. Найдвар нь Цагаатгал дээр төвлөрдөг. Энэрэл нь ‘Христийн цэвэр хайраар’ харагддаг. Энэ гурван чанар нь хоорондоо сүлжилдэн холбогдсон, салгаж болдоггүй кабелийн утаснуудтай адил юм. Биднийг энэ гурван зүйл хамтдаа селестиел хаант улс уруу хөтлөх болно” хэмээн сургажээ (“A More Excellent Hope,” *Ensign*, 1997 оны 2-р сар, 61).

Нифай цэдгийнхээ төгсгөлд Есүс Христийн тухай бошиглон ингэж бичсэн юм: “Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой” (2 Нифай 31:20).

Нифайн өгүүлсэн энэхүү “найдварын төгс гэрэл” нь Аврагчийн золиослолоор боломжтой болсон мөнхийн авралын төлөөх Цагаатгалын найдвар юм. Энэхүү найдвар нь гайхамшигтай үйлсийг бүтээхэд эрэгтэй, эмэгтэйчүүдийг түүхийн туршид удирдан хөтөлсөн юм. Эрт үед амьдарч байсан Төлөөлөгчид дэлхий даяар аялж, Түүний тухай гэрчлэн, эцэстээ Түүнд үйлчлэхийн төлөө амь насаа өгч байлаа.

Энэ эрин үед Сүмийн анхны олон гишүүн гэр орноо орхин, төгс итгэл, найдварыг зүрх сэтгэлдээ тээн, өргөн уудам хээр талыг туулж, Солт Лейкийн хөндийг зорин өрнөд нутаг уруу аян хийсэн.

1851 онд Мэри Мурри Мурдок Шотландад жаран долоон настай бэлэвсэн эмэгтэй байхдаа Сүмд нэгдсэн ажээ. Дөрвөн фут долоон инч (1.2 м) өндөр, 90 фунт (41 кг) жинтэй жижигхэн энэ эмэгтэй найман хүүхэд төрүүлснээс зургааг нь хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзганд хүргэн өсгөжээ. Намхан нуруутай, жижигхэн биетэй учраас хүүхдүүд, ач зээ нар нь түүнийг “Бяцхан эмээ” гэж дууддаг байсан гэнэ.

Түүний хүү Жон Мурдок болон түүний эхнэр Сүмд нэгдэж, 1852 онд хоёр бяцхан хүүхдийнхээ хамт Ютаг зорин гарчээ. Жон амьдрал нь хэцүү байсан ч гэсэн дөрвөн жилийн дараа ээжийгээ Солт Лейкэд ирүүлэхийн тулд мөнгө явуулсан гэнэ. Мэри жижигхэн биеэсээ илүү агуу найдвар тээн, 73 настайдаа өрнөд нутаг уруу Ютаг зорин хүнд хүчир аянд гарчээ.

Тэрбээр Атлантыг эсэн мэнд туулж хувь тавилан нь золгүйгээр эргэсэн Мартины гар тэрэгтэй бүлэгтэй нийлсэн ажээ. Эдгээр анхдагчид 7-р сарын 28-нд гар тэргүүдээ түрэн өрнөд нутгийг зорьсон юм. Анх 576 гишүүнтэй аянд гарсан энэ бүлгээс бараг дөрөвний нэг нь Ютад хүрэхээсээ өмнө хорвоог орхисон юм. Хэрэв Ерөнхийлөгч Бригам Янг цасанд боогдож, эзгүй зэлүүд газарт хаягдсан Гэгээнтнүүдийг авчрахаар морин тэрэг, дулаан хувцас явуулах ажлыг зохион байгуулаагүй бол бүр ч олон хүн амь насаа алдах байсан биз ээ.

Мэри Мурдок 1856 оны 10-р сарын 2-нд Небраскийн Чимни Рокийн ойролцоо нас барав. Тэр халуунд халж, хүйтэнд хөрч явсаар, хүнд хүчир аянд туйлдан сөхөрч унажээ. Түүний турьхан бие Гэгээнтнүүдэд тулгарсан хүнд хүчир зовлон бэрхшээлийг даагаагүй юм. Тэр үхлийн ирмэг дээр ирээд байхдаа Юта дахь гэр бүлийнхээ тухай бодож байжээ. Энэхүү агуу итгэлтэй анхдагч эмэгтэй амьсгал хураахынхаа өмнө: “Намайг нүүрээ Сион уруу харуулан нас барсныг Жонд хэлээрэй” гэж захьсан гэдэг (Кеннет В.Меррел, *Scottish Shepherd: The Life and Times of John Murray Murdoch, Utah Pioneer* [2006], 34, 39, 54, 77, 94–97, 103, 112–113, 115-ыг үз.).

Өрнөд нутаг уруу эрэлхэг зоригт аян хийсэн анхдагчдын итгэл найдварын жишээ нь Мэри Мурри Мурдок юм. Өнөөдрийн сүнслэг байдлын аян нь эхэн үеийн анхдагчдынхаас багагүй итгэл найдварыг биднээс шаардаж байна. Бидэнд тулгарч байгаа сорилт бэрхшээлүүд өөр ч гэлээ ижил хэмжээний хичээл зүтгэл шаардагдаж байна.

Бидний найдвар зөв шударга олон мөрөөдлийн биелэлт уруу удирдахын төлөө би залбирч байна. Цагаатгалд тавьдаг найдвар бидний итгэл, энэрэл хайрыг бэхжүүлж, ирээдүйн амьдралаа мөнхийн байдлаас харахад туслаасай хэмээн би онцгойлон залбирч байна.

Энэхүү найдварын төгс гэрэл бид бүгдэд байх болтугай хэмээн би Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

Санваартны хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Аароны санваарын ариун түлхүүрүүд

Ларри М.Гибсон

Залуу Эрэгтэйчүүдийн Ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Миний хөвгүүдийн нэг 12 настай хүү маань туулай тэжээхээр шийдэж бид хөршөөсөө нэг том эр туулай, хоёр эм туулай авч, тороор үүр хийж өгсөн юм. Гэхдээ цаашид юу болохыг бид төсөөлөө ч үгүй байв. Хэсэгхэн хугацааны дараа манай саравч бүжингүүдээр дүүрч эхлэв. Хүү маань нэгэнт насанд хүрсэн учир тэр үед туулайнуудын тоог тэд хэрхэн хянаж байсныг анх сонсоод би хэчнээн гайхаж байснаа та бүхэнтэй хуваалцъя. Хөршийн маань нохой саравч руу үе үе орон бүжингүүдээс нь бариад идчихдэг байсан юм билээ.

Гэхдээ тэр үед би хүүгээ, ах нарынхаа хамт туулайнуудыг хэрхэн сайн харж хамгаалж, санаа тавин асарч байхыг харахад сэтгэл минь их догдолдог байж билээ. Харин одоо тэд нөхөр, аавын хувьд гэр бүлээ хайрлан хамгаалж, бэхжүүлдэг зөв зохистой санваартнууд болсон.

Аароны санваартан залуу эрэгтэйчүүд та нар болон эргэн тойронд тань байдаг гэр бүлийнхэн, чуулгын гишүүд болон бусад олон хүмүүсийн төлөө санаа тавьж дэмжих, урамшуулах энэхүү ариун үүрэгтээ би ихэд талархдаг. Би та нартаа үнэхээр их хайртай.

Саяхан би 13 настай нэгэн хөвгүүнийг диконы чуулгын ерөнхийлөгчөөр томилоход хамт байсан юм. Дараа нь бишоп түүний гараас барин, “ерөнхийлөгч” хэмээн хүндэтгэн, чуулгынх нь гишүүдэд, “ерөнхийлөгчийн энэхүү дуудлага нь ариун болохыг би онцлон тэмдэглэж байна. Диконы чуулгын ерөнхийлөгч нь, тойргийн ерөнхийлөгчийн зөвлөлийн түлхүүрүүдийг атгадаг дөрөвхөн хүний нэг нь юм. Тэр эдгээр түлхүүрээр зөвлөхүүдийнхээ хамт Их Эзэнээс ирэх илчлэлтийн дагуу чуулгынхаа гишүүдийг удирдах болно” гэж билээ. Энэ бишоп, санваарын ариун түлхүүрүүдийг хэрэглэдэг ерөнхийлөгчөөр удирдуулсан ерөнхийлөгчийн зөвлөлийн хүчийг мэддэг ажээ (С ба Г 124:142-143-ыг үз).

Сүүлд нь би тэр хүүгээс, гайхалтай сайхан чуулгаа тэргүүлэхэд бэлэн байгаа эсэхийг нь лавлахад тэрээр, “Би үнэхээр их санаа зовж байна. Диконы чуулгын ерөнхийлөгч юу хийдгийг би сайн мэдэхгүй. Та надад яахыг зааж өгч болох уу?” гэсэн юм.

Бишопын гайхалтай зөвлөл болон зөвлөхүүд нь түүнд амжилттай, хүчирхэг санваартны удирдагч болоход туслахаар дуудагдсаныг хэллээ. Мөн тэд түүний эзэмшдэг ерөнхийлөгчийн зөвлөлийн ариун түлхүүрүүдийг хүндлэнэ гэдгийг би мэдэж байлаа.

Дараа нь би: “Их Эзэн чамайг энэхүү чухал дуудлагад томилохдоо чамд ямар нэгэн удирдамж өгөх байх гэж бодохгүй байна уу?” гэж асуув.

Тэрээр бодсоноо, “Би хаанаас энэ удирдамжийг олж авах вэ?” гэж асуулаа.

Бид хэдэн хором ярилцсаны эцэст судруудаас, амьд бошиглогчдын хэлсэн үгнээс, залбирлынхаа хариунаас зааврыг олж болохыг тэр ухаарсан юм. Бид шинэ дуудлагынхаа үүрэг хариуцлагын талаар мэдэж авахыг хичээхдээ эхлээд судраас суралцахаар болсон билээ.

Бид Сургаал ба Гэрээний 107 дугаар хэсгийн 85 дугаар шүлгийг уншлаа. Энэ хэсэгт чуулгын ерөнхийлөгч чуулгынхаа гишүүдтэйгээ ярилцан тэдэнд үүргийнх нь талаар заах ёстойг сануулсан байв. Чуулгын гишүүд бол зөвхөн нэг анги биш, харин зөвлөл болохыг мөн тэд ерөнхийлөгчийн удирдлаган дор бие биендээ зааж, нэг нэгнээ хүчирхэгжүүлэх ёстойг бид мэдэж авав. Тэгээд би түүнийг урамшуулан, Их Эзэнээс илчлэлт хүлээн авч, ариун дуудлагаа өндөрт өргөн, чуулгын диконууддаа үүргийг нь зааж өгдөг сайн ерөнхийлөгч байна гэдэгт нь итгэж байгаагаа илэрхийллээ.

Эцэст нь, “Чи диконууддаа үүргийнх нь талаар заах ёстойгоо мэдлээ, харин юу заахаа мэдэж байгаа юу?” гэж асуув.

Бид дахин судраас хариултаа хайлаа:

1. Диконууд сүмийг харж хандахын тулд Сүмд байнга ажилладаг үйлчлэгчид байхаар томилогдох ёстой (С ба Г 84:111-ийг үз).

Гэр бүл нь Сүмийн үндсэн нэгж учраас Аароны санваар атгагчийн хамгийн чухал үүрэг бол гэр бүлдээ хүлээсэн үүргийг биелүүлэх юм. Тэрээр эцэг эхдээ гэр бүлээ авч явахад нь санваартны дэмжлэг үзүүлдэг. Мөн ах, эгч, дүү нараа болон чуулгын залуу эрэгтэйчүүд, тойргийнхоо гишүүдийг харж хандаж байх үүрэгтэй юм.

2. Дикон нь шаардлага гарвал багшид, Сүмийн бүх үүргийг гүйцэтгэхэд нь туслах ёстой (С ба Г 20:57-г үз).

Дикон нь багшид үүргээ гүйцэтгэхэд нь туслах ёстой болохоор багшийн үүргүүдийг мөн мэдэж байх ёстойг ойлгон судраас багшийн албан тушаалын олон үүргийг бид тэр даруй мэдэж авав. (С ба Г 20:53–59; 84:111-ийг үз). Судруудад хандан, өөрсдийн яг юу хийх ёстой үүргүүдээ олж мэддэг залуу эрэгтэйчүүд нэг бүрийн мөн тэдний эцэг, зөвлөхүүд болон бусад хүмүүсийн хийдэг энэхүү ажил нь бидэнд үнэхээр сургамжтай туршлага болдог билээ. Бидний олонх нь эндээс илчлэлтийг хүлээн авч, сүнсээр нөлөөлөгдөн, гайхалтай зүйлсийг мэдэрдэг гэдэгт би эргэлзэхгүй байна. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь товхимол бол Аароны санваартны үүргүүд болон сүнслэг өсөлтийн талаар олон хэрэгтэй зөвлөмжүүдийг агуулдаг нэн чухал эх сурвалж юм. Энэ товхимлыг байнга ашиглаж байхыг би та бүхнээс хичээнгүйлэн хүсч байна.

3. Дикон, багш нар нь “сануулж, тайлбарлаж, ухуулж мөн зааж, мөн Христэд ирэхэд бүхнийг урьдаг байх ёстой. (С ба Г 20:59; пристүүдэд зориулсан шүлэг 46, 68-ыг үз.).

Олон залуу эрэгтэй номлолын туршлага нь 19 нас хүрч Номлогчийн Бэлтгэлийн Төвд очсоноор эхэлдэг гэж боддог. Харин бид энэ нь бүр эрт эхэлдгийг судраас суралцдаг. Их Эзэн Аароны санваартан нэг бүрийг өөрийн гэр бүлээс эхлээд хүн нэг бүрийг Христэд авчраасай хэмээн урьдаг билээ.

Дараа нь, тэрхүү залуу ерөнхийлөгчид чуулгын тэргүүлэх эрх мэдэлтний хувьд юу хийх ёстойг өөрт нь ойлгуулахын тулд би, Сургаал ба Гэрээний 107:85-д заасан эхний үүргийг гурван удаа уншихыг түүнд санал болгосон юм. Тэр “Арванхоёр диконы дээр тэргүүлэх” гэж уншив. Тэгээд би, “Их Эзэн чамайг ерөнхийлөгчийн хувьд яг юу хийх ёстой гэж хэлж байна вэ?” гэж асуулаа.

“За, бидний ярилцаж байхад нэлээд хэдэн санаа орж ирлээ ” гээд “Их Эзэн намайг 12 диконы ерөнхийлөгч байлгахыг хүсч байгаа юм байна. Гэтэл манайд ердөө таван дикон байдгаас нэг нь хааяа л ирдэг. Тэгэхээр бид яаж арванхоёр диконтой болох вэ?” гэв.

Би энэ судрыг яг түүний ойлгосон шигээр хэзээ ч ойлгож байгаагүй бөгөөд одоо зөвхөн түүнд байгаа, надад байхгүй тэрхүү ариун түлхүүрүүдийг тэрээр ашиглаж эхэлсэн. Тэр 13 настай Аароны чуулгын ерөнхийлөгч, нас, бие, боловсрол хамаарахгүйгээр ерөнхийлөгчийн зөвлөлийнхөнд өгөгддөг тэрхүү ариун түлхүүрүүдийг хэрэглэн, надад илчлэлтийн агуу хүчийг мэдрүүлж, ойлгуулсан билээ.

“Мэдэхгүй юм даа. Харин чи юу гэж бодож байна?” гэж би эргүүлэн асуув.

Тэрээр, “Яаж түүнийг дандаа ирүүлж болохыг олж мэдэх хэрэгтэй юм байна. Манай чуулгад байх ёстой мөртлөө ирдэггүй хоёр хүүхдийг би мэднэ. Тэдний нэгэнтэй нь би дотно найз болж болох л юм. Нөгөөтэй нь манай зөвлөхүүд бас ажиллаж болно. Хэрэв тэд ирчихвэл бид долуулаа болно. Харин дахиад таван хүн хаанаас олдог билээ?” гэв.

Би “мэдэхгүй байна” гээд, “Харин Тэнгэрлэг Эцэг тэднийг энд байгаасай гэж хүсч байгаа бол Тэр л хариултыг нь мэдэж байгаа” гэж хэллээ.

“Тэгвэл бид ерөнхийлөгчийн зөвлөл болон чуулгаараа хамт юу хийх тухайгаа асууж залбирах хэрэгтэй юм байна” гэснээ тэр, “Ер нь манай тойрогт байгаа дикон болох насны бүх хөвгүүдийг бас гишүүн бус хөвгүүдийг ч гэсэн би хариуцах ёстой юу?” гэж асуулаа.

Сэтгэл минь ихэд хөдлөн, “Их Эзэн танай бишопыг зөвхөн тойргийнхоо гишүүдийг л хариуц гэдэг болов уу эсвэл нутаг дэвсгэрийнхээ бүх хүмүүст анхаарал тавь гэдэг болов уу?” гэж асуув.

Өсвөр насны тэр залуухан “үйлчлэгч” үүнийг дор нь ухаарсан юм. Тэрээр, багш, дикон, прист болгон сүмийг харж, хамгаалж мөн бүх хүмүүсийг Христэд ирэхийг урих үүрэгтэй юм байна гэдгийг ойлгосон.

Сүмийнхээ гайхалтай залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн талаар эргэцүүлэн бодож байх зуур Моронайн Иосеф Смитэд хэлсэн, “энэ нь хараахан гүйцэлдээгүй ч гэсэн, удахгүй тохиох болно (Иосеф Смит---Түүх 1:41) гэсэн сударт миний анхаарал татагдав.

“Түүний дараа Би Өөрийн Сүнсийг бүх хүн төрөлхтөнд цутгана. Та нарын хөвгүүд, охид эш үзүүлэн,... өвгөд чинь зүүд зүүдэлж, залуус чинь үзэгдлүүд үзнэ” (Иоел 2:28).

Энэ залуу ерөнхийлөгчийн “толгойд орж ирсэн” тэрхүү үзэгдэл бол Тэнгэрлэг Эцэг Өөрийн чуулгыг ямархуу байлгахыг хүсдэг Түүний хүсэл байсан юм. Чуулгынхаа идэвхтэй гишүүдийг хүчирхэгжүүлэх, сул нэгнийг аврах, бүгдийг Христэд ирэхийг урих Өөрийн чин хүслийг Тэрбээр илчлэн харуулсан билээ. Тиймээс тэр сүнслэг илчлэлтээр, Их Эзэний хүслээр хийгдсэн төлөвлөгөөг тоймлон гаргаж чадсан юм.

Их Эзэн “санваар” гэдэг нь бусдад хүрч үйлчлэх гэсэн үг болохыг энэ залуу ерөнхийлөгчид ойлгуулсан. Бидний хайрт бошиглогч Томас С.Монсоны тайлбарласнаар,

“Санваар бол зөвхөн бэлэг бус, бусдад үйлчлэх, бусдыг өргөх эрх мэдэл, хүмүүсийн амьдралыг адислах онцгой боломж юм” (“Our Sacred Priesthood Trust,” *Ensign*, 2006 оны 5-р сар, 57).

Үйлчлэл бол санваарын үндсэн суурь бөгөөд Аврагчийн жишээг даган бусдад үйлчлэнэ гэсэн үг юм. Энэ бол Түүний санваар, Түүний ажил болохыг мөн Тэрээр санваар атгагч бидэнд итгэлээр үйлчлэх бүхий л арга замуудыг үзүүлснийг би гэрчилж байна.

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл бүр чуулгынхаа талаар Их Эзэний хүслийг мэдэхийн төлөө тогтмол зөвлөлдөж, хамтран суралцаж, залбираасай хэмээн би урьж байна. Чуулгынхаа гишүүн бүрд үүргийг нь заахын тулд “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” гарын авлагыг ашигла. Чуулгын гишүүн бүрийг би санваарын бүх үүргээ чин шударгаар биелүүлэхийн тулд юу хийх ёстойгоо чуулгынхаа ерөнхийлөгчөөс асууж мэдэхийг урьж байна. Их Эзэн залуу эрэгтэйчүүдээ энэ үед Бурханы хаант улсыг байгуулах, төлөвшүүлэн бэхжүүлэх ажлын хүчирхэг нөөц, сурвалж хэмээн хардаг шиг хүн бүр мөн тэднийг ийн хараасай хэмээн би урьж байна.

Гайхалтай залуу эрэгтэйчүүд минь, та нар бол Пеннсилванийн Хармонийн ойролцоо Иохан Баптист, Иосеф Смит, Оливер Каудери хоёрт сэргээн хүртээсэн Аароны санваарыг эзэмшигчид билээ. Энэ санваар нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг Түүний Хүү Есүс Христэд ирж, Түүнийг дагах үүд хаалгыг нээж өгдөг тэрхүү ариун түлхүүрүүдийг атгадаг билээ. Энэ нь “наманчлалын хийгээд баптисмын мөн нүглийн уучлалын сайн мэдээ;” долоо хоног тутмын ариун ёслол; мөн “тэнгэр элчүүдийн үйлчлэлээр” дамжин ирдэг. (С ба Г 13:1; Иосеф Смитийн түүх 1:69). Та нар бол үнэхээр бүх цаг үе, бүх газарт байсантай адил цэвэр ариун, зохистой, итгэлтэй санваар эзэмшигч “үйлчлэгчид” билээ.

Яагаад? Бидний хайрт Тэргүүн Зөвлөлөөс та бүхэнд хандан:

“Аароны санваарын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэл танд бий... Та эргэн тойрны хүмүүсийнхээ амьдралыг агуу ихээр адислах болно... Тэнгэрлэг Эцэг танд агуу итгэл найдвар хүлээлгэдэг. Танаар гүйцэтгүүлэх чухал ажил Түүнд бий” (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь: Аароны санваар атгагчдад* [2010], 5-р хууд) хэмээн хэлсэн юм.

Энэ үгс үнэн гэдгийг би мэднэ. Бидний хүн нэг бүр мөн ийм гэрчлэлтэй байхын төлөө би залбирдаг. Эдгээр зүйлсийг би санваараа бидэнд эзэмшүүлдэг Их Эзэн Есүс Христийн ариун нэрээр хэлж байна, амен.

Санваартны хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Та нарын чадавх ба онцгой боломж

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх

Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф

Нэгэн эр усан онгоцоор тойрон аялал хийж, Газрын дундад тэнгис хүрэхийг мөрөөддөг байжээ. Тэрээр Ром, Афин, Станбул хотын гудамжаар алхаж явна гэж мөрөөддөг байв. Тэр олсон зоос бүрээ хураасаар, аялал хийх мөнгөтэй болжээ. Гэвч хүнсэндээ зарах хангалттай мөнгө байгаагүй учир лаазтай вандуй, хайрцагтай жигнэмэг, хуурай ундаа зэргээр өдрийг зогоодог байв.

Тэр усан онгоцон дээрх биеийн тамирын зааланд спортоор хичээллэж, бичил гольф, усан санд сэлэх зэрэг үйл ажиллагаанд оролцохыг хүсч байлаа. Мөн кино, үзвэр, соёлын үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүст атаархан сууна. Хөөрхий тэр эр усан онгоц дээр үйлчилдэг сайхан хоолнуудаас идэхсэн гэж арааных нь шүлс асгарч суусан гэдэг. Хоол бүр нь найрын зоог лугаа адил харагдана! Гэвч мөнгө багатай болохоор алинд нь ч мөнгө зарахыг хүссэнгүй. Очиж үзэхийг хүссэн хотуудаараа аялсан ч, ихэнхдээ өрөөндөө сууж, бэлдсэн энгийн хоолоо л иддэг байв.

Тойрон аяллын сүүлийн өдөр усан онгоцны ажилтан үдэлтийн үдэшлэгүүдээс алинд нь оролцохыг нь асуухад сайхь эр зөвхөн үдэлтийн үдэшлэг төдийгүй усан онгоцон дээрх хоол хүнс, үзвэр болон бүх үйл ажиллагааны хөлс тасалбарынх нь үнэнд шингэснийг мань эр дэндүү оройтож мэдсэн гэнэ.

Энэ сургаалт зүйрлэлээс гарах асуулт бол санваарыг эзэмшигч, тийм ээ, Бурханы санваарыг эзэмшигчид бид өөрсдийн боломж, эрх болох ариун хүч, хувийн хишиг, бэлэг болон адислалуудыг хүртээхдээ онцгой боломжоо хэрхэн ашиглаж байна вэ?

Санваарын хүч ба алдар суу

Санваар нь ор нэрийн төдий зүйл эсвэл цол хэргэм биш үүнээс ч илүү зүйл гэдгийг бид бүгд мэднэ. Бошиглогч Иосеф Смит: “Санваар нь өдрийн эхлэл юм уу жилийн төгсгөл гэж үгүй Бурхантай . . . мөнхийн зарчим мөн.”¹ Энэ нь “тэр бүү хэл Бурханы мэдлэгийн түлхүүрийг”² атгадаг. Санваараар дамжуулан жинхэнэ “бурханлиг хүч тунхаглагдана”³ гэж

заасан билээ.

Санваарын адислалууд нь бидний ойлгох чадвараас ахадсан зүйл юм. Итгэлтэй Мелкизедек санваартнууд “Бурханы сонгосон хүмүүс болж”⁴ чадна. Тэд “биеэ шинэчлэхийн тулд Сүнсээр ариусгагдах ёстой”⁵ болж, “Эцэгт байгаа бүхнийг”⁶ эгнэгт хүлээн авдаг гэжээ. Хэдийгээр үүнийг ойлгоход хэцүү ч энэ нь үнэхээр сайхан бөгөөд үнэн гэдгийг нь би гэрчилж байна.

Энэхүү хүч болоод үүрэг хариуцлагыг Тэнгэрлэг Эцэг хүмүүнд итгэл хүлээлгэн өгсөн нь Түүний агуу хайрын нотолгоо, үхлийн дараах амьдрал дахь бурханы хөвгүүд бидний чадавхыг угтан харсны нотолгоо мөн.

Гэвч бид энэхүү чадавхаасаа дэндүү доогуур амьдарч байгааг бидний үйл хэрэг үргэлж харуулдаг. Санваарын талаар асуухад бидний ихэнх нь тодорхойлолтыг нь үг үсэгчлэн тоочиж чаддаг хэрнээ өдөр тутмын амьдралдаа цээжилсэн үгсийнхээ ойлголтоос илүү зүйл хэлж чадах нь юу л бол.

Ах нар аа, бидэнд сонголт байна. Бид санваар эзэмшигчдийн хувьд золиослол бага гарган, онцгой боломжоосоо доогуур байж болно. Эсвэл сүнслэг боломжийнхоо хэрээр элбэг дэлбэг зоогоос амталж, санваарын адислалуудыг хүртэж болно.

Бид чадавхынхаа төвшинд амьдрахын тулд юу хийж болох вэ?

Судруудад бичигдсэн, ерөнхий чуулган дээр хэлсэн үгс зөвхөн уншихад эсвэл сонсоход⁷ зориулагдсан биш гэдгийг сануулъя.⁸ Бид цуглаануудад оролцохдоо ойлгож, санал нийлж байгаа мэт инээмсэглэн, толгой дохин суудаг байх. Бид хийх ёстой зүйлээ тэмдэглэн, өөртөө “Энэ л яг миний хийх зүйл байна” гэж хэлдэг байх. Гэсэн ч сонсох, гар утсан дээрээ сануулан бичиж, бичсэн зүйлээ үйлдэл болгох, “үүнийг хийх” гэдгийг “сүүлд” хийх болгон хойш тавих нь элбэг байна. Ах нар аа, “үүнийг хийх” гэж бичээд түүнийгээ “яг одоо” хийцгээе!

Судраасаа уншихдаа мөн бошиглогчийн үгсийг сонсохдоо анхаарлаа төвлөрүүлж, зүрх сэтгэлээсээ ханддаг бол Их Эзэн та нарт санваарын боломжуудаа хэрхэн ашиглаж амьдрахыг тань хэлэх болно. Өдрийг үр бүтээлгүй, Сүнсний өдөөлтөнд хариу үйлдэл хийлгүй бүү өнгөрүүл.

Нэгдүгээрт: Эзэмшигчийн гарын авлагыг унш

Хэрэв та нар дэлхийн хамгийн дэвшилт, хамгийн үнэтэй компьютер эзэмшдэг бол түүнийгээ зөвхөн ширээний чимэг болгон ашиглах байсан гэж үү? Компьютер сэтгэл хөдөлгөм сайхан харагдаж болно. Энэ нь бүхнийг чаддаг байж болно. Гэвч та зөвхөн эзэмшигчийн гарын авлагыг уншиж программ хангамжийг хэрхэн ашиглахыг ойлгож, компьютероо асааж байж л бүрэн хүчин чадлаар нь ажиллуулна.

Бурханы ариун санваар нь эзэмшигчийн гарын авлагатай байдаг. Судрууд болон гарын авлагуудыг илүү зорилготойгоор, анхаарлаа төвлөрүүлэн уншицгаая. Сургаал ба Гэрээний 20, 84, 107, 121-р хэсгийг дахин уншицгаая. Бид санваарын зорилго, чадамж, ач тусыг хэдий чинээ ихээр судална, төдий чинээ суралцан, Сүнс бидэнд хэрхэн ашиглахыг зааж, тэрхүү хүч гэр бүл, нийгэм, Сүмийг адислах болно.

Бид боловсрол, мэргэжлээрээ өсч хөгжих асуудалд гол анхаарлаа хандуулдаг. Бид эрдэм мэдлэгт суралцаж, мэргэжил боловсрол олох хэрэгтэй, тэгэхийг ч хүсдэг. Би та бүхнийг боловсрол олж авахын төлөө хичээн зүтгэж, сонгосон салбартаа сайн мэргэжилтэн болохыг зөвлөж байна. Мөн сайн мэдээний сургаал ялангуяа санваарын сургаалд суралцаж, дадлага туршлагатай болохыг уриалж байна.

Бид бүх цаг үеэс илүү судрууд, өнөө үеийн бошиглогчдын үгсэд илүүтэйгээр хялбар хүрч болох цаг үед амьдарч байна. Гэвч тэдний заасан зүйлсийг ойлгож ухаарах нь бидний үүрэг хариуцлага, онцгой боломж юм. Санваарын зарчим ба сургаалууд нь агуу бурханлиг билээ. Бид санваарын зорилго, чадавх, бодит хэрэгцээнд хэдий чинээ суралцана бидний бодгаль өсөн хөгжиж, бидний ойлголт төдий чинээ өргөжиж Их Эзэний бидэнд зориулан нөөцөлсөн зүйлсийг харах болно.

Хоёрдугаарт: Сүнсний илчлэлтүүдийг эрэлхийл.

Есүс Христ болон Түүний сэргээгдсэн сайн мэдээний тухай баттай гэрчлэл нь мэдлэгээс илүүтэйгээр сайн мэдээний зарчмуудын үнэнч, шударга хэрэглээгээр батлагдсан хувийн илчлэлтийг шаарддаг. Бошиглогч Иосеф Смит, санваар нь “Бүхнийг чадагч Бурхан энэ дэлхийн бүтээлтийн эхэнд Өөрийн суу билгийг илчилж эхэлсэн үеэс өнөө үеийг хүртэл хүмүүний хүүхдүүдэд Өөрийгөө илчилсээр байгаа суваг”⁹ хэмээн тайлбарласан байдаг.

Хэрэв бид энэ илчлэлтийн сувгийг эрэлхийлэхгүй, хэрэглэхгүй байгаа бол бид санваарын онцгой боломжоосоо доогуур амьдарч байна гэсэн үг. Жишээлбэл: итгэдэг мөртлөө

итгэдэг гэдгээ мэддэггүй хүмүүс байдаг. Тэд олон янзын хариултыг цагаас цагт намуухан, зөөлөн дуу хоолойноос хүлээн авдаг боловч энэ өдөөлт үл анзаарагдам, ялимгүй бага санагддаг тул жинхэнэ утга учрыг нь ойлгодоггүй. Үүний үр дүнд санваарын чадавхаа бүрэн ашиглахын оронд тэд эргэлзэж эхэлдэг.

Илчлэлт ба гэрчлэл үргэлж гайхуулан цочроох хүчтэйгээр ирдэггүй. Ихэнхдээ гэрчлэл намуухан, амар амгалан байдлаар ирдэг. Заримдаа яг хэзээ гэдгийг нь хэлж мэдэхгүй ч сайн мэдээ үнэн гэдгийг жинхэнээр мэдсэн байдаг. Их Эзэн бидэнд “шат шатаар, дүрэм дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханыг”¹⁰ өгдөг.

Заримдаа бидний гэрчлэл цаг тутамд өсөн томрох цасан бөмбөлөгтэй адилхан юм. Бидний итгэл бүдэг гэрлээс бүр итгэх хүслээс эхэлдэг. Яваандаа “гэрэл гэрэлтэй нэгдэн нийлдэг,”¹¹ “гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг, мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг”¹² бөгөөд “тогтоосон цагт [бид] түүний бүрэн байдлыг хүлээж авдаг.”¹³

Бид дэлхийн хязгаарлалтаас давж, ойлголтын мэлмий нээгдэн, селестиал эх сурвалжаас гэрэл ба мэдлэгийг хүлээн авна гэдэг ямар гайхамшигтай зүйл болохыг бодоод үз дээ! Санваар атгагчдын хувьд хувийн илчлэлтийг эрэлхийлж, Ариун Сүнсний баттай гэрчлэлээр дамжуулан үнэнийг хэрхэн мэдэхэд суралцах нь бидний онцгой боломж, бололцоо юм.

Хувийн илчлэлтийн гэрлийг шударгаар эрэлхийлцгээе. Их Эзэн оюун ухаан, бодгальд маань итгэлийн очийг асааж, бидний онцгой нөхцөл байдал, саад бэрхшээл болон санваарын үүргүүдэд Ариун Сүнсний бурханлиг дэмжлэгийг амьдралдаа болон тулгарсан сорилт бэрхшээлүүдийг даван туулахад хүлээн авч, таньж мэдэх боломжийг олгох болтугай.

Гуравдугаарт: Санваартны үйлчлэлдээ баяр баяслыг ологтун

Би онгоцны нисгэгч байхдаа бусад нисгэгчдийн дадлага туршлагыг шалгаж, тэдэнд заадаг, сургагч ахмад байлаа. Миний ажил үүргийн нэг нь мэргэшсэн нисгэгчдэд сүрлэг том онгоцнуудыг аюулгүй, чадварлаг жолоодоход шаардлагатай мэдлэг, ур чадварыг сурган, шалгах явдал байв.

Мэргэжлийн нисгэгчээр олон жил ажилласан ч “газар дэлхийгээс тасран, гүн цэнхэр

огторгуйд мөнгөн цагаан хөлгөөрөө бүжиглэх мэт дүүлэн хөөрөх”¹⁴ сэтгэл хөдлөлөө хэзээ ч орхиогүй нисгэгчид байдгийг би мэднэ. Тэд агаар мандал, хүчирхэг хөдөлгүүрийн хүнгэнэх чимээнд дуртай. Тэд “сэнгэнэх салхи, түнэртэн бараатах огторгуй, өмнө нь гэрэлтэх оддын нэгэн хэсэг болсон лугаа адил”¹⁵ мэдрэмжийг мэдрэх дуртай. Тэдний өөдрөг үзэл бусдад нөлөөлдөг байсан шүү.

Бас сэтгэлийн хөдөлгөөн багатай хүмүүс ч байдаг. Тэд онгоцны системүүдийг ажиллуулж, жолоодож сурсан ч ямар нэгэн байдлаар “болжмор, тэр бүү хэл бүргэд ч нисээд үл хүрэх”¹⁶ агаар мандалд дүүлэн нисэхийн баяр баясгаланг мэддэггүй. Тэд далай тэнгис, тив дэлхийг гатлан нисэхдээ гялалзан мандах нарыг, Бурханы бүтээлүүдийн гоо сайхныг харан цочирдон баясах мэдрэмжгүй байдаг. Тэд шалгалтуудаа сайн өгдөг, би тэднийг нисгэгч байхаар баталсан ч, тэр үед надад тэдний төлөө харамсах сэтгэл төрж билээ.

Та нар санваар эзэмшигчийн хувьд шаардлагатай зүйлийг хийгээд л өөрсдийн амсах ёстой баяр баясгаланг мэдрэхгүй өнгөрч байна уу гэж өөрөөсөө асууж болох юм. Санваарыг атгах нь Аммоны: “Баясах агуу шалтгаан бидэнд байхгүй гэж үү? Бид энэ агуу хийгээд гайхамшигт ажлыг хийхэд түүний [Их Эзэний] мутар дахь зэмсгүүд байсан билээ. Тиймийн тул бахархацгаая ... тийм ээ, бид Их Эзэнээр бахархах болно”¹⁷ гэдгийг мэдрэсэнтэй адил баяр баяслыг мэдрэх агуу боломжийг бидэнд олгодог.

Ах нар аа, манай шашин бол үнэн шашин! Бид Бурханы санваар эзэмшигч байхаар адислагдсан хүмүүс! Дуулалын номноос бид “Баярт дууг мэддэг ард түмэн юутай ерөөлтэй вэ! Өө, Эзэн, тэд Таны нүүр царайны гэрэлд алхдаг”¹⁸ хэмээн уншдаг. Бид үүнийг эрэлхийлэх юм бол энэхүү агуу баяр баяслыг мэдэрч чадна.

Өдөр тутмын энгийн санваарын үйлчлэлээс ирэх баяр баяслыг бид дэндүү олон удаа мэдрэлгүй өнгөрөөдөг. Зарим үед бидний ажил үүрэг дийлдэшгүй ачаа мэт санагдах үе бий. Ах нар аа амьдралдаа туульдсан, санаа зовсон, гомдоллосон байдалтайгаар бүү өнгөрүүлээрэй. Итгэлтэй санваарын үйлчлэл ялангуяа өөрсдийн орон гэрт үзүүлэх санваарын үйлчлэлээс ирэх элбэг дэлбэг баяр баяслаас зайлуулан холдуулах дэлхийн зангууг бид хүлээн зөвшөөрөх юм бол онцгой боломжоосоо доогуур амьдрах болно. Итгэлтэй, тууштай санваарын үйлчлэгч нарт Бурханы өгөөмрөөр хайрласан баяр баясал, аз жаргал, амар амгалангийн зоогоос хүртэхгүй байгаа бол бид онцгой боломжоосоо доогуур амьдарч байна гэсэн үг.

Залуу эрэгтэйчүүд ээ, тойргийн тань нэгэн гишүүнд эсвэл танд сүм дээр эрт ирж, ариун

ёслолдоо бэлтгэх нь адислал бус хэцүүхэн ажил мэт санагддаг бол та нар долоо хоногийг хүндхэн өнгөрөөсөн байж болзошгүй ч ариун ёслол ямар утга учиртайг бодож үзэхийг хүсч байна. Ах нар аа, хэрэв та нарын гэрийн багшлалт тийм ч үр дүнтэй санагдахгүй байгаа бол ямар нэгэн асуудлуудтай тулгарсан гэр бүлийнхний төлөө Их Эзэний үйлчлэгчийн хийх айлчлал юу хийж болохыг итгэлийн нүдээр харахыг хүсч байна. Та санваарын үйлчлэлийн бурханлиг чадавхыг ойлгох аваас Бурханы Сүнс бодол санаа, зүрх сэтгэлээр дүүрч та нарын нүүр царай, нүд тань туяаран гэрэлтэх болно.

Санваар эзэмшигчид бид Их Эзэнээс итгэмжлэл хүлээлгэсэн үйл хэргээс хэзээ ч зүрхшин шантрахгүй байцгаая.

Төгсгөл

Хүндэт ах нар аа, ариун санваарын сургаалыг хичээнгүйлэн судлахыг эрэлхийлж, Сүнсний илчлэлтүүдийг шат шатаар хүлээн авч, гэрчлэлээ хүчирхэгжүүлэн, санваарын өдөр тутмын үйлчлэлээс жинхэнэ баяр баяслыг олцгооё. Санваар эзэмшигчид бид эдгээр зүйлсийг хийх юм бол өөрсдийн онцгой боломж, чадавхид тохирохуйцаар амьдарч, “[бидэнд] хүчийг өгөгч Христээр бүгдийг хийх”¹⁹ боломжтой болно. Үүнийг би Их Эзэний төлөөлөгчийн хувьд өөрийн адислал болон гэрчлэлийг ариун Есүс Христийн нэрээр үлдээж байна, амен.

Эшлэл

1. Иосеф Смит, Teachings of Presidents of the Church , 3:386.
2. Сургаал ба Гэрээ 84:19.
3. Сургаал ба Гэрээ 84:20.
4. Сургаал ба Гэрээ 84:34.
5. Сургаал ба Гэрээ 84:33.

6. Сургаал ба Гэрээ 84:38.
7. 1Нифай 19:24
8. Иаков 1:22-г үз.
9. Иосеф Смит, *History of the Church*, 4:207.
10. 2 Нифай 28:30.
11. Сургаал ба Гэрээ 88:40.
12. Сургаал ба Гэрээ 50:24.
13. Сургаал ба Гэрээ 93:19.
14. Бага Жон Гиллеспи Маги, “High Flight,” Дайан Равитч, *The American Reader: Words That Moved a Nation* (2000), 486.
15. Ричард Бах, *Stranger to the Ground* (1963), 9.
16. Маги, “High Flight,” 486.
17. Алма 26:13, 15–16.
18. Дуулал 89:15,16.
19. Филиппой 4:13.

Санваартны хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Санваарт суралцахуй

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг

|Бурханы санваартнуудын энэ цуглаанд та бүхэнтэй хамт байгаад би баяртай байна. Бид хэдийгээр янз бүрийн газарт цуглаад байгаа ч өөр өөрсдийн шатанд санваарын үйлчлэлээ гүйцэтгэж байгаа билээ. Бидний нөхцөл байдал харилцан адилгүй ч нийтлэг хэрэгцээ болох санваарын үүргүүддээ суралцаж, түүнийгээ биелүүлэх хүч чадлаар өсч хөгжиж байх нь бидний зорилт юм.

Би бүр дикон байхдаа энэхүү хэрэгцээг хүчтэйгээр мэдэрсэн. Тэр үед би Нэгдсэн Улсын зүүн эрэг дэх Нью Жерси мужийн Сүмийн жижигхэн салбарт явдаг байсан. Би салбартаа цорын ганц дикон зөвхөн сүмд идэвхтэй төдийгүй Сүмийн бүртгэлтэй ганц дикон нь байлаа. Миний ах Тед цорын ганц багш байсан. Тэр өнөө орой энд ирээд байгаа.

Намайг дикон байхад манайх Юта мужид нүүж ирэв. Тэнд миний санваартаа өсч хөгжих өсөлтийг түргэсгэх онцгой гурван зүйлийг би олсон юм. Эхнийх нь: чуулгынхаа гишүүдтэй зөвлөлд хэрхэн хуралдахыг мэддэг ерөнхийлөгч, хоёрдахь нь, бидний олонтоо сонссон бие биеэ хайрлах агуу хайр уруу удирдан хөтөлдөг Есүс Христэд итгэх агуу итгэл, гурав дахь нь, бидний санваарын олон талт зорилго бол хүмүүний авралын төлөө хөдөлмөрлөх явдал мөн гэсэн итгэл үнэмшил хүн бүрд төлөвшсөн явдал байлаа.

Шилжиж ирсэн салбар маань тийм онцгой сайн салбар байгаагүй. Сүмийн аль ч нэгжид тохиолддог зүйлс тэр тойрогт мөн л тохиолддог л байв.

Энэ гурван зүйл танай санваартны чуулгад байдаг ч та эдгээрийг анзаардаггүй байж мэднэ. Харин зарим ах нар өсч хөгжих хэрэггүй хэмээн бодоод эдгээр зүйлсийг

ойшоолгүй өнгөрөөдөг байж магадгүй. Харин одоо тэдгээр зүйлсийг тодорхой болгоход Сүнс надад туслахын төлөө бас та нарын анхаарлыг татахын төлөө би залбирч байна.

Санваартаа өсч хөгжихөд туслах гурван зүйлийн тухай ярьсан нь эдгээрийн үнэ цэнийг ойлгож, ашиглахад би та нарт туслах гэсэн зорилготой юм. Үүний үнэ цэнийг ойлгосноор үйлчлэл тань улам сайжрах болно. Илүү хүч чармайлт гарган хийсэн санваартны үйлчлэл тань Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг төсөөлж байгаагаас тань илүүтэйгээр адислах болно.

Би пристийн чуулгад анх орсон үедээ нэг дэх зүйлийн тухай олж мэдсэн юм. Пристийн чуулгын ерөнхийлөгч нь бишоп өөрөө байсан бөгөөд энэ нь та нарт өчүүхэн, гайхаад баймааргүй зүйл мэт санагдаж болох ч, миний санваартны үйлчлэлийг эрс өөрчилж санваарын хүчийг надад мэдрүүлсэн билээ. Бишоп биднийг хэрхэн удирдаж байсан нь намайг өөрчлөгдөхөд нөлөөлсөн юм.

Тэрбээр залуу пристүүд биднийг дэлхий дээрх хамгийн ухаалаг хүмүүс мэт ханддаг байв. Тэр бүх хүмүүсийг ярьж дуустал нь анхааралтай сонсдог байсан. Бишопын гаргасан шийдвэрийг Сүнс бидний хэн хэнд маань баталж өгдөг юм шиг санагддаг байлаа.

“Ерөнхийлөгч нь чуулгынхаа гишүүдтэй зөвлөлдөхөөр хуралдах”¹ гэсэн судрын үгс ямар утгатайг тэр үед л би ойлгосон. Олон жилийн дараа би бишоп болоод чуулгынхаа залуухан пристүүдтэй хамт сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлэх боломж олдсон юм.

Хорин жилийн дараа би бишоп болоод зөвлөлийн хурлын үр ашгийг зөвхөн цуглааны байранд төдийгүй ууланд аялаж явахдаа харах боломж олдсон. Бямба гарагийн үйл ажиллагааны үеэр манай чуулгын нэг гишүүн ойд төөрчихөв. Ганцаараа, дулаан хувцасгүй, хоол ундгүй, толгой хоргодох газаргүй байх нь түүнд ямар байгааг бид сайн ойлгож байлаа. Бид түүнийг хайсан ч олж чадсангүй.

Санваарын чуулгын гишүүд бид хамтдаа залбирсны дараа би хүн бүрээс үг хэлэхийг хүссэнээ санадаг. Би хүн бүрийн яриаг анхааралтай сонссон бөгөөд бусад маань ч мөн тэгж сонссон гэж надад санагдсан. Хэсэг хугацааны дараа амар амгалангийн мэдрэмж бидэнд төрөв. Манай чуулгын төөрсөн гишүүн хаа нэгтэй эсэн мэнд, аюулгүй байгаа юм шиг санагдаж билээ.

Чуулга юу хийх ёстой, юу хийх ёсгүй нь надад тодорхой болсон юм. Түүнийг олсон хүмүүс ойд аюулгүй газраа хэрхэн олж очсоныг дүрслэн ярихад би тэр газрыг таньж мэдэрч билээ. Энэ нь санваарын түлхүүрүүдтэй хүнд илчлэлт авчирдаг санаа нэгтэй санваартнуудын зөвлөлийн Есүс Христэд итгэх итгэлийн хүчийг харсан гайхамшигт явдал байлаа. Бид бүгд тэр орой санваарынхаа хүчээр өсч хөгжсөн.

Идэвхтэй суралцахын хоёр дахь түлхүүр бол агуу итгэлээс ирдэг бие биеэ хайрлах хайрыг агуулах явдал юм. Хайр, агуу итгэл хоёрын аль нь түрүүлж ирдгийг би мэдэхгүй гэвч санваарын үүрэгт суралцахад хоёулаа чухал. Үүнийг Иосеф Смит бидэнд үлгэр жишээгээрээ харуулсан.

Тэрээр Сүм байгуулагдсан энэ эрин үеийн эхний жилүүдэд санваарын хүч чадлаа төлөвшүүлэх зарлигийг Бурханаас хүлээн авч, санваар эзэмшигчдэд зориулан сургууль байгуулахаар удирдагдсан. Заах болон заалгах хүмүүс бие биеэ хайрлах ёстой гэсэн шаардлагыг Их Эзэн өгсөн юм. Санваартаа суралцах газрыг байгуулах тухай мөн тэнд суралцаж байгаа хүмүүс ямархуу байх тухай Их Эзэн ийн хэлжээ:

“Өөрсдийгөө зохион байгуул ... суралцахын өргөө...дэг журмын өргөөг байгуул...”

“Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн бүгд тэгш боломжтой байж болохын тулд харин нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог.”²²

Бидний санваартны хурал буюу хичээл дээр мэдэрсэн Сүнсний илчлэлтийг Их Эзэн энд дүрсэлсэн байна. Илчлэлт нь Есүс бол Христ гэдэгт итгэх цорын ганц арга зам. Энэхүү агуу итгэл нь сайн мэдээний зарчмуудад суралцах шатны эхний гишгүүр юм.

Сургаал ба Гэрээ 88-ын 123, 124-р шүлэгт Их Эзэн бие биеэ хайрлаж, бие биеэсээ дутагдал эрж хайхгүй байхыг онцлон захижээ. Хүн бүр "хайрын холбоонуудад...ах, мөн найз байхаар"³ гар өргөж гэрээ байгуулах замаар Их Эзэний бошиглогчийн байгуулсан санваартны сургуульд суралцжээ.

Бид өнөөдөр гар өргөж, найз нөхөд болдог ёсыг баримталдаггүй ч санваарын үүрэгтээ суралцахад онцгой амжилт гаргасан газар бүхэнд хайрын холбоо байдгийг би харсан. Дахин хэлэхэд, хайрын холбоо нь сайн мэдээний үнэнд суралцах зорилго тэмүүлэл, үр дүн аль аль нь болдгийг би харсан. Хайр үнэнийг батлах Ариун Сүнсийг урьдаг. Бурханлиг үнэнүүдийг мэдэхийн баяр баясгалан нь суралцах туршлагаа хуваалцдаг хүмүүсийн зүрх сэтгэлд хайрыг бий болгодог.

Үүнд бас эсрэг тал байдаг. Зөрчил сөргөлдөөн, атаа жөтөө нь Ариун Сүнс бидэнд заахад, гэрэл ба үнэнийг хүлээн авах бидний чадварыг сулруулдаг. Түүнчлэн зөрчил сөргөлдөөн, бие биеэсээ өө сэв эрж хайх нь нэмэгдэх юм бол сурч мэдэх туршлагатай болохыг хүсэн хүлээдэг хүмүүсийн урам хугарч, хүсэн хүлээсэн туршлага нь хэрэгждэггүй.

Амжилттай хамтран суралцдаг санваартнууд өөрсдийнхөө дунд ямагт энхийг тогтоогчид байдаг гэж бид боддог. Та нар үүний жишээг санваартны хичээл, хурал цуглаан дээр хардаг. Өөрчлөлтийг олж харах нь өөрсдөд нь буй адил нийтлэг зүйлээ олж авахад нь хүмүүст тусалж байгаа хэрэг юм. Хүний хэлсэн зүйлээс засч залруулах зүйлийг биш харин ашиг тусаа өгөх зүйлийг олж харахад нь хүмүүст туслах нь энхийг тогтоогчийн бэлэг билээ.

Христийн цэвэр хайр болон энхийг тогтоох хүсэл байсан цагт хурал цуглаан болон хичээл дээр эв нэгдэл байх боломжтой. Янз бүрийн туршлага, мэдлэгтэй хүмүүс тэвчээртэй, даруу байснаар санваартны зөвлөл болон ангиудад аливаа хүнд асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эв нэгдэлтэй байхыг би харсан.

Чуулгуудад шийдвэр гаргаснаар санваартнуудад зориулан Их Эзэний тогтоосон өндөр жишигт хүрэх боломжтой юм. Агуу итгэл, хайр байгаа цагт зөрчил сөргөлдөөн байдаггүй. Бидний шийдвэрийг Их Эзэн хүлээн зөвшөөрч батлахдаа тавьдаг шаардлагыг авч үзье:

“Эдгээр чуулгуудын аль алиных нь гаргасан шийдвэр бүр мөн тэдний нэгдмэл дуу хоолойгоор байх ёстой; энэ нь тэд бие биетэйгээ нэгэн адил хүч хийгээд хүчин төгөлдөр байх шийдвэрүүд гаргахын тулд чуулга бүр дэх гишүүн болгон үүний шийдвэрүүдийг зөвшөөрсөн байх ёстой гэсэн үг юм.”²⁴

Санваарт суралцахад бидэнд тусалдаг гурав дахь зүйл нь Их Эзэн яагаад Өөрийн санваарыг эзэмшиж, ашиглахыг бидэнд итгэл хүлээлгэн өгч, биднийг адисалсан тухай адил нийтлэг итгэл үнэмшил бидэнд байснаар ирдэг. Энэ бол хүмүүний авралын төлөө хөдөлмөрлөх явдал мөн. Энэхүү адил нийтлэг итгэл үнэмшил нь чуулгуудыг эв нэгдэлтэй

болгодог. Сүнсэн хөвгүүд бид ариун санваарыг хүндэтгэлтэйгээр эзэмшихийн тулд төрөхөөсөө өмнө хэрхэн бэлтгэгдсэн тухай судрын шастираас энэ тухай мэдэж болно.

Бидэнд энэ амьдралд итгэл хүлээлгэсэн агуу санваарын тухай Их Эзэн:

"Бүр тэд төрөхөөсөө өмнө бусад олны хамт, сүнсний дэлхийд анхныхаа хичээлүүдийг хүлээн авч, мөн Их Эзэний тогтоосон цагт хүмүүний бодгалийн авралын төлөө түүний талбайд хөдөлмөрлөхийн тулд урагш гарч ирэхээр бэлтгэгдсэн байжээ"⁵ хэмээн хэлсэн юм.

Бидний эзэмшдэг санваарт хүмүүний авралын төлөө хөдөлмөрлөх ариун үүрэг бий. Энэ бол бидний үүрэг гэдгийг мэдэхээс илүү их зүйлийг хийх ёстой. Залуу насанд бидний ажил үйлсэд тавигддаг олон шаардлагууд, нас ахиж өглөх үед ирдэг сорилт бэрхшээлүүд ч биднийг энэ зорилгоос ухарч няцахад хүргэж чадахгүй гэдгийг бид гүнээ ухамсарлах ёстой.

Би саяхан нэгэн дээд пристийн гэрээр очлоо. Тэр өвчтэй учраас чуулгын хурал цуглаануудад хойшид оролцох боломжгүй болсон байв. Тэр ганцаараа амьдардаг бөгөөд хайрт хань нь өөд болж, хүүхдүүд нь алс хол амьдардаг ажээ. Өндөр нас, өвчин эмгэг үйлчлэх чадварыг нь хязгаарлажээ. Гэвч тэрээр хүч тэнхээгээ хадгалахын тулд хүндийн өргөлтийн дасгал хийсээр байгаа гэнэ.

Намайг тэднийд ороход надтай мэндлэхээр тэргэнцэрээ түшин зогсож байв. Намайг дэргэдэх сандал дээрээ суухыг уриад санваартны чуулгад хэрхэн хамтран ажилладаг байсан тухайгаа ярилцав.

Тэгснээ тэр: "Би яагаад өдий хүртэл амьд мэнд байгаа юм бол? Яагаад энд байсаар байгаа юм бол? Би юу ч хийж чадахгүй байна шүү дээ" гэж сэтгэл нь ихэд догдлон асуув.

Тэр итгэл, хайраараа миний санаа сэтгэлийг өргөлөө. Энэ бол миний төлөө түүний хийсэн зүйл гэдгийг би түүнд хэллээ. Түүгээр ч зогсохгүй тэр энэхүү богинохон уулзалтаар улам сайн хүн болох хүслийг надад төрүүлсэн юм. Ямар нэг зүйлийг хийхийн төлөө шийдвэр төгс байх түүний үлгэр жишээ бусдад болон Их Эзэнд үйлчлэхийн төлөө улам шаргуу хичээхэд надад сүнслэгээр нөлөөлсөн.

Гэвч уйтгар гуниг шингэсэн түүний дуу, нүднийх нь харцнаас би түүний асуултанд хариулж чадаагүйгээ мэдэрч билээ. Үйлчлэх чадвар нь хязгаарлагдсан түүнийг Бурхан яагаад амьд мэнд байлгаад байгааг тэр ойлгохгүй л байв.

Тэр өөртэй нь уулзахаар ирсэн надад сайхан зангаараа талархал илэрхийлэв. Намайг тэднийхээс явахаар босох үед өдөр бүр эргэж ирдэг сувилагч орж ирэн өөр өрөөнд орлоо. Аминчлан ярих үедээ тэрбээр энэ сувилагчийн тухай надад цухас дурдсан юм. Тэр бол гайхамшигтай эмэгтэй гэж өвгөн прист хэллээ. Тэр эмэгтэй амьдралынхаа ихэнх хэсгийг Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дунд өнгөрөөсөн ч өдий хүртэл гишүүн болоогүй гэнэ.

Сувилагч намайг гаргаж өгөхөөр хүрч ирлээ. Өвгөн сувилагч уруу зааж, инээмсэглэн: "Хар л даа, би юу ч хийж чадахгүй байна. Би түүнийг Сүмд баптисм хийлгэхийг хэчнээн ч ятгаад барахгүй л байна шүү дээ" гэв. Сувилагч бид хоёр уруу хараад инээмсэглэхэд би тэднийхээс гарч, ойрхон байдаг гэр өөдөө явлаа.

Өвгөн дээд пристийн асуултын хариу зүрх сэтгэлд нь бүр олон жилийн өмнөөс байраа олсныг би ийнхүү мэдсэн юм. Эрэлхэг зоригт тэр дээд прист санваар эзэмшсэн хэдэн арван жилийнхээ туршид өөрт оногдсон үүргээ биелүүлэхийг хичээн чармайсаар ирсэн ажээ.

Сувилагч эмэгтэй Есүс Христийн авралын адислалуудыг олж авах цорын ганц арга зам бол сайн мэдээгээр дамжуулан баптисм хүртэж, гэрээ хийх явдал гэдгийг тэр мэдэж байгаа. Диконы чуулгын ерөнхийлөгчөөс эхлээд дээд пристүүдийн чуулгын ерөнхийлөгчийн хийдэг гэрээнүүдийн дагуу юу хийх ёстойг тэрбээр заалгасан байлаа.

Тэр санваарын тангараг болон гэрээгээ санаж, мэдэрсэн байна. Тэр гэрээгээ өдий хүртэл сахисаар ирсэн.

Нөхцөл байдал ямар ч байсан тэрбээр Аврагчийн гэрч, номлогч хэвээр байсан юм. Түүний гэрээ зүрх сэтгэлд нь оршсоор байлаа. Сувилагч эмэгтэйн зүрх сэтгэл Есүс Христийн Цагаатгалаар дамжин, ариун гэрээнүүдийг хийснээр өөрчлөгдөөсөй гэсэн бодол түүний зүрх сэтгэлийн хүсэл байсан юм.

Энэ амьдралд санваарын сургуульд түүний өнгөрүүлсэн хугацаа үүрд мөнхийн цаг хугацаатай зүйрлүүлэхэд харьцангуй богинохон боловч энэ хугацаанд тэрээр үүрдийн ач холбогдолтой сургамжийг мэдэж авчээ. Тэрбээр санваарын талаарх мөнхийн үнэ цэнэтэй сурч мэдсэн зүйлээ Их Эзэний дуудсан газар бүрд өөртэйгөө авч явах болно.

Та санваартны үүргүүддээ зөвхөн амьдралд суралцах ирмүүн хүсэлтэй байх төдийгүй бас хийх боломжтой зүйлсийнхээ талаар өөдрөг санаа бодолтой байх ёстой. Их Эзэнээс Өөртөө үйлчлүүлэхээр бидэнд санал болгодог зүйлийг сурч мэдэх боломжийг зарим хүмүүс бүрэн ашигладаггүй .

Нэг залуу эр 1840-өөд оны эхээр Уэльс дахь жижигхэн тосгоноо орхиж, Бурханы төлөөлөгчдийн үгсийг сонсож, улмаар дэлхий дээрх Бурханы хаант улсад иржээ. Тэрбээр гэгээнтнүүдтэй хамт далайгаар Америкт ирж, уудам хээр талыг туулан, морин тэргээр өрнөд нутгийг зорин гарчээ. Тэрээр Бригам Янгийн бүлгийн дараагийн бүлэгтэй хамт энэ хөндийд хүрч ирсэн гэнэ. Санваартны үйлчлэл нь нэг фермийн газрыг цэвэрлэн анжсаар хагалах ажил байсан ажээ.

Тэрээр Их Эзэний төлөө номлолд явж, эдүгээ Невада хэмээн нэрлэгддэг зэлүүд газарт хонин сүрэг хариулахын тулд нөгөөх фермээ маш хямдхан зарсан аж. Түүнийг тэр номлолоос нь өөр нэг номлолд, ядуу зүдүү байхдаа Их Эзэнийг дагахаар орхин явсан, далайн чанад дахь өөрийнх нь амьдарч байсан тосгонд дуудсан гэнэ.

Тэрбээр энэ бүхнээс санваартан ах нараасаа суралцах арга замыг олсон ажээ. Тэр зоригтой номлогч байсан учраас дөрвөн удаа Английн ерөнхий сайд байсан нэгэн хүнд Есүс Христийн сайн мэдээг санал болгохоор зуны эдлэн газар уруу нь Уэльс дахь нарийн жимээр уруудан алхжээ.

Тэрхүү агуу хүн түүнийг харшдаа орохыг зөвшөөрсөн гэнэ. Тэр хүн Этоны коллеж, Оксфордын их сургуулийг дүүргэсэн нэгэн байв. Номлогч түүнтэй хүний гарал үүсэл, дэлхийн түүхэнд Есүс Христийн гүйцэтгэсэн онцгой чухал үүрэг, тэр ч байтугай үндэстнүүдийн хувь тавилангийн тухай ярьсан ажээ.

Ярилцлагын эцэст гэрийн эзэн баптисм хүртэх номлогчийн саналаас татгалзсан ч тэд салж явах үед дэлхийн агуу гүрнүүдийн нэгнийх нь удирдагч асан тэр хүн сайхь даруухан номлогчоос: "Та хаана боловсрол эзэмшсэн бэ?" гэж асуухад номлогч, "Бурханы санваараар мэргэшсэн" гэж хариулсан гэдэг.

Зөвхөн ямар нэг аятайхан сургуульд л орчихвол амьдрал чинь суга дээшилчих юм шиг боддог байсан тийм үе та нарт байсан биз ээ. Өөрсдийг тань хайрладаг Бурханы агуу хайрыг болон Түүний санваарын сургуульд орох боломжийг Тэрбээр та нарт олгосныг та бүхэн олж харахын төлөө би залбирч байна.

Хэрэв та нар санваартаа анхаарал төвлөрүүлж, дуулгавартай байх юм бол сүнслэг мэдлэгийн сан хөмрөг та нарын дээр юүлэгдэж, нүгэл хилэнцийг эсэргүүцэх болон аврал уруу хөтлөгч үнэнийг тунхаглах хүч чадал тань өсөн нэмэгдэх болно. Өргөмжлөл өөд удирдан хөтөлсөн хүмүүсийнхээ аз жаргалыг хараад та нар баярлах болно. Гэр орон тань эрдэм мэдлэгт суралцах газар болно.

Санваарын түлхүүрүүд сэргээгдсэнийг би гэрчилж байна. Ерөнхийлөгч Томас С.Монсон эдгээр түлхүүрүүдийг эзэмшиж, ашигладаг юм. Бурхан амьд бөгөөд та нарыг төгс мэддэг. Есүс Христ амьд. Та нар бол ариун санваарыг хүндэтгэлтэйгээр авч явахаар сонгогдсон хүмүүс. Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

Эшлэл

1. Сургаал ба Гэрээ 107:87-г үз.
2. Сургаал ба Гэрээ 88:119, 122.
3. Сургаал ба Гэрээ 88:133
4. Сургаал ба Гэрээ 107:27.
5. Сургаал ба Гэрээ 138:56.

Санваартны хуралдаан
2011 оны 4-р сарын 2

Санваарын хүч

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Өнөө орой би юу ярих вэ гэдэг талаараа залбирч, удаан хугацаанд судаллаа. Би хэнийг ч гомдоохыг хүсдэггүй. “Бидэнд ямар сорилт бэрхшээлүүд байгаа билээ? Заримдаа шөнө дунд намайг сэтгэлдээ шаналан уйлахад хүргэдэг зүйлсийг шийдвэрлэхийн төлөө би өдөр бүр юу хийдэг билээ?” гэж бодлоо. Тэдгээр асуудал сорилтуудаас өнөө орой заримынх нь тухай ярихыг хичээгээд үздэг юм бил үү гэж бодлоо. Зарим асуудал сорилт нь залуу эрэгтэйчүүдэд, зарим нь дунд насныханд хамаатай. Зарим асуудал дунд наснаас яльгүй өнгөрч яваа хүмүүст хамаатай юм. Өндөр настнуудын тухай бид ярихгүй.

Иймээс, өнөө орой цугласан нь үнэхээр сайхан байна гэдгээс эхэлье. Бид Бурханы санваарын талаар гайхамшигтай, цагаа олсон захиасуудыг сонсоцгоолоо. Би та нарын адил гэгээрэн сэнхэрлээ.

Өнөө орой би та бүгдэд хандан, сүүлийн үед сэтгэл санаанд минь өдрийн бодол, шөнийн зүүд болсон, та бүгдтэй хуваалцах хэрэгтэй гэсэн мэдрэмж төрсөн, нэгэн зүйлийн талаар яримаар байна. Энэ бол санваар атгагчдын хувьд үүний ариун хүч чадлыг хүлээн авч, энэхүү хүчийг ашиглахын тулд биднээс шаардагддаг хувийн зохистой байдал юм.

Хэлэх үгээ Сургаал ба Гэрээний 121 дүгээр бүлгээс эш татан эхэлье:

“Санваарын эрхүүд нь тэнгэрийн хүчтэй салшгүй холбоотой байдаг, мөн тэнгэрийн тэрхүү хүч нь зөв шударга ёсны зарчмуудаас бусдаар хянагдаж ч мөн шийдвэрлэгдэж ч үл чадах бөлгөө.

“Тэдгээр нь бидэнд хүртээгддэг байж болох нь, энэ нь үнэн бөлгөө; харин бид нүглээ далдлахыг оролдоход, эсвээс бардамналаараа, хоосон санаархлаараа сайрхах, эсвээс хүмүүний үрсийг хянах, эзэгнэх, эсвээс албадахад болгоогтун, тэнгэр өөрийгөө татан авдаг буюу; Их Эзэний Сүнс гашууддаг болой; мөн энэ нь буцаан татагдахад, тэр хүний санваарт эсвээс эрх мэдэлд Амен.”¹

Ах нар аа, эдгээр судруудад Их Эзэн тэнгэрлэг эрх мэдлийнхээ талаар маш тодорхой хэлсэн байна. Бурханы санваартнууд бид сударт дурдагдсан үүрэг хариуцлагдаа эргэлзэх хэрэггүй.

Бид энэ дэлхий дээр хүнд хэцүү цагт ирсэн хүмүүс. Хүмүүсийн ёс суртахууны луужин

нь “юу ч хамаагүй хийж болно” гэж заах болжээ.

Би туулж өнгөрүүлсэн он жилүүдийнхээ турш нийгмийн ёс суртахуун хэрхэн өөрчлөгдөхийг харсаар ирлээ. Нэгэн цагт Сүмийн жишгүүд болон нийгмийн жишгүүдийн хооронд зөрөө ялгаа төдийлөн байдаггүй байсан бол өнөө үед эдгээрийн хооронд том ангал бий болж, улам томорсоор байна.

Олон кино, телевизийн нэвтрүүлгээр үзүүлж буй зан суртахуун нь Бурханы хуулиудыг сөрөн зогсож байна. Эдгээрийн санаа болон ил тодорхой зүй бус, бусармаг зүйлст бүү бууж өг. Одоогийн ихэнх дуунуудын үг бас л ийм байна. Хэдхэн жилийн өмнө огт хэрэглэгддэггүй байсан бохир үг хэллэг, хараалын үгс одоо бидний эргэн тойронд ердийн зүйл болжээ. Их Эзэний нэрийг хаа сайгүй хоосноор дурдаж байгаа нь харамсалтай юм. Их Эзэнээс Синай уулан дээр Мосед өгсөн Арван зарлигийн нэгийг бүгдээрээ эргэн санацгаая: “Чи өөрийн Бурхан эзэний нэрийг дэмийн бүү дурд. Учир нь Эзэн өөрийн нэрийг дэмий дурдагчийг шийтгэлгүй орхихгүй.”²

Хэрвээ бохир үг хэллэг хэрэглэдэг хэн нэгэн байвал дахиж битгий хэлээрэй гэж аминчлан гуйж байна. Хийх үйлдэл, хэлэх үгс тань таныг сэтгэл хангалуун үлдээхгүй бол үүнээс татгалзахыг би та бүгдээс хүсч байна.

Порнографас бүрмөсөн татгалз. Үүнийг үзэхийг өөртөө хэзээ ч бүү зөвшөөр, Учир нь энэ нь ялан дийлэхэд туйлын хэцүү донтолт болон хувирдаг нь батлагдсан юм. Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис болон нэгэнт орвол гарахад хэцүү аливаа донтуулагч зүйлсээс хол байцгаа.

Та нарыг хүрээлэн буй нүгэл болон муу муухай зүйлсээс юу та нарыг хамгаалж чадах вэ? Аврагч болон Түүний сайн мэдээний сургаалын талаарх хүчтэй гэрчлэл та нарыг аюулгүй газар уруу хөтөлнө гэдгийг би гэрчилж байна. Та нар гэрчлэлтэй болсныхоо дараа үүнийгээ байнга тэтгэж, бэхжүүлж байх хэрэгтэй. Хэрэв та Мормоны Номыг уншиж амжаагүй бол уншаарай. Уншсан дүр исгэхийг би та нараас хүсээгүй шүү. Хэрвээ та нар залбирч, үнэнийг мэдэх чин хүсэлтэйгээр унших юм бол Ариун Сүнс та нарт энэ ном үнэн гэдгийг илчлэх болно. Хэрвээ энэ нь үнэн байх аваас -- Иосеф Смит Бурхан Эцэг ба Түүний Хүү Есүс Христийг харсан бошиглогч гэдэг нь үнэн юм. Мөн Сүм үнэн. Хэрвээ та эдгээр зүйлийн талаар гэрчлэлтэй болоогүй бол гэрчлэл олж авахад шаардлагатай зүйлсийг хийгээрэй. Хувийн гэрчлэлтэй байх нь маш чухал бөгөөд бусдын гэрчлэл дээр бид тулж түшиж чадахгүй. Бурханы тушаалуудыг дуулгавартай дагаж, тогтмол залбирч, судраас судалснаар бид олж авсан гэрчлэлээ амьд бөгөөд хүчирхэг байлгаж чадна. Сүмдээ ир. Залуу эрэгтэйчүүд та нар семинар, институт байгаа газарт амьдардаг бол үүнд хамрагдаарай.

Хэрвээ та нарын амьдралд ямар нэг буруу зүйл орсон бол үүнээс гарах арга зам бий. Зөв шударга бус зүйлсийг тэр даруй зогсоо. Бишоптойгоо ярилц. Ямар ч асуудлыг зөв зүйтэй наманчлалаар шийдвэрлэж болно. Та нар эргээд цэвэр болж чадна. Нүглээ наманчилдаг хүмүүсийн талаар Их Эзэн ийн хэлжээ: “Та нарын нүглүүд час улаан мэт боловч, цас шиг цагаан болно”³ “мөн Их Эзэн, бибээр тэдгээрийг цаашид санах нь үгүй.”⁴

Хүн төрөлхтний Аврагч Өөрийгөө дэлхийд байсан боловч дэлхийнх биш байсан гэж тайлбарласан. Бид ч бас худал хуурмаг сургаалуудаас татгалзаж Бурханы тушаасан зүйлсийг дагаснаар дэлхийд байгаа боловч дэлхийнх биш байж чадна.

Сүүлийн үед би гэрлэх нас нь болсон ч гэрлэхгүй байгаа залуу эрчүүдийн талаар их бодох боллоо. Гэр бүл болж, үр хүүхдээ өсгөхийг хүсч буй хайр хүрэм залуу эгч нарын хүсэлт нь гэрлэлтийг хойш тавьж буй залуу эрчүүд олон байгаагийн улмаас хязгаарлагдаж байгааг би харж байна.

Энэ бол шинэ нөхцөл байдал биш юм. Энэ асуудлын талаар Сүмийн өмнөх Ерөнхийлөгч нар их зүйлийг хэлж байсан. Би тэдгээр сургамжуудын ганц хоёроос нь эш татъя.

Ерөнхийлөгч Харольд Б.Лий , “Хэрвээ гэрлэх нас нь болсон ч эдгээр хайр хүрэм эгч нартай гэрлэхийг хойш тавьж байгаа бол бид санваар атгагч нарын хувьд үүргээ биелүүлэхгүй байгаа хэрэг”⁶ гэсэн юм

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли ийн хэлсэн юм: “Гэрлэхийг зүрх сэтгэлээсээ хүсдэг ганц бие эгч нарын төлөө миний сэтгэл ихэд зовнидог. ... Бидний өнөөгийн нийгмийн ёс журмын дагуу түрүүлж санаачлага гаргах ёстой боловч ихэнх үед ингэхгүй байгаа залуу эрчүүдийг бол тийм ч их өрөвддөггүй.”⁷

Гэрлэхийг хойш тавих олон шалтгаан та нарт байж болно. Хэрвээ та эхнэр болон гэр бүлээ тэтгэх санхүүгийн талаар санаа зовж байгаа бол хосууд хамтдаа хөдөлмөрлөж, арвич хямгач амьдрахад зовох зүйл байхгүй гэдгийг би амлая. Иймэрхүү хүнд үеүдэд золиослол, хэцүү сонголтуудыг хийж сурснаар та хоёр бие биетэйгээ илүү ойр дотно болно. Магадгүй та буруу хүн сонгохоос айж байж магадгүй. Үүнд би итгэлийг үзүүл хэмээн хэлмээр байна. Хамт амьдарч чадах хэн нэгнийг ол, гэхдээ төгс хамтрагч гэж байхгүй гэдгийг ойлгоорой. Гэрлэлтийн турш тохиолдох бүх асуудлуудыг урьдчилан хэлж чадахгүй, гэвч гэрлэлтийнхээ амлалтуудыг сахьж, аливаа асуудлыг зөвөөр шийдвэрлэх арга замуудыг эрэлхийлбэл бүх асуудал бэрхшээлийг шийдвэрлэж чадна.

Магадгүй та нар амралтаараа ийш тийш зугаалж, үнэтэй машин болон тоглоомуудыг худалдан авч, хариуцлагаас зайлсхийсэн амьдралын зугаатай мөчүүдийг амтлан дэндүү

их зугаа цэнгэлтэй байгаа байх. Би та нар шиг залуучуудтай хааяа тааралддаг бөгөөд нуулгүй хэлэхэд яагаад энэ сайхан эмэгтэйчүүдийг дагуулан гарахгүй байгаа юм бол гэж боддог шүү.

Ах нар аа, бидний амьдралд гэрлэлтийн тухай нухацтай бодож, үүрд хамтдаа байхыг хүсэх хамтрагчаа хайх цаг ирдэг. Хэрвээ та ухаалаг сонголт хийж, гэрлэлтээ тогтвортой сайхан авч явбал энэ амьдралд үүнээс илүү аз жаргал авчрах зүйл гэж үгүй.

Ах нараа та нар Их Эзэний өргөөнд гэрлэхийг эрхэмлээрэй. Санваарыг атгагч та нарт өөр сонголт гэж үгүй. Ийнхүү гэрлэх боломжоо алдахгүйн тулд анхаарал болгоомжтой байхыг би сануулж байна. Та нар цагийг хамтдаа сайхан өнгөрүүлэхдээ үерхлээ зохистой жишигт хадгалах боломжтой.

Одоо би та нарт хандаж захихыг хүссэн өөр нэг сэдэв уруу оръё. Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдаж ажилласан гурван жилийн хугацаанд миний гүйцэтгэсэн хамгийн гунигт бөгөөд сэтгэл эмзэглүүлсэн үүрэг бол мөнхийн гэрлэлтүүдийг цуцлах ажил байлаа. Бие биедээ хайртай хосууд шинэ амьдралыг эхэлж, бие биетэйгээ үүрд мөнхөд хамт байхыг хүссэнээр тэд Их Эзэний өргөөнд баяр баяслаар дүүрэн хуримласан байдаг. Сар, жилүүд улиран одоход янз бүрийн шалтгаанаас болж, хуримласан хосын хайрын гал нь бөхдөг. Энэ нь санхүүгийн болон хоорондын харилцааны асуудлууд, биеэ барьж чаддаггүй уур хилэн, хадмуудын хөндлөнгийн оролцоо, түүнчлэн гэм нүгэл үйлдсэн зэргээс улбаатай байж магадгүй. Энд маш олон төрлийн нөлөөлөх хүчин зүйлс байдаг. Ихэнх тохиолдолд эдгээр нь гэр бүл салж сарнин, гэрлэлтийг цуцлах ч хэрэггүй байдаг.

Лацдалтыг цуцлах хүсэлтүүд нь гэр бүлийн амьдралаа болж бүтэх талаас нь харахыг хичээсэн ч эцэстээ асуудлыг шийдвэрлэж чадаагүй эгч нараас ихэнхдээ ирдэг.

Үүрд мөнхийн ханиа нягт няхуураар залбирч сонгогтун. Гэрлэснийхээ дараа бие биеэ бүх хүч чадлаараа хайрла. Авга ах эгч нарын маань гэрт байдаг жаазалсан захиас бидэнд үнэлж баршгүй чухал зөвлөгөөг өгдөг. Энд “Хайрт ханиа сонго; сонголтгоо бас хайрла” гэсэн үгс байдаг. Энэ хэдхэн үгэнд агуу мэргэн ухаан агуулагдаж байна. Гэр бүлд тууштай чигч байдал амин чухал.

Эхнэр тань тантай эрх тэгш эн чацуу хамтрагч юм. Гэрлэсэн хосуудын хувьд аль нэг нь нөгөөгөөсөө дээгүүр байж болохгүй. Бурханы хүү, охины хувьд та хоёр мөр зэрэгцэн алхах ёстой. Эхнэрээ дорд үзэх эсвэл гомдоохын оронд хүндэлж, хайрлах хэрэгтэй. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, “Сүмийн аль нэг хүн эхнэртээ зүй бусаар дээрэлхвэл тэр хүн санваарыг атгах зохисгүй болно. Тэрээр хэдийгээр томилогдсон байсан ч тэнгэр өөрийгөө татан авч, Их Эзэний Сүнс гашуудаж, тэр хүний санваарын эрх мэдэл нь төгсгөл болно.”⁸

Гэрлэлтийн талаар Ерөнхийлөгч Ховард В. Хантер ингэж хэлжээ: “Аз жаргалтай мөн амжилттай гэрлэлтэд хүрэхэд зөв хүнтэй гэрлэхээс илүүгээр өөрөө зөв хүн байх нь чухал юм.” Надад энэ үг их таалагддаг. “Өөрөөсөө шалтгаалах зүйлсийг санаачлан, хичээнгүйлэн хийх нь энэхүү амжилтад хүргэх хамгийн чухал зүйл болдог.”⁹

Олон жилийн өмнө миний бишопоор үйлчилж байсан тойрогт хоорондоо их ширүүн маргалддаг нэг хос байлаа. Үнэхээр ширүүн маргалддаг байсан. Тэд өөрсдийнхөө зөв гэсэн байр суурьтай байлаа. Аль аль нь буулт хийхийг хүссэнгүй. Тэд хэрэлдээгүй үедээ миний бодлоор “байлдааны түр амсхийлтэд” байдаг байв.

Нэг өглөө шөнийн 2:00 цагт тэр хоёр над уруу утасдлаа. Тэд надтай яг тэр даруйд уулзахыг хүсэв. Би орноосоо арайхийн босож, хувцаслаад тэднийхийг зорилоо. Тэд өрөөний хоёр өнцөгт суугаад бие биетэйгээ ярихыг ч хүсэхгүй байв. Эхнэр нь нөхөртэйгөө надаар дамжуулан ярьж байсан бол нөхөр нь ч мөн адил тэгж байлаа. “Ийм байдалтай байгаа хоёр хосыг яаж нийлүүлнэ дээ?” гэж би толгойгоо гашилгаж билээ.

Би сүнсний удирдамжийн төлөө залбиртал, тэднээс нэг асуулт асуух хэрэгтэй гэсэн бодол толгойд орж ирэв. Би тэднээс “Хамгийн сүүлд хэзээ ариун сүмд орж лацдан холболтын гэрч болсон бэ?” гэж асуухад тэд их удсан гэдгээ хүлээн зөвшөөрөв. Тэд ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй бөгөөд нас барагсдын төлөө ёслолуудыг хийлгэдэг хүмүүс байв.

Би тэднээс “Та хоёр надтай хамт ариун сүмд лхагва гарагийн өглөө 8 цагт орох уу? Бид тэнд лацдан холболтын гэрч болно” гэхэд тэд нэгэн зэрэг “Хэний лацдан холболт?” гэж асуухад нь би “Мэдэхгүй ээ. Тэр өглөө гэрлэх хэн нэгний л холболт байх болно” гэж хариуллаа.

Дараагийн лхагва гарагт бид товлосон цагтаа Солт Лейкийн ариун сүмд уулзав. Тэнд бид лацдан холболтын нэгэн үзэсгэлэнт танхимд нэгээс бусдыг нь огт танихгүй хүмүүстэй хамт орлоо. Ганц таньдаг хүн нь Ахлагч Элрей Л.Крисченсен байсан бөгөөд Арванхоёрын Чуулгын туслах гэсэн тэр үеийн Ерөнхий эрх мэдэлтний дуудлагатай байсан юм. Тэрбээр тэр өдөр лацдан холболтыг гүйцэтгэхээр ирсэн байв. Бүсгүйн талынхан биднийг “сүйт залуугийн найз нар байх” гэж бодсон бол харин сүйт залуугийн талынхан биднийг “сүйт бүсгүйн найз нар байх” гэж бодсон гэдэгт би эргэлзэхгүй байлаа. Миний дагуулж ирсэн гэр бүлийн хос хоорондоо 60 сантиметр зайтай суусан байлаа.

Ахлагч Крисченсен гэрлэж буй хост хандан маш сайхан зөвлөгөө өглөө. Тэрээр нөхөр нь эхнэрээ хэрхэн хайрын дээдээр хайрлаж, гэр орныхоо зүрх лүгээ адил үзэн, хүндэлж байх ёстойг тайлбарлав. Үүний дараа эхнэр нь нөхрөө өрх гэрийн тэргүүний хувьд хүндлэн дээдэлж, бүх талын дэмжлэг үзүүлж байх ёстойг ярилаа.

Ахлагч Крисченсенийг гэрлэж буй хост хандан ярьж байх үед миний авчирсан гэр бүлийн хос хоорондоо ойртож эхлэв. Их удалгүй тэд хоорондоо зэрэгцэн суулаа. Энд намайг баярлуулсан нэг зүйл гэвэл тэр хоёр бие бие рүүгээ зэрэг дөхөж байв. Ёслол дуусахад тэр хоёр шинээр гэрлэсэн хосууд мэт хоорондоо огтхон ч зайгүй зэрэгцэн суусан байв. Бас хоёулаа инээмсэглэж байлаа.

Бид ариун сүмээс гаран явахад тэнд байсан хүмүүсээс хэн нь ч биднийг хэн бэ гэдгийг бас яагаад тэнд ирснийг мэдээгүй юм. Найзууд маань харин үүдээр гараасаа хөтлөлцөн гарч ирсэн. Тэд маргаанаа орхисон байв. Би тэдэнд нэг ч үг хэлэх шаардлага байсангүй. Тэд гэрлэсэн өдрөө болон Бурханы Өргөөнд тэр өдөр хийсэн гэрээгээ санасан юм. Тэд дахин эхлэх зорилт тавьж, энэ удаа илүү их чармайлт гаргахаар шийдсэн байлаа.

Хэрвээ та нар дотроос гэрлэлт чинь хүнд байдалд байгаа хүн байвал, үүнийг засахад шаардлагатай бүх зүйлсийг чадлынхаа хэрээр хийхийг би та нарт уриалж байна. Ингэснээр гал голомтоо дөнгөж бадраасны дараахан байсан аз жаргалыг та нар дахин мэдрэх боломжтой болно. Их Эзэний өргөөнд гэрлэсэн бид мөнхөд хамт байхаар лацдагддаг бөгөөд үүнд хүрэхийн тулд хүч чармайлт гаргах хэрэгтэй. Гэрлэлтийг аварч чадахгүйд хүрэх зарим тохиолдол байж болох юм. Гэвч ихэнх тохиолдолд гэр бүл салахаас зайлсхийж болно, тэгэх ч хэрэгтэй юм. Гэрлэлтэндээ сэв суулгах зүйлээс зайлсхий.

|Бурханы санваарыг атгагч бид дэлхийн арга замаас дээгүүр замаар замнах эсэхээ өөрсдөө сонгодог хэмээн ерөнхийлөгч Хинкли заасан байдаг. Гэхдээ бид шударга, зохистой байх нь маш чухал юм. Бид бусдаар шүүмжлүүлэх зүйлсийг хийх ёсгүй.

Бидний хэлэх үгс, бусдад хандах хандлага болон амьдралаа авч яваа байдал нь санваар атгагч ах нар, хөвгүүд хийгээд бид бүгдийн үр бүтээлтэй байдалд нөлөөлнө.

Санваарын бэлгийг үнэлж баршгүй юм. Энэ нь Бурханы үйлчлэгчийн хувьд ажиллах эрх мэдэл, өвчтөнийг, гэр бүлээ болон бусдыг адислах эрх мэдлийг өөртөө агуулж байдаг. Санваарын эрх мэдэл нь үхлийн хөшгөөс цааш гарч мөнхийн зүйлст хүрч чаддаг. Энэ дэлхийд үүнтэй зүйрлэх өөр юу ч үгүй билээ. Санваараа хамгаалан, эрхэмлэн дээдэлж, үүнийг эзэмшихээр зохистой амьдарцгаая.¹⁰

Хайрт ах нар минь, зөвт байдал бидний амьдралын алхам бүрийг чиглүүлэх болтугай. Өнөөдөр болон цаашид бид атгах санваарынхаа бурханлиг хүч чадлыг үргэлж авах зохистой хүмүүс байх болтугай. Бидний төлөө амьдарч, мөн бидний төлөө амиа өргөсөн Их Эзэн, Аврагч Есүс Христийн адил бид ч бас энэхүү санваарыг бусдын болон өөрсдийнхөө амьдралыг адислахад ашиглацгаая. Энэ бол миний залбирал, Түүний ариун нэрээр, амен.

Эшлэл

1. Сургаал ба Гэрээ 121:36-37.

2. Египетээс Гарсан нь 20:7.

3. Исаиа 1:18.

4. Сургаал ба Гэрээ 58:42.

5. Иохан 17:14-ийг үз. Сургаал ба Гэрээ 49:5.

6. “President Harold B. Lee’s General Priesthood Address,” *Ensign*, 1974 оны 1-р сар, 100.
7. Гордон Б.Хинкли, “What God Hath Joined Together,” *Ensign*, May 1991 оны 5-р сар, 71.
8. Гордон Б.Хинкли, “Personal Worthiness to Exercise the Priesthood,” *Лиахона*, 2002 оны 7-р сар, 60.
9. *The Teachings of Howard W. Hunter*, ed. Clyde J. Williams (1997), 130.
10. Гордон Б.Хинкли, *Лиахона*, 2002 оны 7-р сар, 58–61.

Ням гарагийн өглөөний хуралдаан

Ерөнхий чуулган

Ням гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Дамаск орох зам дээр хүлээн сууна

Ариун Сүнс

итгэл

үйлчлэл

ерөнхий чуулган

Дамаск орох зам дээр хүлээн сууна

Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх

Христийг мэдэхийн төлөө шаргуу эрэлхийлдэг хүмүүс эцэстээ Түүнийг мэдэх болно.

Дэлхийн түүхэнд болсон хамгийн гайхамшигт үйл явдлуудын нэг нь Дамаск орох замд болжээ. Та нар “чуулганыг хоосруулж, айлаас айлд орж... [Гэгээнтнүүдийг]... шоронд хийсэн”¹ Саул нэртэй залуугийн түүхийг сайн мэднэ. Саул маш түрэмгий байсан тул түүний уур хилэнгээс зугтахын тулд эртний сүмийн олон гишүүн Иерусалимыг орхиж явжээ.

Саул тэдний хойноос мөшгиж яваад Дамаскт ойртон ирэхэд гэнэт тэнгэрээс гэрэл гарч түүнийг хүрээлэн гэрэлтэхэд тэр газарт хөсөр унав. Тэгээд Саул аа, Саул аа, юунд чи намайг хавчина вэ?”² гэх дууг сонсчээ.

Энэ явдал Саулыг эргэлт буцалтгүйгээр өөрчилсөн төдийгүй дэлхийг ч мөн өөрчилсөн юм.

Үүн лүгээ адил илэрхийлэлт ирдгийг бид мэднэ. Тэр ч байтугай 1820 онд Иосеф Смит нэртэй хүүд ийм тэнгэрлэг зүйл тохиолдсоныг бид гэрчилдэг. Энэ бол тэнгэрийн үүд дахин нээгдэж, Бурхан бошиглогч, дагалдагчидтайгаа ярьдаг гэсэн бидний чин сэтгэлийн, баттай гэрчлэл билээ. Бурхан хүүхдүүдийнхээ залбирлыг сонсож, хариулдаг.

Зарим хүмүүс Саул болон Иосеф Смитэд тохиолдсон шиг зүйл өөрсдөд нь тохиолдсон үед л итгэнэ гэдэг. Тэд баптисмын усанд ойрхон ирсэн ч, дотор нь ордоггүй. Тэд гэрчлэлийн босгон дээр ирсэн ч үнэнийг хүлээн зөвшөөрдөггүй. Их Эзэний шавь болох замаар итгэлтэйгээр, бага багаар алхахын оронд өөрсдийг нь шууд итгүүлэх зүйлсийг тэд хүсдэг.

Тэд Дамаск орох зам дээр олон өдрийг өнгөрөөн хүлээж суудаг.

Итгэл нь алхам алхмаар ирдэг

Нэгэн эгч амьдралынхаа турш Сүмийн итгэлтэй гишүүн байжээ. Гэвч тэр зүрх сэтгэлдээ нэгэн шаналалыг тээж явдаг байлаа. Хэдэн жилийн өмнө охин нь өвчний улмаас нас барсан учир сэтгэл санааных нь шарх эдгэрээгүй байв. Ийм үед гарч ирдэг асуултууд түүнийг зовоож байлаа. Тэр хэчнээн хичээсэн ч ер ойлгохгүй байв. Гэрчлэл нь урьдынхтай адил байхаа болж, улмаар тэнгэр үүдээ нээхгүй л бол хэзээ ч дахин итгэхгүй гэж бодогдох болжээ.

Тэрээр итгэж, урагш ахихаа болж, дэмий хоосон хүлээж суудаг болов.

Өөр олон шалтгаанаар Дамаск орох зам дээр хүлээн суух болсон олон хүн бий. Тэд жинхэнэ шавь болох замаа хойшлуудаг. Тэд санваар хүртэх хүсэлтэй ч энэхүү онцгой боломжийг хүлээн авахуйц зохистой амьдрахаас түтгэлздэг. Тэд ариун сүмд орохыг хүсдэг ч, тийшээ орох боломжийг олгодог итгэлийн шалгуурыг хойш нь тавьж, аливаа эргэлзээ, айдас бүхнийг нь нэг мөсөн арилгаж өгөх Христийг, Карл Блокийн гайхамшигт уран зураг шиг тэдэнд авч ирж өгөхийг хүлээн суудаг.

Чухамдаа Христийн тухай сурч мэдэхийг шаргуу эрэлхийлсэн хүн хэзээ нэгэн цагт Түүнийг таньж мэдэх нь гарцаагүй. Тэд Бүтээгчийн бурханлиг төрхийг өөр дээрээ хүлээн авна. Гэхдээ энэ нь эвлүүлдэг тоглоом адил хэсэгчлэн ирдэг. Хэсэг болгоныг дангаар нь харахад хэцүү, зургийн аль хэсэг болохыг мэдэх нь хүндрэлтэй ч, хэсэг болгон нь бүхэл зургийг илүү сайн харахад бага багаар тусалдаг. Хангалттай хэсгүүдийг эвлүүлсний дараа л зургийн агуу бахдам үзэсгэлэнг олж хардаг. Бид үүн лүгээ адил туулсан амьдралаа эргэн харсан үедээ Аврагч үнэхээр бидэнтэй хамт байхаар ирснийг шууд, бүгдийг нэг дор олж мэдээгүй ч, алгуурхан, аажмаар, бараг анзаарагдахгүйгээр бүхний эцэст мадаггүй олж хардаг.

Бид хэрвээ Дамаск орох зам дээр удаан зогсолгүй, итгэлтэйгээр урагш явбал үүнтэй адил болж чадах юм.

Сонсож, анхаарал тавь

Бидний Тэнгэрлэг Эцэг хүүхдүүддээ хайртай гэдгийг би гэрчилж байна. Тэр бидэнд хайртай. Тэр танд хайртай. Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр Түүний амар амгаланг эрж хайвал шаардлагатай үед Их Эзэн саад бэрхшээлээс тань үүрэлцэнэ. Ихэвчлэн Тэр бидэнтэй зөвхөн зүрх сэтгэлд сонсогдохоор ярьдаг. Түүний дуу хоолойг сонсохын тулд бидний эргэн тойронд байгаа бусад чимээ шуугианы дууг багасгах хэрэгтэй. Ямар ч шалтгаан байсан Сүнсний өдөөлтийг ойшоохгүй буюу хаавал тэдгээрийг мэдрэхээ больж, эцэст нь огт сонсогдохоо больдог. Бүгдээрээ Сүнсний өдөөлтийн сонсож, дараа нь түүнд хүч чармайлт гарган анхаарал тавьж сурцгаая.

Бидний хайрт Бошиглогч Томас С.Монсон үүний тод жишээ юм. Сүнсний шивнээг анхааралтай сонсож чадсан тухай түүний түүхүүд олон. Ахлагч Жеффри Р.Холланд ийм нэгэн түүхийг дурсан ярьжээ.

Ерөнхийлөгч Монсон ажлын шугамаар Люизианад очиход хорт хавдарын сүүлийн үе шатанд хүрсэн Кристал нэртэй 10 настай охинтой очиж уулзах зав байгаа юу гэж тойргийн бишоп түүнээс лавлав. Кристалын гэр бүлийнхэн Ерөнхийлөгч Монсоныг ирээсэй хэмээн залбирч байжээ. Тэдний гэр хол учир тийшээ очих цаг байхгүй байв. Гэвч Ерөнхийлөгч Монсон тойргийн чуулганд залбирал хийх хүмүүсийг Кристал охиныг залбиралдаа оруулахыг гуйжээ. Их Эзэн болон гэр бүлийнхэн нь ойлгоно биз дээ гэв.

Ерөнхийлөгч Монсон бямба гарагийн чуулган дээр үг хэлэхээр гарч иртэл “Хүүхдүүдийг над уруу ирэхийг зөвшөөр. Тэднийг бүү хорь. Учир нь Бурханы хаанчлал тэдэн шиг хүмүүсийх юм” гэж Сүнс шивнэжээ.

“Түүний бичсэн үгс харагдахаа болив. Тэр үргэлжлүүлэх гэж хичээсэн ч охины дүр зураг, нэр санаанаас нь огт гарсангүй.”⁴

Тэр Сүнсний мэдрэмжийг дагаж, цагийн хуваарьтаа өөрчлөлт орууллаа. Очих зам хол учир 1 цаг гэхэд амжиж очихын тулд Ерөнхийлөгч Монсон өглөө эрт босч, яравчлан гарч, урт замыг туулж очив.

Очсоныхоо дараа тэр “босох чадалгүй, ярих тэнхэлгүй болсон охиныг харав. Өвчин бас түүнийг хараагүй болгожээ. Түүний байдлыг харж, зүрх сэтгэл нь шархиран эмзэглэж, Ариун Сүнснийг мэдэрсэн Монсон ах охины турьхан гарнаас барьлаа.

“Кристал, Би энд байна” гэж шивнэхэд охин маш их хүч гарган байж түүнд “Монсон ах аа, таныг ирнэ гэдгийг би мэдэж байсан” гэжээ.”⁵

Хайрт ах эгч нар аа, Саул Дамаск орох замдаа “Их Эзэн минь та надаар юу хийлгэх вэ?”⁶ гэж асуусны адилаар түүний шивнээг сонсож хариулах хүмүүсийн эгнээнд байхын төлөө чармайцгаая.

Үйлчил

Бид заримдаа Их Эзэний дуу хоолойг амьдралдаа танилгүй өнгөрөөдөг өөр нэг шалтгаан нь Сүнсний илчлэлтүүд бидний залбирлын шууд хариу болж ирдэггүйд байдаг.

Бид хувийн амьдралдаа тулгардаг асуулт, сэтгэл санаа зовоосон асуудлуудынхаа хариултыг эрэлхийлэхдээ эхлээд сайтар судалж, дараа нь зааварчилгаа авахаар Түүнд хандан залбирахыг Тэнгэрлэг Эцэг маань хүсдэг. Хариулт нь та нарын итгэлтэй найз нөхөд, гэр бүлийн хүмүүс, судар болон бошиглогчдын дуу хоолой, мэргэн ухаанаар дамжин ирж болно.

Бидэнд ирдэг сүнсний хамгийн хүчтэй өдөөлтүүд нь зөвхөн бидний тусын тулд төдийгүй харин бусдын тусын тулд ирдгийг би хувийн туршлагаасаа мэднэ. Хэрвээ бид зөвхөн хувиа хичээх юм бол өөрсдөдөө ирэх хамгийн хүчтэй сүнслэг илчлэлтүүд авах боломжоо алдана.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл энэхүү зарчмыг “Бурхан биднийг ажиглаж, харж хандаж байдаг. Гэвч Тэр ихэвчлэн бусдаар дамжуулж бидний залбиралд хариулдаг. Иймд, бид нэг нэгэндээ үйлчилж байх нь нэн чухал юм”⁷ хэмээн заасан байдаг. Ах эгч нар аа, бүгдээрээ хэрэгцээг мэдэрч, Аврагчтай адил хүмүүст туслан, адисалж, сэтгэлийн дэм өгөх ёстой гэрээт хүмүүс билээ. Заримдаа бидэнд чухал сануулгууд ирсэн ч бидний залбирлын шууд хариу биш хэмээн үл ойшоон өнгөрөөдөг. Гэхдээ тэдгээр нь хэн нэгнийх нь залбирлын хариу байхыг үгүйсгэх аргагүй юм.

Бидний залбирлын хариу ихэнхдээ өвдөг сөгдөн сууж байхад биш, харин Их Эзэнд болон эргэн тойрныхоо хүмүүст үйлчилж байхад ирдэг. Амь бие хайргүй үйлчилж, бүхнээ зориулах нь бидний сэтгэл санааг ариусган, сүнсний мэлмийг нээж, тэнгэрийн үүдийг дэлгэж өгдөг. Бид хэн нэгний залбирлын хариу болсноороо өөрсдийнхөө залбирлын хариуг авдаг.

Хуваалц

Их Эзэн зарим үед зөвхөн бидэнд зориулсан зүйлийг илчилдэг. Гэсэн ч Тэр ихэнхдээ үнэний тухай гэрчлэлийг бусадтай хуваалцах тэр хүнд итгэмжлэн өгдөг. Адамын үеэс өнөөдрийг хүртэл бошиглогч бүрд мөн ийнхүү өгсөн байдаг. Мөн Түүний сэргээгдсэн Сүмийн гишүүдийн хувьд “сайн мэдээг баяслын дуугаар тунхаглан, ам чинь бүх цаг үед нээлттэй...”⁸ байгаасай гэж Их Эзэн биднээс хүсэн хүлээдэг.

Энэ нь тийм ч амар зүйл биш. Зарим хүмүүс найз нөхөд, ажлынхантайгаа итгэл, шүтлэг бишрэлийн сэдвээр ярьснаас хэдэн мянган бээрийн урт замаар гар тэрэг чирч явах нь хавьгүй амар гэж үздэг. Хүмүүс яаж хүлээж авах бол, эсвэл харилцаагаа сэвтүүлчих вий хэмээн санаа зовдог. Ингэх хэрэггүй, учир нь бусадтай хуваалцах баярт мэдээ-аз жаргалын мэдээ, мөн баяр баяслын захиас бидэнд байгаа шүү дээ.

Олон жилийн өмнө манай гэр бүл голдуу биднээс өөр шүтлэг бишрэлтэй хүмүүсийн дунд ажиллаж амьдардаг байлаа. Амралтын өдрүүдээ яаж өнгөрөөсөн тухай лавлахад бид спортын арга хэмжээ, кино, цаг агаарын тухай ярилцахын оронд гэр бүлээрээ амралтын өдрүүдээр ямар сүнслэг зүйлс хийсэн тухайгаа хуваалцахыг хичээдэг байв. Ариун ёслолын цуглаан дээр нэгэн залуу *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишигт яаж нийцэх тухай юу гэж ярьсан эсвэл номлолд гарах гэж байгаа залуугийн хэлсэн зүйл яаж бидний сэтгэлийг уяраасан тухай ч юм уу аль нэг асуудлыг шийдвэрлэхэд сайн мэдээ, Сүм гэр бүлд минь хэрхэн тусалсан талаар ярилцдаг байлаа. Бид хэтэрхий номлож, хүндрүүлэхгүй байхыг хичээдэг байв. Миний эхнэр Хариет сүнслэг, сэтгэл сэргээсэн, хөгжилтэй зүйлсийг олж бусадтай хуваалцахдаа нэн гарамгай. Энэ нь ихэнхдээ

гүнзгий сэдэв уруу хөтөлдөг байлаа. Сонирхолтой нь, амьдралын бэрхшээлүүдийг даван туулах талаар найз нартайгаа ярилцахад тэд, “Та нарт бол амархан л даа. Сүм чинь байгаа шүү дээ” гэсэн тайлбар өгдөг байв.

Олон янзын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэрнээс ч олон төрлийн хэрэгцээтэй багаж төхөөрөмжүүд хэрэглээнд гарч ирж байгаа нь сайн мэдээг бусадтай хуваалцах ажлыг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр хялбар бөгөөд өргөн хүрээнд нөлөөлөх боломжтой болгож байна. Тэр ч байтугай миний өнөөдрийн үгийг сонсож байгаа хүмүүс дунд хэн нэг нь “Тэр 10 минутын турш ярьж байгаа ч одоогоор нисэх онгоцныхоо тухай ярихгүй л байна” гэж найздаа мессежээр бичиж суугаа байх гэдэгт би бараг эргэлзэхгүй байна. Миний залуу найз нар аа, бидний үед “ам (чинь) нээлттэй байг” гэсэн Их Эзэний уриан дээр сайн мэдээг зурвас илгээж, блогдох, мессеж илгээхдээ “гараа ашиглаж бай” гэсэн уриаг нэмж болох юм! Мэдээж зөв газар, зөв цагт гэдгийг санаж яваарай.

Ах эгч нар аа, бид орчин үеийн техник технологийн ачаар Бурхан хүүхдүүддээ зориулан бэлтгэсэн аугаа төлөвлөгөөнд баярлан талархаж байгаагаа зөвхөн ажил дээрээ биш харин дэлхий даяар сонсогдохоор тунхаглах боломжтой. Зарим үед гэрчлэлийн ганц үг өөр нэгэн хүний амьдралыг мөнхөд өөрчлөх хүчин зүйлсийг эхлүүлж болох юм.

Сайн мэдээг зааж тунхаглах хамгийн үр дүнтэй арга бол бусдад үлгэр жишээ үзүүлэх явдал мөн. Хэрвээ та итгэлийнхээ дагуу амьдарвал хүмүүс чамайг анзаарч эхэлнэ. Хэрвээ Есүс Христийн дүр төрх бидний амьдралд гэрэлтэж байвал, хэрвээ бид эргэн тойрны хүмүүстэйгээ эв нартай байж, аз жаргалаар дүүрэн байвал, хүмүүс яагаад гэдгийг асуух болно. Номлол хийж байхад заагдсан хамгийн агуу сургаалуудын нэг нь Ассисийн Гэгээн Францисын “Сайн мэдээг үргэлж номлож бай, гэхдээ зөвхөн шаардлагатай үед л үг хэрэглэж бай”¹¹ гэсэн энгийн үгс байдаг. Ингэх боломж бидний эргэн тойронд дүүрэн байна. Дамаск орох зам дээр удаан хүлээж, эдгээр боломжуудаа битгий алдаарай.

Дамаск орох бидний зам

Их Эзэн Өөрийн бошиглогч, дагалдагч нартай өнөө үед ярьдаг гэдгийг би гэрчилж байна. Мөн Түүнд чин сэтгэл, үнэн хүсэлтэйгээр ирж байгаа хүн бүхэнтэй Тэрбээр ярьдаг юм.¹²

Бүү эргэлз.”Хараагүй байж итгэсэн хүмүүс ерөөлтэй еэ!”¹³ гэдгийг санаж яваарай. Бурхан та нарт хайртай. Тэр та нарын залбирлыг сонсдог. Тэр хүхдүүдтэйгээ ярьдаг бөгөөд Түүнийг эрэлхийлж, Түүний замаар яван, Түүнийг дээдлэн хүндэлсэн нэгэнд

Тэрбээр урам дэм, ухаарал тайвшралыг өгдөг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бидний Аврагч Есүс Христээр удирдагдагддаг бөгөөд биднийг Түүн уруу аваачих зам мөн гэдэг ариун гэрчлэлээ би хэлж байна. Бидэнд амьд бошиглогч байдаг. Нэрийг нь бид өөрсөд дээрээ авсан Аврагч Есүс Христ энэ Сүмийг удирддаг.

Хайрт ах, эгч, найз нараа Дамаск орох зам *дээрээ* удаан хүлээхгүй байцгаая. Харин бүгдээрээ итгэл найдвартай, энэрэл хайртай, урам зоригтойгоор урагш алхацгаая. Тэгсэн цагт бид Түүний шавь болох замаар алхлахдаа бүгд хайж эрж байгаа тэрхүү гэрлийг олж авснаар адислагдна. Үүний төлөө би Есүс Христийн ариун нэрээр залбирч мөн адисалж байна, амен.

|

Эшлэл

|

1. Үйлс 8:3.

2. Үйлс 9:3-4.

3. Марк 10:14.

4. Жеффри Р.Холланд, “President Thomas S. Monson: Man of Action, Man of Faith, Always ‘on the Lord’s Errand,’” Тамбули, 1986 оны 11-р сар, 20-ийг үз.

5. Жеффри Р.Холланд, Тамбули, 1986 оны 10-11-р сар, 20.

6. Үйлс 9:6.

7. *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 82.

8. Сургаал ба Гэрээ 28:16.

9. Сургаал ба Гэрээ 60:2.

10. Алма 5:14-ийг үз.

11. In William Fay and Linda Evans Shepherd, *Share Jesus without Fear* (1999), 22.

12. Моронай 10:3--5-ыг үз.

13. Иохан 20:29.

Лиахона

2011 оны 5-р сар

Ням гарагийн өглөөний хуралдаан
2011 оны 4-р сарын 3

“Биднийг хайрладаг Түүгээр дамжуулан бид давуулан дийлдэг”

Далын Ахлагч

Пол В.Жонсон

Дэлхий ертөнц зовлон зүдгүүр, сорилт, шалгуураар дүүрэн байдаг бөгөөд бидний туулдаг зарим зовлон бэрхшээл нь үнэхээр хүнд, сэтгэл эмзэглүүлэм байдаг. Өвчин эмгэг, шударга бус, бусармаг явдал, сорилт бэрхшээл, байгалийн гамшиг, хайртай хэн нэгнээ алдах зэрэг зовлон зүдгүүр бол мөнх бус амьдралын нэгэн хэсэг билээ. Бидний ихэнх нь бид яагаад ийм хүнд сорилтуудыг даван туулах ёстой юм бэ гэж боддог. Сорилт бэрхшээлүүд бидэнд өгөгддөг нэг шалтгаан нь Их Эзэний өгсөн бүх зарлигуудыг бид дуулгавартай дагах эсэхийг харуулах итгэлийн шалгуур юм.¹ Энэ амьдрал нь сорилт бэрхшээлтэй тулгарч, түүнийг даван туулах төгс нөхцөл байдлыг бүрдүүлдэг юм.²

Гэвч хүнд сорилт бэрхшээлүүд нь зөвхөн биднийг сорихын төлөө биш харин бурханлиг мөн чанарыг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл болдог.³ Бид эдгээр бэрхшээлүүдийг зөв аргаар даван туулж чадвал эдгээр нь биднийг өсөн дэвжихэд тусалж адислал болдог.⁴

Ахлагч Оорсон Ф.Витни хэлэхдээ: “Бидний туулж өнгөрүүлсэн зовлон шаналал, бэрхшээлүүд бүгд үр ашиггүй өнгөрөөгүй юм. . . . Зовж шаналж, тэсвэр тэвчээрээрээ соригдоход, ялангуяа үүнийг тэвчээртэйгээр даван туулахад бидний зан араншин төлөвшин, зүрх сэтгэл цэвэршиж, бодол санаа тэлж, бид улам өрөвч, энэрэнгүй болдог . . . Мөн сорилт бэрхшээл, зовлон зүдгүүр, тэсвэр хатуужил тэмцлээр дамжуулан бид энэ дэлхийд олж авах ёстой мэдлэгээ хуримтлуулдаг юм”⁵ гэжээ.

Саяхан нэгэн есөн настай хүү ховор тохиолдох ясны хорт хавдар өвчин туссан юм. Энэ өвчнийг илааршуулахын тулд химийн эмчилгээ болон нарийн мэс засал шаардагдах бөгөөд энэ нь бяцхан хөвгүүн болон түүний гэр бүлийнхэнд хүндхэн тусах болно гээд:

“Энэ бүхний дараа би урьдын адил болох уу? гэж хүмүүс надаас асуухад ‘Үгүй ээ. Чи илүү хүч чадалтай, улам сайн болно!’ гэж би хэлдэг”¹ гэжээ.

Заримдаа бидний амьдрал болоод эмзэг сул тал уруу сорилт, шалгуурууд давшилж байгаа мэт санагдах үе байдаг. Энэ бүхний эцэст хувийн өсөлт дэвшил ирдэг учир бэрхшээл нь бидний онцлог, чухал хэрэгцээ, сул талуудыг онилж байгаад харвасан сум мэт ирдэгт гайхах хэрэггүй биз ээ. Үүнээс хэн ч зайлсхийж чадахгүй. Зарим дуулгавартай Гэгээнтнүүд “Яагаад би гэж? Би сайн байхыг хичээж байгаа! Их Эзэн яагаад надад ийм зүйл тохиолдохыг зөвшөөрч байгаа юм бол?” гэж асууж магадгүй. Зовлон бэрхшээлийн галд орох нь бүр хамгийн сайн Гэгээнтнийг ч цэвэр бус зүйлсээ таягдан хаяж, шижир алт лугаа адил цэвэрхэн болоход тусалдаг юм.⁶ Хамгийн баялаг агуулгатай хүдрийг ч цэвэршүүлэн баяжуулах шаардлагатай байдаг. Зүгээр л сайн байх нь хангалтгүй. Учир нь бид Аврагчтай адил болохыг хүсч байгаа бөгөөд Тэрээр суралцахын тулд бүх төрлийн зовлон зүдгүүр, уруу таталтуудыг даван туулсан билээ.⁷

Логан хавцал дахь Кримсон жимээр би аялах дуртай. Энэ жимийн гол хэсэг нь гүн хавцлын ирмэгээр гарч, хавцлын үзэсгэлэнт байдлыг зураг мэт гоёмсоор харуулдаг бөгөөд хавцлын ёроолд уулын хөндий харагдана. Уул өөд авиран гарахад тийм ч амархан биш. Жимээр өгсөн, огцом эгц газраар явах хэрэгтэй болдог бөгөөд оргилд нь хүрэхийн өмнөхөн уулчид өгсөхөд хамгийн хэцүү хэсэгт ирдэг. Гэсэн ч хадан хавцлын үзэсгэлэнт байдал нь уулын бэлд нуугдсан байдаг. Ийнхүү эцсийн хүчээ шавхан уулын оргил дээр гарахад биднийг байгалийн хосгүй үзэсгэлэнт сайхан байдал хүлээж байдаг. Байгалийн энэхүү хосгүй үзэсгэлэнг харахын тулд зөвхөн дээш авиран оргил дээр гарах хэрэгтэй.

Гайхамшигт үйл явдал агуу өсөлт хөгжилтийн яг өмнөхөн хамгийн хүнд хэцүү цаг үе, сорилтууд тохиолддогийг бид амьдралаасаа болон судраас мэддэг. “Учир нь их гай зовлонгийн дараа адислалууд ирдэг болой.”⁸ Израилын хүүхдүүд Улаан Тэнгисийн дундуур гарахынхаа өмнө хүнд байдалд орсон юм.⁹ Нифай гуулин ялтсуудыг олж авахаасаа өмнө олон аюулыг, түүнийг дотор уурлан хилэгнэсэн ах нарынхаа хорт явуулгыг болон хэд хэдэн бүтэлгүй оролдлогыг давж гарах шаардлагатай болсон.¹⁰ Иосеф Смит чөтгөрийн хүчинд санаандгүй автаж, бараг л цөхрөн бууж өгөхөд бэлэн болоод байхдаа бүх хүчээ шавхан Бурханыг дуудсан яг тэр агшинд Эцэг, Хүү хоёр түүн дээр хүрч ирсэн билээ.¹¹ Сонирхогчид баптисм хүртэхийнхээ өмнөхөн олон эсэргүүцэл,

сорилтуудтай тулгардаг. Эх хүн хүүхэд төрүүлэх хүнд агшныг давсны дараа шинэ хүн мэндэлсний гайхамшгийг мэдэрдэг. Үе үе хэцүү сорилт бэрхшээлүүд өнгөрсөн даруйд агуу адислалууд ирдгийг бид хардаг.

Эмээ маань 19 настайдаа хүндээр өвдсөн гэдэг. Хожим нь тэр “Би алхаж чадахаа больсон. Хэдэн сар хэвтэрт байсны дараа босоод алхах гэхэд зүүн хөл даагдахгүй байлаа. Яс маань бараг л резин шиг зөөлхөн болж, хөлөөрөө газар хүрэхэд цахилгаан гүйдэлд цохиулж байгаа юм шиг болж билээ”¹² гэж ярьсан юм. Эмээ хэвтэрт байх хэцүүхэн үедээ Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гарын авлагуудыг авч, уншиж эхэлсэн гэдэг. Тэр хожим нь Сүмд хөрвөж, баптисм хүртсэн юм. Хүнд сорилтууд биднийг ихэндээ ямар нэгэн хэрэгцээтэй, чухал зүйлд бэлтгэдэг.

Бидэнд тохиолдож буй өвчин зовлон, даруусгал, зүрх сэтгэлийн шаналлаас хожим нь ирэх адислалууд хамаагүй илүү байх болно гэдгийг хүнд байдалд орсон үедээ олж харах нь бараг л боломжгүй байдаг. “Бүх сахилгажуулалт нь тухайн үедээ уй гашуутай мэт санагдавч дараа нь энэ нь түүгээр сургагдсан хүмүүст зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг төрүүлж өгдөг.”¹³ Төлөөлөгч Паул, “Учир нь цаг зуурын ялихгүй зовлон нь бидэнд мөнх алдрыг үлэмж арвинаар бий болгож байна”¹⁴ гэж заажээ. Тэрээр “ялихгүй зовлон” гэдэг үгийг хэрэглэсэн нь хачирхалтай. Энэ бол зодуулж, чулуугаар шидүүлж, усан онгоцны сүйрэлд өртөж, шоронд хоригдож бас бусад олон зовлонг туулсан хүний амнаас гарсан үг юм. ¹⁵ Биднээс хэд нь өөрт тохиолдсон зовлонгоо ялихгүй зүйл гэж хэлж чадах бол? Гэвч бидний туулсан зовлон зүдгүүр энэ амьдрал болоод үүрд мөнхөд хүлээн авах бидний адислал, өсөлт дэвшилтийн хажууд үнэхээр ялихгүй зүйл юм.

Бид сорилт бэрхшээл, зовлон зүдгүүрийг эрж хайдаггүй. Амьдрал дахь аялал бидэнд шаардлагатай сорилтуудыг өгөх болно. Олон хүнд сорилт нь мөнх бус байдлын ердийн хэсэг боловч бидний өсөлт хөгжилтөнд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тэрбээр мөнх бус үйлчлэлийнхээ төсгөлд Гетсемани болон Голготад үнэхээр дааж давшгүй зовлон тарчлалыг амссан билээ. Энэ нь бидний бүх зовлон шаналал нэгэн цагт арилан алга болох болно гэсэн амлалтыг болоод амилуулалтыг улируулан тохиолгосон юм. Түүний зовлон шаналал хоосон булш, Улаан өндөгний баяр буюу Христийн Амилалт, бидний үхэшгүй байдал болон мөнх амьдралд зайлшгүй шаардлагатай байсан.

Заримдаа бид ямар ч бэрхшээлгүйгээр өсч хөгжин, ямар ч тэмцэлгүйгээр хүчирхэг болохыг хүсдэг. Гэвч өсөлт хөгжилт нь амар хялбараар ирдэггүй билээ. Тамирчид бэлтгэл сургуульгүйгээр хэзээ ч дэлхийд алдартай тамирчин болж чадахгүйг бид сайн мэддэг. Бурханлиг мөн чанарыг хөгжүүлэхэд бидэнд тусалдаг зүйлст гомдоллохгүй байхыг хичээе.

Ямар ч сорилт бэрхшээл нь бидний хэрээс буюу хүч чадлаас хэтэрсэн байдаггүй. Учир нь бид Их Эзэнээс тусламж авах эрхтэй. Биднийг үргэлж хүчирхэгжүүлж байдаг Христээр дамжуулан бид бүх зүйлийг хийж чадна.¹⁶

Ахлагч Роберт Д.Хейлс хүндээр өвдөөд эдгэрснийхээ дараа ерөнхий чуулган дээр ийнхүү ярьсан билээ. “Хэд хэдэн тохиолдолд би Их Эзэнд ‘би сурах ёстой зүйлсээ сурлаа, одоо би үүнээс илүү зовлонг тэвчих шаардлагагүй’ гэж хэлж байсан. Иймэрхүү хүсэлт нь үр дүнгүй юм шиг санагдаж билээ. Учир нь сорилт бэрхшээлээс ирэх цэвэршүүлэлтийн энэхүү үйл явц нь Их Эзэний цаг хугацаа, тааллаар болдог нь тодорхой юм. Сорилт бэрхшээл дунд намайг ганцааранг нь орхиогүйг харин миний эргэн тойронд намайг харж хандан, хамгаалах тэнгэр элчүүд байсныг би ойлгосон. Тэнгэр элч гэж хэлж болмоор эмч, сувилагч нар дэргэд минь байсан бөгөөд тэдний дундаас хайрт гэргий Мэригээ би онцлон хэлмээр байна. Үүнчлэн Их Эзэний хүслийн дагуу хэрэгтэй цаг мөчид тэнгэрлэг дайчид ирж надад тайтгарал, үүрд мөнхийн дэмжлэгийг авчирсан юм.”¹⁷

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд “Бурханд найдлага тавьсан хэн боловч өөрсдийн зүдгүүрүүдэд, мөн өөрсдийн бэрхшээлүүдэд хийгээд зовлонгуудад дэмжигдэх болно мөн эцсийн өдөр өргөгдөх болно”¹⁸ гэдгийг би мэднэ. Бид нэгэн өдөр хөшигний нөгөө талд гарахдаа хэн нэгэн нь бидэнд зөвхөн “За, чи сайн байлаа” гэж хэлэхээс илүүг хүсэх болно. Бид Их Эзэнийг “Сайн байна, итгэмжит сайн боол минь”¹⁹ гэж хэлээсэй гэж хүсэх болно.

“Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, гай зовлон уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэн байдал уу, аюул уу, илд үү?...”

Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжуулан давуулан дийлдэг”²⁰ гэсэн Паулын үгсэд би дуртай.

Бурхан, Түүний Хүү Есүс Христ хоёр амьд гэдгийг би мэднэ. Мөн бид Тэдний тусламжтайгаар амьдралд тохиолдох олон саад бэрхшээлийг “давуулан дийлж” чадна. Бид тэдэнтэй адилхан болж чадна. Есүс Христийн нэрээр, амен.

Эшлэл

1. 1 Петр 1: 6–8; Абрахам 3:25-ыг үз.
2. 1 Петр 2:20-ийг үз.
3. 2 Петр 1:4-ийг үз.
4. 2 Нифай 2:2-ыг үз.
5. Оорсон Ф.Витни, in Spencer W. Kimball, *Faith Precedes the Miracle* (1972), 98.
6. Исаиа 48:10; 1 Нифай 20:10-ыг үз.
7. Алма 7:11–12-ыг үз.
8. Сургаал ба Гэрээ 58:4.
9. Египетээс Гарсан нь 14:5–30-ийг үз.
10. 1 Нифай 3–4-ийг үз.
11. Иосеф Смит—Түүх 1:15–17-г үз.
12. Амали Холленвегер Амачер, зохиогчийн эзэмшилд байгаа, нийтлэгдээгүй түүх.
13. Еврей 12:11.
14. 2 Коринт 4:17.
15. 2 Коринт 11:23–28-ыг үз.
16. Филиппой 4:13-ыг үз.

17. Роберт Д.Хейлс, “The Covenant of Baptism: To Be in the Kingdom and of the Kingdom,”

Лиакона, 2001 оны 1-р сар, 6.

18. Алма 36:3.

19. Матай 25:21.

20. Ром 8:35, 37.

Ням гарагийн өглөөний хуралдаан

Ерөнхий чуулган

Ням гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Биднийг ариусгагч халамжийн ажил

Тэргүүлэх бишоп

Х.Давид Бертон

халамж

хайр, энэрэл

бие даах чадвар

ерөнхий чуулган

Биднийг ариусгагч халамжийн ажил

Бие биедээ анхаарал халамж тавьж, “ядуучуудад элэгсэг дотно” хандах нь Тэнгэрлэг Эцэгийн зарлиг болгосон ариусгагч ажил юм.

Өглөөний мэнд, ах эгч нар аа. 1897 онд залуу Давид О.МкКей Шотландын Стерлинг номлолд үйлчилж байхдаа байнга хаалга тогшин хүмүүстэй уулздаг байлаа. Харин тэр өдөр хаалга тогшиход тун ядруухан царайтай, хацар нь хонхойж, үс нь сэгсийсэн, хувцас муутай эмэгтэй хаалга онгойлгож түүний өөдөөс харан зогсож байв.

Тэр эмэгтэй Ахлагч МкКейн өгсөн товхимлыг аваад: “Энэ чинь намайг талхтай болоход тусалж чадах уу?” гэж асуужээ. Эдгээр үгсийг Ахлагч МкКей хожим огт мартаагүй ажээ.

Энэ тохиолдол залуу номлогчид маш том сургамж болсон гэнэ. Хожим нь тэрээр ийн бичжээ. “Тэр үед би Христийн Сүм гэдэг чинь хүмүүсийн материаллаг ахуй амьдралд санаа тавих ёстой юм байна гэдгийг гүнзгийгээр ухаарсан юм. Хүмүүс болон Бурханд голдоо ортол гомдсон тэр эмэгтэй. . . сайн мэдээний захиасыг хүлээн авах тэнхэлгүй байгааг ухааран би тэднийхээс явсан юм. Түүнд материаллаг тусламж хэрэгтэй байсан ч миний олж мэдсэнээр Стерлингд л лав түүнд тусалчихаар байгууллага байсангүй .”¹

Тэр үеэс хойш дөчөөд жилийн дараа дэлхий, Эдийн засгийн их хямралын дарамтанд сөхөрсөн. Яг энэ үед буюу 1936 оны 4-р сарын 6-нд Ерөнхийлөгч Хебер Ж. Грант болон түүний зөвлөх Ж.Рюбен Кларк, Давид О.МакКей нар хожим нь “Сүмийн халамжийн хөтөлбөр” гэж нэрлэгдсэн хөтөлбөрийг танилцуулсан юм. Хоёр долоо хоногийн дараа Ахлагч Мелвин Ж.Баллард уг хөтөлбөрийн анхны удирдагчаар, Харольд Б.Лий анхны үйл ажиллагаа хариуцсан захирлаар томилогдсон нь сонирхолтой юм.

Энэ бол ер бусын зоримог хүч чармайлт байлаа. Их Эзэн хэдийгээр хөтөлбөрийг удирдуулахаар гайхамшигтай хүмүүсийг бэлтгэсэн ч Ерөнхийлөгч Ж.Рюбен Кларк дараах тодруулгыг хийжээ. Тэрээр: “Халамжийн хөтөлбөр нь Ариун Сүнсээр Ерөнхийлөгч Грантад ирсэн илчлэлтийн үр дүнд бий болсон бөгөөд тэр үеэс хойш дээрх илчлэлттэй адил илчлэлтүүдийг уг хөтөлбөрийг хариуцсан ах нарт өгч байгаа учраас энэ нь амжилттай хэрэгжиж байна”² хэмээн хэлсэн.

Сүмийн удирдагчдаас хүмүүний зовлонг нимгэлэх шийдвэр гарах нь тодорхой бөгөөд зайлшгүй байлаа. “Өртөг зардлаас үл хамааран хүмүүст хүрч, тэдэнд туслах тогтолцоог” Ерөнхийлөгч Грант бий болгохыг хүсч байлаа. “Хүмүүсийг өлсгөлөнгөөс аврахын төлөө шаардлагатай бол семинарыг хааж, номлолын ажлыг түр хугацаагаар зогсоож, тэр ч байтугай ариун сүмүүдийг ч хүртэл хаах зэрэг алхмуудыг хийхэд бэлэн байна”³ гэж тэр мэдэгдсэн.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Никарагуагийн Манагуад 11,000 хүний амийг авч одсон гамшигт хар салхинаас эсэн мэнд үлдсэн Сүмийн 1300 гишүүнд хандаж үг хэлэхэд нь би хамт байсан. Тэрбээр: “Сүмд нөөц боломж байсан цагт та нар өлсгөлөн болон хувцас хунар, орон гэрийн талаар санаа зоволтгүй. Их Эзэний тогтоосон жишгээр та бүхэнд туслахын тулд бид чадах бүхнээ хийх болно”⁴ гэж хэлж билээ.

Сайн мэдээн дээр тулгуурласан, сүнслэг нөлөө бүхий энэ ажлын нэг онцлог нь хувийн хариуцлага, бие даах чадварт онцгой анхаарал хандуулдаг явдал юм. Ерөнхийлөгч Марион Ж.Ромни: “Ядарч зовсон хүмүүст туслахын тулд сайн санаат хүмүүс олон янзын хөтөлбөр санаачилсан байдаг. Гэхдээ эдгээр хөтөлбөрүүдийн ихэнх нь хүмүүст “цаашид бие даан амьдрахад” нь туслахгүй, зөвхөн “түр хугацаагаар асуудлаа шийдэхэд” нь чиглэсэн байдаг гэжээ.

Бие дааж амьдарна гэдэг нь арвич хямгач байж, төсөв, төлөвлөгөөтэй ажиллаж сурахыг хэлнэ. Үүсгэн байгуулагдсанаасаа хойш Сүм нь гэр бүлүүд материаллаг хэрэгцээгээ чадлынхаа хэрээр өөрсдөө хангах хэрэгтэй гэж заасаар ирсэн билээ. Бие дааж амьдрах ухааны суурь болох өрөөс зайлсхийх, арвич хямгач байх, хүнд бэрх цагт бэлтгэх, амьд бошиглогчдын үгийг сонсож дагах, хэрэгцээ хүсэл хоёроо ялгаж сурах мөн боломжийнхоо хэрээр амьдрах зэрэг зарчмуудыг үе үеийнхэн шинээр сурах шаардлагатай болдог.

Ядуу болон тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг халамжлах ажлын зорилго, амлалт, зарчмууд нь мөнх бус энэ амьдралаар хязгаарлагдаггүй билээ. Энэ ариун ажил нь зөвхөн зовж зүдэрсэн буюу тусламж хэрэгтэй хүмүүст ашиг тусаа өгдөг юм биш. Бурханы охид хөвгүүдийн хувьд бид энэ дэлхийд байх хугацаандаа өөрт байгаагаа ядуустай хуваалцахгүйгээр селестиел хаант улсад орж чадахгүй. Учир нь зөвхөн сэтгэл харамгүйгээр золиослол хийж, бусдын төлөө явснаар бид селестиел хаант улсын золиос болон өргөлийн зарчмыг ойлгодог.⁶

Хаан Бенжамин: “Бид Бурханы өмнө гэмгүйгээр алхахын тулд ядуустай байгаа юмаа хуваалцаж, тэдэнд туслах нь ...өдрөөс өдөрт нүглүүдийнхээ ангижралыг хадгалан үлдэхийн төлөө юм” гэж заасан байдаг.⁷

Дэлхий бүтээгдсэнээс хойшх зөв шударга нийгмийн салшгүй хэсэг нь энэрэл байжээ. Бид амар амгалан дэлхий, хөгжин цэцэглэсэн нийгмийг хүсэн мөрөөддөг билээ. Бид бусармаг явдлыг зайлуулж, сайн сайхан, зөв шударга үйлс ноёрхсон найрсаг мөн ариун журамт нийгэмд амьдрахын төлөө залбирдаг. Бид хэчнээн олон ариун сүм барьсан ч, сүмийн гишүүдийн тоо хэчнээн нэмэгдсэн ч дэлхийн нүдэнд хэчнээн сайхан харагдсан ч хэрэв

бид “сул доройчуудад тусалж, доош унжсан гарнуудыг өргөн, сул дорой өвдөгнүүдийг хүчирхэгжүүл”⁸ гэсэн хамгийн чухал зарлигийг биелүүлэхгүй эсвэл зовж зүдрэн, уй гашууд автсан хүмүүсээс нүүрээ буруулбал зэмлэл хүлээн, Их Эзэний⁹ сэтгэлд хүрэхгүй болно. Сайн сайхан нийгэм байгуулах зүрх сэтгэлийнхээ хүслийг биелүүлж чадахаа болино.

Эдүгээ дэлхий даяар бараг 28,000 бишоп тусламж хэрэгтэй хүмүүсийг тодорхойлж, тэдэнд туслахаар ажиллаж байна. Санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчид, тэдний дотор энэ хэрэгт нэгэн үзүүрт сэтгэлээр ханддаг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нар бишопт тусалдаг билээ. Тэд “танихгүй нэгэнд туслахаар яаравчилж; . . . зовлонд унаж, шаналагсдын зүрхэнд тос, дарс дусааж; . . . өнчрөгсдийн нулимсыг хатааж, бэлэвсэн эмэгтэйн сэтгэл зүрхийг баярлуулж”¹⁰ чаддаг юм.

Хөршүүдээ хайрлаж, тэдний төлөө санаа тавих сургаал болон бурханлиг мэдрэмж нь дэлхий даяарх Сүмийн гишүүд, удирдагчдын зүрх сэтгэлийг зөөлрүүлж, тэдэнд удирдамж болж байна.

Өмнөд Америкийн нэгэн гадасны гишүүдэд учирсан өлсгөлөн, гачигдал нь санваартан удирдагчийн санааг ихэд зовоох болжээ. Хүүхдүүд өлсөж байхыг хараад тэр зүгээр суухыг тэвчсэнгүй, хэсэг сул газар олж, хагалан, ногоо тарихад санваартнуудыг уриалсан аж. Тэд нэг хөгшин морь, муухан анжис олж газраа боловсруулж эхэлжээ. Гэвч ажлаа дуусгахаас өмнө гай дайрч, нөгөөх хөгшин морь нь үхчихэж гэнэ.

Ах, эгч нараа өлсгөхгүйн тулд санваартан ах нар нөгөөх хуучин анжисыг өөрсдөө чирэн, хатуу газрыг хагалж эхэлжээ. Тэд жинхэнэ утгаараа ах, эгч нарынхаа зовлонгийн буулганд өөрсдөө орцгоосон юм.¹¹

Миний гэр бүлд тохиолдсон нэг явдал тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавихын үлгэр жишээ болсон юм. Вилли, Мартин нарын гар тэрэгтнүүдийн бүлэг болон итгэлтэй тэрхүү анхдагчид өрнөд уруу хийсэн аяны үед хөхөө өвлийн хүйтнээр хүнд хүчир аянаас болж хэрхэн амь насаа алдаж байсан тухай олон хүн сонсож байсан биз ээ. Миний элэнц өвөг эцгүүдийн нэг Роберт Тейлор Бэртон бол гай зовлонд унаж, хээр талд

үрэгдэж буй хөөрхий Гэгээнтнүүдэд тусалж, тэднийг аврахаар Бригам Янгийн илгээсэн хүмүүсийн нэг байсан.

Тэр үеийн тухай өвөг эцэг минь өдрийн тэмдэглэлдээ: “Цас зузаан хунгарлаж, хүйтэн жавар тачигнаж байлаа. Бүр хөдөлж ч чадахгүй болтол хүйтэрч байна. Хасах 24 хэм хүйтэн байна . . . аянаа үргэлжлүүлэх боломж алга” гэж бичжээ.

Хээр талд зовж буй Гэгээнтнүүдэд [аврагчид] эн тэргүүний хэрэгцээт зүйлсийг хүргэж өгөн, чадах бүхнээ хийсэн ч олон хүний амь эрсдэж, тэднийг замын дэргэд оршуулсан юм” гэж бичжээ.

Аврагдсан Гэгээнтнүүд Цуурайт Хавцлын дундуур өнгөрөх үед нэг бяцхан охин дэлхийд мэндэлжээ. Роберт саяхан төрсөн нярай хүүхдээ дааруулахгүй өлгийдчих олигтойхон даавуу ч залуу эхэд байхгүйг ажигласан гэнэ. Хүйтэн жавар тачигнаж байсан ч тэр “гар хийцийн цамцаа тайлж, хүүхдээ [өлгийд] гэж өгчээ”.¹⁴ Тэр хүүхдэд Цуурайт буюу--- Цуурайтын Эзэн хэмээн төрсөн газар, нөхцөл байдлыг нь дурссан нэр хайрласан гэнэ.

Хожим нь Роберт Сүмийн Тэргүүлэх бишопын зөвлөлд дуудагдаж, гуч гаруй жил үйлчилсэн юм. Роберт Тейлор Бертон 86 настайдаа хүндээр өвчилж, сүүлчийн адислалаа өгөхөөр гэрийнхнээ орныхоо дэргэд цуглуулсан аж. Түүний сүүлчийн гэрээс үгсийн дотор “Ядуучуудад нинжин сэтгэлээр хандаж бай”¹⁵ гэсэн эгэл даруухан атлаа агуу зөвлөгөө байв.

Ах эгч нар аа, Өөрийн Сүмийн тусламж хэрэгтэй гишүүдэд хүрч туслах өргөн хүрээтэй хөтөлбөрийг хэрэгжүүлж, удирдахаар Их Эзэний дуудсан тэр агуу хүмүүст бид талархаж байна. Өнөө үед олон арга замаар, ихэнх тохиолдолд нэрээ мэдэгдэхгүйгээр ядуучуудад “нинжин сэтгэлээр хандаж” өлссөнийг хооллож, нүцгэнийг хувцаслан, өвчтөнүүдэд үйлчилж, боолчлогдогсдыг эргэж очдог хүмүүст бид талархаж байна.

Энэ бол Аврагч шавь нараасаа хүсэн хүлээдэг ариун ажил юм. Энэ ажлыг Тэрбээр дэлхий дээр амьдарч байхдаа дуртайяа хийдэг байсан юм. Хэрэв өнөөдөр Тэр бидэнтэй хамт байсансан бол энэ л ажлыг хийх байсан гэдгийг би мэднэ.¹⁶

Далан таван жилийн тэртээ хүн төрөлхтний сүнслэг болон материаллаг сайн сайхан байдлыг хангах зорилготой хөтөлбөр дөнгөж эхэлж байсан билээ. Тэр цагаас хойш энэ хөтөлбөр нь дэлхий даяар хэдэн арван сая хүний амьдралыг дээшлүүлж, адислаад байна. Бошиглолоор бий болсон халамжийн энэхүү төлөвлөгөө нь Сүмийн түүхэн дэх жирийн нэгэн сонирхолтой хэсэг биш. Энэ хөтөлбөрийн тулгуур зарчмууд нь биднийг ямар хүн вэ гэдгийг тодорхойлдог юм. Энэ нь Үлгэр жишээ үзүүлэгч, Аврагч Есүс Христийн шавь нар бид чухам хэн болохыг тодорхойлдог.

Бие биедээ анхаарал халамж тавьж, “ядуучуудад нинжин сэтгэлээр хандах” ажил нь биднийг ариусгадаг билээ. Энэ ажлыг Эцэг бидэнд зарлиг болгосон бөгөөд энэ нь Түүний хүүхдүүдийг адислан, төгөлдөржүүлж, өргөмжлөх бурханлиг зорилготой юм. Сайн самари хүний тухай сургаалт зүйрлэлд Аврагч нэгэн хуульчид: “Явж, үүний адил үйлдэгтүн”¹⁷ хэмээн өгсөн зөвлөгөөг бүгдээрээ дагацгаая. Үүнийг би Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

Эшлэл

1. *Cherished Experiences from the Writings of President David O. McKay*, Clare Middlemiss, (1955), 189-тэй харьцуул.

2. Ж.Рюбен Кларк, “Testimony of Divine Origin of Welfare Plan,” *Church News*, 1951 оны 8-р сарын 8, 15; Глен Радд, *Pure Religion*, (1995), 47.

3. Глен Л.радд, *Pure Religion*, 34.

4. “President Hinckley Visits Hurricane Mitch Victims and Mid-Atlantic United States,” *Ensign*, 1999 оны 2-р сар, 74..

5. Марион Г.Ромни, “The Celestial Nature of Self-Reliance,” *Liahona*, Mar. 2009 оны 3-р сар, 15.

6. Сургаал ба Гэрээ 104:15–18; мөн Сургаал ба Гэрээ 105:2–3-ыг үз.

7. Мозая 4:26, 27-г үз .

8. Сургаал ба Гэрээ 81:5; мөн Магай 22:36–40-ийг үз.

9. Сургаал ба Гэрээ 104:18-ыг үз.

10. Joseph Smith, in *History of the Church*, 4:567–568.

11. Халамжийн Үйлчлэлийн Газрын гүйцэтгэх захирал асан Харольд К.Браунтай хийсэн ярилцлага.

12. Journal of Robert T. Burton, Church History Library, Salt Lake City, 1856 оны 11-р сар, 2-6.

13. Robert Taylor Burton, in Janet Burton Seegmiller, “*Be Kind to the Poor*”: *The Life Story of Robert Taylor Burton* (1988), 164.

14. Lenore Gunderson, in Jolene S. Allphin, *Tell My Story, Too*, tellyourstory.com/art_imagepages/image43.html.

15. Robert Taylor Burton, in Seegmiller, “Be Kind to the Poor,” 416.

16. Диегер Ф.Угдорф, “You Are My Hands”-ыг үз, *Лиахона*, 2010 оны 5-р сар.

17. Лук 10:37.

Лиахона

2011 оны 5-р сар

Шавь байхын утга учир

Сильвия Х.Оолред

Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Их Эзэн цаг хугацааны эхлэлээс өнөөг хүртэл Өөрийнхөө хүмүүсийг нэг зүрх сэтгэл, нэг оюун ухаантай байх хэрэгтэй хэмээн заасаар ирсэн билээ.¹ Аврагчийн хуулин дахь агуу хоёр зарлиг нь “Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа Бурхан Эзэнээ хайрла,” “Чи хөршөө өөрийн адил хайрла”² хэмээх зарлигууд юм. Сүм дахин зохион байгуулагдсаны дараахан Их Эзэн “ядуус хийгээд гачигдагсад зочлон мөн тэдэнд тусалж”³ байхыг Гэгээнтнүүдэд зарлигласан билээ.

Эдгээр зарлигууд нь юугаараа нийтлэг вэ? Энэ нь бид бие биеэ хайрлаж, бие биедээ үйлчлэх ёстой гэсэн санааг агуулдаг бөгөөд энэ нь Есүс Христийн үнэн Сүм дэх шавь буюу дагалдагч байхын гол утга учир юм.

Бид Сүмийн Халамжийн хөтөлбөрийн 75 жилийн ойг тэмдэглэхдээ гишүүдийг бие даах чадвартай болоход нь тусалж, ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг анхаарч халамжлах, үйлчлэх халамжийн зорилгыг санах ёстой. Сүм гишүүдийнхээ болон тэдний гэр бүл, бусад хүмүүсийн биемахбод, нийгэм, сэтгэл санааны болон сүнслэг байдалд нь туслахын тулд нөөц боломжуудаа нэгтгэж зохион байгуулсан юм. Бишоп нь ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавих, тойргийнхоо гишүүдийн төлөө Сүмийн нөөц боломжуудыг ашиглан зохион байгуулах онцгой үүрэг хариуцлагыг хүлээдэг. Бишопын энэ ажилд санваартны чуулга, Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар түүнчлэн гэрийн болон айлчлагч багш нар тусалдаг.

Нийгмийн Халамжийн бүлгийнхэн халамжийн ажлын тэргүүн эгнээнд ямагт явсаар ирсэн билээ. Бошиглогч Иосеф Смит 1842 онд Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулаад, эмэгтэйчүүдэд хандан: “Энэ бол ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийн хувьд сайхан цагийн эхлэл юм”⁴ гэжээ. Тэрбээр энэхүү бүлгийн зорилго нь ядуус, үгээгүйчүүд, бэлэвсэн эмэгтэйчүүд, өнчин хүмүүст бүхий л талаар тусалж, буян үйлдэх явдал мөн... Тэд зовж зүдэрсэн хүмүүсийн шархалсан зүрхэнд тос, дарс асгаж, өнчин хүмүүсийн нулимсыг дэвтээн, бэлэвсэн эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлд баяр баясгаланг авчрах болно”⁵ гэдгийг хэлжээ.

Мөн тэрбээр нийгмийн халамж нь “Ядуус, энэрлийн болоод эд зүйлсийн тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавьж, тэдний хэрэгцээг хангах, ёс суртахууныг залруулж, нийгмийн үнэт зүйлсийг бэхжүүлэхийн төлөө ах нарыг сайн үйлсэд өдөөх болно”⁶ гэж тунхагласан байна.

Сүмийн эрэгтэй, эмэгтэйчүүд өнөөдөр тусламж хэрэгтэй хүмүүст туслах үйлсэд хамтран ажиллаж байна. Санваартнууд сүнслэг удирдамж, туслалцаа хэрэгтэй байгаа хүмүүст нэн чухал дэмжлэг үзүүлэн гэрийн багш нар айл бүрийн амьдралыг адисалж, сайн мэдээний адислалуудыг хүртэхэд нь тусалж байна. Түүнээс гадна тэд гэр орондоо засвар хэрэгтэй гэр бүлд болон нүүхэд туслах, ажилгүй байгаа хэн нэг ахад ажил олоход нь туслахын тулд хүч боломж, авьяас чадвараа зориулдаг.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нар гэр бүлүүдэд хэрэгцээтэй ямар зүйл байгааг мэдэж бишопод тодорхойлж өгөхийн тулд айлуудаар очдог. Сүнслэг нөлөө бүхий айлчлагч багш нар гэр бүлүүдийг харж хандан, анхаарал халамж тавьдаг. Тэд ихэнх тохиолдолд тулгамдсан асуудалд анхлан хариу өгөгчид болдог. Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар нигүүлсэнгүй сэтгэлээ харамгүй өгч, хоол хүнсээр туслан хүнд сорилт бэрхшээлийн үед байнгын дэмжлэг туслалцаа үзүүлэгч байдаг.

Дэлхий даяарх Сүмийн гишүүд өнгөрсөн үеэрээ бахархан өнөө үед бусдад үйлчлэх боломжтой байгаадаа баярладаг билээ. Бид хамтын хүч чармайлтаараа ядуус, өлсөж, зовж зүдэрсэн, санаа сэтгэлээр унасан хүмүүст тусалдаг бөгөөд үүгээрээ бодгалиудыг авардаг.

Бишоп бүр Их Эзэний агуулахыг ашиглах боломжтой юм. Энэ агуулахыг “итгэлтэй гишүүд ядуусд анхаарал халамж тавьж, Бурханы хаант улсыг дэлхий дээр байгуулахын тулд цаг зав, авьяас билэг, ур чадвар, өрөвч нигүүлсэнгүй сэтгэл, эд материал, мөнгө төгрөгөө бишопт хандивласнаар үндэслэн байгуулдаг билээ.”⁷ Бид мацгийн өргөлөө төлж, гачигдагсад туслахад нь бишоптоо өөрсдийн бүхий л нөөц бололцоогоор хандсанаар Их Эзэний агуулахад хувь нэмрээ оруулж чадна.

Хэдийгээр дэлхий дээр бүх зүйл хувьсан өөрчлөгдөж байгаа ч халамжийн зарчмууд нь бурханлигаар нөлөөлөгдсөн, илчлэгдсэн учраас цаг хугацаа улиран өнгөрөхөд ч өөрчлөгддөггүй юм. Сүмийн гишүүд болон гэр бүлүүд амьдралаа өөд нь татахын тулд чадах бүхнээ хийснээр өөрсдийгөө тэтгэж чадна. Харин үндсэн хэрэгцээгээ хангаж чадахгүй бол Сүм туслахад бэлэн байдаг. Тусламж хүлээн авагчид түр зуурын хэрэгцээт зүйлсийг яаралтай шийдвэрлэж өгдөг бөгөөд бие даах чадвартай болоход нь туслах

төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг. Бие даах чадвар бол өөрийгөө болон гэр бүлээ сүнслэг болон эн тэргүүний хэрэгцээт материаллаг зүйлсээр хангах чадвартай болох явдал юм.

Бид бие даах чадвараа дээшлүүлснээр Аврагчийн арга замаар бусдад тусалж, үйлчлэх чадвараа дээшлүүлж чадна. Бид тусламж хэрэгтэй, өвчтэй буюу зовж зүдэрсэн хүмүүст үйлчилснээр Аврагчийн үлгэр жишээг дагадаг. Бусдад анхаарал халамж тавих үйлсэд хайрыг эн тэргүүнд тавьснаар бидний үйлчлэл сайн мэдээний үйлс болдог. Энэ бол сайн мэдээний сэтгэл догдлом агшин, цэвэр ариун шүтлэг бишрэл юм.

Миний бие Сүмийн олон төрлийн ажил үүргийг биелүүлэх явцдаа бишоп, Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгчдийн гишүүддээ үзүүлдэг хайр, халамжийг хараад даруусдаг байлаа. Намайг 1980-аад оны эхээр Чилийн нэгэн гадасны Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгчөөр үйлчилж байхад тус оронд эдийн засгийн гүнзгий хямрал болж, ажилгүйдлийн хэмжээ 30 хувьд хүрэв. Тэр хэцүү нөхцөл байдалд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч болон айлчлагч багш нар хэрхэн “сайныг үйлдэж”⁸ явсныг би гэрчилж чадна. Тэд Сургаалт Үгс 31:20 дахь: “Ядуу хүнд гараа сунгадаг. Гачигдаж дутагдсан хүмүүст тусалдаг” гэсэн судрыг биелүүлэгчид байсан юм.

|Өөрсдийнх амьдрал хомс тарчигхан байсан эгч нар ч өөрсдөөс нь илүү их тусламж хэрэгтэй гэж бодсон хүмүүст байнга тусалдаг байлаа. Тэр үед би Аврагч маань Лук 21:3–4 дэх үгсийг хэлэхдээ юу харсныг илүү тодорхой ойлгосон юм:

“Би та нарт үнэнээр хэлье. Энэ ядуу бэлэвсэн эмэгтэй бүхнээс илүүг өглөө.

Учир нь тэд бүгд илүүдлээсээ өргөлд хийсэн атал харин энэ эмэгтэй ядуу хэрнээ амин зуулгандаа хэрэгтэй байсан бүхнээ өглөө.”

Хэдэн жилийн дараа би Аргентинд гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа мөн ийм зүйлийн гэрч болсон юм. Тэр үед улс оронд мөнгөний ханш маш ихээр унаж, эдийн засгийн хямралд нэрвэгдсэн нь манай итгэлтэй олон гишүүнд сөргөөр нөлөөлөв. Би Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын Киншаса, Мадагаскарын Антананариво, Зимбабвегийн Булаваёо хотуудад саяхан очихдоо бас ийм байдлыг харсан билээ. Эдгээр хотуудад тойргийн гишүүд болон ялангуяа Нийгмийн Халамжийн Бүлгийн гишүүд итгэлээ хөгжүүлэн хувь хүн болон гэр бүлүүдийг бэхжүүлж, тусламж хэрэгтэй хүмүүст газар сайгүй тусалсаар байлаа.

Сүмд дуудлагатай, даруухан нэгэн эгч эсвэл хэн нэгэн ах ядуурал, уй гашуу, өвчин эмгэгт нэрвэгдсэн, санаа сэтгэлээр унан доройтсон айлд очиж, амар амгалан, тусламж дэмжлэг, аз жаргалыг түгээж байгааг бодоход гайхан биширмээр. Тойрог, салбар хаана байрладаг, бүлэг хэдэн хүнтэй нь хамаагүй, дэлхий даяарх бүх гишүүд бусдад үйлчлэх боломжтой байдаг. Үйлчлэл өдөр бүр хийгдэж байдаг бөгөөд яг одоо энэ агшинд ч хаана нэгтээ хийгдэж байгаа.

Карла хоёр хүүхэдтэй залуухан эх. Нөхөр Brent нь олон цагаар ажилладаг бөгөөд ажилдаа ирж, очиход хоёр цагийг зарцуулдаг аж. Хоёр дахь охиноо төрүүлээд удаагүй байхад энэ явдал тохиолджээ. Тэрээр “Тойргийнхоо Нийгмийн Халамжийн Бүлэгт зөвлөхөөр үйлчлэх дуудлага хүлээн авсныхаа маргааш санаа минь нэг л зовж эхлэв. Айлын эхнэр дээр нь бас маш их хөдөлгөөнтэй 2 настай нэг хүүхэд, саяхан төрсөн нялх үрийн эх байх үүргээ арай ядан биелүүлж байж, яаж тойргийнхоо эмэгтэйчүүдэд анхаарал халамж тавьж чадах юм бэ, би чинь? Ийм бодолд түүртэн байтал хоёр настай хүүхэд маань өвдчих нь тэр. Хоёр настай охиныхоо төлөө юу хийх, түүний хажуугаар нялх үрээ хэрхэн халамжлахыг би үнэндээ мэдэхгүй байлаа. Тэгтэл манай айлчлагч багш нарын нэг Уозден эгч хүрч ирэв. Том болсон хоёр хүүхэдтэй тэр эгч надад хэрхэн туслахаа мэдэж байлаа. Тэр эмийн сан уруу яваад ирэх тэр хугацаандаа миний юу хийх ёстойг хэлж өгөв. Дараа нь нөхрийг маань гэртээ түргэн ирэхэд нь туслахын тулд галт тэрэгний буудал дээр түүнийг тосч авах ажлыг зохион байгууллаа. Энэхүү үйлдэл надад үйлчлэх гэсэн түүний хүсэл, Ариун Сүнсний өдөөлт бөгөөд шинэ дуудлагаа биелүүлэхэд Их Эзэний тусламж надад хэрэгтэй байгаагийн нотолгоо мөн гэдэгт би итгэсэн юм.”

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай, бас бидний хүн нэг бүрийн нөхцөл байдал, чадварыг мэддэг. Бид өдөр тутмын залбирлаар дамжуулан Түүний тусламжийг хүсдэг ч Тэрбээр бидний хэрэгцээг өөр хэн нэгнээр дамжуулан шийдвэрлэж өгдөг.⁹

“Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно”¹⁰ гэж Их Эзэн хэлсэн билээ.

Бид амин хувиа бодолгүй бусдад үйлчилсэн үед Христийн цэвэр хайр бидэнд илэрдэг. Бие биедээ туслах нь ариусах үйл явц бөгөөд үйлчлэл хүлээн авагчийн зүрх сэтгэлийг ариусгаж, өгөгчийг даруусгадаг. Энэ нь Христийн жинхэнэ дагалдагчид болоход бидэнд тусалдаг.

Халамжийн төлөвлөгөө сайн мэдээний мөнхийн зарчмуудыг хэрэгжүүлсээр ирсэн билээ. Энэ нь үнэхээр Их Эзэний арга замаар хангадаг. Бусдыг адислах үйл хэрэгт Их Эзэний агуулахын ажилд оролцох хүслээ бүгдээрээ шинэчилцгээе.

Их Эзэн бидний хүн нэг бүрийг нигүүлсэл, энэрэл, өрөвч сэтгэлийн агуу мэдрэмжээр адислахын төлөө би залбирч байна. Зовж зүдэрсэн, гай зовлонд нэрвэгдсэн хүмүүст гар сунган туслах бидний хүсэл, чадвар өсөн нэмэгдэхийн төлөө тэдний хэрэгцээ шийдвэрлэгдэхийн төлөө тэдний зүрх сэтгэл хайр, талархлаар дүүрэн байхын төлөө би залбирч байна.

Их Эзэний зарлиг, сайн мэдээ, гэрэлд дуулгавартай алхах биднийг Тэрээр адислах болтугай. Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

Эшлэл

1. Моце 7:18-ыг үз.
2. Матай 22:36–40-ийг үз.
3. Сургаал ба Гэрээ 44:6.
4. *History of the Church*, 4:567.
5. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 452.
6. *Teachings: Joseph Smith*, 452.
7. *Providing in the Lord's Way: A Leader's Guide to Welfare* (1990), 11.
8. Acts 10:38; Articles of Faith 1:13.
9. *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 82-ыг үз.
10. Иохан 13:35.

Ням гарагийн өглөөний хуралдаан

Ерөнхий чуулган

Ням гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Илчлэлтийн сүнс

илчлэлт

Ариун Сүнс

Сүмийн түүх

дуулгавартай байдал

итгэл

ерөнхий чуулган

Илчлэлтийн Сүнс

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Давид А.Беднар

Илчлэлтийн сүнс үнэн бодитой бөгөөд бидний амьдралд болон Сүмд үйл ажиллагаагаа явуулж чаддаг, явуулсаар ч байгаа билээ.

Миний хэлэх үгийн дараа дуулах “Би ямар нэгэн сайн юм хийсэн үү?” (*Hymns*, no. 223) гэсэн сүнслэг нөлөө бүхий дууллыг сонгосонд талархал илэрхийлье. Би хэлэх үгэндээ энэ дууллын санааг ашигласан юм.

Бидний ихэнх нь мэддэг гэрэл гэгээтэй холбоотой доорх хоёр туршлагын талаар эргэцүүлэн бодохыг би та бүгдээс хүсч байна.

Эхний туршлага нь бид харанхуй өрөөнд орж, гэрэл асаахад тохиодог. Гэрлийн цацраг хэрхэн агшин зуур өрөөг гэрэлтүүлэн, түнэр харанхуйг арилган үгүй болгодгийг санаж байгаа биз дээ? Өмнө нь харагдахгүй, тодорхой бус байсан зүйлс тодорч, танигдахаар болдог. Энэ туршлага нь гэрлийг тэр даруй, тодоор харахыг тодорхойлж байна.

Хоёр дахь туршлагыг бид үүр цайх агшинд мэдэрдэг. Тэнгэрийн хаяанд алгуур, үл мэдэгдэм гэрэл өсөн нэмэгддэгийг та нар санаж байна уу. Мандах нарны гэрэл нь харанхуй өрөөнд гэрэл асаахтай адил гэнэт үзэгддэггүй. Харин гэрэл нь алгуурхнаар тасралтгүй нэмэгдсээр, шөнийн харанхуй үүрийн гэгээгээр солигддог. Ийнхүү эцэст нь тэнгэрийн хаяанд наран манддаг. Гэвч нар мандах баталгаа нь тэнгэрийн хаяанд гарцаагүй үзэгдэхээс хэдэн цагийн өмнө тохиодог. Энэ туршлага гэрлийг нарийн, алгуур байдлаар тодорхойлон харуулсан байна.

Гэрэлтэй холбоотой энэхүү энгийн хоёр туршлагаас бид илчлэлтийн сүнсний тухай маш их зүйлийг сурч болно. Одоо илчлэлтийн сүнс болон илчлэлт хүлээн авах үндсэн загвар дээр анхаарлаа төвлөрүүлэхэд Ариун Сүнс бидэнд урам зориг өгч, чиглүүлэх болтугай хэмээн би залбирч байна.

Илчлэлтийн сүнс

Илчлэлт нь дэлхий дээрх хүүхдүүдтэйгээ харьцах Бурханы харилцаа холбоо төдийгүй, бэлэгтэй адилтгах агуу адислалуудын нэг ба Ариун Сүнсний байнгын нөхөрлөл юм. Бошиглогч Иосеф Смит “Ариун Сүнс бол илчлэгч” ба “хэн ч илчлэлтүүдийг хүлээн авахгүйгээр Ариун Сүнсийг хүлээн авч чадахгүй” (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 132.) хэмээн заасан байдаг.

Илчлэлтийн сүнс нь зохистой санваарын эрх мэдлээр нүглүүдээс ангижрах усанд умбуулах баптисм ба толгой дээрх гар тавилтаар Ариун сүнсний бэлэг хүртэн авралын ёслолуудыг хүлээн авсан мөн санваарыг гүйцэтгэхээр “Ариун Сүнсийг хүлээн авах” тушаалыг итгэлтэйгээр үйлдэгч хүн бүрт ирэх боломжтой юм. Энэ адислал нь Сүмийн тэргүүлэх эрх мэдэлтнүүдэд өгөгддөг төдийгүй нандин гэрээнүүдэд орсон эрэгтэй, эмэгтэй, хариуцлагын насанд хүрсэн хүүхэд бүрт хамаатай бөгөөд тэдний амьдралд нь үйлчлэн нөлөөлөх ёстой. Чин сэтгэлийн үнэн хүсэл ба зохистой байдал нь илчлэлтийн сүнсийг бидний амьдралд буй болгодог.

Иосеф Смит, Оливер Каудери хоёр Мормоны Номыг орчуулж байхдаа илчлэлтийн сүнсний талаар үнэ цэнэтэй туршлагыг олж авчээ. Тэд үнэнч зүрх сэтгэлтэйгээр, хүлээн авна гэдэгтээ найдан, итгэлтэйгээр асуух аваас өөрсдийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай аливаа мэдлэгийг хүлээн авч болно гэдэгт суралцсан юм. Мөн хэсэг хугацааны дараа тэд илчлэлтийн сүнс нь Ариун Сүнсний хүчээр бидний оюун санаа, зүрх сэтгэлд ирдэг бодол болон мэдрэмжийн адил ердийн үйл явц гэдгийг улам сайн ойлгожээ (С ба Г 8:1–2; 100:5–8-ыг үз). Их Эзэн тэдэнд, “Эдүгээ, болгоогтун, энэ бол илчлэлтийн сүнс болой, болгоогтун, энэ бол Мосе Израилын хүүхдүүдийг Улаан Тэнгисийн дундуур хуурай газраар гаталган авчирсан тэр сүнс бөлгөө. Тиймийн тул энэ нь чиний бэлэг болой; үүнийг ашиглагтун”(С ба Г 8:3–4) хэмээн зааварлажээ.

Би илчлэлтийн сүнсэнд хамаатай “үүнийг ашиглагтун” гэсэн үгийг тодруулан үзэхийг хүсч байна. Судрууд дээр Ариун Сүнсний нөлөөг “намуухан дуу хоолой” (1 Нифай 17:45; Хаадын Дээд 19:12; мөн 3 Нифай 11:3-ыг үз), “төгс зөөлөн тайван дуу хоолой” (Хиламан 5:30) гэж дүрсэлсэн байдаг. Сүнс бидэнд намуухан, тайвнаар шивнэдэг учраас бид яагаад зохисгүй нэвтрүүлэг, порнограф болон хөнөөлтэй донтуулагч зүйлс ба донтуулах байдлаас зайлсхийх ёстойг ойлгоход хялбар юм. Дайсны эдгээр хэрэгслүүд Бурханы Сүнсний хүчээр илгээгдсэн түүний мэргэн захиасуудыг таньж мэдэн, хариулах чадварыг маань сулруулан доройтуулж улмаар устгаж ч болох юм. Хүн бүр чөтгөрийн өгөөшөөс татгалзаж, илчлэлтийн сүнсийг хувийн амьдрал ба гэр бүлдээ хэрхэн зөв шударгаар “ашиглах” талаар нухацтайгаар эргэцүүлж, залбиралтайгаар тунгаан бодох ёстой.

Илчлэлтийн хэв маягууд

Илчлэлтүүд нь зүүд, үзэгдэл, тэнгэрлэг элч нартай ярилцах, сүнслэг өдөөлт зэрэг олон янзын хэв маягаар дамжин ирдэг. Зарим илчлэлтийг шууд, хүчтэй хүлээн авдаг бол зарим нь алгуур, нарийн учир шалтгаантайгаар танигддаг. Миний ярьсан гэрлийн тухай хоёр туршлага илчлэлтийн үндсэн хоёр хэв маягийг илүү сайн ойлгоход бидэнд тусална.

Харанхуй өрөөнд гэрэл асаах нь Бурханаас ямар нэгэн захиас хурдан, бүрэн дүүрнээр, нэг дор хүлээн авахтай адил юм. Бидний олонх нь илчлэлтийн энэ хэв маягийг чин сэтгэлийн залбирлын хариултаар эсвэл Бурханы хүссэн цагт Түүний тааллын дагуу бидэнд шаардлагатай удирдамж буюу хамгаалалтаар хангагдах зэргээр мэдэрсэн. Ийм шууд, хүчтэй илчлэлтийн дүрслэлүүдийг судруудад мөн Сүмийн түүхэнд өгүүлсэн байдаг бөгөөд бидний амьдралд ч тохиолдсон байдаг. Үнэхээр ийм хүчит гайхамшгууд тохиодог билээ. Гэхдээ илчлэлтийн энэ хэв маяг нь тийм ч нийтлэг тохиолддоггүй.

Мандах нарны алгуур нэмэгдэх туяа нь Бурханаас “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) өгөгдөх захиастай адил юм. Ихэнх тохиолдолд илчлэлт нь бага багаар бидний хүсэл, зохистой байдал, бэлтгэлийн дагуу ирдэг. Тэнгэрлэг Эцэгээс ирэх ийм харилцаа нь эцэстээ “тэнгэрээс буух шүүдэр лугаа адил [бидний сүнсэнд] намуухан буух болно” (С ба Г 121:45). Илчлэлтийн энэ хэв маяг нь Нифай Лебенээс гуулин ялтсуудыг амжилттай олж авахын өмнөх хэдэн удаагийн оролдлогод илэрдэг (1 Нифай 3–4-г үз). Хамгийн сүүлд нь “хийвэл зохих зүйлүүдийг [гэр] урьдаас мэдэхгүй” (1 Нифай 4:6) байсан ч Сүнсээр Иерусалим уруу хөтлөгдсөн. Нифай уран хийцтэй усан онгоц хэрхэн барихыг шууд нэг дор сураагүй ч Их Эзэн “усан онгоцны дүнг модыг ямар маягаар бэлтгэхийг цагаас цагт [түүнд] үзүүлж байсан бөлгөө” (1 Нифай 18:1).

Сүмийн түүх болон бидний хувийн амьдралд “шат шатаар, дүрэм дүрмээр” илчлэлт хүлээн авах Их Эзэний энэхүү хэв маягийн жишээ олон байдаг. Жишээлбэл, Бошиглогч Иосеф Смитэд сэргээгдсэн сайн мэдээний гол үнэнүүд Ариун төгөлд шууд нэг дор бүгд өгөгдөөгүй. Эдгээр үнэ цэнэтэй эрдэнэсүүд зөв цагт, нөхцөл байдал зохистой үед илчлэгдэж байсан.

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит илчлэлтийн энэ хэв маяг түүний амьдралд хэрхэн ирснийг тайлбарласан байдаг.

“Би хөвгүүн байхдаа гэрчлэлтэй болохын тулд Их Эзэнээс зарим нэгэн гайхамшиг үзүүлэхийг байнга хүсдэг байлаа. Гэвч Их Эзэн надаас гайхамшигийг нууж, надад үнэнийг зулайнаасаа хөлийнхөө ул хүртэл, эргэлзээ ба айдсаасаа бүрэн чөлөөлөгдөх хүртэл, шат шатаар үзүүлсэн юм. Үүнийг хийлгэхийн тулд Тэр тэнгэрээс тэнгэр элчийг илгээгээгүй, бас Тэр бүрэн дуугаар ч яриагүй. Амьд Бурханы Сүнсний намуухан, тайван дуу хоолойгоор шивнэн, надад буй гэрчлэлийг Тэр өгсөн юм. Энэ зарчим ба хүчээр Тэр хүмүүний бүх хүүхдэд тэдэнд үлдэх үнэний тухай мэдлэгийг өгдөг бөгөөд энэхүү мэдлэг нь тэднийг Бурхантай адил мэдлэгтэй, Эцэгийн хүслийг Христийн адил гүйцэлдүүлэх чадлыг өгөх болно. Ямар ч өөр гайхамшигтай илэрхийлэл үүнийг хэзээ ч гүйцэлдүүлж чадахгүй.” (in Conference Report, 1900 оны 4-р сар, 40–41).

Сүмийн гишүүд бид гайхамшигтай, үр нөлөөтэй сүнслэг илэрхийлэлтийг онцгой чухалчлан, талархахаа мартаж, Ариун Сүнсээр гүйцэлдүүлэх түүний ажлын ердийн хэв маягийг анзааралгүй өнгөрөх хандлагатай байдаг. Хэсэг хугацааны дараа, эцэст нь хүссэн хариулт эсвэл бидэнд хэрэгтэй удирдамжийг бүрдүүлэн батлах, жижиг бөгөөд өсөн нэмэгдэх сүнслэг мэдрэмжийг хамгийн “энгийн байдал”-аар (1 Нифай 17:41) хүлээн авах нь биднийг “зорилгоос алсуур хайх” (Иаков 4:14) байдалд хүргэж мэднэ.

|Би тогтмол, гайхамшигтай эсвэл хүчтэй сэтгэгдлийг хүлээн аваагүйгээс хувийн гэрчлэлийн хүчиндээ эргэлзэж, сүнслэг байдлаа дутуу үнэлсэн олон хүнтэй ярилцаж байсан. Магадгүй бид Ариун төгөл дэх Иосефын, Дамаск орох зам дээрх Саулын мөн Залуу Алмагийн туршлагын талаар эргэцүүлэн бодоод эдгээр сайн мэдэх, сүнслэг сэтгэл догдлом жишээнүүдтэй ижил төстэй зүйл тохиогоогүйд өөрсдийгөө хэвийн биш эсвэл дутагдалтай гэж бодож эхэлсэн байж мэднэ. Хэрэв та нарт үүнтэй ижил бодол эсвэл эргэлзээ төрж байсан бол өөрсдийгөө хэвийн гэдэгт итгэлтэй байгаарай. Зүгээр л Аврагчид итгэлтэй байж, урагш дуулгавартайгаар үргэлжлүүлэн алхаарай. Тэгвэл та нар “буруудах нь үгүй” (С ба Г 80:3).

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит “Сүмд тууштай итгэлтэй байхын тулд гайхамшиг, үзэгдэл болон гэмдгүүдэд найддаг Хожмын үеийн Гэгээнтнүүдийг надад үзүүл. Тэгвэл би тэдэнд Бурханы өмнө сайн биш байгаа, халтирхайтай зам дээр алхаж буй гишүүдийг үзүүлэх болно. Бид үнэн дээр тогтсон байх эсэх нь ер бусын гайхамшигтай илэрхийлэлтээр бус харин Бурханы зарлиг болон хуулиудад итгэлтэй, даруу дуулгавартай байснаар илчлэгддэг” (*Ерөнхий чуулган дээр хэлсэн үг*, 1900 оны 4-р сар, 40) гэж зөвлөсөн.

Бас нэгэн гэрэлтэй холбоотой нийтлэг туршлага нь илчлэлтийн “шат шатаар, дүрэм дүрмээр” ирэх хэв маягийн тухай үнэнд суралцахад бидэнд тусалдаг. Заримдаа үүлэрхэг, манантай өглөө нар манддаг. Бүрхэг үүлтэй нөхцөлд гэрлийг мэдрэх илүү хүндрэлтэй бөгөөд тэнгэрийн хаяанд нар мандах мөчийг нарийн тодорхойлох боломжгүй байдаг хэдий ч шинэ өдрийг таньж мэдэх, ажил хэргээ явуулах хангалттай гэрэл байж л байдаг.

Үүнтэй адил замаар бид олон удаа хэрхэн эсвэл хэзээ хүлээн авснаа мэдэхгүйгээр илчлэлтийг хүлээн авдаг. Сүмийн түүхэн дэх нэгэн чухал явдал энэ зарчмыг үзүүлдэг.

1829 оны хавар Оливер Каудери Нью-Йоркийн Палмирад сургуулийн багш ажилтай байлаа. Тэр Иосеф Смит болон Мормоны Номын орчуулгын ажлын тухай олж мэдэн, ихэд биширсэн Оливер залуу бошиглогчид өөрийн чадах тусламжийн талаар санал болгохыг хүссэн байдаг. Иймээс тэр Пенсильванийн Хармони хүртэл аялан ирж, Иосефын бичээч нь болсон тухай түүхэнд байдаг. Түүний ирэлт болон үзүүлсэн тусламж нь Мормоны Номыг гаргахад асар чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Хожим нь Аврагч түүний заавар хүсч байнга залбирах бүрд Их Эзэний Сүнснээс удирдамж хүлээн авч байгааг Оливерт илчилжээ. Их Эзэн “Хэрэв энэ нь ийм байгаагүй аваас, чи энэ цагт өөрийнхөө байгаа тэр газарт хүрч ирэхгүй байх байсан. Болгоогтун, чи надаас асууснаа мэдэж байгаа мөн бибээр чиний оюуныг гэгээрүүлсэн билээ; мөн үнэний Сүнсээр гэгээрсэн гэдгээ чамайг мэдээсэй гэсэндээ би эдгээр зүйлүүдийг чамд хэлж байна” (С ба Г 6:14–15) гэж тунхаглажээ.

Ийнхүү, Оливер, Иосеф Смитээр дамжуулан тэр илчлэлтийг хүлээн авч байна гэсэн өөртөө мэдэгдсэн илчлэлтийг хүлээн авсан. Мэдээжийн хэрэг, Оливер Бурханаас хэрхэн, хэзээ удирдамжийг хүлээн авч байснаа мэдээгүй ба илчлэлтийн сүнсний тухай түүний ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд энэ заавар хэрэгтэй байлаа. Мөн чанартаа Оливер үүлэрхэг өглөө нар мандахтай адил гэрэлд алхаж байсан юм.

Бидний амьдралд эргэлзээтэй зүйл болон олон саад бэрхшээл тулгарах үед Бурхан биднийг өөрсдийн чадах бүхнээ хийж, өөрсдийн төлөө үйлдэх мөн өөрсөд дээрээ үйлдүүлэх нь үгүй болой (2Нифай 2:26) Түүнд найдахыг хүсдэг. Бид тэнгэр элчүүдийг харж, тэнгэрлэг дуу хоолойнуудыг сонсож, хязгааргүй их сүнслэг илэрхийлэлтүүдийг хүлээн авахгүй байж болно. Олон тохиолдолд бид Бурханы тааллын дагуу үйлдэж байгаа гэсэн бүрэн баталгаагүйгээр итгэн найдаж, залбиран урагш тэмүүлж болно. Гэвч өөрсдийн гэрээнүүддээ үнэнч байж, зарлигуудыг сахиж, байнга сайныг хийхийг эрэлхийлэн, илүү сайн хүн болохыг хичээх аваас бидний алхмыг Бурхан залан чиглүүлэх

болно гэсэн итгэлтэйгээр алхаж чадна. Мөн Бурхан бидний хэлэх үгсийг маань заан чиглүүлнэ гэсэн баталгаатайгаар ярьж чадна. Энэ нь “Тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болох болно” (С ба Г 121:45) хэмээн тунхагладаг судрын хэсэгтэй дүйцэх юм.

Та нар зохистойгоор илчлэлтийн сүнсийг эрэлхийлэн, ашиглах аваас “Их Эзэний гэрэлд алхацгаах” (Исаиа 2:5; 2 Нифай 12:5) болно гэдгийг би та нарт амлаж байна. Заримдаа илчлэлтийн сүнс шууд, ил тодоор, зарим үед нарийн учир утгатайгаар, алгуурхан ажиллах болно. Ихэвчлэн түүнийг таньж мэддэггүй. Тэр бүү хэл мэдэрдэггүй. Гэвч энэ адислал хүлээн авагдсан загварын ачаар гэрэл та нарын бодгалыг гэрэлтүүлэн, өсгөж, ойлголтыг тань гэгээрүүлэн, (Алма 5:7; 32:28-г үз) та нарыг болон гэр бүлийн тань замыг заан, хамгаалах болно.

Эцэг, Хүү хоёр амьд гэсэн Бурханы төлөөлөгчийн гэрчлэлээ би тунхаглаж байна. Илчлэлтийн сүнс үнэн бодитой бөгөөд хувь хүн бүрийн амьдралд болон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд үйл ажиллагаагаа явуулж чаддаг бөгөөд явуулсаар байгаа билээ. Эдгээр үнэнийг би Их Эзэн Есүс Христийн ариун нэрээр гэрчилж байна, амен.

Лиахона

2011 оны 5-р сар

Ням гарагийн өглөөний хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Ариун Сүм---дэлхийн гэрэлт цамхаг

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Хайрт ах эгч нар минь, хайр болоод мэндчилгээгээ хүн бүрд хүргэхийн сацуу, өнөөдөр та бүхэнд хандан үг хэлэхэд минь Тэнгэрлэг Эцэг оюун ухааныг минь удирдаж, үгсийг минь хурцлах болтугай хэмээн залбирч байна.

Энэ өглөө бид Оолред эгч, бишоп Бертон болон бусад үг хэлэгчдээс Сүмийн халамжийн тусламжийн хөтөлбөрийн талаар сонссон сайхан захиасуудтай холбоотой хэдэн тайлбар хийхийг минь зөвшөөрнө үү. Дээр дурдсанчлан энэ жил маш олон хүмүүсийн амьдралыг адисалсан энэхүү сүнслэг хөтөлбөрийн 75 жилийн ой тохиож байна. Энэ хөтөлбөрийг эхлүүлсэн энэрэнгүй сэтгэлтэй, алсын хараатай анхдагчдын заримыг биечлэн таньдаг байсандаа би бахархдаг.

Бишоп Бетон, Оолред эгч бусад хүмүүсийн хэлсэнчлэн тойргийн бишоп нь тойргийнхоо нутаг дэвсгэрт амьдарч байгаа тусламж хэрэгтэй хүмүүст анхаарал, халамж тавих үүрэгтэй. Солт Лейк хот дахь 84 бэлэвсэн эмэгтэй, 1,080 гишүүнтэй нэгэн тойргийн нэн залуу бишоп байхад ч миний онцгой боломж ийм л байсан. Тусламж хэрэгтэй олон хүн байлаа. Би Сүмийн халамжийн хөтөлбөр, Нийгмийн Халамжийн Бүлэг болон санваартны чуулгын тус дэмжлэгт ямар их талархалтай байсан гээч.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн халамжийн хөтөлбөр нь Бүхнийг Чадагч Бурханы ажил гэдгийг би тунхаглаж байна.

Ах эгч нар аа, энэ ерөнхий чуулган намайг Сүмийн Ерөнхийлөгчөөр баталснаас хойш гурав дахь жилдээ болж байна. Мэдээж эдгээр жилүүдэд саад тотгор олон байсан ч тоолж баршгүй адислалуудаар дүүрэн, ажил өрнөсөн завгүй он жилүүд байлаа. Ариун сүмүүдийг онцгойлон адислах, дахин онцгойлон адислах боломж маань хамгийн сайхан баяр баясгалантай, тэдгээр адислалууд хамгийн эрхэм ариун зүйл байв. Тиймээс би өнөөдөр та нарт ариун сүмийн талаар ярихыг хүсч байна.

1902 оны аравдугаар сарын ерөнхий чуулгаар Сүмийн Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит нээлтийн үгэндээ бид хэзээ нэгэн өдөр “[дэлхийн] олон газарт хүмүүстээ ойр ариун сүмүүдийг барих”¹ ёстой гэсэн итгэл найдварыг илэрхийлсэн билээ.

Сүм зохион байгуулагдсанаас хойших эхний 150 жил буюу 1830 оноос 1980 оныг хүртэл Огайогийн Кертланд, Иллинойн Наувугийн ариун сүмүүдийг оролцуулан 21 ариун сүм

баригдсан юм. Үүнтэй харьцуулахад 1980 оноос хойш сүүлийн 30 жилд 115 ариун сүм баригдаж, онцгойлон адислагдсан байна. Өчигдрийн шинээр зарлагдсан 3 шинэ ариун сүмтэй нийлээд 26 ариун сүм баригдаж байгаа буюу ашиглалтанд ороход бэлэн болоод байна. Ариун сүмүүдийн тоо өссөөр байх болно.

1902 онд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн тавьсан зорилго эдүгээ биелэгдээд байна. Бидний хүсэл тэмүүлэл бол ариун сүмийг гишүүдэд аль болох ойр дөт болгох явдал юм.

Дөнгөж саяхан ашиглалтанд орсон ариун сүмүүдийн нэг бол Бразилын Манаус дахь ариун сүм. Хамгийн ойр, ойролцоогоор Манаусаас 2,500 бээр (4000 км) хол орших Бразилын Сан Пауло дахь ариун сүмд очихын тулд Манаусаас гарч, Амазоны ширэнгэн ой дундуур аялсан зуу гаруй гишүүний тухай би олон жилийн өмнө уншиж байсан. Эдгээр итгэлтэй Гэгээнтнүүд дөрвөн өдрийн турш Амазон мөрнөөр болон энэ мөрний зам харгуйгүй салаагаар усан онгоцоор аялжээ. Усаар аялсан энэ аяллын дараа тэд бартаатай замаар өлөн зэлмүүн, тухтай унтаж амрах зайгүй, автобусанд шахцалдан, дахиад гурван өдрийн аяныг хийсэн ажээ. Долоон өдөр, долоон шөнийн турш аялсны эцэст тэд гүйцэтгэх ёслолууд нь мөнхийн утга учиртай Сан Паулогийн ариун сүмд иржээ. Мэдээж, тэдний гэртээ буцах аян ирсэн шигээ хүнд хэцүү байлаа. Гэвч тэд ариун сүмийн ёслолууд болон адислалуудыг хүлээн авсан аж.² Хэдийгээр түрийвч нь хоосорсон ч тэд ариун сүмийн сүнсээр дүүрэн, хүлээн авсан адислалуудынхаа төлөө талархалтай байсан юм. Одоо олон жил өнгөрсний дараа Манаус дахь гишүүд Рио Негро мөрний эрэгт өөрсдийнх нь ариун сүм баригдсаныг харан баярлаж байна. Ариун сүмүүд хаана ч баригдсан итгэлтэй гишүүдэд баяр баясгаланг авчирдаг.

Зөвхөн Бурханы ариун сүмүүдэд хүлээн авч болох адислалуудын төлөөх золиослолын түүхүүдэд зүрх сэтгэл минь үргэлж догдлон, ариун сүмүүдэд талархах шинэхэн мэдрэмжийг надад авчирдаг.

Тайхи болон Тараина Моу Там мөн тэдний 10 хүүхдийн тухай түүхийг та нартай хуваалцъя. 1960-аад оны эхээр номлогчид Тахитигаас өмнө зүгт 100 бээр (160км) хол орших арал дээр ирэх үед тэд гэр бүлээрээ Сүмд нэгджээ. Удалгүй тэд ариун сүм дэх мөнхийн гэр бүлийн лацдан холболтын адислалуудыг авахыг хүссэн гэнэ.

Тэр үед Моу Тамын гэр бүлд хамгийн ойр байсан ариун сүм нь зөвхөн онгоцоор баруун өмнө зүгт 2,500 бээр (4000 км) газарт нисэн очих боломжтой Шинэ Зеландын Хамилтоны ариун сүм байлаа. Моу Тамын өнөр гэр бүл бараг орлогогүй шахам жижиг тариалангийн газар, тарчигхан амьдралтай байсан тул онгоцны тасалбар авах мөнгөгүй, Номхон далайн дундах тэдний арал дээр ажилтай болох ямар ч боломж байсангүй. Тиймээс Моу Там ах болон түүний хүү Герард нар баруунтаа 3,000 бээр (4800 км) хол орших Нью Каледонийн никелийн уурхайд ажилладаг хүү дээрээ очих хүндхэн шийдвэрийг гаргасан аж. Уурхайн ажил олгогч ажилчиддаа уурхайд хүрэх замын зардлыг нь төлдөг байсан ч гэрт нь буцах зардлыг төлдөггүй байв.

Моу Тамын гэр бүлийн гурван эр халуун орны никелийн уурхайд хүндхэн үнэт төмөрлөгийг малтах, өргөх ажилд дөрвөн жил хөдөлмөрлөжээ. Моу Там ах хөвгүүдээ Нью Каледонид орхин, жилд нэг удаа гэртээ богино хугацаагаар харьдаг байв.

Дөрвөн жилийн турш зогсолтгүй ажилласны эцэст Моу Там ах болон түүний хөвгүүд Шинэ Зеландын ариун сүмд гэр бүлээрээ явах хангалттай мөнгийг цуглуулжээ. Нэг охиноос нь бусад гэр бүлийн гишүүд бүгд явсан юм. Тэд энэ амьдралд болон үүрд мөнхөд лацдан холбуулж, үгээр дүрслэхийн аргагүй, баяр баясгалантай мэдрэмжийг авчээ.

Моу Там ах ариун сүмээс Нью Каледони уруу шууд буцаж, тэдэнтэй ариун сүмд хараахан хамт байж чадаагүй нөхөрт гарсан охиныхоо хүүхэд, нөхрийнх нь замын зардлыг төлөхийн тулд тэндээ хоёр жил ажилласан аж.

Сүүлдээ Моу Там ах эгч хоёр ариун сүмд үйлчлэхийг хүсчээ. Тэр үеэр Папийте Тахитийн Ариун сүм баригдаж, онцгойлон адислагдсаны дараа тэд хоёр удаа номлолд үйлчилжээ.³

Ах эгч нар аа, ариун сүмүүд бол барилгын чулуу, шохойн уусмалаас илүү эрхэм зүйл. Ариун сүмүүд хүмүүсийн итгэл ба мацаг барилтаар дүүрэн юм. Тэдгээр нь сорилт болон гэрчлэлээр баригддаг. Ариун сүмүүд золиослол ба үйлчлэлээр ариусгагддаг.

Энэ эрин үед баригдсан анхны ариун сүм нь Огайогийн Көртланд дахь ариун сүм байв. Гэгээнтнүүд тарчиг хэцүү цаг үед ч Их Эзэн ариун сүм барь гэж зарлигласан л бол тэд барьдаг байлаа. Ахлагч Хебер С.Кимбалл энэ тухай, “Бид Көртландын ариун сүмийг хэчнээн ядуу тарчиг байдалд, хэчнээн их гай зовлон, уй гашуу амсан байж барьсныг зөвхөн Их Эзэн л мэднэ”⁴ гэж бичсэн байдаг. Тэгээд тэд шаргуу хөдөлмөрөөрөө бүхнийг дуусгасны эцэст Гэгээнтнүүд Огайог, хайртай ариун сүмээ албадуулан орхихоос аргагүй болсон. Тэд эцэстээ хэдий түр зуурын байх байсан ч Иллиной мужийн Миссиппи мөрний эрэгт түр хугацаагаар толгой хоргодох газар олсон юм. Тэд суурингаа Науву гэж нэрлэж, юм бүхнээ дахин өгөх хүсэлтэйгээр, итгэл бишрэлээ орхилгүй, Бурхандаа өөр нэг ариун сүмийг барьсан юм. Мөрдлөг хавчлага, уур хилэн ширүүссэн ч Наувугийн ариун сүмийг дөнгөж дуусгаад байтал тэд орон гэрээсээ дахин хөөгдөж, зэлүүд газарт толгой хоргодох оромж эрэн бэдэрсэн билээ.

Өнөөдөр бидний байгаа Ерөнхий Чуулганы төвөөс өмнө зүгт нэг барилгын цаана гайхамшигтайгаар сүндэрлэж буй Солт Лейкийн Ариун Сүмийг барихаар 40 жилийн турш хөдөлмөрлөх явцад тэдний тэмцэл, золиослол дахин эхэлсэн юм.

Золиослолын төвшин ариун сүмийн барилга, ариун сүмд орохтой үргэлж холбоотой байсан. Асар олон гишүүд Бурханы ариун сүмд өөрсдийн болон гэр бүлийнхээ төлөө адислалуудыг олж авахын тулд хөдөлмөрлөн, тэмцсэн.

Яагаад ийм олон хүн ариун сүмийн адислалуудыг хүлээн авахын тулд бүхнээ золиослохыг хүссэн юм бол? Ариун сүмээс ирэх мөнхийн адислалуудыг ойлгодог хүмүүс эдгээр адислалуудыг хүлээн авахад зориулсан ямар ч золиослол үүнээс агуу бус, ямар ч төлбөр их бус, ямар ч тэмцэл хэцүү биш гэдгийг мэднэ. Алс холын аяныг туулж, бүх саад бэрхшээлийг даван гарч, аливаа таагүй байдлыг тэвчин дуусгах болно. Ариун сүмд хүлээн авсан авралын ёслолууд буюу хэзээ нэгэн өдөр биднийг Тэнгэрлэг Эцэгтээ мөнхийн гэр бүлдээ буцаж очих зөвшөөрөл ба дээд тэнгэр дэх адислал болон хүчээр хангагдсан байхын тулд гаргах золиослол, хүч чармайлт бүр үнэ цэнэтэй.

Өнөөдөр бидний олонх нь ариун сүмд орохын тулд асар их хүндрэлийг туулан, шаналах шаардлагагүй. Одоо Сүмийн гишүүнчлэлийн наян таван хувь нь ариун сүмээс 200 бээр (300 км)-ийн дотор амьдарч байна. Бас бидний олонхид нь энэ зай үүнээс ч ойр байна.

Хэрэв та нар өөрсдийнхөө төлөө ариун сүмд орсон бол хэрэв та нар ариун сүмд ойр амьдардаг бол ариун сүмд байнга орохын тулд завгүй амьдралаа умартан цаг гаргах нь таны золиослол байж болно. Хөшигний цаана хүлээж байгаа хүмүүсийн тусын тулд ариун сүмүүдэд хийх хэрэгтэй маш их зүйл бий. Тэдний төлөө ажлыг хийснээр бид, өөрсдийнхөө төлөө тэдний хийж чадахгүй зүйлийг гүйцэтгэсэнээ ойлгох болно. Сүмийн Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит маш хүчтэй тунхаглалыг хэлсэн билээ. Тэрээр: “Бидний хичээл зүтгэлээр дамжуулан тэдний тусын тулд боолчлолын гинж нь тэднээс тасран унаж, тэднийг нөмрөх харанхуй сарнин арилж, тэдний дээр гэрэл цацран, хүүхдүүдийнх нь тэдний төлөө энд хийгдсэн ажлыг сүнсний дэлхийд тэд сонсож, эдгээр хүндэтгэлийг үзүүлсэн та нарын хамт тэд баярлан баясах болно.”⁵ Ах эгч нар аа, хийх ажил нь биднийх шүү.

Манай гэр бүлд хамгийн үнэ цэнэтэй, ариун туршлагуудын зарим нь нас барсан өвөг дээдсийнхээ төлөө лацдан холбох ёслолуудыг гүйцэтгэхээр ариун сүмд хамтдаа байхад тохиолдсон байдаг.

Хэрэв та нар ариун сүмд хараахан орж амжаагүй эсвэл ариун сүмд орох зөвшөөрлийн бичгээ сунгуулж амжаагүй байгаа бол та нарын хувьд ариун сүмд орохоор зохистой байхын төлөө ажиллахаас илүүтэй чухал зорилго гэж үгүй! Магадгүй та нар эрхийг тань боогдуулах хэвшин тогтсон зуршлуудаа орхисноор зөвшөөрлийн бичгээ хүлээн авахаар зохистой болоход өөрийгөө дайчлах золиослол хийх хэрэгтэй байж болно. Магадгүй аравны нэгээ итгэлтэйгээр төлөх сахилга баттай байх ч байж болно. Энэ нь юу ч байлаа гэсэн өөрийгөө Бурханы ариун сүмд орохоор бэлтгэ. Ариун сүмийн бичгээ ав. Түүнийгээ үнэхээр үнэт баялаг, эрдэнэс мэт үзэж, хайрлан санаа тавь.

Их Эзэний өргөөнд орж, та нарыг хүлээж байгаа адислалуудыг хүлээн аваагүй цагт та нар Сүмийн санал болгож буй бүхнийг олж аваагүй л гэсэн үг. Сүмд гишүүн байх хамгийн дээд, чухлаас чухал адислалууд нь Бурханы ариун сүмд бидний хүлээн авдаг адислалууд юм.

Одоо идэр насандаа яваа миний залуу найз нар аа, ариун сүмийг зорилгоо болго. Ариун сүмийн хаалгаар орох, тэнд өгөгддөг ариун нандин, мөнхийн адислалуудыг хүртэхээс та нарыг холдуулах юуг ч бүү хий. Нас барагсдын төлөө баптисм хийлгэхээр ариун сүмд байнга ордог хүмүүст би сургуульдаа явахаас өмнө амжиж ийм баптисмуудад оролцохын тулд өглөө маш эрт босч байхыг уриалж байна. Өдрийг ингэж эхлэх үүнээс илүү эрхэм сайхан арга зам гэж үгүй гэж би бодож байна.

Залуу хүүхдүүдийн эцэг эхчүүдэд би Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын мэргэн зөвлөмжөөс хуваалцъя. Тэрээр хэлэхдээ: “[Тэдний хүүхдүүд] нялх балчраасаа эхлэн амьдралынх нь нэг хэсэг болтол өдөр бүр зургийг харж болохын тулд эцэг эхчүүд гэрийнхээ унтлагын өрөөнүүдэд ариун сүмийн зурагтай байвал сайн. [Тэд] хамгийн чухал шийдвэр [ариун сүмд орохтой холбоотой] гаргах шаардлагатай насандаа хүрэхэд түүнийгээ аль эрт хийж чаддаг болсон байх болно”⁶ гэжээ.

Бидний хүүхдүүд Хүүхдийн Хэсэгтээ:

Би ариун сүм харах дуртай
Нэгэн цагт тэнд орно
Эцэгтэйгээ гэрээ байгуулж
Дагана хэмээн амлана⁷ гэж дуулдаг.⁷

Ариун сүмийн онцгой ач холбогдлыг хүүхдүүддээ заахын төлөө би та нартай хамт залбирч байна.

Дэлхий амьдрахад ихэд төвөгтэй, эвгүй газар байж болно. Биднийг үргэлж доош чирэх юмсаар хүрээлэгдсэн байдаг. Та нар болон миний хувьд Бурханы ариун өргөөнд ороход, түүний дотор хийх гэрээнүүдээ санахад бид сорилт, уруу таталт бүхнийг даван туулах илүү их чадвартай болно. Энэ ариун газар бид амар амгаланг олж, шинэчлэгдэн, бат бөх хамгаалалттай болно.

Ах эгч нар аа, хэлэх үгээ дуусгахын өмнө нэг ариун сүмийн талаар дурдахыг зөвшөөрнө үү. Ойрын ирээдүйд, дэлхий даяар олон шинэ ариун сүм баригдах бөгөөд тэдгээр ариун сүмүүдийн нэг нь 2500 жилийн өмнөөс өдийг хүртэл оршин байгаа нэгэн хотод баригдах болно. Би Италийн Ромд баригдаж буй ариун сүмийг хэлж байна.

Ариун сүм бүр ижил үйл ажиллагаа явуулдаг, адил адислалууд болон ёслолуудыг хийдэг, Бурханы Өргөө юм. Италийн Ромын Ариун сүм нь дэлхийн хамгийн түүхэн газруудын нэг, эртний Төлөөлөгч Петр, Паул нар Христийн сургаалыг номлосон мөн хоёул итгэлийнхээ улмаас егүүтгэгдсэн хотод баригдаж байгаагаараа онцлог юм.

Өнгөрсөн арван сард бид Ромын зүүн хойт хэсэгт орших үзэсгэлэнтэй хөдөө нутагт хамтдаа цугларч, газар хөндөхөд бэлтгэх үед онцгойлон адислалтын залбирлыг хэлэх боломж надад олдсон. Эхэлж газар хөндөх боломж олгогдсон Ром хотын орлогч дарга Гвисеппе Сиарди, Италийн сенатор Лучио Малан нарын дунд залбирал хэлэх нь сэтгэл догдлуулсан үйл хэрэг байлаа. Тэр хоёр бол тэдний хотод ариун сүм барихыг бидэнд зөвшөөрсөн шийдвэрийг гаргахад хувь нэмрээ оруулсан хүмүүс юм.

Тэр өдөр бүрхэг, үүлтэй ч, дулаахан байлаа. Бороо орох нь уу гэтэл ганц хоёр дуслaad өнгөрөв. Гайхамшигтай найрал дуучид итали хэлээр “Бурханы Сүнс” хэмээх яруу сонсголонт дууллыг дуулахад Бүхнийг Чадагч Бурхандаа өргөх сүрлэг яруу сайхан дуулалд тэнгэр, газар хоёр нэгдсэн мэт хүн болгонд санагдаж билээ.

Цаг нь болоход нэг өдөр энэхүү “Мөнхийн хот” дахь итгэлтнүүд Бурханы ариун өргөөнд үүрд мөнхийн ёслолуудыг хүлээн авах болно.

Би Тэнгэрлэг Эцэгтээ одоо баригдаж байгаа Ром дахь ариун сүм болон хаана байх нь хамаагүй бүх ариун сүмийн төлөө үүрдийн талархлаа илэрхийлж байна. Ариун сүм бүр дэлхийн гэрэлт цамхаг болж, Бурхан, Мөнхийн Эцэг амьд гэдгийг гэрчлэн, Тэр биднийг мөн бүх эрин үеийн Өөрийн охид хөвгүүдийг адислах хүсэлтэй байгаагаа илэрхийлэн, сүндэрлэж байна. Ариун сүм бүр булшны дараах амьдрал нь дэлхий дээрх бидний амьдралын адил үнэн бодитой гэдгийг гэрчлэх илэрхийлэл. Би ийнхүү гэрчилж байна.

Хайрт ах эгч нар аа, ариун сүмд орж зүрх сэтгэл болон гэр орондоо ариун сүмийн сүнслэг байдлыг авчрахын тулд ямар ч золиослолыг хийж чадах болтугай. Бид Тэнгэрлэг Эцэгийн хаант улсад мөнх амьдарч, өргөмжлөгдөж болохын тулд хамгийн агуу золиослолыг бидний төлөө хийсэн Их Эзэн, Аврагч Есүс Христийн үлгэр жишээг дагах болтугай гэсэн зүрх сэтгэлийхээ энэхүү залбирлыг би бидний Аврагч, Их Эзэн Есүс Христийн нэрээр хэлж байна, амен.

Эшлэл

1. Жозеф Ф.Смит, Conference Report, 1902 оны 10-р сар, 3.
2. Вилсон Фелип Сантьяго, Линда Ричи Арчибалд нар, “From Amazon Basin to Temple,” Church News, 1993 оны 3-р сарын 13, 6-г үз.
3. К.Жей Ларсон, “Temple Moments: Impossible Desire,” Church News, 1996 оны 3-р сарын 16, 16-г үз.
4. Хебер К.Кимбалл, in Orson F. Whitney, *Life of Heber C. Kimball* (1945), 67.
5. *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 247.
6. *The Teachings of Spencer W. Kimball*, хянасан Эдвард Л.Кимбалл (1982), 301.

7

7. Жанис Капп Перри, 1938, ©1980 Жанис Капп Перри, “I Love to See the Temple,”
Children’s Songbook 95.

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

Ерөнхий чуулган

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Гэрлэлтийн мөнхийн адислалууд

гэрлэлт

гэр бүл

хайр

эцэг эх болох

гэрээ

ерөнхий чуулган

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Ричард Г.Скотт

Амьдралын туршлага суух тусам ариун сүмийн лацдан холболт улам гүнзгий утга учиртай болдог. Энэ ёслол та нарыг хэзээ хэзээнээс илүү ойртуулж, мөнх бус амьдралд агуу баяр баясгалан, сэтгэл ханамжийг олоход тань тусална.

Энэхүү гайхамшигтай найрал дууны сэтгэлд хоногшим сайхан захиас нь, биднээс олных нь хувьд “Христтэй адилхан байхыг хичээх нь” амьдралын загвар болсныг дүрслэн харууллаа гэж бодно.

1953 оны 7-р сарын 16-нд би хайрт Женинтэйгээ Ютагийн Мантай Ариун сүмийн тахилын ширээний өмнө өвдөг сөхрөн суусан юм. Ерөнхийлөгч Луис Р.Андерсон санваартны эрх мэдлээр бид хоёрыг энэ амьдралд болон үүрд мөнхөд эхнэр, нөхөр болсныг зарлав. Их Эзэний өргөөнд, санваарын зохих хүчээр гүйцэтгэгдсэн энэхүү эрхэм нандин ёслолыг хүртэхдээ цаашид үргэлж зохистой амьдарвал хайрт Женин болон хүүхдүүдтэйгээ үүрд мөнх хамт амьдарна гэсэн баталгааг тэр мөчид үгээр илэрхийлэхийн аргагүй амар амгалан байдлаар хүлээн авсан билээ.

Бидний долоон хүүхэд маань ариун сүмийн нандин ёслолуудаар бидэнтэй холбогдсон. Миний хайрт гэргий Женин болон хоёр хүүхэд маань хөшигний нөгөө талд байгаа. Зөв шударга амьдарснаар ариун сүмд амласан мөнхийн адислалуудыг хүлээн авах болно гэдэгт тэд биднийг зоригжуулдаг.

Тэнгэр дэх Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний амин чухал хэсэг бол гэрлэлт ба гэр бүл билээ. Гэр бүлд ан цав гаргах, гэр бүлийг үүрд мөнхөд холбох ариун сүмийн ёслолуудын утга учрыг бууруулах Сатаны оролдлогууд нь гэрлэлт болон гэр бүл нь ямар чухал болохыг бидэнд сануулдаг. Амьдралын туршлага суух тусам ариун сүмийн лацдан холболт улам гүнзгий утга учиртай болдог. Энэ ёслол та нарыг хэзээ хэзээнээс илүү ойртуулж, мөнх бус амьдралд агуу баяр баясгалан, сэтгэл ханамжийг олоход тань тусална.

Эхнэр минь надад нэг чухал зүйлийг ойлгоход тусалсан юм. Би ажлын шугмаар томилолтоор байнга явдаг байв. Бараг хоёр долоо хоног томилолтоор яваад нэгэн бямба гарагийн өглөө гэртээ ирлээ. Гэхдээ дөрвөн цагийн дараа дахиад л нэг хуралд суух

хэрэгтэй байв. Тэр үед манай угаалгын машин эвдэрсэн учраас эхнэр маань гараараа хувцас угааж байхыг би хараад угаалгын машинаа засч эхлэв.

Женин хажууд ирээд, “Рич, чи юу хийж байгаа юм бэ?” гэж асуулаа.

“Би угаалгын машинаа засчихъя, тэгвэл чи гараараа угаах хэрэггүй болно шүү дээ” гэлээ.

Тэгэхэд: “Хэрэггүй ээ, чи явж хүүхдүүдтэйгээ тогло” гэлээ.

Намайг: “Би тэдэнтэй хэзээ ч тоглож болно шүү дээ. Харин одоо чамд тусалмаар байна” гэхэд,

“Ричард, гуйж байна, явж хүүхдүүдтэйгээ тогло” гэв.

Тэр надад нэлээд шийдэмгий аясаар хэлсэн болохоор би түүнийг дуулгавартайгаар дагалаа.

Тэр өдөр би хүүхдүүдтэйгээ цагийг маш сайхан өнгөрөөж, хөөцөлдөн гүйлдэж, намрын унасан навчис дунд өнхрөлдөн тоглосны дараа хуралдаа явсан. Эхнэр минь надад хүүхдүүдтэйгээ тоглох нь ямар сайхан болохыг санах боломж өгөөгүй бол би үүний чухлыг мартаж ч болох байлаа.

Маргааш өглөө нь үүрээр дөрвөн цагийн үед хүзүүгээр минь хоёр жижигхэн гар тэврэн, хацар дээр минь үнсээд, чихэнд минь шивнэх: “Аав аа, би танд хайртай шүү. Та миний хамгийн сайн найз” гэсэн хэзээ ч мартагдахгүй үгсийг сонсоод би сэрсэн юм.

Хэрэв та гэр бүлдээ ийм аз жаргалыг мэдрээгүй бол амьдралын хамгийн дээд баяр баяслын нэгийг мэдрээгүй байна гэсэн үг шүү.

Хэрэв гэрлэх насанд хүрсэн залуус та нар хараахан гэрлээгүй бол цагаа битгий дэмий үрээрэй. Амьдралаа төвхнүүлж, гал голомтоо бадраахад анхаарлаа төвлөрүүл. Залуу

насаа зөв зорилгуудаа биелүүлэхэд зориулж, идэвхтэй амьдар. Залуу эрэгтэйчүүд ээ, номлолд үйлчил. Тэгээд зохистой, мөнхийн ханиа олоход хамаг хүчээ зориул. Залуу эмэгтэй сонирхлыг чинь татвал онцгой хүн гэдгээ түүнд харуул. Түүнтэй зохистой сайхан газруудаар зугаалж, сонирхолтой болзоонд түүнийг урьж бай. Хэрэв та гайхамшигтай эхнэртэй болохыг хүсч байгаа бол түүндээ сайн эр хүн мөн ирээдүйн эр нөхөр болж чадна гэдгээ харуулах хэрэгтэй.

Хэрэв та нар хэн нэгнийг олсон бол түүнтэйгээ маш сайхан үерхэж улмаар гэрлэж Их Эзэний тогтоосон зохистой байдлын хүрээнд үүрд мөнхөд хамгийн, бүр хамгийн аз жаргалтай байгаарай.

Хэрэв та гэрлэсэн бол бие болон оюун санаагаараа ханьдаа итгэлтэй байна уу? Та ханьдаа сонсгохооргүй зохисгүй зүйлийг өөр хэн нэгэнтэй ярилгүй гэрлэлтийн гэрээнүүддээ үнэнч байдаг уу? Та хань болон үр хүүхэддээ эелдэг, халамжтай байдаг уу?

Ах нар аа, та нар гэр бүлээрээ судруудаас судлах, залбирал болон гэр бүлийн үдэш хийх зэрэг гэр бүл дэх үйл ажиллагаануудыг удирдан явуулж байна уу? эсвэл эдгээр үүргийг гэргий тань таны өмнөөс хийж байна уу? Та нар эхнэртээ хайртайгаа байнга хэлдэг үү? Энэ үг түүнд агуу аз жаргалыг авчрах болно. Намайг энэ тухай хэлэхэд эрчүүд “Аан, эхнэр үүнийг мэднэ ш дээ” гэж хэлэхийг би нэг бус удаа сонссон. Та нар түүнд хайртайгаа үргэлж хэлж байх хэрэгтэй. Эмэгтэй хүн эдгээр үгсээр цэцэглэж, өсч хөгжиж, мөн энэхүү баталгаагаар агуу их адислагддаг. Таны төлөө хийж байгаа ханийнхаа үйлсд талархлаа илэрхийл. Хайр, талархлаа байнга илэрхийлж байгаарай. Энэ нь амьдралыг баяжуулж, илүү тааламжтай, тодорхой зорилготой болгодог юм шүү. Хайраа нууж хаах хэрэггүй ээ. Үүнийг эхнэрийнхээ гараас барин ойроос хэлбэл илүү үр дүнтэй байдаг.

Ийнхүү хайраа илэрхийлж байх нь чухал болохыг би эхнэрээсээ сурсан. Гэрлэлтийнхээ эхэн үед хурал цуглаан дээр захиас өгөхөөр судраа нээхэд хуудсуудын завсар Жениний минь энхрий ялдамхан, урам хайрласан зурвас байхыг би олж хардаг байв. Зарим нь үгээр дүрслэх аргагүй эелдэг ялдамхан байсан. Хайрт эхнэрийн минь ялдамхан зурвасууд надад тайтгарлын үнэлж баршгүй эрдэнэс болсоор байна.

Тэгээд би бас түүнд ийм зурвасууд бичдэг болж билээ. Зурвасууд түүний хувьд ямар их утга учиртайг би тийм сайн ойлгоогүй байв. Нэг удаа гэргийдээ валентины баяраар өгөх юмгүй, мөнгөөр тарчигхан байсан болохоор би хөргөгчнийхөө нүүрэн дээр усан будгаар зураг

зурахаар шийдлээ. Би маш их хичээж зурсан ч харамсалтай нь усан будаг биш арилдаггүй будгаар зурсан байв. Гэргий минь энэ зургийг хөргөгчнөөс арилгахыг огт зөвшөөрөөгүй юм.

Нэг өдөр би цаасны цоолтуураар цоолж гаргасан дугариг цааснууд дээр 1-100 хүртэлх тоо бичээд, цаас бүрийн ар талд нь нэг үг бичсэн зурвас түүнд бичсэнээ санаж байна. Дараа нь би тэдгээрийг холиод, дугтуйнд хийлээ. Би түүнийг баярлан инээх байх даа гэж бодож байсан.

Харин түүнийг өөд болсны дараа бидний энгийн зурвасууд түүнд хэчнээн их баяр баясгалан авчирдаг байсныг хувийн зүйлсээс нь би олж мэдсэн билээ. Тэрээр нөгөө олон жижиг цаасыг нэг бүрчлэн цаасан дээр нааж хадгалсан байв. Тэр миний явуулсан зурвасуудыг зөвхөн хадгалаад зогсохгүй үнэт эрдэнэс адил нандигнан гялгар хавтсанд хадгалдаг байсныг нь би мэдсэн. Өөр нэг зурвас нь манай гал тогооны өрөөний цагны шилний ард хадгалаастай хэвээр байгаа. Түүн дээр “Женин, би чамд хайртайгаа хэлэх цаг болжээ” гэсэн үгс байдаг. Энэ зурвасыг байсан байранд нь үлдээсэн бөгөөд энэ нь Тэнгэр дэх Эцэгийн ер бусын онцгой охины тухай надад сануулдаг.

Би түүнтэйгээ хамт амьдарсан хугацаандаа ямар их адислагдсанаа ойлгодог. Манай гэрт хэрүүл маргаан огт байгаагүй бөгөөд бид бие биедээ хэзээ ч хатуу хахир үг хэлж байсангүй. Гэргий маань дэргэд байсан болохоор адислал ирж байсныг би одоо л ойлгож байна. Түүний маань өгөх, хуваалцах хүсэл, хэзээ ч хувиа боддоггүй зангийн үр дүн юм. Хамтын амьдралынхаа сүүлийн хэдэн жилүүдэд би түүний үлгэр жишээг дууриахыг хичээж байлаа. Та бүхнийг нөхөр, эхнэрийн хувьд үүнтэй ижил зүйлийг гэр орондоо хийж байхыг би санал болгож байна.

Цэвэр хайр нь сайн зүйлийн төлөөх зүйрлэшгүй, агуу хүч бөгөөд зөв шударга хайр нь сайн сайхан гэрлэлтийн үндэс мөн. Ийм хайр бол сэтгэл хангалуун байх, зөв хүмүүжилтэй сайн хүүхдүүдтэй байхын гол учир шалтгаан юм. Эхийн хайрыг юугаар ч хэмжиж чадахгүй билээ. Хүүхдийн гэнэхэн оюун ухаан, зүрх сэтгэлийн үржил шимтэй хөрсөнд эх хүний тариалж, хайраар ургуулсан үнэний үрээс ургасан жимс ямар байх бол? Үр хүүхдийнхээ онцгой авьяас билэг, өвөрмөц чадварыг мэдрэхэд туслах бурханлиг зөн билэг ээж нарт өгөгдсөн байдаг. Нөхрийнхөө хамт та нар эдгээр зан чанараа төлөвшүүлж, хүчирхэгжүүлэн, өсгөж чадна.

Гэрлэлт гэдэг үнэхээр гайхамшигтай. Он жилүүд улиран өнгөрөх тусам гэрлэсэн хос нэг хүн лүгээ адил бодол санаа нэгтэй болдог. Та нарт аз жаргалтай мөчүүд, сорилт, саад бэрхшээл тулгарах цаг мөчүүд байх ч бүхнийг хамтдаа туулан гарахад Их Эзэн та нарыг удирдах болно.

Нэгэн шөнө зүрхний өвчтэй бяцхан хүү Ричард минь сэрээд уйлахыг бид сонслоо. Эхнэр минь бяцхан хүүгээ үргэлж асардаг ч энэ удаа, би “Би түүнийг авъя” гэж хэллээ.

Хүү минь зүрхний өвчтэй болохоор уйлахад нь бяцхан зүрх нь хурдан цохилон, идсэн хоол ундаа бөөлжин гаргаж, унтлагын хувцсаа завааруулдаг байв. Би хувцсыг нь бас орны даавууг нь солих зуураа хөөрсөн зүрхнийх нь цохилтыг намсгаж, уйлахыг нь зогсоохыг хичээн, хүүгээ биедээ наан тэвэрлээ. Би түүнийг унтгал тэвэрсээр байв. Тэр үед би түүнийг хэдхэн сарын дараа нас барна гэдгийг мэдээгүй байлаа. Тэр шөнө хүүгээ цээжиндээ тэвэрч байснаа би үргэлж санах болно.

Би түүний нас барсан өдрийг сайн санадаг. Тэр өдөр Женин бид хоёр эмнэлгээс ирээд, замын хажууд машинаа тавьсан. Би гэргийгээ тэврээд хоёулаа жаахан уйлсан ч ариун сүмд хийсэн гэрээнүүдийн учир бид түүнтэй хөшигний цаана хамт байна гэдгээ ойлгосон. Энэ нь бидний уй гашууг хөнгөлөн тайвшруулсан юм.

Жениний нинжин сэтгэл үй олон үнэлж баршгүй зүйлсийг надад заасан. Би үнэхээр томоогүй, харин тэр чанд сахилгатай, сүнслэг хүн байлаа. Гэрлэлт нь амин хувиа хичээсэн байдлаа даван туулж, өв тэгш болон хөгжих боломжийг олгодог. Залуудаа гэрлэхийг зөвлөдөг шалтгааны нэг нь өөрчлөхөд хүндрэлтэй зохисгүй зан чанаруудыг эртхэн өөрчлөх боломжтой байдагт оршино.

Би үүрд мөнхийн ханиа эрж олон, сонгож амжаагүй эрэгтэйчүүдийн өмнөөс харамсаж байна. Мөн гэрлэх боломж олдоогүй байгаа эгч нарын төлөө зүрх сэтгэл минь харуусч байна. Та нарын зарим нь өөрсдийгөө ганцаардмал, хэн ч таныг тоодоггүй мэт санаж, гэрлэлт болон үр хүүхэдтэй болох адислалуудыг авах нь танд боломжгүй гэж бодож байж магадгүй. Их Эзэний хувьд бүх зүйл боломжтой шүү. Тэрбээр бошиглогч нарт өгсөн амлалтаа биелүүлдэг. Үүрд мөнх гэдэг урт хугацаа. Эдгээр амлалтуудад итгэлтэй байж, зохистойгоор амьдар. Тэгэх аваас Түүний цагт Их Эзэн тэдгээр амлалтыг жинхэнэ бодит үнэн болгоно. Зохистой байсныхаа төлөө амлагдсан адислал бүрийг хүлээн авах нь эргэлзээгүй юм.

Хайрт гэргий Женинийхээ тухай ярьж байгааг минь өршөөгөөрэй. Гэхдээ бид мөнхийн гэр бүл шүү. Тэр үргэлж баяр баясгалантай, аз жаргалтай байсан. Тэрхүү аз жаргалын

ихэнх нь бусдад үйлчилснээс ирсэн баяр баясгалан байлаа. Тэр маш хүнд өвчтэй байхдаа ч Тэнгэр дэх Эцэгээсээ тусалж чадах хэн нэгнийг өөр уруугаа хөтлөхийг гуйдаг байсан. Энэхүү чин сэтгэлийн гуйлт нь цаг үргэлж хариулагддаг байлаа. Тэрээр олон хүний ачааг хөнгөлж, амьдралыг нь өөрчлөхөд тусалсан юм. Тэр Их Эзэнээр удирдагдсан зэмсэг нь байхаар адислагдсан байв.

Эмэгтэй хүний үүргээ шударгаар биелүүлж, гоо үзэсгэлэн, энэрэл хайраар дүүрэн амьдарсан Тэнгэр дэх Эцэгийн охиныг хайрлах нь ямар байдгийг би мэднэ. Ирээдүйд хөшигний цаана түүнийгээ харж, нэг нэгнээ улам их хайрлах болсноо мэдрэнэ гэж бодоход надад таатай байна. Ийм учраас бид хөшигний хоёр талд байсан энэ цаг мөчид улам илүүтэй талархах болно, Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

Лиахона

2011 оны 5-р сар

Ням гарагийн үдээс хойших хуралдаан
2011 оны 4-р сарын 3

“Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Д.Тодд Кристофферсон

Тэнгэрлэг Эцэг Бурхан өндөр жишгийг биднээс хүсэн хүлээдэг. Биднээс хүсэн хүлээдэг зүйлсийг нь Түүний Хүү Есүс Христ дараах үгсээр илэрхийлсэн юм: “Би, эсвээс Тэнгэрт буй Эцэг тань төгсийн адил та нарыг төгс байгаасай хэмээнэ би” (3 Нифай 12:48). Бид “сестиеел алдар сууг тэсэн гарч,” (С ба Г 88:22), “Түүний дэргэд амьдрахын тулд” (Мосе 6:57) биднийг ариун болгох нь Түүний зорилго юм. Үүнд юу шаардлагатайг Тэр мэддэг учраас өөрчлөгдөх боломжийг олгодог зарлигууд, гэрээнүүд, Ариун Сүнсний бэлэг, хамгийн чухал нь Өөрийн Хүүгийн Цагаатгал ба Амилалтыг бидэнд өгсөн билээ. Энэ бүхний цаадах Бурханы зорилго бол Түүний хүүхдүүд---бид төгс баяр баясгаланг олж, Түүнтэй хамт үүрд амьдран, Түүнтэй адилхан болох явдал мөн. Хэдэн жилийн өмнө Ахлагч Даллин Х.Өүкс ийн тайлбарлажээ: “Эцсийн шүүлт бол бидний *хийсэн* сайн ба муу үйлсийг дэнслэн, үнэлэлт дүгнэлт өгөх төдий зүйл биш. Энэ бол бидний үйл хэрэг, санаа бодлын эцсийн үр дүн биднийг ямар хүмүүс *болгосныг* үнэлж дүгнэх явдал мөн. Хүмүүс зүгээр л урсгалаараа явах нь хангалтгүй. Сайн мэдээний зарлигууд, ёслолууд болон гэрээнүүд нь тэнгэр дэх хадгаламжинд хураагдаж байдаг зүйлсийн жагсаалт биш. Есүс Христийн сайн мэдээ бол Тэнгэрлэг Эцэгийн хүсэн хүлээдэг шиг тийм хүмүүс хэрхэн болохыг бидэнд харуулдаг төлөвлөгөө юм.”¹

Орчин үеийн Христэд итгэгчдийн дийлэнх нь Бурхан Өөрт нь итгэдэг хүмүүст бодит шаардлагуудыг тавьдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй нь харамсалтай. Тэд Түүнийг “дуудсан үед хэрэгцээг нь хангаж өгдөг” үйлчлэгч, эсвэл “өөрсдийнхөө тухай сайнаар бодоход” нь хүмүүст тусалдаг сэтгэл зүйч лүгээ адил боддог.² бол “хүмүүсийн амьдралыг өөрчлөхийн төлөө байдаггүй” шашны үзэл баримтлал юм.”³ “Үүний эсрэгээр, нэгэн зохиолч “Еврейн болон Христийн судруудад дүрслэгдсэн Бурхан зөвхөн бидний

Comment [m1]: Энэ хэсэг ойлгомжгүй байна. Утгыг дахин харна уу

тууштай итгэл бишрэлийг төдийгүй, амь насаа түүнд зориулахыг хүсдэг. Библийн Бурхан сайн, сайхан байх талаар бус харин үхэл, амьдралын асуудлуудыг авч үздэг бөгөөд ямар нэгэн үлбэгэр мохоо үзэл баримтлалыг биш, харин хайраа золиослолоор үзүүл хэмээн биднийг уриалдаг” гэж мэдэгджээ.⁴

Тэнгэрлэг Эцэгийнхээ өндөр шаардлагуудад хүрэхийн тулд өөрсдийн болгож хэвшүүлсэн байх ёстой нэгэн хандлага, дадал зуршлын тухай ярихыг хүсч байна. Энэ нь алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрч, алдаагаа залруулахын тулд зүтгэх явдал юм. Хэрвээ бид “төгс хүмүүн болоход, Христийн бэлгийн хэмжээгээр бидний хүн нэг бүрд өгөгдсөн нигүүлсэлд” (Ефес 4:7) зохицохоор амьдралаа өөрчлөхийг хүсч байвал алдаандаа залруулга хийх нь нэн чухал юм. Бурханлиг залруулга буюу сахилгажуулалтын тухай Паул, “Учир нь Эзэн хайрладаг хүмүүсээ сахилгажуулдаг юм” (Еврей 12:6) гэжээ. Энэ нь ихэвчлэн хэцүү байдаг ч Бурхан бидний алдаа дутагдлыг залруулахад цагаа заваа зориулж, анхаарал тавихаар үнэ цэнэтэй гэдэгтэй бид баярлах ёстой.

Бурханлиг зэмлэл нь: (1) биднийг наманчлахад чиглүүлэх, (2) төгөлдөржүүлж, ариусгах, (3) заримдаа бидний амьдралын замыг Бурханы мэдэх илүү сайн зам уруу өөрчлөн чиглүүлэх гэсэн гурван зорилготой юм.

Уучлал, ариусалтыг хүлээн авахад эхлээд наманчлах нь нэн чухал. “Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм. Тиймээс зүтгэлтэй бай, гэмш” (Илчлэлт 3:19) хэмээн Их Эзэн хэлсэн. Тэрбээр түүнчлэн, “Мөн тэд дуулгавартай байдлыг сурах хүртлээ миний хүмүүс, хэрэв энэ нь шаардагдах ёстой аваас тэдний амсах тэр зүйлүүдээр зэмлэгдэх ёстой нь шаардлагатай байна” гэжээ (С ба Г 105:6; мөн С ба Г 1:27-г үз). Их Эзэн хожмын үед өгөгдсөн нэг илчлэлтэд, Сүмийн дөрвөн удирдагчид хандан, (тэр бидэнд бас ингэж хэлэх байсан байх) хүүхдүүддээ “зарлигуудын дагуу” зохих ёсоор заагаагүй мөн “гэр орондоо илүү хичээнгүй байж, санаа тавиагүйн” (С ба Г 93:41–50) улмаас тэдэнд наманчлахыг зарлиг болгосон байдаг. Мормоны ном дээрх Жаредын ахад Их Эзэн үүлэн дотор зогсон, түүнтэй “гурван цагийн турш . . . [ярьж], Их Эзэний нэрийг дуудахаа эс санасных нь учир зэмлэхэд” (Ифер 2:14) тэр наманчилсан байдаг. Тэр хатуу зэмлэлийг дуртайяа хүлээн авсан тул хожим нь мөнх бус байдлын өмнөх Гэтэлгэгчийг харж, түүнээс заавар хүлээн авах онцгой боломж Жаредын ахад олдсон байдаг. (Ифер

3:6–20-ийг үз). Бурханы зэмлэлийн үр жимс нь зөв шударга байдал өөд хөтөлдөг наманчлал юм (Еврей 12:11-ийг үз).

Наманчлахад түлхэц үзүүлэхээс гадна зэмлэлийг тэвчээртэйгээр хүлцэн өнгөрөөх явц нь биднийг төгөлдөржүүлж, илүү агуу сүнслэг зүйлсд бэлтгэдэг юм. “Тэдний тулд надад буй алдар сууг, бүр Сионы алдар сууг хүлээн авахад бэлтгэгдэхийн тулд миний хүмүүс бүх зүйлд зовлон зүдгүүр үзэн соригдох ёстой; мөн зэмлэл үл даах тэрээр миний хаант улсын хувьд зохистой бус бөлгөө” (С ба Г 136:31) гэж Их Эзэн хэлсэн байдаг. Мөн Тэрбээр “Учир нь гэсээн цээрлүүлэлтийг тэвчихгүй, харин намайг үгүйсгэдэг тэд бүгд ариусгагдаж чадах нь үгүй” (С ба Г 101:5; мөн Еврей 12:10-ыг үз) гэжээ. Ахлагч Пол В.Жонсоны өнөө өглөө хэлсэнчлэн, бид бурханлиг шинж чанарыг өөрсдөдөө төлөвшүүлэхэд туслах зүйлсд дургүйцдэггүй байх ёстой.

Алмаг дагалдагчид Хеламд Сионы сууринг бий болгосон ч дараа нь боолчлолд ордог. Тэд зовлон зүдгүүр үзэхийн оронд харин ч үүний эсрэгээр адислал хүртэх ёстой байсан ч цэдэгт, “Гэсэн хэдий ч Их Эзэн өөрийн хүмүүсийг зэмлэх нь зүйд нийцэх бөлгөө; тийм ээ, тэрээр тэдний тэвчээр, мөн тэдний итгэлийг сорьдог билээ. Гэсэн хэдий ч—түүнд найдлага тавих хэн боловч мөнхүү тэр нь эцсийн өдөр өргөмжлөгдөх болно. Тийм ээ, мөн энэ хүмүүсийн хувьд тийм байв” (Мозая 23:21–22) хэмээн өгүүлжээ. Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлж, мөрөн дээрх ачаагаа бараг мэдрэхгүй болтол нь ачааг нь хөнгөлж, цаг нь болоход тэднийг чөлөөлдөг (Мозая 24:8–22-ыг үз). Үүнийг туулж чадсан учраас тэдний итгэл хэмжээлшгүй ихээр хүчирхэгжиж үүнээс хойш Их Эзэн болон тэдний дунд онцгой холбоо бий болсон байдаг.

Бурхан одоогоор бид харж буюу төсөөлж чадахгүй тэрхүү ирээдүйд хөглөх бидний хувьд илүү сайн гэдгийг нь зөвхөн Тэр л мэддэг өөр нэгэн төрлийн залруулга, зэмлэлийг ашигладаг. Үүний тухай Арванхоёрын гишүүн, хожим нь Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан Ерөнхийлөгч Хью Б.Браун нэг туршлагаа хуваалцсан байдаг. Тэр олон жилийн өмнө Канадад нэг хуучирч муудсан ферм худалдаж авсан тухайгаа ярьсан юм. Тэр фермээ цэвэрлэж, засвар хийж байгаад, зургаан фут (1.8 м) өндөр ургасан ч, жимс ургаагүй улаалзганы бутыг жижигхэн хожуул болтол нь тайралт хийж гэнэ. Тэгээд хартал жижигхэн хожуул бүрийн орой дээр нулимс шиг дусал бөнжийхийг хараад, улаалзганы бут уйлж,

“Та намайг яаж байгаа нь энэ вэ? Би ийм сайхан ургаж байхад, . . . намайг тайраад хаячихлаа. Цэцэрлэг дэх ургамал бүхэн над руу тонгойж харна . . . Та намайг яаж байгаа нь энэ вэ? Би таныг цэцэрлэгч гэж бодсон шүү” гэж хэлэхийг сонсох шиг түүнд санагджээ.

[Ерөнхийлөгч Браун ингэж хариулжээ], “Улаалзганы бяцхан бут минь ээ, аан гэж бай, би энд цэцэрлэгч нь. Чамайг ямар болгохыг хүсч байгаагаа би мэдэж байна. Би чамайг жимсний юм уу сүүдрээр халхлах мод байгаасай гэж бодохгүй байна. Харин чамайг нэгэн цагт дааж ядсан арвин их жимстэй улаалзганы бут болгохыг хүсч байна. Тэр үед ч, ‘Баярлалаа ноён цэцэрлэгч ээ, та намайг хайрласан учраас тайрсан байжээ. . . гэж хэлэх болно” гэжээ.

Олон жилийн дараа Ерөнхийлөгч Браун Англид Канадын Армийн хээрийн штабын ахлах офицерын алба хашжээ. Ахлах тушаалтан тулалдаанд амь үрэгдэж, генералыг орлож дэвших дараагийн хүн Ерөнхийлөгч Браун байсан учраас түүнийг Лондонд дуудсан байв. Ахлагч Браун албан тушаал дэвшүүлэх шаардлагыг бүрэн хангасан ч тэр Мормон байсан учир цолыг нь ахиулахаас татгалзжээ. Командлагч генерал, “Та энэ ажилд тэнцэнэ, гэвч би үүнийг танд өгч чадахгүй нь” гэжээ. Бүтэн 10 жилийн турш Ерөнхийлөгч Брауны найдвар тавин, залбирч, үүний төлөө бэлтгэж байсан зүйл нь ялгаварлан гадуурхалтын улмаас хормын төдийд замхран алга болох нь тэр. Тэрбээр өөрт тохиолсон явдлынхаа тухай цааш нь өгүүлсэн нь:

“Тэгээд би сэтгэл санаагаар унаж, гомдлоор дүүрсэн нэгэн. . . галт тэргэнд сууж буцлаа . . . Майхандаа орж, . . . малгайгаа авч аяны орон дээрээ чулуудлаа. Би нударга зангидан, тэнгэр өөд зангаж, “Намайг яаж байгаа нь энэ вэ, Бурхан минь? Шаардлагыг нь хангахын төлөө би бүхнийг хийсэн. Би хийх ёстой бүх зүйлийг хийж, хийгээгүй үлдсэн зүйл гэж үгүй. Та намайг яаж байгаа нь энэ вэ?” гэж хэлэв. Миний уур хорсол буцалсан гэдэг нь.

Тэгтэл нэгэн дуу хоолой сонсогдож би дуу хоолойг танилаа. Энэ нь миний өөрийн дуу хоолой байв. Нөгөөх дуу хоолой, “Би эндхийн цэцэрлэгч. Чамайг яаж байгааг мэдэж байна” гэв. Уур хилэн тэр даруй сэтгэл зүрхээс минь холдож, аяны орныхоо дэргэд өвдөг сөгдөн талархалгүй байсныхаа төлөө уучлал гуйв . . .

... Эдүгээ бараг 50 жилийн дараа, би [Бурханд] хандан, “Баярлалаа, Ноён Цэцэрлэгч ээ, Та надад хайртай учраас намайг тайрсан байжээ”⁵ гэж хэлдэг.

Хью Браун ямар хүн болох ёстойг мөн түүнд юу тохиолдох учиртайг Бурхан мэдэж байсан бөгөөд ариун төлөөлөгч болоход бэлтгэн түүний замыг өөрчлөн чиглүүлсэн юм.

Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийн өндөр жишгүүдэд хүрэхийг чин сэтгэлээсээ хүсч, үүний төлөө хичээн чармайвал, Тэрбээр шаардлагатай үед биднийг тайтгаруулж хүчирхэгжүүлэн, зарим үед алдаа дутагдлыг залруулан зэмлэх гээд бидэнд хэрэгтэй бүхий л тусламжийг өгнө. Хэрэв бид хүсвэл хийгдэх ёстой залруулга нь олон эх сурвалжаас, олон хэлбэрээр ирэх болно. Энэ нь Бурхан бидний залбирлын хариуд Ариун Сүнсээр дамжуулан бидний зүрх сэтгэл, оюун ухаанд хандан ярих үед ирж болно (С ба Г 8:2-ыг үз). Энэ нь бидний залбиралд “Үгүй” буюу бидний хүсэн хүлээснээс өөрөөр хариулах үед ирж болно. Зэмлэл нь судраас судлах үед бидний дуулгаваргүй байдал, алдаа дутагдал, эсвэл зүгээр л хайхралгүй орхисон зүйлсийг сануулахаар ирж болно.

Залруулга нь өөр хүмүүсээр, ялангуяа Бурханы сүнсээр нөлөөлөгдөж бидний аз жаргалыг тунхаглагчдаар дамжиж ирж болно. Төлөөлөгч, бошиглогч, патриарх, бишопууд болон бусад хүмүүс эрт дээр үед байсантай адилаар өнөө үед, “ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биенийг байгуулахын тулд” (Ефес 4:12) Сүмд өгөгдсөн юм. Энэ чуулган дээр яригдсан зарим зүйлс та нарыг наманчлал буюу өөрчлөлтийг хийхэд уриалан дуудаж, хэрэв тэдгээрт анхаарал тавин дагах юм бол та нарыг илүү өндөр төвшинд гаргах болно. Бид бие биедээ Сүмийн гишүүний хувьд тусалж чадна. Энэ нь Аврагч сүмийг байгуулсан үндсэн шалтгааны нэг мөн. Биднийг ойшоодоггүй хэн нэгэн биднийг хурцаар шүүмжилсэн бол бид тэдний хэлсэн зүйлсээс хэрэгтэйг нь өөрсөддөө тусгаж авах чадалтай, даруухан байх хэрэгтэй.

Залруулга нь аядуу зөөлөн, зэмлэлийн хэлбэрээр нөхөр буюу эхнэрээс нь хэн нэгэнд ирж болно. Саяхан бидэнд хандаж үг хэлсэн ахлагч Ричард Г.Скотт, гэрлээд удаагүй байх үед гэргий Женин нь түүнд хүмүүстэй ярилцахдаа өөдөөс нь эгцлэн харж байхыг зөвлөснийг санадаг байна. “Чиний харц хүний нүд уруу биш шал, тааз, цонх юм уу өөр юу ч байсан

тэр уруу л ширтэх юм” гэж хэлсэн гэдэг. Тэрбээр энэхүү эелдэг зөөлхөн сануулгыг чин сэтгэлээсээ хүлээн авснаар энэ нь түүнийг хүмүүст зөвлөгөө өгч, ажиллахад нь үр ашгаа өгчээ. Ерөнхийлөгч Скоттын удирдлага дор бүрэн цагийн номлогчоор үйлчилж байсан хүний хувьд би тэр хүмүүстэй ярилцахдаа нүд уруу нь эгцлэн харж ярьдаг байсныг гэрчилж чадна. Мөн алдаагаа ухамсарлах ёстой нэгэн уруу түүний харц цоортол ширтэх шиг болдог байсныг бас нэмж хэлье.

Хүүхдүүдээ Сатан болон түүнийг дэмжигчдийн аясаар замаа алдаж, өршөөлгүй хатуу эрхшээлд нь оруулахгүйн тулд эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ алдааг залруулж, зарим үед зэмлэх ёстой. Хэн нэгний алдаа дутагдлыг засч залруулах үүрэг хариулагатай нэгэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тэр хүн зөвхөн өөрийнхөө тухай бодож байдгийг Ерөнхийлөгч Бойд К.Пакер ажиглажээ. Зэмлэл нь цагаа олсон, оновчтой, тодорхой бөгөөд, “Ариун сүнсээр хөдөлгөгдсөн үед хурц тодоор, цагаа олж шүүмжил; мөн тэрээр чамайг дайснаа гэж үзэхгүйн тулд, та нар шүүмжилсэн түүнийг хайрлах хайраа дараа нь нэмэгдүүлснээ харуул”-даг (С ба Г 121:43) байх ёстой.

Хэрэв бид залруулга буюу зэмлэлийг эсэргүүцэх юм бол бусад хүмүүс хэдийгээр биднийг хайрладаг ч гэсэн дахин залруулга өгөхөө бүрмөсөн больж магадгүй гэдгийг санагтун. Хэрэв бид хайр энэрлээр дүүрэн Бурханы зэмлэлийг хүлээж авч, өөрчлөлт хийхгүй бол Тэр ч бас зэмлэхээ болино. “Миний Сүнс хүмүүний төлөө үргэлж зүтгэх нь үгүй” (Ифер 2:15) гэж Тэрбээр хэлсэн билээ. Яваандаа бид ихэвчлэн өөрсдийгөө зэмлэж, өөрөө өөрсдийгөө өөрчилдөг болох ёстой. Эдүгээ хорвоог орхисон бидний хайрт, хамтран зүтгэгч ахлагч Жозеф Б.Вертлин цэвэр ариун бөгөөд даруухан шавь болсны нэг арга нь, биелүүлсэн ажил үүрэг бүрээ эргэн харж, үнэлж дүгнэдэгт байсан юм. Тэрбээр Бурханыг баярлуулах хүсэлтэйгээр хийсэн ажилдаа дүгнэлт хийж сайжруулах ёстой зүйлийг сурч, сурч мэдсэн зүйлээ дараагийн ажил үүрэгтээ хичээнгүйлэн хэрэглэдэг байлаа.

Бидний авьяас чадвар өөр өөр ч гэсэн, бид бүгдээрээ Бурханы өндөр жишгүүдэд хүрч чадна. “Хэрэв та нар бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзаж, Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун ухаан, чадлаараа хайрлах аваас [Бурханы] хүч, ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно” (Моронай 10:32) гэж Моронай амласан байдаг. Бидний хичээнгүй, бие сэтгэлээ харамгүй зориулсан хөдөлмөрийн үр дүнд бидэнд хүчийг өгөгч, боломжийг олгогч нигүүлсэл ирдэг билээ. Мөн ингэхэд

Бурханы мутрын хилэгнэлд захирагдах хүсэл, чин сэтгэлийн, бүрэн наманчлал хэрэгтэй.

Түүний хайраас үүдэлтэй сүнслэг зэмлэлийг авахын төлөө залбирцгаая.

Бурханы өндөр жишгүүдэд хүрэхийн төлөө та нарыг хичээн чармайхад тань Тэрбээр дэмжиж, урсан ирэх бүрэн дүүрэн аз жаргал, амар амгаланг та бүхэнд соёрхох болтугай. Бид бүгд Бурхан болон Христтэй нэг болж чадна гэдгийг би мэднэ. Тэнгэрлэг Эцэгийнхээ тухай, Түүний хайртай Хүүгийн тухай, Тэдний ачаар бидэнд байгаа агуу боломжийн тухай би Есүс Христийн нэрээр, даруухан бөгөөд итгэлтэйгээр гэрчилж байна, амен.

ЭШЛЭЛ

1. Даллин Х.Өүкс, “The Challenge to Become,” *Лиакхона*, 2001 оны 1-р сар, 40.
2. Кенда Креси Дийн, *Almost Christian: What the Faith of Our Teenagers Is Telling the American Church* (2010), 17.
3. *Almost, 30*; мөн *Кристиан* Смит, Мелинда Лундквист Дентон, *Soul Searching: The Religious and Spiritual Lives of American Teenagers* (2005), 118–171-ийг үз.
4. Dean, *Almost Christian*, 37.
5. Хью Браун, “The Currant Bush,” *Лиакхона*, 2002 оны 3-р с ар, 22, 24.

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Их Эзэний хамгийн үнэ цэнэтэй адислалууд

Далын Ахлагч Карл Б.Пратт

Гэр бүлийн цуглааныг албан ёсоор хийж эхлэхээс ч өмнө хүүхдүүддээ сайн мэдээг заадаг байсан өвөг дээдэстээ би талархаж байна. Миний эмээг Айда Жесперсон, өвөөг Жонн А.Виттен гэдэг байв. Тэд Мексикийн Чивава дахь Колониа Хуарес хэмээх жижигхэн сууринд амьдардаг байлаа. Виттений хүүхдүүд эцэг эхийнхээ сургамж болон үлгэр жишээнээс сайн мэдээг суралцдаг байв.

1920-иод оны эхээр Мексикт хэцүүхэн цаг үе байлаа. Хүч хэрэглэсэн хувьсгал дөнгөж дуусаад байлаа. Тун бага мөнгө гүйлгээнд байснаас ихэнх нь зоосон мөнгө байлаа. Хүмүүс хувийн бизнесээ бараа, эд зүйлс солилцох аргаар явуулж байв.

Зуны сүүл сарын нэгэн өдөр Жон өвөө хоёр үхрээ 100 песотой (Мексикийн мөнгөн тэмдэгт) тэнцэх мөнгөн зоосоор зараад гэртээ иржээ. Тэр мөнгөө хүүхдүүдийнхээ сургуулийн төлбөрт зориулаарай гээд эхнэр Айдадаа өгөв.

Айда мөнгөтэй болсондоо баярласан ч тэднийх зуны турш аравны нэгээ төлөөгүйг Жонд сануулжээ. Тэд бэлэн мөнгөний орлогогүй ч мал амьтад нь мах, өндөг, сүүгээр хангаж, тарьсан жимс, ногоо нь хангалттай болохоор эд бараагаар солилцох боломжтой байв. Ийм учраас аравны нэгээ нөхөн төлөхийн тулд мөнгөө бишоптоо өгье гэж Айда хэлжээ.

Мөнгөөрөө хүүхдүүдийнхээ сургуулийн төлбөрийг төлнө гэж бодож байсан Жон бага зэрэг санаагаар унасан ч энэ санааг нь дэмжлээ. Тэгээд тэр зоос хийсэн хүнд цүнхээ аван аравны нэгийн оффист очиж, бишоптоо аравны нэгээ төлжээ.

Энэ явдлын дараахан Нэгдсэн Улсаас баян худалдаачин ноён Хорд хэдэн хүнтэй ууланд ан хийж, загасчлахаар ирэх сураг сонсогдов.

Жон өвөө Колониа Хуаресаас холгүйхэн байдаг төмөр замын буудал дээр тэднийг тосон уулзжээ. Тэрбээр унах морьд, ууланд явахад шаардлагатай аяны тоног төхөөрөмж болон ан амьтад зөөх уяа сэлт зэргийг бэлтгэсэн байв. Дараагийн долоо хоногийн турш тэр ирсэн гийчдэд газарчлан, аяллыг зохицуулж явав.

Долоо хоногийн эцэст нөгөөх хүмүүс Нэгдсэн Улс уруу буцахаар галт тэрэгний буудал дээр иржээ. Тэд Жоны ажилласан хөлсийг нь төлж, бусад зардлыг нь төлөхөд хангалттай уут дүүрэн мөнгөн зоос өгчээ. Ажилчдадаа хөлсийг нь төлж үлдсэн мөнгийг ноён Хордод

эргүүлэн өгөхөд хариулт өгнө гэж бодоогүй байсан тэрээр ихэд гайхжээ. Тэр Жоноос бүх зардал төлөгдсөн эсэхийг асуухад Жон аялалд зориулсан зардал бүгд төлөгдсөн. Энэ үлдсэн мөнгө нь гэжээ.

Галт тэрэг хөдлөх дохиогоо дуугаргахад ноён Хорд гэнэт эргэн хараад, зоостой уутыг Жон уруу чулуудан, “Үүнийг хөвгүүддээ зориулаарай” гэв. Жон ууттай зоосыг аваад, Колониа Хуаресийнхээ зүг явжээ.

Үдэш хоолоо идсэний дараа гэр бүлээрээ аяны сонин сонсохоор цугларахад Жон мөнгөтэй уутны тухай санан уутыг авчирч ширээн дээр тавив. Жон уутанд хэчнээн мөнгө байгааг сайн мэдэхгүй ч ууттай мөнгөн зоосыг ширээн дээр асгахад нэлээд том овоо болжээ. Зоосыг тоолоход яг 100 песотой тэнцэх мөнгөн зоос байлаа. Ноён Хорд энэ аяллыг хийхээр шийдсэн нь Виттений гэр бүлд асар их адислал болсон аж. Жон болон түүнтэй хамт ажилласан хөвгүүд нь сайн цалин хөлс аваад зогсохгүй үлдсэн 100 песо нь долоо хоногийн өмнө төлсөн аравны нэгийн дүнтэй яг таарч байв. Зарим хүмүүст энэ нь сонирхолтой тохиолдол мэт боловч, Виттений хувьд Их Эзэн итгэлтэйгээр аравны нэгээ төлдөг хүмүүст амласан амлалтаа биелүүлдгийн тод жишээ байлаа.

Хүүхэд байхдаа би энэ түүх нь, ууланд ан хийж, загасчилж, мориор аялсан тухай байсан учраас сонсох дуртай байлаа. Үүнээс гадна бид зарлигуудыг дагавал адислагдана гэдгийг ойлгуулсан учир би энэ түүхэнд дуртай байлаа. Энэ түүхээс бид аравны нэгийн тухай хэдэн зүйлийг мэдэж болно.

Нэгдүгээрт: Аравны нэгээ төлөхөд заавал мөнгөн орлого байх шаардлагагүйг та нар энэ түүхээс анзаарсан байх. Тэд мал болон ногооны талбай дээрх жимс ногооныхоо үр шимээр хангалттай амьдардаг учраас Виттенийхэн эхний олсон бэлэн мөнгөө тэр чигээр нь аравны нэгдээ зориулахаар шийдсэн ажээ. Тэд адислалуудынхаа хариуд өөрсдийгөө Их Эзэнд өртэй гэж үздэг байв.

Энэ нь “Хүн Бурханыг луйвардах уу? гэсэн ч та нар Намайг луйвардаж байна” гэсэн Их Эзэний үгсийг бидэнд сануулдаг. Хүмүүс Түүнээс “Бид Таныг яаж луйвардсан юм бэ?” гэж асуухад Их Эзэн сүр хүчтэйгээр: “Аравны нэгээр ба өргөлөөр” (Малахи 3:8) гэж хариулсан байдаг. Тийм ээ, ах эгч нар аа, яг л Жон Виттен, Айда Виттен хоёр хэдэн арван жилийн өмнө тэр нэгэн зун энэ сургаалыг ойлгож мэдсэний адилаар бид бүгд Их Эзэндээ өртэй. Бурханаа луйвардсан гэм буруутан бүү бай. Шударга байж, Их Эзэнд өрөө төлцгөөе. Тэрээр зөвхөн 10 хувийг л хүсдэг юм. Их Эзэнд өрөө төлөхөд шударга байх нь нөхөддөө шударга хандахад бидэнд туслах болно.

Энэ түүхээс ойлгож мэдсэн бас нэг зүйл бол эмээ өвөө хоёр минь ядуу тарчиг байсан ч аравны нэгээ төлдөг байсан явдал юм. Тэд Их Эзэний зарлигийг мэддэг учраас судрын үгсийг өөрсөдтэйгөө адилтган (1 Нифай 19:23–24-г үз), хуулинд дуулгавартай байжээ. Энэ бол Их Эзэний хүн бүрээс хүсэн хүлээдэг тэр зүйл мөн. Тэр биднээс аравны нэгийг элбэг

дэлбэг байдлаасаа бус гэр бүлийн төсвөөс үлдсэн мөнгөнөөсөө бус харин орлого бага ч бай их ч бай гагцхүү өөрийн анхны орлого “анхны үр төл”-өөс төлөхийг хүсдэг. Их Эзэн: “чи өөрийн анхны үр жимсээс өргөх өргөлөө бүү хойшлуул” (Египетээс Гарсан нь 22:29) гэж зарлигласан юм. Аливаа орлогоноос аль болох түргэн итгэлтэйгээр аравны нэгээ төлөх нь хамгийн баталгаатай арга зам гэдгийг би хувийн туршлагаасаа мэднэ. Энэ нь үнэхээр цорын ганц арга зам гэдгийг би мэдсэн.

Би аравны нэг нь чухамдаа мөнгөний асуудал биш харин Их Эзэнд итгэх итгэл гэдгийг эмээ өвөөгийнхөө түүхээс ойлгож мэдсэн юм. Хэрэв бид Түүний зарлигуудад дуулгавартай байвал Тэрээр адислалуудыг амласан билээ. Жон Виттен, Айда Виттен хоёр аравны нэгээ төлснөөр агуу итгэлийг үзүүлсэн юм. Аравны нэгээ төлж, Их Эзэндээ итгэлээ харуулцгаая. Аравны нэгээ бүхнээс урьд, үнэнч шударгаар төлж бай. Авсан багахан тэтгэмж эсвэл олсон бусад орлогоосоо аравны нэгээ төлж байхыг хүүхдүүддээ бас заа. Тэгээд тэднийг аравны нэгээ төлөхдөө дагуулж яв. Тэгснээр хүүхдүүд маань бидний үлгэр жишээгээр бидний Их Эзэний төлөөх хайрыг мэдэх болно.

Аравны нэгээ мөнгөөр төлөхөд Их Эзэн биднийг үргэлж мөнгөөр адисална гэж зарим хүн өвөө эмээгийн маань түүхийг буруугаар ойлгож магадгүй. Хүүхэд байхдаа энэ түүхийг би мөн тэгж ойлгосон. Хожим нь би энэ нь тийм биш гэдгийг ухаарч ойлгосон юм. Их Эзэн аравны нэгээ төлдөг хүн бүрийг адислахаар амласан билээ. Тэрбээр “тэнгэрийн цонхыг нээж, ивээлийг хальтал асгана” (Малахи 3:10) гэж амласан. Их эзэн амлалтуудаа бүрэн биелүүлдгийг би гэрчилж байна. Хэрэв бид итгэлтэйгээр аравны нэгээ төлбөл амьдралын аливаа хэрэгцээт зүйлсээр дутагдахгүй. Гэхдээ тэрээр эд баялгийг амлаагүй. Мөнгө болон банкны данснууд нь Их Эзэний үнэ цэнэтэй адислалууд биш. Тэрбээр хэрэгцээт эд юмсаа хэрхэн зөв зохицуулах, орлогынхоо 100 хувиар биш харин 90 хувиар илүү сайн амьдрах мэргэн ухаанаар биднийг адисалсан. Иймийн тул аравны нэгээ итгэлтэйгээр төлөгч тэд арвигч, хямгач амьдралыг ойлгодог бөгөөд илүү их бие даасан хүн болохыг зорьдог.

Их Эзэний хамгийн үнэ цэнэтэй адислал нь сүнслэг байдаг бөгөөд энэ нь гэр бүл, найз нөхөд, сайн мэдээтэй үргэлж холбоотой байдаг гэдгийг би ойлгосон юм. Ялангуяа гэрлэлт, хүүхэд хүмүүжүүлэх зэрэг гэр бүлийн асуудлаа зохицуулахад тэрээр ихэвчлэн биднийг Ариун Сүнсний нөлөө ба удирдамжийг үргэлж мэдрэх хүчээр адисалдаг мэт надад санагддаг. Иймэрхүү сүнслэг мэдрэмжтэй байснаар орон гэртээ амар амгалан, эвтэй найртай амьдардаг. Ерөнхийлөгч Жеймс И.Фауст “гэр бүл салалтаас хамгаалах хамгийн сайн арга бол аравны нэгээ төлөх явдал” гэж зөвлөсөн юм. (“Enriching Your Marriage,” *Лиакхона*, 2007 оны 4-р сар, 2–5).

Аравны нэгээ төлөх нь дуулгавартай, даруу мөн “бүх зүйл дээр түүний гарыг ... хүлээн зөвшөөрдөг” (С ба Г 59:21) талархалтай зүрх сэтгэлтэй болоход тусалдаг. Аравны нэгээ төлснөөр бид Христийн цэвэр хайраар дүүрэн, өгөөмөр, энэрэнгүй зүрх сэтгэлтэй болдог. Мөн бид Их Эзэний хүсэл зорилгод захирагдсан дуулгавартай зүрх сэтгэлээр бусдад үйлчилж, бусдыг адислах ирмүүн хүсэлтэй болдог. Аравны нэгээ тогтмол төлдөг гэр

бүлийн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл нь хүчирхэгжиж, Түүний сайн мэдээ болон сүмийн тухай гэрчлэл нь баттай өсдөг. Эдгээр нь Их Эзэний хамгийн үнэтэй цэнэтэй адислалууд бөгөөд үүнийг мөнгө болон эд юмстай харьцуулшгүй юм.

Бид аравны нэгээ итгэлтэйгээр төлөх юм бол Их Эзэн тэнгэрийн цонхыг нээж, бидний дээр хамгийн үнэ цэнэтэй адислалуудаа асгах болно гэдгийг би гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен.

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

Ерөнхий чуулган

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?

Есүс Христ

хүүхдүүд

дуулгавартай байдал

эцэг эх

үүрэг хариуцлага

ерөнхий чуулган

Эрэгтэй, эмэгтэйчүүд ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?

Далын Ахлагч Линн Ж.Робинс

Аврагчтай адил болохын төлөөх та бүгдийн хүчин чармайлт амжилт олох болтугай. Түүний төрх та бүгдийн нүүр царайнд тодорч, Түүний зан чанар та нарын зан төлөвөөс илэрч байг.

“Орших уу эс орших уу?” хэмээх асуулт нь үнэхээр сайн асуулт¹. Аврагч энэхүү асуултыг илүү гүн утга учиртай, чухал сургаалын асуулт болгож бидний хүн нэг бүрээс:

“Эрэгтэйчүүд [эмэгтэйчүүд] ямархуу маягийн хүмүүс *байвал зохих* билээ? Үнэнээр би та нарт хэлье, бүр *миний адил* буюу” хэмээн хариулсан (3 Нифай 27:27, хашилтан дахь үгийг нэмэв) юм. Байх гэдэг үйл үгийн нэгдүгээр биеийн одоо цаг нь Би байна гэсэн хэлбэртэй байдаг. Тэрбээр биднийг Түүний нэр болон зан чанарыг өөрсөддөө авахыг урьдаг.

Бид Түүнтэй адил болохын тулд Түүний хийсэн зүйлсийг хийх ёстой: “Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бол миний сайн мэдээ; мөн миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ; учир нь миний хийхийг та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно” (3 Нифай 27:21; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Байх ба *хийх* хоёр хоорондоо салшгүй холбоотой. Харилцан холбоотой сургаалын хувьд эдгээр нь нэг нэгэндээ тулгуурлан хүчирхэгждэг. Жишээлбэл, итгэл хүмүүнийг залбирахад хүргэдэг бол залбирал нь итгэлийг хүчирхэгжүүлдэг бөлгөө.

Сайн үйлс хийдэг боловч сайн хүн байж чаддаггүй хүмүүсийг Аврагч хоёр нүүртнүүд хэмээн нэрлээд “Энэ ард түмэн Намайг уруулаараа хүндэтгэдэг. Харин тэдний зүрх Надаас алс хол юм” (Марк 7:6) гэжээ. Сайн үйлсийг хийдэг боловч сайн хүн байж чаддаггүй, хуурамч дүр эсгэдэг хүн хоёр нүүртэн болой.

“Итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм” (Иаков 2:17) гэж сударт заадгийн адилаар *зөвт хүн мөртөө сайн үйлс хийдэггүй* бол үнэ цэнэгүй юм. Энэ нь өөрийгөө хуурч байгаа хэрэг бөгөөд зөвхөн сайн хүн байхыг хүссэнээр зөвт хүн болохгүй.

Сайн биш хэрнээ сайн зүйлс хийгчид хуурамч дүр эсгэгчид бөгөөд зөвт атлаа сайн үйлс *хийдэггүй* хүмүүс өөрсдийгөө хуурагчид мөн.

Аврагч хоёр нүүрт хуулийн багш нар болон фарисайчуудад хандаж: “Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар гаа, гоньд, зирааны аравны нэгийг өгдөг атлаа хуулийн чухал нөхцлүүд болох шударга ёс, өршөөл, итгэлтэй байдлыг орхигдуулдаг” (Матай 23:23) хэмээн зэмлэсэн байдаг. Өөрөөр хэлбэл тэд *байх ёстойгоороо оршиж* чадаагүй ажээ.

Аврагч сайн үйлс хийхийн чухлыг хэлсэн ч зөвт хүн болох нь “илүү чухал” гэдгийг онцлон тэмдэглэжээ. Зөвт хүн байхын чухлыг доорх жишээнүүдэд харуулсан байна.

•

Бидний хийдэг зүйлсийн нэг бол баптисм хүртэхээр усанд *умбах* явдал юм. Бид баптисм хийлгэхээсээ өмнө Есүс Христэд итгэж, зүрх сэтгэлдээ хүчтэй өөрчлөлт хийсэн байх ёстой.

•

Бидний хийдэг өөр нэг зүйл бол ариун ёслолоос *хүртэх* явдал. Ариун ёслол хүртэхээр зохистой байна гэдэг нь илүү чухал хэрэг.

•

Санваарт томилох нь үйлдэл буюу *хийх* зүйл. Гэхдээ хамгийн чухал нь санваарын хүч нь “зөв шударга ёс” (С ба Г 121:36) буюу зөвт байдалд тулгуурласан байх ёстой.

Бидний ихэнх нь хийж бүтээх зүйлсээ санаж байхын тулд жагсаалт гарган бичдэг мөртлөө ямар хүн байх ёстойгоо жагсаалт гарган бараг бичдэггүй. Яагаад? *Хийх зүйлс* нь үйл ажиллагаа эсвэл үйлдлүүд байдаг бөгөөд хийж *дууссаны* дараа жагсаалтан дээр хянан дүгнэж болно. Харин ямар хүн байх нь төгсгөлгүй үргэлжлэх үйл явц бөгөөд бид жагсаалтан дээр хянан дүгнэх боломжгүй юм. Ирэх баасан гарагт би эхнэртээ нэгэн сайхан үдшийг бэлэглэж болно. Энэ бол хийх зүйл. Харин сайн нөхөр байх нь ямар нэгэн арга хэмжээ биш; энэ нь миний зан чанар, араншин буюу миний хэн бэ гэдгийг тодорхойлох хувийн чанар болсон *байх* шаардлагатай.

Эцэг эхийн хувьд бид хүүхдээ өөрийн жагсаалтанд хийгээд дууссан ажил мэт чагталж болох уу? Бид хэзээ ч сайн эцэг эх байхаа дуусгавар болгохгүй. Сайн эцэг эх байхын тулд хийх хамгийн чухал зүйлсийн нэг бол бид хүүхдүүдээ Аврагчтай адил болохыг заах юм.

Христийнх шиг зан чанарууд *байгаа* эсэх нь харагддаггүй ч энэ нь бидний хийдэг зүйлсийн хөдөлгөгч хүч болж байдаг. Мөн үйлдэл нь нүдний өмнө ил байдаг. Жишээлбэл, хөлд орж буй бяцхан хүүхдэдээ тусалж байгаа эцэг эх тэднийг магтаж урамшуулан, тэнцвэрээ олоход нь тусалж байгааг бид хардаг. Эдгээр үйлдэл тэдний үл үзэгдэх зүрх сэтгэлийнх нь хайр болоод хүүхдийнхээ чадварт итгэсэн итгэл, найдварыг илчилдэг. Тэдний хичээл зүтгэл нь тэвчээр хатуужил, тууштай байдал зэрэг үл үзэгдэх олон зан чанарынх нь баталгаа болдог.

Зөвт *байх* чанар нь *хийх* үйлдлийг тодорхойлдог учраас, тэдний хэн байх ёстойг заах нь тэдний юуг хийх ёстойг заахаас илүүтэйгээр зан араншин, төлөв байдлыг нь төлөвшүүлж, сайжруулдаг юм.

Хүүхдүүдийг дүрсгүйтэж, хоорондоо маргахад нь бид ихэвчлэн юу *хийсэн* эсвэл хэрхэн маргалдсаныг нь харснаараа буруу шийдвэр гарган, тэднийг шийтгэдэг. Гэтэл тэдний үйлдэл болох зан төлөв нь зүрх сэтгэлийнх нь гүнд орших үл үзэгдэх өдөөгч хүчний илрэл юм. Бид өөрсдөөсөө “Хүүхэддээ юуг сайн ойлгуулбал энэ занг нь засах бол? Залхсан ч гэсэн хайр, тэвчээр, уучлалыг үзүүлэх үү? Эвийг сахиулагч байх уу? Буруушаалгүйгээр, тэдний үйлдлийн төлөөх хариуцлагыг өөртөө хүлээх үү?” гэж асууж магад.

Эдгээр зан чанарыг эцэг эхчүүд хүүхдүүддээ хэрхэн заах вэ? Тэднийг шийтгэхийн оронд Христтэй адил зан чанарыг үзүүлж заахаас илүү агуу боломж та нарт хэзээ ч олдохгүй шүү. Сахилга бат гэдэг үг нь шавь гэдэг үгнээс гаралтай бөгөөд бидний хувьд тэвчээр, заах гэсэн утгыг агуулдаг. Уураар асуудлыг шийдэх ёсгүй. Бид Сургаал ба Гэрээний 121-д заасны дагуу “сэнхрүүлгээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар; нинжин сэтгэл мөн цэвэр мэдлэгээр” (41–42-р шүлгүүд) хүмүүжүүлэх ёстой. Бид тэгж ч чадна. Эдгээр нь эцэг эх болон Христийн шавь нарын хувьд бидний эзэмших ёстой Христийн зан чанарууд мөн.

Сахилга баттай байснаар хүүхэд аливаа үйлдлийн үр дагаврыг суралцдаг. Энэ үед буруу занг нь засч залруулах нь тустай байдаг. Хэрэв хүүхэд буруу хэрэг хийснээ шударгаар хүлээвэл буруугаа хүлээх зоригтой байсных нь төлөө магт. Хүүхдээс алдаа болон буруу үйлдлээсээ юуг ойлгож авсныг нь асуух нь тэдний зүрх сэтгэлийг хөндөж, заах боломжийг танд болон хамгийн чухал нь ариун сүнсэнд өгдөг юм. Бид хүүхдэдээ Сүнсээр сургаалыг заахад, сургаал тэдэнд байх ёстой жинхэнэ зан төлөвийг аажмаар өөрчлөх хүчтэй байдаг.

Алма үүнтэй ижил зарчмыг “шударга байсан түүнийг хийхэд хүмүүсийг удирдахад үгийг номлох нь их нөлөө болж байсан учир—тийм ээ, энэ нь хүмүүсийн оюун ухаанд илднээс илүү хүчтэйгээр нөлөө үзүүлж байв” (Alma 31:5; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) гэж хэлжээ. Яагаад? Яагаад гэвэл сэлэм зөвхөн гэмт үйлдлийг шийтгэдэг харин үгийг номлох

нь хүмүүний жинхэнэ зан төлөв, тэд хэн *байсныг* эсвэл хэн *болж болох* байсныг өөрчилсөн.

Дуулгавартай, өхөөрдөм хүүхэд эцэг эхдээ хүүхэд хүмүүжүүлэх талаар өчүүхэн зүйлийг заадаг бол тэвчээрийг тань бардаг хүүхэдтэй эх эцэг хүүхэд хүмүүжүүлэх дамжаа төгслөө л гэсэн үг. Өмнөх амьдралдаа юуг буруу хийж ийм шанг хүртэх болсондоо гайхшрахын оронд дүрсгүй хүүхэд өөрийг чинь Бурхантай илүү адил болоход тусална гэж бодох нь дээр болов уу. Ямар хүүхэд нь та нарын тэсвэр тэвчээр болон Христтэй адил бусад ариун журмыг илүүтэйгээр шалгаж, өсгөн нэмэгдүүлж, шинэчилж чадах вэ? Та нар энэ хүүхдэд хэрэгтэй байгаатай адилхан энэ хүүхэд та нарт хэрэгтэй байж болох уу?

Хүүхдүүд дүрсгүйтэхэд бид нүгэл үйлдэгчийг бус нүглийг буруутгах хэрэгтэй гэсэн зөвлөгөөг сонсож байсан. Үүнтэй адил бид хүүхдүүдээ алдаа гаргахад тэднийг муу хүүхдүүд учраас буруу зүйл хийсэн гэж итгүүлэх үгсийг хэлэх ёсгүйг анхаарах хэрэгтэй. “Тэдний үйлдлийг ‘тэнэг’—‘хөшүүн’—‘залхуу,’ ‘болхи’ гэхчлэнгээр хэзээ ч бүү нэрлэ.”² Бидний хүүхэд Бурханы хүүхдүүд бөгөөд энэ бол тэдний үнэн мөн чанар болоод чадамж юм. Түүний төлөвлөгөө нь Өөрийн хүүхдүүдэд алдаа болон буруу үйлдлүүдээ даван туулах, Түүнтэй адил болохоор өсч хөгжихөд нь туслах билээ. Сэтгэл гонсойлгосон зан төлөв үүрдийн биш—түр зуурынх бөгөөд үйлдэл болохоос мөн чанар биш.

Тиймээс бид хүүхдийг сахилга баттай болгохдоо, “Чи дандаа л...” эсвэл “Чи хэзээ ч...” гэх мэтийн үгсийг хэрэглэхээс болгоомжлох хэрэгтэй. “Чи миний хэлснийг огт тоодоггүй шүү дээ,” “Чи яагаад биднийг дандаа хүлээлгэдэг юм бэ?” гэхчлэнгийн өгүүлбэрүүдээр ярихаас зайлсхий. Иймэрхүү үг хэллэг нь өөрийгөө өмөөрөх муу занд хүүхдийг сургаж болох бөгөөд үйлдлийнхээ талаар зөв дүгнэлт хийж, өөрийгөө үнэлэхэд нь сөрөг нөлөө үзүүлж болно.

Бид хүүхдээсээ өсч том болоод ямар хүн болохыг хүсч байна гэж асуухдаа сонгосон мэргэжил нь тэднийг хэн болохыг илэрхийлэх юм шиг боддог. Эзэмшсэн мэргэжил, эд баялаг нь хувь хүний шинж чанар, үнэ цэнийг тодорхойлдоггүй юм. Жишээ нь, Аврагч жирийн мужаан байсан ч энэ нь түүний агуу амьдралыг тодорхойлж чадахгүй юм.

Бид хүүхдийг өөрийгөө таньж мэдэн үнэ цэнээ ойлгоход нь туслахдаа тэдний зан төлөв, ололт амжилт, үйлдлийг нь зүй ёсоор сайшааж болно. Гэхдээ бид магтаалаа тэдний хэн *байх* буюу зан төлөв, итгэлд нь чиглүүлбэл илүү ухаалаг хэрэг болно.

Спортын тэмцээн уралдаанд оролцсон хүүхдийнхээ тоглолтынх нь (хийх) ур чадварыг магтах ухаалаг арга бол тэдний эрч хүч, цөхөршгүй оролдлого, бэрхшээлийн өмнө зориг мохоогүй гэхчлэн ямар байж, юу хийснийг нь магтвал хэн *байхыг* нь мэдрүүлж чадах зөв арга зам мөн.

Бид хүүхдүүдээсээ гэрийн ажилд туслахыг хүсэхдээ “чи гэрийн ажилд тусладагт би их баяртай байдаг” гэх мэт тэдний тийм зан төлөвтэй *байсныг* магтаж болно.

Хүүхэд сургуулиасаа сурлагын дэвтрээ авчрахад авсан сайн дүнгийнх нь талаар магтаж болох ч хэрэв түүний *хичээл зүтгэлийг* нь “Чи бүх даалгавраа хийжээ. Мөн хэцүү үүрэг даалгавруудыг ч биелүүлж чаджээ. Би чамаараа маш их бахархаж байна” гэвэл илүү үр дүнтэй байх болно.

Гэр бүлээрээ судраас судлахдаа судар дээр гарсан онцлог зан чанаруудын жишээнүүдийг олж ярилцаарай. Христийнхтэй адил зан чанар нь Бурханы бэлэг учраас Түүний тусламжгүйгээр³ тэдгээрийг та хөгжүүлж чадахгүй учраас эдгээр бэлгийн төлөө гэр бүлээрээ болон хувиараа залбираарай.

Гэр бүлээрээ хамт хооллохдоо, ялангуяа өглөө судраас суралцахдаа мэдэж авсан зан чанаруудынхаа тухай заримдаа ярилцаж байгаарай. “Өнөөдөр чи сайн найз байж чадав уу? Ямар арга замаар бусдад өрөвч нинжин сэтгэлээ харуулав? Өнөөдөр тулгарсан бэрхшээлийг даван туулахад итгэл чинь хэрхэн туслав? Бусдад түшиг тулгуур болж чадсан уу? Шударга, өгөөмөр сэтгэлтэй, даруу байсан уу?” Бидний заалгаж, сурах хэрэгтэй олон зан чанарын тухай судруудад гардаг.

Хэн байхыг заах хамгийн чухал арга зам бол Тэнгэр дэх Эцэг бидэнд сайн эцэг байдаг шиг эх эцэг болох юм. Тэр бол төгс Эцэг бөгөөд бидэнтэй эцэг эхийн гарын авлага болох— судруудыг хуваалцсан.

Өнөөдөр миний хэлсэн үгс эцэг эхчүүдэд хандсан байлаа. Гэхдээ зарчмын хувьд хүн болгонд хамааралтай юм шүү. Аврагчтай адил болохын төлөөх та бүгдийн хүчин чармайлт амжилт олох болтугай. Түүний төрх та бүгдийн нүүр царайнд тодорч, Түүний зан чанар та нарын зан төлөвөөс илэрч байг. Тэгж чадсан үед та нарын үр хүүхдүүд болон бусад хүмүүс танаас хайрыг мэдэрч, зан төлөвийг тань харснаар энэ нь тэдэнд Есүс Христийг санагдуулж, тэднийг Түүн уруу эргүүлэх болно. Энэ бол миний залбирал ба гэрчлэл. Есүс Христийн нэрээр, амен.

Эшлэл

1.

[Виллям Шекспир, *Гамлет, Данийн хун тайж*, бүлэг 3, үзэгдэл 1, мөр 56.

2.

Карол Двейк, “Make Up Your Mind to Succeed,” *Reader’s Digest*, 2009 оны 5-р сар, 54–55.

3.

Миний сайн мэдээг номло: Номлогчийн удирдамж (2004), 115.

Лиахона

2011 оны 5-р сар

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

Ерөнхий чуулган

2011 оны 4-р сарын 3

Гэгээнтэн гэж дуудагдах нь

бэрхшээл

Цагаатгал

Сүмийн гишүүнчлэл

итгэл

хүнд сорилтууд

ерөнхий чуулган

Гэгээнтэн гэж дуудагдах нь

Далын Ахлагч

Бенжамин Де Хоёс

Бид Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн нэг хэсэг байх боломжтой, үнэхээр адислагдсан хүмүүс шүү!

Хайрт ах эгч нар аа, Ариун Сүнс миний захиасыг ойлгоход та нарт туслахын төлөө би залбирч байна.

Томилогдсон нэгжүүддээ очиж, хурал зөвлөгөөнд оролцох үедээ би цаг хугацааны голчид байсан итгэгчдийн нэгэн адил Гэгээнтнүүд хэмээн дуудагдах өнөө үеийн олон сайхан гишүүдтэй уулзсаар ирлээ. Тэдэнтэй хамт байхад мэдэрдэг амар амгалан болон хайрын мэдрэмж намайг Сионы гадсуудын нэгэнд нь байгаагаа ухаарахад тусалдаг юм.

Биднээс олон нь Сүмийн хоёр, гурав дахь үеийн гишүүдийн гэр бүлд төрж өссөн хэдий ч бусад олон гишүүн харьцангуй шинэ хөрвөгчид байдаг. Эдгээр хөрвөгчдөд би Төлөөлөгч Паулын ефесчүүдэд хандан хэлсэн дараах элэгсэг дотно үгсийг давтан хэлмээр байна:

“Тийм бол та нар цаашид харь хүмүүс болон гадны хүмүүс биш, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм;

Та нар элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ” (Ефес 2:19–20).

Хэдэн жилийн өмнө биднийг Мексик дэх Сүмийн олон нийттэй харилцах албанд үйлчилж байхад радиогийн нэвтрүүлэгт ярилцлага өгөхийг урьсан юм. Нэвтрүүлгийн зорилго нь дэлхий даяарх олон өөр шашны талаар танилцуулах байлаа. Бид Сүмээ төлөөлж, нэвтрүүлгийн үеэр тавигдах асуултанд хариулах үүрэгтэй байсан. Нэвтрүүлэг эхлээд хэд хэдэн зар сурталчилгаа гарч өнгөрөхөд, нэвтрүүлгийн найруулагч “Бид өнөөдөр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хоёр ахлагчийг нэвтрүүлэгтээ урьж оролцуулаад байна” гээд, биднээс “Танай сүм яагаад ийм урт нэртэй байдаг юм бэ? Та нар арай богинохон, хэлэхэд амархан нэрийг хэрэглэж болдоггүй юм уу?” гэж асуулаа.

Бид энэ асуултыг тавьсанд нь баяртай байлаа. Сүмийн нэрийг ямар нэгэн хүн сонгоогүй харин хожмын үеийн бошиглогчоороо дамжуулан Аврагч өгсөн бөгөөд “Учир нь эцсийн өдрүүдэд миний сүм ийн, бүр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэмээн нэрлэгдэх ёстой” (С ба Г 115:4) хэмээн айлдсаныг тайлбарласан юм. Нэвтрүүлгийн найруулагч тэр даруй эелдгээр, “Бид энэ нэрийг хүндэтгэлтэйгээр хэлэх болно” гэлээ. Тэр хэдэн удаа энэхүү утга учир бүхий нэрийг давтсаныг яг одоо би санахгүй байгаа ч,

Сүмийн нэрийг болон уг нэр нь Хожмын Үеийн Гэгээнтнүүд болох Сүмийн гишүүдэд хэчнээн их утга учиртай болохыг тайлбарлахдаа мэдэрсэн сүнслэг мэдрэмжийг би хэзээ ч мартажгүй ээ.

Бид, Есүс Христийн Сүмийн гишүүд Антиох хотод анх удаа Христийнхэн гэж нэрлэгдсэнийг Шинэ Гэрээнээс уншдаг (Үйлс 11:26-г үз), гэхдээ тэд бие биеэ гэгээнтнүүд хэмээн дууддаг байжээ. Төлөөлөгч Паул тэд бол “ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх” (Ефес 2:19) мөн тэд “ариун хүмүүс *байхаар* дуудагдсан” (Ром 1:6–7; налуу бичлэг нэмсэн) гэж хэлэхэд гэгээнтнүүд баяртай байсан нь лавтай.

Сүмийн гишүүд сайн мэдээ болон бошиглогчдын зөвлөгөөг хэр сайн дагаж байгаагаас шалтгаалан өөрсдөө ч анзааралгүйгээр бага багаар ариусгагдаж байдаг. Гэр бүлээрээ тогтмол залбирч, судраас судлан, гэр бүлийн түүхээ бичих болон ариун сүмд байнга шүтэн бишрэхээр очиход үнэт цаг заваа зориулдаг Сүмийн даруухан гишүүн бүр гэгээнтэн болдог. Тэд бол мөнхийн гэр бүлийг үүсгэхэд зориулагдсан хүмүүс мөн. Мөн тэд Сүмээс холдож буй гишүүдийг аврахад болон тэднийг эргэж ирэн, Их Эзэний ширээнд хамтдаа суухад нь урамшуулахын тулд завгүй амьдралынхаа үнэт цагаас золиосолдог хүмүүс юм. Тэд бол Их Эзэний номлогчийн дуудлагад хариулсан ахлагч, систер болон ахмад номлогч нар билээ. Тийм ээ, ах эгч нар аа, тэд Христийн цэвэр хайр, энэрэл гэж нэрлэгдэх гайхамшигт, халуун дотно мэдрэмжийг бий болгох хүртлээ өсөн дэвшиж байдаг гэгээнтнүүд билээ. (Моронай 7:42–48-г үз).

Гэгээнтнүүд эсвэл Сүмийн гишүүд гэж хэлэгдэх тэд зовлон бэрхшээлээр дамжуулан мөн Аврачийг таньж мэддэг. Тэрбээр бүр бүх зүйлийн зовлонг үзэх ёстой байсныг битгий мартаарай. “Мөн тэрээр үхлийг өөр дээрээ авах болно, тэр өөрийнх нь хүмүүсийг хүлсэн тэрхүү үхлийн хүлээсийг тайлж болохын тулд бөлгөө; мөн түүний зүрх сэтгэл бие махбодийн дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно” (Алма 7:12).

Хайрт ах, эгч нар аа, өнгөрсөн хэдэн жилд би үй түмэн хүний зовлон зүдгүүрийн гэрч болсон бөгөөд тэдний дотор маш олон гэгээнтэн байсан юм. Бид тэдгээр хүмүүсийн төлөө Их Эзэнээс тусламж хүсч, итгэл нь дундрахгүй, тэвчээртэйгээр урагш тэмүүлж

байгаасай хэмээн үргэлж залбирдаг. Эдгээр зовж зүдрэгсдэд бид Мормоны Номын Иаковын тайтгаруулагч үгсийг давтан хэлэхийг хүсч байна.

“Ай тэгээд, хайрт ах дүү нар минь, Ариун Нэгэн, Их Эзэнд ирцгээ. Түүний замууд зөв шударгыг сана. Болгоогтун, хүмүүнд зориулагдсан харгуй нарийн, гэвч энэ нь түүний өмнө шулуунаар зурайна, мөн Израилын Ариун Нэгэн бол их хаалганы сахиул; мөн тэрээр нэгээхэн зарцыг тэнд үл ажиллуулдаг; мөн уг хаалганаас өөр зам гэж үгүй; учир нь тэрээр мэхлэгдэх боломжгүй, түүний нэр Их Эзэн Бурхан билээ.

Мөн хэн тогшнов, түүнд тэрээр нээх болно” (2 Нифай 9:41–42).

Бид хаана, ямар нөхцөл байдалд байх нь хамаагүй; сорилт бэрхшээл, саад тотгор бидний замд саад болсон ч, Христийн сургаалын талаарх ойлголт, Түүний Цагаатгал бидний хүч чадал, амар амгалангийн эх сурвалж байсаар байх болно. Тийм ээ, ах эгч нар аа, энэ бол Их Эзэн итгэлтэй гэгээнтнүүддээ өгөх сүнснээс төрөх дотоод сэтгэлийн амар тайван байдал билээ: “Амар амгаланг Би та нарт үлдээнэ... Та нар зүрхээ бүү зовоо, бүү ай” (Иохан 14:27).

Олон жилийн турш би Сүмийн гишүүд, Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн итгэлтэй байдлын гэрч болсоор ирсэн билээ. Тэдгээр нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө болоод Аврагчийн Цагаатгалд итгэл найдвар тавьдаг бөгөөд сорилт бэрхшээл, зовлон зүдгүүрийг агуу урам зоригоор даван гардаг. Ийм ч учраас тэд ариусгалын давчуу бөгөөд нарийн зам дээр цөхрөлтгүйгээр, тууштай үлддэг юм. Хамт байх боломжтой байсан бүх итгэлтэй гэгээнтнүүддээ баярлаж талархсан сэтгэл, гүн хүндэтгэлээ үгээр илэрхийлэх аргагүй билээ!

Хэдийгээр сайн мэдээний талаарх бидний ойлголт сайн мэдээний үнэний талаарх бидний гэрчлэлтэй адил гүн гүнзгий биш байж болох ч, хэрэв Их Эзэнд итгэл, найдварыг тавих юм бол Тэрээр зовлон зүдгүүр, уй гашууд нэрвэгдсэн үед ч биднийг түшиж тулах болно (Алма 36:3-ыг үз). Гэгээнтнүүддээ өгөх Их Эзэний энэхүү амлалт нь зовлон зүдгүүр, уй гашуугаас биднийг чөлөөлнө гэсэн үг биш юм. Харин тэр хүнд хэцүү үеүдэд тулж түших бөгөөд энэхүү тулгуур нь Их Эзэнээс ирж байгааг бид мэдэх болно.

Хайрт ах эгч нар аа, бид Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн нэг хэсэг байх боломжтой үнэхээр адислагдсан хүмүүс шүү! Мөн бид эрт үеийн болон хожмын үе дэх бошиглогчдын адил Аврагчийн тухай агуу гэрчлэлтэй адислагдсан хүмүүс шүү!

Их Эзэн, Израилын Ариун Нэгэн амьд бөгөөд Тэрбээр Өөрийн Сүм болох Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг бидний хайрт бошиглогч Томас С.Монсонгоор дамжуулан удирддагийг би гэрчилж байна. Бидний Их Эзэн Есүс Христийн нэрээр, амен.

Лиахона

2011 оны 5-р сар

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Цагаатгалын гайхамшиг

Далын Ахлагч К.Скотт Гроу

Би чуулганд хэлэх үгээ бэлтгэж байтал аав утасдан эрэгтэй дүүг маань нойрондоо зуурдаар таалал төгссөнийг дуулгав. Би маш ихээр гашуудлаа. Дүү маань дөнгөж 51 настай байсан юм. Би түүний тухай бодож байхдаа та нартай түүний амьдралд тохиосон зарим зүйлийн талаар хуваалцах хэрэгтэйг мэдэрсэн юм. Үүнийг хуваалцах зөвшөөрлийг би авсан.

Тэр залуудаа царайлаг, нөхөрсөг, хүмүүстэй эв дүйгээ ололцдог нийтэч нэгэн байсан бөгөөд сайн мэдээнд өөрийгөө зориулсан хүн байв. Бүрэн цагийн номлолд үнэнч шударгаар үйлчилсний дараа хайртай бүсгүйтэйгээ ариун сүмд гэрлэж, тэд хүү, охинтой болж, түүний ирээдүй амлалтаар дүүрэн байлаа.

Гэвч тэрээр сул дорой байдалд орж, хувийн таашаалаа илүүд тавьснаар эрүүл мэнд, гэрлэлт, тэр бүү хэл Сүмийн гишүүн байх эрхээ ч алдахад хүрсэн юм.

Дүү маань гэр орноосоо алс хол арав гаруй жил өөрийн дураар амьдарсан ч Аврагч түүнийг мартаж орхиогүй билээ. Эцэст нь тэр энэ дорой байдалдаа зовж шаналан төлөв даруу сүнснийг бодгальдаа оруулахыг зөвшөөрч, уур хилэн, эсэргүүцэл нь аажмаар намдсан юм. Яг л үрэлгэн хүүгийн адил тэр алдаагаа “ухаарсан.”¹ Тэрээр Аврагчийг эрэлхийлэн, хуучин амьдралынхаа хэв маягийг орхин сайн мэдээгээр явах замдаа эргэж орсон бөгөөд итгэлтэй эцэг эх нь хэзээ ч түүнийг орхиогүй юм.

Энэ нь амар байгаагүй ч тэр наманчлалын замаар алхсан. 12 жил сүмээс хол байсны эцэст тэр дахин баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг дахин хүлээн авсан. Түүний санваар ба ариун сүмийн адислалууд ч мөн сэргээгдсэн.

Дүү минь өмнөх амьдралынхаа хэв маягаас шалтгаалсан эрүүл мэндийн асуудалтай байсан ч, нэгэн эмэгтэй түүнтэй ханилж, тэд ариун сүмд лацдан холбогдсон билээ. Тэд

хоёр хүүхэдтэй болсон бөгөөд дүү маань бишопын зөвлөлд хэдэн жил итгэлтэйгээр үйлчилсэн.

Миний дүү гуравдугаар сарын 7-ны даваа гарагт нас барсан бөгөөд нас барахынхаа өмнөх баасан гарагийн орой нь эхнэртэйгээ ариун сүмд орж, ням гарагт дээд пристийн бүлэгтээ санваартны хичээл заасан байв. Дүү маань тэр орой нойрсоод дахиж сэрээгүй ч зөвт хүмүүсийн амилалтаар ирэх болно.

Дүүгийн минь амьдралд Цагаатгалын гайхамшиг байгаад би талархаж байна. Аврагчийн Цагаатгал хүн нэг бүрт боломжтой байдаг.

Бид наманчлалаар дамжуулан цагаатгалыг хүлээн авдаг. Биднийг наманчлахад Их Эзэн алдаа дутагдлуудаа ардаа орхихыг минь зөвшөөрдөг билээ.

“Болгоогтун, нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, бибээр тэдгээрийг нь цаашид санах нь үгүй.

“Хүн нүглүүдээ наманчилдаг эсэхийг та нар үүгээр нь мэдэж болно, болгоогтун, тэрээр тэдгээрийг хүлээж мөн орхих болно.”²

Амьдралдаа сорилт бэрхшээлтэй тулгарч, будилж төөрсөн хэн нэгнийг бид мэддэг. Тэр нь та нарын найз, хамаатан садан, эцэг эх, хүүхэд, нөхөр, эхнэр хэн ч байж болно. Энэ хүн нь та өөрөө ч байж болно.

Би бүх хүнд хандан Цагаатгалын гайхамшигийн тухай ярьж байна.

Адамын уналтын учир Мессиа Уналтаас хүмүүсийг гэтэлгэхээр ирсэн.³ Есүс Христийн сайн мэдээний бүх зүйлс Мессиа, Бурханы Хүүгийн цагаатгалын золиослолын зүг чиглүүлэгддэг.⁴

Авралын төлөвлөгөө цагаатгалгүйгээр гүйцэлдэхгүй байсан. “Тиймийн тул Бурхан нь төгс, шударга Бурхан, мөн түүнчлэн нигүүлсэнгүй Бурхан байж болохын тулд нигүүлслийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэхээр, шударга ёсны шаардлагыг хангахаар Бурхан өөрөө дэлхийн нүглийн төлөө цагаатгалыг нөхөн төлдөг”.⁵

Унасан хүмүүс нүглүүдийнхээ төлөө цагаатгал хийж чадахгүй тул цагаатгалын золиослол нь нүгэлгүй Бурханы Хүүгээр хийгдэх ёстой байсан.⁶ Цагаатгал нь бүх цаг үеийн бүх хүмүүсийг цагаатгах хэмжээлшгүй хийгээд мөнхийн байх ёстой байсан.⁷

Аврагч зовлон шаналал болон үхлээрээ дамжуулж бүх хүмүүний нүглийг цагаатгасан билээ.⁸ Түүний Цагаатгал Гетсамений цэцэрлэгт эхэлж, загалмай дээр үргэлжлэн, Амилалтаар төгссөн юм.

“Тийм ээ, бүр тийн тэр хөтлөгдөн, цовдлогдон, мөн хөнөөгдөх болно, уг маханбодь бүр үхлийн харьяат болж, Хүүгийн таалал Эцэгийн таалалд багтах бөлгөө.”⁹ Өөрийн цагаатгалын золиослолоороо дамжуулан Тэрбээр “өөрийн бодгалийг нүглийн төлөөс”¹⁰ болгосон.

Бурханы Цорын Ганц Хүүгийн хувьд Тэр биеийн үхлийн хүчийг давах өвийг авсан. Тэр нь Түүнд Өөрийн амийг авч үлдэх боломжийг олгож, Тэрээр “уруу таталтыг, мөн биеийн өвчин, өлсгөлөн, цангаа, мөн зүдрэлийг, энэ нь үхэлд хүргэхээс бусдаар бол бүр хүмүүний гэвчиж чадахаас илүүг гэвчих”¹¹ зовлонд унасан юм.

Тэр зөвхөн бүх хүмүүний нүглүүдийн төлөөсийг төлөөд зогсохгүй, Тэрбээр мөн “бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг өөр дээрээ” авсан юм. Тэр “мөн түүний зүрх сэтгэл бие махбодийн дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авсан.”¹²

Аврагч хүн төрөлхтний зовлон зүдгүүрийг, тийм ээ нүгэл ба харамслын зовлонг мэдэрсэн. “Гарцаагүй тэр бидний гашуудлыг хүлээн авч, мөн бидний харамслыг үүрсэн.”¹³

Цагаатгалаараа дамжуулан Тэр зөвхөн нүгэлтнийг эдгээдэггүй, эдгээр нүглүүдийн учир зовон шаналж байгаа гэмгүй хүмүүсийг мөн эдгээдэг билээ. Аврагчийн Цагаатгалд итгэснээр нүгэлтнийг өршөөсөн нэгэн мөн эдгэж чадна.

Хүн бүр “алдаа, нүглүүдээс ирдэг гэм буруугийн мэдрэмжүүдээс хөнгөвчлөгдөх хэрэгтэй”¹⁴ цаг мөчүүд байдаг. Бид наманчлах аваас Аврагч бидний бодгалиас гэм бурууг зайлуулдаг.

Түүний цагаатгалын золиослолоор дамжин бидний нүглүүд уучлагддаг. Цагаатгал мөхлийн хүүг давах болзлыг, бүх цаг үед, нүглийнх нь “наманчлалын нөхцлийн”¹⁵ хэмжээнээс үл шалтгаалан хүн бүрд боломжтой болгосон.

Есүс Христ бидэнд хэмжээлшгүй хайртай учраас биднийг наманчлалд урьдаг.

Наминчилснаар бид нүглүүдийнхээ дүүрэн ачаанд зовж шаналах шаардлагагүй болно.

“Наманчил, мөн чиний зовлон гашуун байх болно, хэр зэрэг гашууныг чи мэдэх нь үгүй, хэр зэрэг хүчтэйг чи мэдэх нь үгүй, тийм ээ, тэвчихэд хэр зэрэг хэцүүг чи мэдэх нь үгүй.

“Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ;

“Хэрэв тэд үл наманчлах аваас бүр миний адилаар тэд зовох ёстой.

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн.”¹⁶

Аврагч гэм нүглээс болж зовж шаналж яваа тэднийг эдгээхийг хичээж байна. “Би та нарыг эдгээж болохын тулд та нар надад эргэн ирж, мөн нүглүүдээ наманчилж, мөн хөрвүүлэгдэхгүй гэж үү?”¹⁷

Есүс Христ бол бидний бодгалийн Агуу Эдгээгч мөн. Түүний Цагаатгалын эдгээх хүчгүйгээр мөхлийн нүглүүдээс ангижрах нүгэл, гэм буруу, өвчин, гашуудал гэж үгүй.

Биднийг нүгэл үйлдэхэд Сатан “та нар өнгөрсөн хүмүүс” гэж хэлдэг бол Гэтэлгэгч маань ямар ч буруу зүйл хийсэн бидэнд гэтэлгэлийг санал болгодог.

Амьдралынхаа тухай эргэцүүлэн бодоход танд өөрчлөх хэрэгтэй зүйлс байна уу? Засах алдаанууд байна уу? гэдгийг бодоорой.

Хэрэв та нар гэм буруу болоод харамслын мэдрэмжийг амсан, уур хилэн, итгэлээ алдан зовж байгаа бол түүнээсээ чөлөөлөгдөх боломжийг эрэлхийлэхийг би уриалж байна. Наманчил мөн гэм нүглээ орхи. Тэгээд Бурханаас уучлал гуйн залбир. Бусдад буруу зүйл хийсэн бол уучлалыг эрэлхийл. Та нарт буруу зүйл хийсэн хүмүүсийг уучил. Өөрийгөө уучил.

Шаардлагатай бол бишоптойгоо уулзаж ярилц. Бишопууд нь Их Эзэний нигүүлслийн зуучлагч мөн. Наманчлалаар дамжуулан цэвэр ариун болоход саад болж байгаа зүйлээс салахад чинь тэрээр та нарт туслах болно.

Өөрийгөө залбирал болон судар судлахад зориулаарай. Ингэснээр та Сүнсний ариусгагч нөлөөг мэдрэх болно. Аврагч: “та нар өөрсдийгөө ариусга; тийм ээ, би та нарыг цэвэр ариун болгож болохын тулд зүрх сэтгэлээ цэвэршүүл, мөн миний өмнө гараа цэвэршүүлэгтүн”¹⁸ гэж хэлсэн.

Бид Түүний Цагаатгалын хүчээр дамжин цэвэршихэд Аврагч Эцэгийн хамт бидний өмгөөлөгч болдог. Тэрбээр:

“Эцэг минь, нүгэл үйлдээгүй, Таны таалалд нийцсэн түүний зовлон хийгээд үхлийг болгоогтун; мөн Хүүгийнхээ асгарсан цусыг, мөн Та Өөрөө алдаршихын тулд Таны өгсөн, бас Түүний цусыг болгоогтун;

Иймийн тул, Эцэг минь, тэд надад ирж бас мөнх амьдралыг авч болохын тулд Миний нэрэнд итгэх эдгээр ах дүүсийг минь өршөөгөөч”¹⁹ гэсэн юм.

Бидэнд чөлөөтэй сонгох бэлэг өгөгдсөн. “Хүмүүн нь бие махбодийн дагуу чөлөөт болой. Мөн тэд бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй.”²⁰

Олон жилийн өмнө дүү маань буруу сонголт хийж амьдралын хэв маягаа өөрчилснөөр эрүүл мэнд, гэр бүл ба Сүмийн гишүүнчлэлээс хасагдах зэрэг үр дагаврыг амссан. Он жилүүд улиран одож тэр мөн чөлөөт сонголтынхоо дагуу наманчлах, амьдралаа Аврагчийн сургаалуудад тохируулах, Цагаатгалын хүчээр дамжуулан дахин төрөхийн гайхамшгийг мэдэрсэн юм.

Би Цагаатгалын гайхамшгийг гэрчилж байна. Цагаатгалын эдгээх хүчийг дүүгийнхээ амьдралаас би харж мөн өөрийн биеэр мэдэрсэн. Цагаатгалын эдгээн, гэтэлгэх хүч нь хүн бүрт үргэлж боломжтой байдаг.

Би Есүс бол Христ бөгөөд бидний бодгалийн Эдгээгч гэдгийг гэрчилж байна. Хүн бүр “Та нар надад эргэн ирж, мөн нүглүүдээ наминчилж, мөн хөрвүүлэгдэхгүй гэж үү?”²¹ гэсэн Аврагчийн урилгад хариулахыг сонгох болтугай хэмээн би залбирч байна. Есүс Христийн нэрээр, амен.

|

Эшлэл

1. Лук 15:17.

2. Сургаал ба Гэрээ 58:42–43.

3. 2 Нифай 2:25–26-г үз.

4. Алма 34:14-ийг үз.

5. Алма 42:15.

6. Алма 34:11-ийг үз.

7. Алма 34:10-ыг үз.

8. Алма 22:14-ийг үз.

9. Мозая 15:7.

10. Мозая 14:10.

11. Мозая 3:7.

12. Алма 7:11-12.

13.

Мозая 14:4.

14. *Миний сайн мэдээг номло: Номлогчийн удирдамж (2004), 2.*

15. Сургаал ба Гэрээ 18:22.

16. Сургаал ба Гэрээ 19:15–18.

17.3 Нифай 9:13.

18. Сургаал ба Гэрээ 88:74

19. Сургаал ба Гэрээ 45:4-5.

20. 2 Нифай 2:27

21. 3 Нифай 9:13.

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Үндэстнүүдийн төлөө өргөх туг

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Жеффри Р.Холланд

Энд дуулсан дуоллуудын үг бүр нь, ах эгч нарын минь хэлсэн үг болгон нь миний сэтгэлийг ихэд догдлуулж, хэлэх үгийнхээ төлөө намайг залбирахад хүргэлээ.

1846 оны өвөл Ерөнхийлөгч Бригам Янг Наувугаас явахынхаа өмнө, нэгэн шовх оройтой толгой дээр зогсоод тэртээ доор харагдах хөндийд Баруун зүгт зааж байгаа тэнгэр элчийг зүүдэндээ үзсэн байна. Тэрбээр 18 сарын дараа Давст нуурын хөндийд анх удаа ирэхдээ бидний одоо цуглараад байгаа газраас холгүй орших толгодыг хараад, тэрхүү толгод нь түүний үзэгдэлд харсан толгод мөн болохыг таньжээ.

Бригам ах цөөхөн удирдагчидтай уг толгод дээр цуглаан хийсэн бөгөөд орчин үеийн Израилын угсааныханд шашны гүн утга агуулсан “Ensign Peak” – Тугийн Оргил хэмээх нэрийг өгчээ. Хоёр мянга таван зуун жилийн тэртээ бошиглогч Исаиа “Эзэний өргөөний уул нь уулсын тэргүүнээр тохоогдон ...Тэр үндэстнүүдийн төлөө тугийг өргөнө” хэмээн тунхаглаж байсан юм.¹

Толгод дээр цугласан ах нар тэдний амьдарч буй үе нь тэрхүү бошиглолын биелэл болж байгааг ухааран “Тэр үндэстнүүдийн төлөө тугийг өргөнө” гэх санааг илэрхийлэхийн тулд туг босгохыг хүсчээ. Ахлагч Хебер С.Кимбалл шар өнгөтэй алчуурыг авч, Бригам ах, Ахлагч Виллард Ричардсын таяганд уг алчуурыг уяад туг болгон хийсгэжээ. Тэрээр агуу Давст нуурын хөндий, түүнийг хүрээлэн буй уулс нь хожмын үед Их Эзэний үгс дэлхий дахинаа урагш гарч ирнэ хэмээн бошиглогдсон газар мөн болохыг тунхаглажээ.

Ах, эгч нар аа, хагас жил тутам явагддаг энэхүү ерөнхий чуулган болон бусад чуулганууд нь тэр үед дэлхийд зарласан тунхгийн нэгэн хэсэг юм. Өнгөрсөн хоёр өдрийн цуглаан

маань нэгэн дуулалд өгүүлсэнчлэн: “Харагтун, Сионы туг намирч байна”² гэдгийн болон “Туг” хэмээх үгийн хоёр өөр утгыг илэрхийлж байна. Бидний ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийн англи хувилбар нь The Ensign буюу Туг гэдэг сэтгүүлд хэвлэгдэн гардаг нь тохиолдлын хэрэг биш ээ.

Чуулган өндөрлөх тийшээ хандаж байна. Иймээс би та бүхнээс нэгэн зүйлийг хүсье. Чуулганы дараа зөвхөн сонссон зүйлийнхээ талаар тунгаан бодоод зогсохгүй чуулган ямар гайхалтай үйл явдал болох мөн Хожмын Үеийн Гэгээнтэн бид энэхүү чуулганы ач холбогдол, үүгээр дамжуулан бид дэлхийд юуг түгээж, юуг харуулахыг хүсдэг талаар бодоод үзээрэй. Бид бүх үндэстэн, ястан, хэлтэнд хандан Бурхан зөвхөн амьд төдийгүй, бидэнд хандан ярьдаг гэдгийг, энэ үе, өнөөдөр бидний сонссон зөвлөмж бол Ариун Сүнсний удирдамжаар өгөгдсөн “Их Эзэний таалал... Их Эзэний үгс... Их Эзэний дуу хоолой.. мөн аврал дахь Бурханы сүр хүч...” мөн гэдгийг гэрчилж байна.³

Чуулганд үг хэлэхээр томилогдсон хүмүүс онцгой тохиолдлоос бусад үед үг хэлэх сэдвээ өөрсдөө сонгодог гэдгийг та бүхэн мэддэг байх. Мэддэггүй байсан бол одоо мэддэг боллоо. Үг хэлэхээр томилогдсон хүмүүс энэ цаг үед, энэхүү чуулганаар тэдний хэлэх үг нь Их Эзэний хэлээсэй гэж хүсч байгаа тэрхүү үг мөн гэдгийг баттай мэдэх хүртлээ тус бүрдээ мацаг барьж залбиран, судалж мөн хайж, хэлэх үгээ бэлдэж, дахин дахин эхнээс нь эхэлдэг билээ. Ерөнхий чуулганы арван цагийн турш үг хэлж байсан хүн бүр энэ бүгдийг хийсэн юм. Хүн болгон нулимс дуслуулан, санаа зовон байж, бодол санаа, хүсэл эрмэлзлээ чиглүүлж өгөхийг Их Эзэнээс чин сэтгэлээсээ хүссэн билээ. Бригам Янг энэ газарт зогсож байсан тэнгэр элчийг харсан шиг би одоо тэнгэр элчүүд энд зогсож байгааг харж байна. Ах, эгч нар минь, Сүмийн ерөнхий удирдагч нар ингэж дуудуулахдаа тийм ч таатай биш байж магадгүй гэсэн ч би тэднийг ингэж л харж байна. Тэд тэнгэр элчийн мэдээг та нарт хүргэж буй мөнх бус элч нар юм. Та бидэнд тулгардаг эрүүл мэнд, санхүү, гэр бүлийн асуудлууд тэдэнд ч мөн ялгаагүй тулгардаг ч тэд итгэлтэйгээр өөрсөддөө ирсэн дуудлагыг биелүүлж, өөрсдийнхөө бус харин Бурханы үгийг тунхаглахад амьдралаа зориулж буй хүмүүс юм.

Мөн та нар хүлээн авч байгаа олон янзын мэдээллээ анзаараад үзээрэй. Тэдгээр нь тэнгэрээс ирсэн удирдамж ба шууд бидэнд өгөгдөж байгаа нь гайхалтай. Гэвч яагаад ийм олон янзын мэдээлэл байна вэ? Энд болон цуглааны байруудад цугласан хүмүүсийн ихэнх нь Сүмийн гишүүн байгаа. Гэвч хараахан Сүмийн гишүүн болж амжаагүй олон

хүн чуулганыг сонсож байна. Тиймээс биднийг маш сайн мэддэг мөн биднийг огт мэддэггүй хүмүүст бид хандан ярих шаардлага гардаг. Сүм дотроо л гэхэд хүүхдүүд, өсвөр насныхан, залуу насанд хүрэгчид, дунд насныхан болон ахмадууддаа хандаж ярих хэрэгтэй болдог. Бид гэр бүл, эцэг эх, гэртээ байгаа хүүхдүүдэд хандахын сацуу ганц бие, хүүхэдгүй, магадгүй гэр орноосоо хол байгаа хүмүүст бас хандан ярих хэрэгтэй болдог. Ерөнхий чуулганы туршид бид итгэл, найдвар, хайр⁴ ба цовдлогдсон⁵ Христийн талаарх мөнхийн зарчмуудыг онцлон анхаардгийн сацуу өнөөдөр бидэнд тулгараад байгаа ёс суртахууны асуудлуудын талаар ч шулуун шударгаар ярьдаг билээ. Судруудад “энэ үеийнхэнд наманчлалаас өөр юу ч бүү ярь”⁶ гэж тушаасан байдаг ч бидэнд бас “зовогсдод сайн мэдээг дэлгэрүүлэх [мөн] шаналсан зүрхтэй хүмүүсийг эдгээх”⁷ ёстой гэж хэлсэн байдаг. Чуулган дээр хэлсэн эдгээр үгс ямар ч үед “боолчлогдогсдод эрх чөлөөг тунхаглаж, Христийн нэвтэршгүй баялгийг”⁸ түгээж байдаг. Эдгээр олон янзын үгсээс хүн болгон өөрт хэрэгтэй тэр хэсгийг олж авдаг юм. Нэлээд хэдэн жилийн өмнө Ерөнхийлөгч Харольд Б.Лий үүнийг хамгийн оновчтойгоор сайн мэдээ бол “тавгүйтсэн нэгнийг тайвшруулж, тайвширсан нэгнийг тавгүйтүүлэхийн тулд юм”⁹ гэж тодорхойлжээ.

Бид ерөнхий чуулган дээр өгдөг зааварчилгааг үргэлж Христийнхтэй адил эелдэг мөн найрсаг байлгахын сацуу түүний захиасуудад байнга гардаг нэгэн зарчмыг давхар санаж байхыг хичээдэг билээ. Есүс хамгийн агуу сургаалаа эхлэхдээ “сүнсэн дотроо ядуу, зүрхэн дотроо цэвэр ариун, амар тайвныг тогтоогч болон дөлгөөн хүмүүст”¹⁰ амлагдсан бидний хүсэмжилж байдаг гайхалтай сайхан адислалуудыг тоочдог. Тэдгээр ерөөл адислалууд нь хэчнээн агуу хийгээд бодгальд ямар агуу тайвшралыг авчирна вэ! Мөн эдгээр нь үнэн юм. Аврагч маань яг энэ сургаалдаа амар тайвныг тогтоогч болон дөлгөөн хүмүүсийн зам нь цаашлах тусам хэчнээн нарийн болдог тухай бас өгүүлдэг. Тэрбээр “Хүн алж болохгүй гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон” гэдгийг онцлоод “Гэвч Би та нарт хэлнэ, ахдаа уурласан хэн боловч шүүлтийн дор аюултай байдалд байх болно”¹¹ гэсэн байдаг.

Үүнтэй адил “Завхайрч болохгүй гэснийг та нар дуулсан. Харин би та нарт хэлье, эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм”¹² гэжээ.

Үүнээс харахад бидний итгэл нэмэгдэх тусам бидний өмнөх зам улам нарийсч, нэгэн өдөр хамгийн агуу шаардлага болох “Тиймээс тэнгэрлэг Эцэг тань төгс байдаг шиг та нар мөн төгс бай”¹³ гэх төвшинд биднийг аваачна гэдгийг Ахлагч Кристофферсон саяхан хэллээ. Эхэн үедээ амархан мэт байсан ч бид жинхэнэ утгаараа дагалдагч болох цагт сайн мэдээ нь биднээс маш ихийг мөн хүнд хүчрийг шаардаж эхэлдэг юм. Хэрэв та Христ нүгэл хийх нь зүгээр хэмээн заасан гэж бодож байвал эндүүрч, судрыг сайн ойлгоогүй байна гэсэн үг. Христийн дагалдагч байна гэдэг нь түргэн хоолны газартай адил биш бөгөөд бид хүссэн бүхнээ хийж болно гэсэн үг биш. Нэг л өдөр өвдөг *бүхэн* сөхөрч, хэл бүр Есүс бол Христ, Аврал зөвхөн *Түүгээр* ирнэ гэдгийг тунхаглах болно.¹⁴

Ерөнхий чуулганаас та амьдралыг тань чиглүүлэх эсвэл тайвшруулах үгсийг эрэлхийлэхдээ, бидний үгс хэчнээн хатуу, шулуухан санагдсан ч бид хүн бүр садар самууныг үйлдэж, гэр бүлээсээ салж, ёс бус бэлгийн харьцаанд ордоггүй гэдгийг мэддэг юм шүү. Хүн болгон Хүндэтгэлийн өдрийг зөрчиж, худал гэрчлэл хуваалцаж эсвэл ханилсан ханиа дээрэлхдэг юм биш шүү. Биднийг сонсож буй хүмүүсийн ихэнх нь эдгээрийг үйлддэггүйг бид мэддэг хэдий ч иймэрхүү ёс бус үйлдэл гаргадаг нэгэнд дэлхийн хаана ч байсан анхааруулах ариун үүргийг бид бас хүлээсэн байдаг юм. Иймээс хэрэв та нар чадах бүхнээ хийдэг бол жишээлбэл: бага насны хүүхдүүд тань сахилгагүйтэж, салхи мэт гүйлдэн, харайлдаж байхад нь та яаж ийгээд гэр бүлийн үдшээ хийхийг хичээдэг бол гэр бүлийн үдшийн талаар биднийг ярихад өөрсөддөө сэтгэл хангалуун байж болно. Харин та нарын тийм ч сайн хийж чаддаггүй өөр сэдвийг хөндвөл түүнээс суралцаж, удирдамж авахыг хичээгээрэй. Бид Сүнсээр зааж, та нар Сүнсээр хүлээн авч байгаа тохиолдолд бидний хувь хүн бүрт хамаатай, хувийн чанартай бошиглолыг зөвхөн өөрт тань зориулан илгээх болно.

Ах, эгч нар аа, ерөнхий чуулганаар бидний гэрчлэл бусдынхтай нийлж Бурханаас та нарт сонсохыг хүсч байгаа дуу хоолойг бид ямар нэг аргаар *хүргэх болно*. “Хүмүүст гэрчлэх хийгээд сэрэмжлүүлэхээр би та нарыг илгээсэн билээ” гэж Их Эзэн бошиглогч нартаа хэлсэн юм.¹⁵

“[Учир нь] та нарын гэрчлэлийн дараа ... газар хөдлөлтүүдийн гэрчлэл ирэх болой ... мөн аянгын ... мөн гялбааны ... мөн шуургануудын ... мөн өөрсдийгөө зааг хязгаараасаа халин шидлэх далайн давалгааны дуу хоолойны гэрчлэл ирэх бөлгөө...

Мөн тэнгэр элчүүд чанга дуу хоолойгоор хашгиран, Бурханы бүрээг дуугаргана”.¹⁶

Энэ индэр дээрээс ярьсан тэнгэр элч болгон өөр өөрсдийнхөөрөө “Бурханы бүрээг дуугаргасан” болно. Тэдний өгсөн захиас бүхэн нэг ёсны хайрын гэрчлэл бөгөөд сэрэмжлүүлэг юм, энэ эцсийн үед байгаль дэлхий хүртэл гэрчилж мөн сэрэмжлүүлэх болно.

Хэсэг хугацааны дараа Ерөнхийлөгч Томас С.Монсон энэ чуулганыг өндөрлөхөөр индэр дээр гарч ирнэ. Бидний амьдарч буй өнөө үеийн ахлах Төлөөлөгч, бошиглогч, энэхүү гайхалтай ахын талаар хэдэн үг хэлэхийг зөвшөөрнө үү. Энэ чуулган дээр та бүхний сонссон бүх зүйл, бошиглогчдын амьдрал тийм ч амар байдаггүйг харууллаа, би ч бас үүнийг батлан хэлж байна. Ерөнхийлөгч Монсонгийн амьдрал ч мөн амар хялбар байсангүй. Тэр энэ тухайгаа өчигдөр орой санваартны хуралдаан дээр ярьсан шүү дээ. 36 настайдаа тэрээр төлөөлөгчөөр дуудагдахад хүүхдүүд нь 12, 9, 4 настай байжээ. Монсон эгч нөхрөө, хүүхдүүд нь аавыгаа амьдралынхаа хагас зуун жилийг Сүмд зориулж, сүмийн үүргүүдийг биелүүлж ирснийг нь харлаа. Тэд энэ дэлхийд хүн болгонд нүүрлэдэг өвчин зовлон, өгсөж уруудахын хүнд хүчрийг даван туулсаар ирсэн, цаашид ч даван туулах болно. Гэвч энэ бүхний дунд Ерөнхийлөгч Монсон маань инээмсэглэн бүхнийг даван туулж байна. Түүнийг юу ч зогсоож чадахгүй. Тэр бол агуу итгэл, ер бусын тэвчээр, сэтгэлийн хаттай хүн.

Ерөнхийлөгч өө, энд байгаа болон дэлхий даяар цуглаад байгаа ах, эгч нар бид бүгдээрээ Танд хайртай, Таныг хүндэлдгийг би батлан хэлж байна. Таны үнэнч шударга зан бидэнд үлгэр жишээ болдог. Таны удирдлаганд бид талархаж байна. Төлөөлөгч болох бусад арван дөрвөн ах, энэ индэр мөн танхимд сууж байгаа удирдагчид, дэлхий дахинаа цуглараад байгаа олон мянган хүн таныг хайрлаж, дэмжин баталж, тантай мөр зэрэгцэн энэ ажлын төлөө зүтгэж байна. Бид чадлынхаа хэрээр таны ачааг хөнгөвчлөх болно. Ертөнц үүсэхээс өмнө энэ дэлхийд Есүс Христийн сайн мэдээний тугийг өргөхөөр дуудагдсан тэнгэрлэг элчүүдийн нэг нь та юм шүү. Таныг хараад бид бахархдаг. Бидний тунхаглаж буй сайн мэдээ болон түүгээр дамжин ирдэг авралыг, мөн Тэрбээр энэхүү авралаар хангасныг би Их Эзэн Есүс Христийн гайхамшигт, сүр жавхлант нэрээр гэрчилж байна, амен.

Эшлэл

1. Исаиа 2:2; 11:12.

2. “The Morning Breaks,” *Hymns*, no. 1.
3. Сургаал ба Гэрээ 68:4.
4. 1 Коринт 13-ыг үз.
5. 1 Коринт 1:23-ыг үз.
6. Сургаал ба Гэрээ 6:9; 11:9.
7. Исаиа 61:1
8. Ефес 3:8
9. Харольд Б.Лий, “The Message,” *New Era*, Jan. 1971 оны 1-р сар, 6-г үз.
10. Матай 5:3-12-ыг үз.
11. Матай 5:21-22; мөн 3 Нифай 12:22-ыг үз.
12. Матай 5:27–28.
13. Матай 5:48
14. Ром 14:11; Мозая 27:31-ийг үз
15. Сургаал ба Гэрээ 88:81.
16. Сургаал ба Гэрээ 88:89-90, 92.

Ням гарагийн үдээс хойших хуралдаан

2011 оны 4-р сарын 3

Чуулган өндөрлөх агшинд

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Ах, эгч нар минь, энэ чуулганыг өндөрлөх агшинд зүрх сэтгэл минь баяр хөөрөөр бялхан байна. Бид Их Эзэний Сүнсийг элбэг дэлбэгээр мэдэрлээ. Чуулганы үйл ажиллагаанд оролцсон газар газрын Сүмийн гишүүн нэг бүрд, түүний дотор залбирал хэлсэн гишүүдэд талархал илэрхийлж байна. Бид энд сонссон захиасуудаа урт удаан хугацаанд зүрх сэтгэлдээ тээн санаж явах болтугай. Эдгээр захиасууд нийтлэгдэх *Ensign*, *Лиахона* сэтгүүлүүдийг хүлээн авсан үедээ захиасуудыг дахин уншиж, судалцгаая.

Бид чуулганы бүх хуралдаануудаар гайхамшигтай сайхан дуу хөгжмийг дахин сонслоо. Бидэнтэй авьяас билгээ хуваалцаж, чуулганы туршид бидэнд сүнслэг нөлөө үзүүлсэн хүмүүст би хувиасаа талархал илэрхийлж байна.

Энэ чуулганы үеэр албан тушаалуудад шинээр дуудагдсан Ах нарыг бид гар өргөн баталлаа. Бид Их Эзэний зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө тэдэнтэй хамтран ажиллахыг тэсч ядан хүлээж байгаагаа мэдэгдэхийг хүсч байна.

Хайрт зөвлөхүүд Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, Диетер Ф.Угдорф нарт хайр, талархлаа илэрхийлж байна. Тэд бол мэргэн ухаан хийгээд мэдлэг туршлагатай хүмүүс. Тэдний үйлчлэл үнэлж баршгүй чухал юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ах нараа би хайрлан, дэмждэг билээ. Тэд дээд зэргийн үр өгөөжтэй үйлчилж байгаа бөгөөд энэ ажилд зүрх сэтгэлээ бүрэн зориулсан хүмүүс юм. Далын болон Тэргүүлэх Бишопын Зөвлөлийн гишүүдэд би мөн хайр, талархлаа дэвшүүлж байна.

Өнөөдөр дэлхийд бидэнд олон сорилт бэрхшээл тулгарч байгаа ч, Тэнгэрлэг Эцэг биднийг санаж байгаа гэдгийг би та бүхэнд батлан хэлж байна. Тэрбээр бидэнд бүгдэд нь хайртай бөгөөд залбирлаар дамжуулан Түүнийг эрэлхийлж, зарлигуудыг нь биелүүлэхийн төлөө хичээн чармайсан үед биднийг адислах болно.

Бид бол дэлхий дахины сүм. Манай Сүмийн гишүүд дэлхий даяар хаа сайгүй аж төрж байна. Улс орныхоо сайн иргэд, нийгэм, хамт олныхоо сайн хөршүүд байж, өөрийн болон

өөр сүмүүдийн хүмүүст аль алинд нь тусламжийн гараа сунгацгаая. Бид байгаа газар бүрдээ, хийдэг юм болгондоо зарчимч шударга байдлын үлгэр жишээ байх болтугай.

Ах эгч нар аа, миний төлөө, Сүмийн Ерөнхий эрх мэдэлтнүүдийн төлөө залбирсанд тань баярлалаа. Бид та бүхэнд бас Их Эзэний ажлыг урагш ахиулахын төлөө та бүхний хийж байгаа ажилд гүнээ талархдаг билээ.

Гэр орондоо харих зам тань өлзийтэй байх болтугай. Тэнгэрийн адислалууд та нар дээр юүлэгдэх болтугай.

Чуулганыг өндөрлөхөөс өмнө би Аврагчийг болон бидний төлөө хийсэн Түүний агуу цагаатгагч золиослолыг эрхэмлэн хайрладаг хайраа та бүхэнтэй хуваалцахыг зөвшөөрнө үү. Гурван долоо хоногийн дараа Христийн ертөнц тэр аяараа Улаан өндөгний буюу Христийн амилалтын баярыг тэмдэглэнэ. Бидний төлөө Гетсеманид Христийн үйлдсэн ач гавьяаг бүрэн ухамсарлан ойлгодог хүн бидний дунд нэг ч байхгүй гэдэгт би итгэдэг. Гэвч бид бүхний төлөө хийсэн Түүний цагаатгагч золиослолын төлөө би амьдралынхаа өдөр бүр баярлан талархаж явдаг билээ.

Сүүлчийн мөчид Тэрбээр эргэн буцаж болох байсан ч, тэгээгүй юм. Тэрбээр бүхнийг аврахын төлөө бүхнээс дорд байдлаар талийгаач болсон. Тэгснээрээ Тэрбээр бидэнд мөнх бус оршихуйгаас гадна амьдралыг өгсөн билээ. Тэрбээр тийнхүү Адамын уналтаас биднийг гаргасан билээ.

Миний бие зүрх сэтгэлийнхээ гүнээс Түүнд баярлан талархаж явдаг билээ. Тэрбээр бидэнд хэрхэн амьдрахыг бас хэрхэн үхэхийг заасан юм. Тэрбээр бидний авралыг баталгаатай болгосон юм.

Чуулганыг өндөрлөх энэ мөчид би Христийн Амилалтын баяр ойртсон энэ үеийн бодол санааг минь онцгой сайхан дүрсэлсэн Эмили Харрисын үгсийг та бүхэнтэй хуваалцъя:

Нэгэн цагт Түүнийг өлгийдсөн даавуу хоосон байна.

Нөгөөх даавуу цав цагаан, шив шинэхэн, цэвэрхнээрээ байна.

Булшны хаалга онгорхой, бул чулууг өнхрүүлэн зайлуулжээ.

Бултаараа тэнгэр элчүүд Түүнд магтуу өргөхийг би сонслоо.

Бөс даавуу ч Түүнийг барьж чадсангүй.

Бул чулуу ч Түүнийг хорьж дийлсэнгүй.

Хар л даа, “Тэр энд байхгүй” гэсэн үгс

Хоосон булшийг нэвтлэн цуурайтсан юм.

Нэгэн цагт Түүнийг өлгийдсөн даавуу хоосон байна.

Нөгөөх даавуу цав цагаан, шив шинэхэн, цэвэрхнээрээ байна.

Өө, халелюя, халелюя, булш хоосон байна.¹

Ах, эгч та нартаа үй түмэн адислалыг бидний Аврагч Есүс Христийн нэрээр хүсэн ерөөе,
амен.

Эшлэл

1. Эмили Харрис, “Empty Linen,” *New Era*, 2011 оны 4-р сар, 49.

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий хуралдаан

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий хуралдаан

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий хуралдаан

2011 оны 3-р сарын 26

Би шударга, үнэнч байхад итгэдэг

шударга зан

үлгэр жишээ

ерөнхий чуулган

Би шударга, үнэнч байхад итгэдэг

Анн М.Дибб

Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Итгэлдээ үнэнч байх нь амар хялбар, хөгжилтэй биш ч биднийг Тэнгэрлэг
Эцэгтэйгээ мөнх амьдрал уруу хөглөх зам дээр аюулгүй байхад тусалдаг билээ.

Хайрт залуу эмэгтэйчүүд ээ, Миний хувьд та нарынхаа өмнө өнөө орой үг хэлэх нь
агуу боломж юм. Та нар минь үнэхээр гайхалтай, сүнслэг харагдаж байна.

Итгэлийн арвангурав дахь Тунхаг нь 2011 оны Мючелийн сэдэв юм. Энэ жил би
залуучуудын болон ариун ёслолын цуглаануудад оролцож байхдаа Итгэлийн
арвангурав дахь Тунхаг манай залуу эрэгтэй, эмэгтэйчүүдэд ямар ач холбогдолтой
мөн амьдралд нь хэрхэн хэрэгждэг талаар хуваалцахыг нь сонссон юм. Энэ нь
Итгэлийн Тунхгийн хамгийн сүүлчийн, хамгийн урт мөн цээжлэхэд хэцүү, бишоп
заавал цээжээр унш гэхгүй байх гэж найддаг хэсэг боловч бидэнд хэрэгтэй олон
чухал зүйл агуулагддагийг та нар мэднэ.

Итгэлийн арвангурав дахь Тунхаг нь Христэд итгэгч, зөв шударга амьдралын хөтөч юм. Тунхагт: "Шударга, үнэнч, ариун явдалтай, нинжин сэтгэлтэй, ач буянтай байхад мөн бүх хүмүүст сайн сайхныг үйлдэхэд бид итгэдэг; чухамдаа-бид бүх зүйлд итгэдэг, бид бүх зүйлд найддаг, бид олон зүйлийг хүлцэн тэвчлээ, мөн бүх зүйлийг хүлцэн тэвчих болно гэдэгт найддаг гэсэн Паулын зөвлөгөөг бид дагадаг хэмээн хэлж болно. Хэрэв ариун журамтай, сайхан эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай ямар нэгэн зүйл байдаг бол бид эдгээр зүйлүүдийг эрэлхийлдэг" гэсэн сургаалын дагуу энэ дэлхийн хүн бүр амьдрахаар шийдвэл дэлхий ямар болохыг төсөөл дөө.

Ням гарагийн Ерөнхий чуулганыг нээн хэлсэн үгэндээ бошиглогч Томас С.Монсон Филиппой 4:8 дахь Паулын үг буюу Итгэлийн Тунхагийн арвангуравт гарсан олон гайхалтай зарчмуудаас эш татсан. Ерөнхийлөгч Монсон одоо бидний амьдарч буй энэ ороо бусгаа үеийн талаар тайвшрал, урамшууллыг бидэнд өгсөн юм. Тэрээр хэлэхдээ, "мөнх бус амьдралын энэ аюултай аяны туршид биднийг аюулгүй зам дээрээ байхад¹ туслах төлөөлөгч Паулын зөвлөгөөг бүгдээрээ дагацгаая" гэсэн юм.

Өнөөдөр би Итгэлийн арвангурав дахь Тунхагийн хоорондоо уялдаатай хоёр чухал зарчмын талаар ярихыг хүссэн бөгөөд энэ нь биднийг аюулгүй, зам дээрээ үлдэхэд туслах юм. Чухал зарчмууд болох шударга, үнэнч байх талаар надад онцгой гэрчлэл байдаг.

Нэгдүгээрт: "Би шударга байхад итгэдэг." Шударга байна гэдэг нь юу гэсэн үг вэ? *Итгэлдээ үнэнч байх нь* товхимолд зааснаар "Шударга байх гэдэг нь үргэлж үнэнч, шударга, заль мэхгүй байна гэсэн үг"² юм. Шударга байх нь³ Бурханаас өгсөн зарлиг бөгөөд чин шударга байх нь бидний авралд зайлшгүй шаардлагатай."⁴

Ерөнхийлөгч Ховард В.Хантер бид чин шударга байхыг үнэн сэтгэлээсээ хүсэх ёстой гэж заасан. Тэрээр хэлсэн нь:

"Хэдэн жилийн өмнө ариун ёслолын танхимуудын орох хаалга, үүдний танхимуудад 'Өөрөө өөртөө шударга бай' гэсэн зурагт хуудсууд байрлуулсан байлаа. Зурагт хуудсуудад амьдралд тохиолдох жирийн зүйлсийн тухай харуулсан бөгөөд амьдрал ахуйн эдгээр ойр зуурын зүйлс дээр л зөв шударга байдал өсөн хөгждөг юм.

Зарим хүн томоохон зүйлд шударга бус хандвал ёс суртахууны хувьд буруу гэж үздэг хэрнээ жижиг зүйлс дээр шударга бус хандахыг уучилж болох зүйл гэж үздэг. Мянган доллар завших, арван цент завших хоёрын хооронд үнэндээ том жижгийн ялгаа бий юү? . . . Тухайн үйлдлийн том жижгээс нь хамаарч шударга бус хандсаны зэрэглэл, хэмжээ гэж байж болох уу?”.

Ерөнхийлөгч Хантер цааш нь хэлэхдээ, “Хэрэв бид Аврагч болон Түүний Ариун Сүнстэй хамт байж чадах юм бол өөрсөддөө болон Бурхан, найз нөхөд, бусад хүмүүст шударга байх болно. Үүний үр дүнд та нар зөв шударга байдлын баяр баясгаланг эдлэх болно”⁵ гэжээ.

Бид том, жижиг ямар ч зүйлд шударга байж чадвал оюун санаандаа амар амгаланг мэдэрч, ой ухаан маань саруул тунгалаг байх болно. Итгэл дээр суурилсан бидний харилцаа улам өсөн нэмэгдэх болно. Үнэнч шударга байдлаас ирэх хамгийн агуу адислал бол өөрсөдтэйгөө Ариун Сүнсийг хамт байлгах явдал юм.

Бүх зүйлд шударга байх амлалтыг минь хүчирхэгжүүлж өгсөн энгийн нэгэн түүхийг би хуваалцъя:

“Нэгэн эр . . . үдшийн цагаар хөршийнхөө талбайгаас эрдэнэ шиш хулгайлахаар явжээ. Тэрээр бяцхан хүүгээ харуулаар тавьж, хашлаган дээр суулгажээ. Тэгээд тэр том шуудай барин хашлага даван үсэрч ороод эргэн тойрноо сайтар харж нягтлаад хэн ч байхгүй тул шуудайгаа дүүргэхээр шулуудав. [Яг тэр мөчид хүү нь]:

‘Аав аа, та өөр нэг зүг уруу харсангүй! . . . Та дээшээ харахаа мартчихлаа’ гэжээ.”

Бидэнд бүгдэд нь шударга бус явдалд уруу татагдах үе гардаг бөгөөд тэр үед бид хэн ч мэдэхгүй гэж боддог. Энэ түүх Тэнгэрлэг Эцэг маань биднийг үргэлж мэддэг ба бид Түүний өмнө хариуцлага хүлээсэн гэдгийг сануулж байна. Энэ мэдлэг намайг “[Би] зөв шударга байхад итгэдэг” гэсэн амлалтандаа үргэлж тууштай байхад тусалдаг.

Итгэлийн Тунхгийн арвангуравт гардаг хоёр дахь зарчим нь: “Би үнэнч байхад итгэдэг” гэсэн хэсэг юм. *Үнэнч байдал* гэдэг үгийг толь бичигт “тууштай,” “үнэнч,” “зөв шударга,” “заль мэхгүй” гэж тодорхойлсон байдаг.⁷

Миний дуртай номуудын нэг бол 1847 онд хэвлэгдэн гарсан Английн зохиолч Шарлотт Бронтийн бичсэн *Жэйн Айер* хэмээх сонгодог зохиол юм. Гол баатар Жэйн Айер нь “үнэнч байх-”ын үлгэр жишээ болсон өнчин ядуу, өсвөр насны охин юм. Энэ зохиолд ноён Рочестер, Хатагтай Айерт хайр сэтгэлтэй болсон ч түүнтэй гэрлэх боломжгүй байсан тухай гардаг. Тиймээс тэрээр хатагтай Айераас гэрлэхгүйгээр хамтран амьдрахыг гуйдаг. Айер, Рочестерт үнэхээр хайртай байсан болохоор тэрхэн мөчид уруу таталтанд автан, “Би юу хийх нь хэнд хамаатай билээ? Миний хийсэн зүйл хэнд ч хор хөнөөлгүй шүү дээ?” гэж боддог.

Гэтэл Жэйний дотоод сэтгэл: “Энэ нь *надад* хамаатай. Ганцаардмал, найз нөхөдгүй, дэмжлэг үзүүлэх хүнгүй байх тусам би өөрийгөө илүү их хүндлэх болно. Би Бурханы өгсөн хуулийг дагана. Эдгээр хууль, зарчмууд нь уруу таталтын нөлөөгүй цаг үед зориулагдаагүй харин энэ нь ийм цаг үед зориулагдсан юм. . . . Хэрэв би нөхцөл байдлын эрхшээлээр зарлигуудыг зөрчих юм бол үр дагавар нь юу болох бол? Үйлдэл бүр үр дагавартай байдаг, иймээс ч би үүнд үргэлж итгэсээр ирсэн . . . Өмнө нь миний гаргасан шийдвэр яг одоо миний хийх ёстой сонголт болоод байна: Би шийдвэртээ үнэнч зогсох болно.”⁸

Яг уруу таталт ирэх мөчид Жэйн Айер итгэлдээ үнэнч байж, Бурханаас өгсөн зарлигийг даган уруу таталттай тэмцэх тэр агшинд ч итгэлээсээ хазайлгүй үлдэж чадсан юм.

Итгэлдээ үнэнч байх нь амар хялбар, хөгжилтэй биш ч биднийг Тэнгэрлэг Эцэгтэйгээ мөнх амьдрал уруу хөтлөх зам дээр аюулгүй байхад тусалдаг билээ. Тэнгэрлэг Эцэгтэйгээ үүрд мөнх хамт амьдрах тэрхүү чин хүсэл болоод баяр баясгаланг сануулж, мэдрүүлдэг нэгэн залуу эмэгтэйн зурсан зурганд би их дуртай.

Үнэнч байх нь бидэнд бусдын амьдралд эерэг нөлөө үзүүлэх боломжийг олгодог. Би саяхан нэгэн залуу эмэгтэй итгэлдээ үнэнч байх амлалтаараа найзынхаа амьдралд гайхалтайгаар нөлөөлсөн тухай сүнслэг түүхийг сонссон юм.

Хэдэн жилийн өмнө Кристи, Жэйн хоёр Техас мужийн Хөөрстөд найрал дууны ангид хамт сурч байжээ. Тэд бие биеэ сайн таньдаггүй байсан ч нэгэн өдөр Жэйн, Кристийг өөрсдийнхөө шашин, итгэл үнэмшил, дуртай Библийн номны түүхүүдийн тухай найзуудтайгаа ярилцаж байхыг нь санаандгүйгээр сонсжээ. Саяхан Жэйн, Криститэй дахин уулзахдаа энэ түүхийг ярьсан байна:

v35

“Тэр үед чамайг найзуудтайгаа юуны тухай ярилцаж байгааг мэдэхгүй байсан нь надад их гунигтай байсан. Тэгээд Христийн Мэндэлсний Баярын үеэр аав ээжээсээ би Ариун Библи авч өгөхийг гуйсан юм. Хүссэн Библиэ аваад би уншиж эхэллээ. Энэ нь миний шашны аяллыг эхлүүлсэн бөгөөд үнэн Сүмийг олох миний эрэл хайгуул ч бас эхэлсэн юм. Түүнээс хойш арван хоёр жил өнгөрчээ. Тэр үед би нэлээд хэдэн сүмд очиж, сүмд тогтмол явдаг байсан ч, нэг л юм үгүйлэгдээд болдоггүй ээ. Нэг орой би өвдөг сөгдөн суугаад юу хийх ёстойгоо асуув. Тэгтэл тэр шөнө би, Кристи чамайг зүүдэлсэн. Дунд сургууль төгссөнөөс хойш чамтай уулзаагүй байлаа. Зүүд минь их сонин санагдсан ч үүнийг ямар нэгэн дохио гэж бодоогүй. Гэтэл дараагийн гурван шөнө дараалан би чамайг зүүдэлсэн, тэгээд энэ ямар учиртай юм бол гэж бодлоо. Гэнэт би чамайг Мормон байсныг санасан. Тэгээд би Мормон сайт уруу орж хайсан юм. Хамгийн эхний олсон зүйл гэвэл Мэргэн Ухааны Үг байлаа. Ээж минь уушигны хорт хавдраар хоёр жилийн өмнө нас барсан юм. Ээж тамхи татдаг байлаа. Мэргэн Ухааны Үгийн тухай уншингуут надад маш хүчтэй мэдрэмж төрлөө. Тэгээд би аавындаа очоод том өрөөнд нь орж, залбирч эхэллээ. Хаашаа явах, яах ёстойгоо асуув. Яг тэр үед зурагтаар нэгэн сүмийн тухай танилцуулга гарч эхлэхэд би утасны дугаараар нь тэр дороо ярилаа. Гурван өдрийн дараа номлогчид надтай ярьж, Мормоны ном аваачиж өгч болох уу гэж асуув. Би "болно" гэж хариулсан. Тэгээд би 3 сар хагасын дараа баптисм хүртэж, 2 жилийн дараа сүм дээр нөхөртэйгөө танилцсан юм. Бид Далласын Ариун сүмд гэрлэж, хоёр хөөрхөн хүүхдийн эцэг эх болоод байна.

Кристи, би чамд баярласнаа хэлэх гэсэн юм. Чи ахлах сургуулийнхандаа үнэхээр гайхалтай үлгэр жишээ үзүүлсэн шүү. Чи маш сайхан сэтгэлтэй бас ариун журамтай байсан. Номлогчид надад хичээл зааж, баптисм хүртэхийг урьсан. Харин чи миний гурав дахь номлогч байсан. Чи үйлдлээрээ тэр үрийг суулган, амьдралыг минь илүү сайхан болгосон. Би одоо мөнхийн гэр бүлтэй. Хүүхдүүд минь сайн мэдээний бүрэн байдлыг сурч мэдэн өсөх болно. Энэ бол бидний хэнд ч ирж болох

агуу адислал юм. Энэхүү агуу адислал миний амьдралд орж ирэхэд чи тусалсан” гэж Жэйн хэлсэн юм.

Намайг түүнтэй холбогдоход тэр, “Итгэлийн арвангурав дахь Тунхагт гардаг зан чанарын жагсаалтыг сонсох үед, энэ чинь бидэнд ахадсан юм биш үү гэж заримдаа бодогдох юм. Гэвч бид Христийн үлгэр жишээг даган эдгээр жишгүүдээр амьдрахыг хичээвэл бидэнд өөрчлөлт ирдгийг би мэднэ. ... Би Алма 26:3 дахь Аммоны хэлсэн ‘Мөн бид энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхэд Бурханы мутар дахь зэмсгүүд болгогдсон нь бидний дээр бэлэглэгдсэн адислал болой’ гэсэнтэй адилхан бодолтой байдаг” гэж билээ.

“Би шударга, үнэнч байхад итгэдэг” гэсэн мөрийг та нар зөвхөн унших биш харин энэ амлалтаа өдөр бүр биелүүлж амьдраасай хэмээн би залбирч байна. Тэнгэрлэг Эцэг маань энэ ажлыг хийлгэхээр та нарыг илгээсэн бөгөөд үүнийг хийснээр Түүний хүч чадал, хайр, адислал та нарт ирэхийн төлөө би залбирч байна. Эдгээр бүх зүйлсийг би Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

1.

Томас С.Монсон, “Looking Back and Moving Forward,” *Лиахона*, 2008 оны 5-р сар,

2.

Итгэлдээ үнэнч байх нь (2004), 84.

3.

Египетээс Гарсан нь 20:15-16-г үз.

4.

Сайн мэдээний зарчмууд (2009), 179..

5.

Ховард В.Хантер, “Basic Concepts of Honesty,” *New Era*, 1978 оны 2-р сар, 4, 5..

6.

Виллям Ж.Скотт “Forgot to Look Up,” *Scott’s Monthly Magazine*, 1867 оны 12-р сар,
953.

7.

Merriam-Webster’s Collegiate Dictionary, 11 дэх хэвлэл, (2003), “true-” г үз.

8.

Чарлотт Бронте, *Jane Eyre*, [2003], 356..

Лиахона

2011 оны 5-р сар

|

Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий хуралдаан

2011 оны 3-р сарын 26

“Санагтун: Би элэгсэг нэгэн баймаар байна”

Мэри Н.Кук

Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Хэдэн долоо хоногийн өмнө манай тойргийн цуглаан дээр үг хэлсэн Лорел залуу эмэгтэйгээс би нэгэн чухал зүйлийг сурсан юм. Түүнийг Есүс Христийн талаар итгэлтэйгээр зааж, гэрчлэлээ хуваалцахад зүрх сэтгэл маань маш ихээр хөдөлсөн. Тэрээр яриагаа “Есүс Христийг амьдралынхаа гол утга учир болгосноор өдөр хоногууд илүү сайхан болж, би хайртай хүмүүстэйгээ улам эелдэг дотно харьцаж, баяр баяслаар дүүрдэг” гэж төгсгөсөн юм.

Үг хэлсэн энэхүү залуу эмэгтэйг би өнгөрсөн хэдэн сарын турш ажигласан. Тэрээр хүн бүхэнтэй нүүр дүүрэн инээмсэглэлээр мэндэлж бусад залуусын амжилтанд баярлан, бахархаж байхыг би харсан юм. Саяхан хоёр Миа Мэйд охин надад энэ залуу эмэгтэйн үзэх гэж байсан кино нь “ариун журамтай, сайхан” зүйл биш болохыг мэдээд тасалбараа буцаах шийдвэр гаргасан тухай надад мэдэгдсэн. Тэр бол хайр татам, эелдэг, дуулгавартай охин. Тэрээр хагас өнчин бөгөөд амьдрал нь дардан сайхан байгаагүй. Тиймээс би түүнийг яаж ийм аз жаргалтай, эелдэг сүнслэг байж чаддаг юм болоо гэж гайхдаг байсан ч хариултаа “Би Есүс Христийг амьдралынхаа гол утга учир болгодог” гэсэн гэрчлэлээс олж авсан.

“Шударга, үнэнч, ариун явдалтай, нинжин сэтгэлтэй, ач буянтай байхад мөн бүх хүмүүст сайн сайхныг үйлдэхэд бид итгэдэг.”¹ Энэ сайхан Христийн зан чанаруудыг Итгэлийн Тунхгийн 13-аас олж болох бөгөөд эдгээр нь биднийг ариун сүмийн адислалууд болон мөнхийн амьдралд бэлтгэх болно.

Би эдгээр зан чанаруудын нэг болох “нинжин сэтгэл” гэдэг үгэн дээр төвлөрөн ярихыг хүсч байна. Бид байнга сонсдоод байдаггүй ч нинжин сэтгэл гэдэг нь үнэхээр сайхан үг юм. Энэ үг нь Латин гаралтай бөгөөд “хэн нэгэнд сайн сайхныг хүсэх”² гэсэн утгатай. Нинжин сэтгэлтэй байна гэдэг нь эелдэг, сайхан сэтгэлтэй,

энэрэнгүй байна гэсэн үг юм. Та нарын ихэнх нь Хүүхдийн Хэсэгт байхдаа
нинжин сэтгэлийн талаар суралцаж, энэ дууг цээжилж байсан байх:

Би элэгсэг нэгэн баймаар байна,
Ийм байх сайхан шүү дээ.
Би өөртөө хэлж, сануулахдаа
“Би л: элэгсэг байя” хэмээнэ³.

Аврагч маань бидэнд нинжин сэтгэлийн талаар зааж, түүнийгээ бусдад үзүүлэн
амьдарсан. Есүс бүгдийг хайрлаж, бүгдэд үйлчилсэн. Амьдралаа Есүс Христ дээр
төвлөрүүлэх нь биднийг нинжин сэтгэлтэй болоход тусална. Эдгээр Христийнхтэй
адил зан чанаруудыг хөгжүүлэхийн тулд бид Аврагчийн талаар суралцаж,
“Түүний замаар замнах”⁴ ёстой.

Сайн санаат самари хүний сургаалт зүйрлэлээс бид хүн бүрийг хайрлах ёстойг
сурдаг. Энэ түүх Лук номны 10-р бүлгээс эхэлдэг. Нэгэн хуульч Аврагчаас “Мөнх
амийг өвлөн авахын тулд би яах ёстой вэ?”¹ гэж асуухад,

Аврагч түүнд “Чи өөрийн Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадал, бүх
оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла” гэж хариулав.

Тэгэхэд нь хуульч, “Миний хөрш гэдэг чинь хэн бэ?” гэж асуув. Энэ нь хуульчийн
хувьд их сонирхолтой асуулт байлаа. Учир нь Иудейчүүдийн хойд хөрш нь тэдний
үнэхээр дургүй самаричууд байсан бөгөөд Иерусалимаас Галил орохын тулд тэд
Самариар дайралгүй Иорданы хөндийгөөр явах тойруу замаар аялдаг байв.

Есүс хуульчийн асуултыг Сайн санаат самари хүний сургаалт зүйрлэлээр
хариулжээ. Сургаалт зүйрлэлд өгүүлснээр,

|“Нэгэн хүн Иерусалимаас Иерихо орохоор явжээ. Тэр хүн дээрэмчдийн дунд
орчихож. Тэд түүнийг нүцгэлэн зодоод амьтай төдий орхиод оджээ. . . .

Харин түүгээр явж байсан нэгэн самари хүн түүнтэй таарчээ. Тэр түүнийг
харуутаа өрөвдөн,

түүн уруу ирж, шарханд нь тос, дарс асгаж боогоод, адгуусан дээрээ тэгнэн дэн буудалд хүргэж ирэв. Тэгээд түүнийг асарчээ.

Маргааш нь тэр хоёр денар авч буудлын эзэнд өгөөд, ‘Түүнийг асарч байгаарай. Та илүүг зарвал, би буцахдаа танд дахин төлье’ гэжээ.”⁵

Шархдаж гэмтсэн хүнтэй үндэс угсаа нэг Иудей тахилч болон Леви хүн түүний хажуугаар өнгөрөөд гарсан ч Самари хүн өрөвч зөөлөн сэтгэлээр түүнд хандаж, Христийн зан чанаруудын нэг болох нинжин сэтгэлийг харуулсан юм. Есүс энэ түүхээрээ дамжуулан хүн бүр бидний хөрш гэдгийг заасан.

Саяхан бишопын зөвлөх хөрш бүр ямар чухал болохыг заасан нэгэн туршлагыг хуваалцсан юм. Тэрээр цуглааны үеэр олон өнгийн харандаа дүүргэсэн том сав барин яваа бяцхан хүүхдийг харжээ. Тэр тойргийнхоо олон гишүүдийг хараад тэд өнгө өнгийн харандааны адил өөр хоорондоо адил төстэй байдаг ч хүн бүр маш онцгой бөгөөд чухал гэдгийг анзаарчээ.

“Тэдний тойрогтоо авчирдаг онцгой өнгө болон ертөнц нь тэднийх л юм. ... Тэд өөр өөрийн гэсэн хүч чадал, сул тал, хүсэл эрмэлзэл, нууцлаг мөрөөдөлтэй байдаг. Гэхдээ тойргийн гишүүд бүр сүнслэг эв нэгдлийн нэгэн өнгөнд нэгдэн нийлдэг юм” гэж тэр хэлсэн.

“Эв нэгдэл нь сүнслэг чанар юм. Энэ нь гэр бүлд байдаг амар амгалан, зорилго тэмүүллийн нандин мэдрэмж бөгөөд яг л өөртөө хүсдэг шиг бусдад сайн сайхныг хүсэх хүсэл юм. Мөн хэн ч чамд буруу зүйл хийхгүй гэдгийг мэдэх юм. [Энэ нь чи хэзээ ч ганцаардахгүй гэсэн үг юм.]”⁶

Бид өөрсдийн онцгой өнгөнүүдийг нинжин сэтгэлийн үйлсээрээ дамжуулан хуваалцаж, эв нэгдлийг бий болгодог.

Та нар ганцаардаж байсан уу? Алаг хорвоод ганцаардсан нэгнийг та нар анзаарч байсан уу? Залуу эмэгтэйчүүд ээ, та нар инээмсэглэл, эелдэг үгс, урам дэмээрээ бусдын амьдралд өөрсдийн онцгой өнгийг авчирч байгааг би харсан.

Ерөнхийлөгч Томас С.Монсон залуу эмэгтэйчүүдэд хандан “Миний эрхэм залуу эгч нар аа, эргэн тойрондоо байгаа хүмүүсийг шүүн хэлэлцэж, шүүмжлэхийн оронд хүн бүрийг хайр болон үнэ цэнээ мэдрэхэд нь урамшуулан дэмжиж байгаарай хэмээн би уриалж байна”⁷ гэсэн үгсээрээ үе тэнгийнхэнтэйгээ болон эргэн тойрныхонтойгоо хэрхэн харьцахыг бидэнд заасан юм.

|Бид сайн санаат самари хүний үлгэр жишээг дагах хэрэгтэй ба зөвхөн ганц л хүн нинжин сэтгэлтэй байснаар “дэлхийг өөрчилж” чадах юм.⁸ Би хүн бүрийг ирэх долоо хоногт Самари хүний адил ямар нэгэн сайн үйл хийхийг уриалж байна. Энэ нь магадгүй өөрийн хүрээнээсээ гадуурх бусад хүмүүстэй найзлах эсвэл ичимтгий зангаа даван гарахыг шаардаж болох юм. Та нарт тийм ч сайн ханддаггүй хэн нэгэнд үйлчлэхийг зоригтойгоор сонгож болно. Хэрвээ чи хийдгээсээ арай илүүг хийхийг хичээвээс маш сайхан мэдрэмжийг авч, эелдэг даруу байдал өдөр тутмын амьдралын чинь нэг хэсэг болж эхлэнэ гэдгийг би амлаж байна. Та нар нинжин сэтгэл нь гэрт, анги, тойрог, сургуульд тань баяр баясгалан, эв нэгдлийг бий болгодог болохыг харах болно. “Санагтун: Би элэгсэг нэгэн баймаар байна”⁹

Аврагч маань бүх хүнийг хайрласан төдийгүй бас бүгдэд үйлчилсэн юм. Өөрийн сайн сайхныг олонд түгээ. Хөгшин, залуу бүгд та нарын нинжин сэтгэлийн үйлчлэлээр дамжуулан агуу ихээр адислагдах болно. Бошиглогч Монсон маань залуу байхаасаа л настай хүмүүст онцгой анхаарал хандуулдаг байжээ. Тэрээр мэнд мэдэх богинохон айлчлал, нүүр дүүрэн инээмсэглэл хийгээд үрчлээстэй гарыг атгахын үнэ цэнийг мэддэг юм. Энэрэл хайрын иймэрхүү энгийн үйлдлүүд нь ч зарим үед тохиох баргар, ганцаардмал, дуусашгүй мэт урт өдрүүдэд ч гэрэл гэгээг авчирдаг. Би та бүхнийг эмээ өвөө болон бусад настай хүмүүст анхаарал халамж тавьж байхыг уриалж байна. Маргааш сүмд очоод эргэн тойрноо хар, тэгээд чиний гайхамшигт гэрлийн өнгө амьдралд нь гэрэл гэгээг авчирч болох тэрхүү настай нэгнийг хайж ол. Энэ нь их зүйлийг шаардахгүй, нэрээр нь дуудан тэдэнтэй мэндэл, товчхон яриа өрнүүл, туслахад бэлэн бай. Та нар хаалга нээн өгч эсвэл гэрийнх нь болон цэцэрлэгийн ажилд нь тусалж чадна биз дээ? Та нар шиг залуучуудад энгийн мэт санагдах үйлдэл нь настай хүмүүст дэндүү хүндэдсэн зүйл байж болно. “Санагтун. Би элэгсэг нэгэн баймаар байна”

Заримдаа нинжин сэтгэлийг гэр бүлдээ үзүүлэх нь хамгийн хэцүү байдаг. Хүчирхэг гэр бүлтэй байх нь хүчин чармайлтыг шаарддаг. “Баяр баясгалантай байж, бусдад туслан тэдэнд үйлчил. Гэр бүлийн гишүүд хувиа хичээсэн, эелдэг

бус зан гаргахад гэр бүлд эвдрэлцэл, асуудлууд үүсдэг. Гэр бүлийн бусад гишүүдийнхээ хэрэгцээ болон хүсэл эрмэлзэлд санаа тавьж бай. Бие биентэйгээ зодолдон, сөргөлдөж, бие биеэ гоочлохын оронд эв нэгдлийг эрхэмлэн дээдлэгч бай.” “Санагтун: Би элэгсэг нэгэн баймаар байна”

Есүс хүүхдүүдийг хайрладаг байсан. Тэр хүүхдүүдийг тэвэрч, тэднийг адисалсан.¹⁰³ Та нар Аврагчийн адил нинжин сэтгэлээрээ зөвхөн орон гэртээ байгаа тэднийг бус бүхий л хүүхдүүдийг адисалж чадна.

Амьдрал болон үлгэр жишээ тань бяцхан хүүхдүүдэд хэрхэн нөлөөлж байгааг та нар мэдэхгүй байж магад. Саяхан би нилээд хэдэн ХҮГ залуу эрэгтэй, залуу эмэгтэйчүүд явдаг орон нутгийн дунд сургууль дахь өдөр өнжүүлэх төвийн захирал нэг найзаасаа захиа хүлээн авсан юм. Тэрээр захидалдаа:

“Бяцхан хүүхдүүдийн хамт танхим дундуур алхах зуур хэчнээн олон шүүгээний дотор талын хаалганд Есүс болон ариун сүмийн зураг наасан байхыг харахад үнэхээр сайхан байлаа. Хэдэн долоо хоногийн өмнө нэг хүүхэд [залуу эмэгтэйн] онгорхой шүүгээний дотор талд байсан Есүсийн зургийг хараад “Хардаа, Есүс манай сургууль дээр байна!” гэлээ. Гэтэл нөгөө сурагчийн сэтгэл хөдөлж нүдэндээ нулимс цийлэгнүүлэн нөгөөх хүүхдийг тэвэрч авав. Эргэн тойрныхондоо сайн үлгэр жишээ болсон тэр залуу эмэгтэйд би талархсан. Хэдийгээр тэдний эргэн тойронд байгаа ертөнц чимээ шуугиантай, хүнд хэцүү ч гэсэн үнэн болон зөв шударгын төлөө бат зогсож, амьдралдаа Сүнснийг урихын тулд хийх ёстой зүйлсээ хийхээр хичээж буй маш олон залуус байгааг мэдэх нь үнэхээр сэтгэл хөдлөм зүйл юм. Манай Сүмийн залуучууд үнэхээр гайхалтай” гэсэн байлаа.

Би үүнтэй санал нэг байна! Залуу эмэгтэйчүүд ээ, *та нар* Есүс Христ дээр амьдралаа төвлөрүүлснээр дэлхийг өөрчилж, “Түүний хэн байгаасай гэж хүсэж байгаа”¹¹ тэр хүн нь болж чадна.

Та нарын нинжин сэтгэлээр дүүрэн амьдралд баярлалаа. Биднээс ялгаатай хүмүүс, үе тэнгийнхэн, настай хүмүүс, гэр бүлийнхэн болон бяцхан хүүхэд бүрд үзүүлж байгаа нинжин сэтгэлд тань талархъя. Сорилт бэрхшээл дунд зүдэрч, зүрх сэтгэл нь өвдөж, ганцаардаж яваа нэгэнд анд нөхөр нь болж байгаад тань талархъя. Та нар нинжин сэтгэлээрээ дамжуулан “Аврагчийн гэрэл өөд [бусдыг] чиглүүлж”¹² яваа билээ. “Элэгсэг байдал өрөөс тань эхэлдэг” гэдгийг санаж явдагт тань талархъя.

Ерөнхийлөгч Томас С.Монсон бол Бурханы бошиглогч бөгөөд түүний амьдрал бидний суралцах нинжин сэтгэлийн бодит жишээ байсаар ирснийг би мэднэ. Бошиглогчийг дагая. Түүний үлгэр жишээнээс суралцаж, түүний үгийг сонсоцгооё. Би Есүс Христийн сайн мэдээнд итгэдэг мөн Иосеф Смитээр дамжин дэлхий дээр санваарын эрх мэдэл дахин сэргээгдсэн гэдгийг мэднэ.

Аврагч маань амьд бөгөөд хүн бүрийг хайрладаг гэдгийг би мэднэ. Тэрээр Өөрийн амьдралыг бид бүгдийн төлөө өгсөн. Бид Есүс Христ дээр амьдралаа төвлөрүүлж, бие биеэ хайрлан, үйлчлэн “Түүний замаар замнахын” төлөө байгаасай хэмээн би залбирч байна.¹³ Ингэснээр бид дэлхийг илүү сайхан газар болгож чадна, учир нь “Бид нинжин сэтгэлтэй байхад итгэдэг.”¹⁴ Би энэ бүгдийг Есүс Христийн нэр дээр гэрчилж байна, амен.

Эшлэл

1. Итгэлийн Тунхаг 1:13-ыг үз.
2. *Oxford English Dictionary Online*, 2 дахь хэвлэл, (1989), “benevolent,” oed.com-ыг үз.
3. “Би элэгсэн нэгэн баймаар байна” хүүхдийн дууллыг үз.
4. “Guardians of Virtue,” *Strength of Youth Media 2011: We Believe* (DVD, 2010); мөн lds.org/youth/video/youth-theme-2011-we-believe-т байгаа..
5. Лук 10:25, 27, 29, 30, 33–35.
6. Jerry Earl Johnston, “The Unity in a Ward’s Uniqueness,” *Mormon Times*, 2011 оны 2-р сарын 9, M1, M12..
7. Томас С.Монсон, “May You Have Courage,” *Лиэхона*, 2009 оны 5-р сар, 125.

8. “Guardians of Virtue.”

9. *Залуучууын бат бөх байдлын төлөө*, (товхимолт, 2001), 10.

10. Mark 10:16-г үз.

11. “Guardians of Virtue.”

12. “Guardians of Virtue.”

13. “Guardians of Virtue.”

14. Итгэлийн Тунхаг 1:13.

Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий хуралдаан

2011 оны 3-р сарын 26

Ариун журмыг сахин хамгаалагчид

Элайн С.Далтон

Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий ерөнхийлөгч

Бид мэдэрч байгаа зүйлээ үгээр илэрхийлэх аргагүй тийм үе байдаг. Сүнс та бүхний зүрх сэтгэлд тэнгэрлэг зорилго, мөнхийн үүрэг хариуцлагыг тань гэрчлээсэй хэмээн би залбирч байна. Та нар Израилын найдвар билээ. Та бүхэн хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгийн сонгогдсон, язгууртан удамтай охид билээ.

Хорвоод мэндэлснээс нь эхлэн мэддэг нэгэн залуу эмэгтэйн ариун сүмийн хуримын ёслолд оролцох завшаан надад өнгөрсөн сард тохиосон юм. Би лацдан холболтын өрөөнд, ариун сүмийн гялалзсан гоёмсог гэрлийн бүрхүүлийг харж суухдаа

түүнийг нялх байхад нь анх тэвэрч байснаа саналаа. Тэр үед ээж нь түүнд цагаан дашинз өмсгөсөн байсан бөгөөд бяцхан охин миний харсан хамгийн хөөрхөн нялх хүүхдүүдийн нэг нь гэж би бодож билээ. Энэ удаа залуу эмэгтэй дахин цагаан дашинз өмсөж, ариун сүмийн хаалгаар орж ирлээ. Нүүр нь туяаран, баяртайгаар гэрэлтэнэ. Залуу эмэгтэй бүр ариун сүмийн эрхэм үнэ цэнэтэй гэрээнүүдийг хийж, түүнийгээ сахин, өргөмжлөлийн адислалуудад бэлтгэхийн төлөө хичээн чармайж, ариун сүмийн ёслолуудыг хийлгэдэг байгаасай гэсэн хүсэл түүнийг өрөөнд орж ирэх үед зүрх сэтгэлд минь төрж билээ.

Гэр бүлийн хос тахилын ариун ширээний дэргэд өвдөг сөгдөн, тэднийг мөнх бус амьдралын аянд нь адисалж, хүч чадал өгч, туслан дэмжих, мөнх бус хүмүүн ойлгохын аргагүй амлалтуудыг хүлээн авлаа. Энэ бол дэлхий анир чимээгүй дүнсийн, тэнгэрт баяр хөөр болсон нэгэн торгон агшин байв. Гэрлэсэн хос өрөөн дэх том толинууд уруу харах үед сүйт залуугаас юу харсныг нь асуухад, тэрбээр, “Надаас өмнө амьдарч байсан бүх өвөг дээдсээ харлаа” гэж хариулсан. Тэгээд гэр бүлийн хос нөгөө талын ханан дахь том толинууд уруу харахад сүйт бүсгүй нүдэндээ нулимс цийлэлзүүлэн, “Бидний дараа ирэх хойч үеийнхнээ би харж

байна” гэж билээ. Тэр ирээдүйн гэр бүлээ, хойч үеийн үр удмаа харсан аж. Залуу эмэгтэй ариун явдалтай, ариун журамтай байх нь хэчнээн чухал болохыг энэ агшинд дахин ухаарсныг би мэднэ. Ариун сүмийн тахилын ширээний дэргэд гэр бүлийн хос өвдөг сөгдөхөд зохих ёсоор бэлтгэгдсэнийг харахаас илүү сайхан зүйл гэж үгүй биз ээ.

Залуу Эмэгтэйчүүдийн бүлэгт хамрах он жилүүд чинь та нарыг ариун сүмд бэлтгэх болно. Бурханы хүндтэй охидын хувьд та нар Ариун сүмд адислалуудаа хүлээн авах болно. Тэнгэрлэг Эцэг тань та нарт хайртай, та нарыг аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Ийнхүү аз жаргалтай байх арга зам бол “ариун журмын замаар алхалж,”¹ “гэрээнүүд[ээ] итгэлтэйгээр сахих”² явдал мөн.

Ёс суртахууны доройтол хийгээд нүгэл хилэнцийг хүлээн зөвшөөрсөн, эмэгтэйчүүдийг мөлжиж, тэдний үүргийг мушгин гуйвуулах нь өсөн нэмэгдэж байгаа дэлхийд та нар өөрсдийгөө болон гэр бүлээ, түүнчлэн эргэн тойрныхоо бүх хүмүүсийг хамгаалах ёстой. Та бүхэн ариун журмыг сахин хамгаалагчид байх ёстой.

Ариун журам гэж юу вэ? Сахин хамгаалагч гэж хэн бэ? “Ариун журам гэдэг нь ёс суртахууны өндөр жишгүүд дээр суурилсан үзэл бодол, зан чанарын загвар мөн. Ариун журамд ариун явдал, цэвэр ариун ёс суртахуун орно.”³ Харин сахин хамгаалагч гэж хэн бэ? Сахин хамгаалагч гэдэг бол ямар нэг зүйлийг эсвэл хэн нэгнийг хамгаалж, өмөөрч өмгөөлдөг хүн юм.⁴ Тийнхүү, ариун журмыг хамгаалагч та нар бол цэвэр ариун ёс суртахууныг сахин хамгаалагчид мөн. Учир нь мөнх бус амьдралыг бүтээгч хүч нь ариун нандин, өргөмжлөлийн хүч бөгөөд та бүхэн гэрлэх хүртлээ энэхүү хүчийг эрхэмлэн хамгаалах ёстой. Ариун журамтай байхын тулд Ариун Сүнсний нөхөрлөл болон удирдамжтай байх шаардлагатай. Аж төрж буй дэлхийдээ зөв сонголтууд хийж, амьдралаа өнгөтэй өөдтэй авч явахад та нарт удирдамж хэрэгтэй. Ариун журамтай байх нь ариун сүмд орох шаардлага юм. Мөн Аврагчийн оршихуйд амьдрахаар зохистой байх шаардлага мөн. Та бүхэн тэр цагийн төлөө одоо бэлтгэж байна. Хувийн Хөгжил Дэвшил болон *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимол дахь жишгүүд маш чухал билээ. Эдгээр товхимол бүр дэх зарчмуудаар амьдарснаар та нар улам хүчирхэгжиж, “хаант улсад илүү тохирохуйц”⁵ болж чадна.

Өнгөрсөн зун Ютагийн Альпийн хэсэг залуу эмэгтэйчүүд “хаант улсад илүү тохирохуйц”⁶ болохоор шийджээ. Тэд анхдагч Жон Рөү Моил ахын адилаар Ютагийн Дрейпер Ариун сүмээс Солт Лейкийн Ариун сүм хүртэл 35 км газрыг явган туулж, ариун сүмд бодол санаагаа төвлөрүүлжээ. Моил ах бол Солт Лейкийн Ариун сүм дээр ажиллуулахаар бошиглогч Бригам Янгийн дуудсан чулуучин байв. Тэр гэрээсээ ариун сүм хүртэл долоо хоног бүр 35 км газрыг явган алхдаг байжээ. Түүний хийх ажлын нэг нь “Ариунаас ариуныг ИХ ЭЗЭНд” гэсэн үгсийг Солт Лейкийн Ариун сүмийн зүүн ханан дээр сийлэх явдал байжээ. Энэ нь амаргүй байсан бөгөөд тэрээр олон саад бэрхшээлийг даван туулсан юм. Нэг өдөр түүнийг үнээ нь тийрснээс хөл нь эдгэрэхгүйгээр бэртэж, тайруулахаас өөр аргагүй болсон ажээ. Гэвч энэ нь бошиглогчид өгсөн амлалтандаа болон ариун сүм дээрх ажилдаа чин үнэнч, тууштай байхад нь түүнд саад болоогүй юм. Тэрээр модон хөл хийж, олон долоо хоногийн дараа хариуцсан ажлаа үргэлжлүүлэхийн тулд ариун сүм тийш 35 км замыг дахин явган туулж эхэлсэн ажээ.

Сидар Хиллсийн зургадугаар тойргийн залуу эмэгтэйчүүд, ариун сүмд орохоор зохистой байхад нь тэдэнд сүнслэг нөлөө үзүүлсэн тэрхүү анхдагчийн ажилдаа очдог байсан зайг явган туулахаар шийдсэн гэнэ. Тэд явган явж байхдаа ариун сүмийн талаар сурч мэдсэн зүйлсээ болон бодол санаагаа хуваалцаж, долоо хоног бүр Мючелийг зохион байгуулдаг байжээ.

Тэд өглөө эрт залбираад ариун сүм уруу явган алхдаг байсан гэнэ. Тэднийг ийнхүү аялалдаа гарах болгонд би тэдний итгэлийг гайхан биширдэг байсан. Тэд сайн бэлтгэлтэй байж, ийнхүү бэлтгэгдсэнээ ч мэдэж байсан. Бас тавьсан зорилгодоо хүрэх итгэл төгс байлаа. Тэдний хийсэн алхам бүр нь одоо та нарын ариун сүмд орох бэлтгэлийн бэлгэдэл юм. Та нарын хувийн бэлтгэл өдөр бүрийн залбирал, Мормоны Номыг өдөр бүр унших болон Хувийн Хөгжил Дэвшил дээрээ ажиллахаас чинь эхэлнэ.

Залуу эмэгтэйчүүдийг явган аяллаа үргэлжлүүлэх замд нь саад гардаг байсан ч тэд зорилгоосоо ухарч няцаагүй. Заримынх нь хөл цэврүүтэж, бусдынх нь өвдөг шархиран өвдөж байсан ч явсаар байлаа. Та нарын ариун сүм уруу очих замд элдэв саад тотгор, бэрхшээл тохиолдлоо ч тууштай явсаар байх хэрэгтэй. Эдгээр залуу эмэгтэйчүүдийн туулсан замыг удирдагчид нь төлөвлөн хамгийн шулуун бөгөөд аюулгүй замыг өөрсдөө явган явж тогтоосон ажээ. Та нарын замыг Аврагч Өөрөө

явган явж тогтоосон төдийгүй, замын алхам бүрд Тэрбээр та нартай дахин хамт алхах болно гэдэгт итгэлтэй байгтун.

Ариун сүмд хүрэх энэхүү аялалд эцэг эх, гэр бүлийн гишүүд, санваартны удирдагчид нь тэднийг хамгаалан явж байсан. Тэдний үүрэг нь охидыг аюул ослоос хамгаалах явдал бөгөөд залуу эмэгтэй бүрийг хүч чадлаа тогтмол сэлбэж байх хангалттай ус, хоол тэжээлээр хангах байлаа. Амарч, үдлэн, амны цангаагаа гаргах газруудад санваартны удирдагчид нь тэдэнд анхан шатны тусламж үзүүлсэн. Залуу эмэгтэйчүүд ээ, та нарын аав ээжүүд, бишоп болон бусад олон хүн ариун сүмд хүрэх замд та нарын хамгаалагчид байх болно. Тэд та нарт анхааруулга, удирдамж чиглэл өгч, хэрэв гэмтэж бэртвэл туслах болно.

Аяллынх нь эцсийн шатанд эдгээр шийдвэр төгс залуу эмэгтэйчүүдийг дэмжиж, урам зориг оруулахаар тэдний ах нар болон залуу эрэгтэйчүүд, найз нар нь хүрэлцэн ирсэнд миний сэтгэл их хөдөлж билээ. Хөлд нь олон том цэврүү гарсан нэгэн эмэгтэйг ах нь ариун сүмд хүрэх сүүлчийн зайд нь үүрч хүргэсэн билээ. Эдгээр гайхалтай залуу эмэгтэйчүүд зорилгоо биелүүлж, ариун сүм уруу очиж, ариун чулуун дээр гараа тавьж, ариун сүмд орохоор үргэлж зохистой байхаар сэтгэл зүрхэндээ шийдсэн тэрхэн агшинд нулимс минь урсаж байлаа.

Эдгээр залуу эмэгтэйчүүд ариун сүм уруу явган явж ирснийг та нарын амьдралтай зүйрлэж болно. Эцэг эхчүүд болон санваартны удирдагчид нь замын турш харуулд гарч хамгаалагчид болон тусалж дэмжлэгийг үзүүлсэн билээ. Залуу эмэгтэйчүүд бие биеэ хамгаалж, урамшуулан дэмжсэн. Залуу эрэгтэйчүүд ч залуу эмэгтэйчүүдийн хүч чадал, шийдвэр төгс байдлаар бахархсан. Ах нар бэртсэн эгч, дүүсээ үүрч явсан юм. Охид нь ариун сүм уруу хийсэн явган аяллаа амжилттай дуусгаж, гэртээ эсэн мэнд эргэж ирсэнд гэр бүлүүд нь баярлаж байлаа.

Ариун сүмд хүрэх зам дээр байхын тулд та нар өөрсдийнхөө болон эргэн тойрныхоо хүмүүсийн ариун журмыг хамгаалах ёстой. Яагаад тэр вэ? Мормон ариун журам болон ариун явдлыг “бүхнээс илүү хамгийн эрхэм мөн үнэтэй”⁷ зүйл хэмээн Мормоны Номонд заасан байдаг.

Ариун журмыг хамгаалагчид байхын тулд та нар юу хийж болох вэ? Энэ нь чи өөрчлөлт хийж чадна гэдэгт итгэж, үүрэг амлалт авахаас эхэлдэг. Би залуу эмэгтэй байхдаа зарим шийдвэрийг амьдралд зөвхөн ганцхан удаа л гаргадгийг ойлгосон.

Байнга хийж байх ёстой бас *огт* хийж болохгүй зүйлсийн жагсаалтыг би жижигхэн тэмдэглэлийн дэвтэрт бичсэн. Уг жагсаалтанд Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагах, өдөр бүр залбирч байх, аравны нэгээ төлөх, сүмийн цуглаан, үйл ажиллагаануудыг хэзээ ч таслахгүй байх зэрэг орсон байлаа. Би нэгэнт шийдвэрээ гаргасан болохоор дараа нь ямар нэг шийдвэр гаргах хэрэгтэй үед юу хийхээ урьдчилан шийдсэн учир арга замаа тодорхой мэддэг байв. Ахлах сургуулийн найз маань “Ердөө ганцхан удаа жаахан балгачихад муу юм юу ч болохгүй” гэхэд би инээгээд “Арванхоёртой байхдаа би архи огт уухгүй байхаар шийдсэн юм” гэж хариулж билээ. Урьдчилан шийдвэр гаргах нь ариун журмыг хамгаалагч байхад тань туслах болно. Та нар өөрсдийнхөө *байнга* хийх ёстой бас *огт* хийх ёсгүй зүйлсийн жагсаалт гаргаж, чанд мөрдөнө гэдэгт би итгэлтэй байна. Тэгээд тэдгээр гаргасан жагсаалтынхаа дагуу амьдраарай.

Ариун журмыг сахин хамгаалагч байна гэдэг нь хувцаслалт, үг яриа, үйл хэрэг, мэдээллийн хэрэгслийг ашигладаг байдлаараа үргэлж даруу төлөв байна гэсэн үг юм. Ариун журмыг сахин хамгаалагч байна гэдэг нь залуу эрэгтэйчүүдийг Сүнснээс холдуулж, санваарын хүч болон ариун журмыг алдагдуулах үг яриа, байдлыг хэзээ ч гаргахгүй байхыг хэлдэг. Та нарын бие бол ариун сүм бөгөөд нөхөн үржихүйн ариун хүчийг гэрлэхээс өмнө хөндөхгүй байхын ач холбогдол болон энэ нь хэчнээн чухал болохыг ойлгосноор ариун журмыг сахин хамгаалагч байж чадна. Мөнхийн сүнснүүдийг бие махбодтой болгож дэлхийд авчрах ариун үүрэгтэйгээ та бүхэн ойлгож байгаа. Энэхүү ариун хүчинд өөр нэгэн ариун бодгаль оршдог. Та нар бол “эрдэнэсээс ч илүү нандин”⁸ зүйлийг хамгаалагчид юм. Итгэлтэй бай. Дуулгавартай бай. Их Эзэний ариун сүмд орсноор хүлээн авдаг бүх адислалуудыг хүртэхэд зохистой байхын тулд одооноос бэлтгэгтүн.

Энэ үдэш бидний үгийг сонсож байгаа эхчүүд та нар бол даруу зан, ариун журмаараа охиддоо хамгийн чухал үлгэр дууриал үзүүлэгчид мөн. Та нартаа их баярлалаа. Охид чинь Бурханы хаан язгуурт охид бөгөөд тэдний эрхэмлэх зүйлс хэзээ ч бие махбодын таашаал дээр суурилах ёсгүй гэдгийг тэдэнд сурган заахдаа огтхон ч бүү эргэлз. Та нарын итгэл бишрэл, зан харьцаа, төрх байдлыг охид чинь үлгэр дууриал болгон үргэлж дагах боломжийг тэдэнд олго.⁹ Та нар бас ариун журмыг сахин хамгаалагчид билээ.

Энэ долоо хоногт би Ensign Оргилд дахин авирлаа. Өглөө эрт Их Эзэний Өргөөний уул болох Солт Лейкийн Ариун сүм уруу доош харахад болор лугаа адил тунгалаг өнгөтэй харагдаж байлаа. Анхдагчид уулсын оргил дээр гарахын тулд бүхнээ зориулсан учраас бид ариун сүмийн адислалуудыг хүртэж, мөнхийн гэр бүл болон лацдан холбуулж байгаа билээ. Юуны учир дөчин жилийн золиослол, нарийн чимхлүүр ажлыг хийсэн юм бол? Юуны учир бүр Альпийн нуруунаас ариун сүм уруу явган аялал хийсэн юм бол? Учир нь тэд та нарын нэгэн адил итгэлээр жигүүрлэсэн юм! Тэд бошиглогчид итгэсэн. Тэрбээр Бурхан болон Түүний хайртай Хүүтэй ярилцсанд итгэсэн. Тэд Аврагчид болон Мормоны Номонд итгэсэн юм. Чухам тиймээс тэд “бид бүх зүйлд итгэдэг, бид бүх зүйлд найддаг, бид олон зүйлийг хүлцэн тэвчлээ, мөн бүх зүйлийг тэвчих болно гэдэгт найддаг”¹⁰ хэмээн хэлсэн билээ. Тэд олон зүйлийг хүлцэн тэвчсэн болохоор бид ч бас тэвчиж чадна. Итгэлийн арван гурав дахь тунхагт өгүүлсэн зүйлс бол ариун сүмд ороход болон нэгэн цагт Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд амьдрахаар зохистой байхад биднийг тэнцэхээр болгодог, цэвэр ариун бөгөөд ариун сүмд лацдан холбуулсан байхыг биднээс шаарддаг зүйлс гэдэгт бид итгэдэг. Энэ нь “хаант улсад илүү тэнцэхээр”¹¹ байхыг мөн хэцүү зүйлсийг хийж чадах итгэлийг өөрсөддөө төлөвшүүлэхийн тулд одооноос бэлтгэхийг биднээс шаардах болно.

Залуу эмэгтэйчүүд та нар агуу ажилд гар бие оролцож байна! Та нар ганцаараа биш ээ! Та нар ариун журам, цэвэр ариун байдлаа хамгаалсан цагт хүч чадал та нарт өгөгдөх болно. Хийсэн гэрээнүүдээ сахьсан үед Ариун Сүнс та нарыг удирдаж, хамгаалах болно. Үй олон тэнгэр элч та нарыг тойрон хүрээлэх болно. “Амьдралын энэхүү агуу буухианд бид ганцаархнаа гүйдэггүйг санагтун. Бид бол Их Эзэний тусламжийг авах эрхтэй хүмүүс”¹² хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон сануулсан билээ. Их Эзэний ариун сүмд зохистойгоор орж, ариун гэрээнүүд хийх тэр өдөрт бэлтгэгтүн. Та нар ариун журмыг сахин хамгаалагчдын хувьд Түүний ариун өргөөнд Аврагчийг *эрэлхийлэхийг* хүсэх болно.

Бурхан амьд бөгөөд Түүний хайртай Хүү, бидний Гэтэлгэгч, Есүс Христ хязгааргүй Цагаатгалынхаа хүчээр амьд гэдгийг би гэрчилж байна. Та бүгд ариун сүм хүрэх замдаа болон Эцэг, Хүү хоёр дээр эргэж очих аяндаа удирдагдан, хамгаалагдах болно. Аз жаргалын дээдийг хайрладаг энэ ажлын төлөө бас та нарыг хүч чадалтай байхын төлөө би залбирч байна. ¹³ Илчлэлтийн номонд өгүүлсэнчлэн “[Та нар] зохистой [учраас] цагаан хувцастай . . . алхлах,” тэрхүү сайхан өдрийн төлөө амьдрагтун, Есүс Христийн нэрээр, амен.

|cNotes

|v0

Эшлэл

1. Сургаал ба Гэрээ 25:2.

2. Сургаал ба Гэрээ 25:13.

3. Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн хөгжил дэвшил (товхимол, 2009), 70.

4. <http://www.thefreedictionary.com/guardian-ыг> үз.

5. “More Holiness Give Me,” *Hymns*, no. 131.

6. Диетер Ф.Угдорф, “Зогсож байгаа газраасаа өргө,” *Лиахона*, 2008 оны 11-р сар, 55.

7. Моронай 9:9.

8. Сургаалт Үгс 3:15.

9. М.Рассел Баллард, “Mothers and Daughters,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 18--21-ийг үз.

10. Итгэлийн Тунхаг 1:13.

11. Томас С.Монсон, “Great Expectations” (Сүмийн Боловсролын Системийн залуу насанд хүрэгчдэд зориулсан галын дэргэдэх ярилцлага, 2009 оны 1-р сарын 11), <http://lds.org/library/display/0,4945,538-1-4773-1,00.html>.

12. Илчлэлт 3:4.

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий хуралдаан

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий хуралдаан

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий хуралдаан

2011 оны 3-р сарын 26

Амьд гэрчлэл

гэрчлэл

залбирал

итгэл

Залуу Эмэгтэйчүүд

мөнх амьдрал

дуулгавартай байдал

ерөнхий чуулган

Амьд гэрчлэл

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх

Гэрчлэл нь итгэлийн залбирал, судрууд дахь Бурханы үгээр өлсөж цангахыг болон үнэнд дуулгавартай байхыг шаарддаг.

Эрхэм хүндэт залуу эгч нар аа, та нар Их Эзэний Сүмийн гэрэлт итгэл найдвар билээ. Өнөө оройн хувьд үүнд итгэх итгэлд тань туслах нь миний зорилго юм.

Хэрэв ийм итгэл нь Бурханаас ирсэн гүнзгий гэрчлэл болж чадах юм бол та бүхний

сонголтуудыг өдөр бүр, цаг тутам чиглүүлж байх болно. Та нарын өчүүхэн гэж боддог сонголтуудаар Их Эзэн та нарын хүсдэг аз жаргал уруу тань удирдах болно. Тэрбээр та нарын сонголтуудаар дамжуулан тоо томшгүй олон хүнийг адислах боломжтой юм.

Өнөө орой та нар энд хүрэлцэн ирсэн нь чухал ач холбогдолтой сонголтын жишээ юм. Энэ цуглаанд сая гаруй залуу эмэгтэй, тэдний ээж болон удирдагч нар уригдсан байгаа. Та нар олон сонголтоос энд бидэнтэй хамт байхыг илүүд үзэж сонгожээ. Та бүхэн итгэлийнхээ улмаас ийнхүү сонгосон байна.

Та нар бол Есүс Христийн сайн мэдээнд итгэгчид. Та нар энд Түүний үйлчлэгчдийн үгсийг сонссоноор амьдралаа улам сайжруулахад тус нэмэртэй ямар нэг зүйлийг мэдэж авна гэсэн итгэлийг өвөрлөн ирсэн нь мэдээж билээ. Есүс Христийг дагах нь агуу аз жаргалд хүрэх зам мөн гэдгийг та нар зүрх сэтгэлээрээ мэдэрсэн байгаа.

Та нар онцгой чухал сонголт хийснээ сайн ухаараагүй байж мэднэ. Зарим нь найз нөхөдтэйгөө эсвэл гэрийнхэнтэйгээ хамт байхаар ирсэн байж болох юм. Нэг хэсэг нь хэн нэгний эелдэг урилгыг аваад ирсэн байх. Харин та нар үүнийг ажиглаагүй байж мэдэх ч “Ирж, Намайг дага”¹ гэсэн Аврагчийн урилгын намуухан цуурайг мэдэрсэн байгаа.

Та биднийг хамт байгаа үед Их Эзэн Түүнд итгэх итгэлийг зүрх сэтгэлд минь гүнзгийрүүлж, гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг билээ. Та нар зүгээр нэг үгсийг сонсож, ердийн нэг хөгжмийг сонсож байгаа юм биш шүү. Дэлхий дээр Их Эзэний үнэн Сүмд амьд бошиглогчид байдаг бөгөөд аз жаргалд хүрэх зам Түүний хаант улсад бий гэсэн Сүнсний гэрчлэлийг та нар зүрх сэтгэлээрээ мэдэрсэн байгаа. Энэ Сүм бол өнөөдөр дэлхий дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд Сүм гэдэг гэрчлэл тань өсөн нэмэгдсэн байгаа.

Бид бүгдээрээ яг адилхан зүйлийг мэдрээгүй. Энэ нь зарим хүмүүст Томас С.Монсон бол Бурханы бошиглогч гэсэн Сүнсний гэрчлэлийг үлдээсэн бол зарим хүмүүст шударга зан чанар, ариун журам, бүх хүнд сайныг үйлдэх нь Аврагчийн зан төлөвийн шинж гэсэн гэрчлэлийг үлдээсэн байгаа. Чухам ийм гэрчлэлтэй байсан цагт Түүнтэй адилхан байх хүсэл улам их төрдөг.

Есүс Христийн тухай гэрчлэл бэхжин бат бөх байгаасай гэсэн хүсэл та нарт бүгдэд нь байдаг. Ерөнхийлөгч Бригам Янг та нарын энэхүү хэрэгцээг олон жилийн өмнө угтан харж чадсан юм. Тэрбээр 142 жилийн тэртээ бошиглолын зөн билэг бүхий, Бурханы бошиглогч байлаа. Тэрбээр та нарыг болон та нарын хэрэгцээг харж чадсан бөгөөд тэрээр энэрэлт эцэг, амьд бошиглогч байлаа.

Тэрбээр охидод нь нөлөөлсөн дэлхийн нөлөөг олж харсан бөгөөд тэднийг аз жаргалд хүрэх Их Эзэний замаас холдуулах дэлхийн нөлөөнд автаж байгааг ч харсан ажээ. Түүний үед эдгээр нөлөө нь дэлхийгээс тусгаарлагдаж, хамгаалагдсан Гэгээнтнүүдэд эх газрын хоёр эргийг холбосон шинэ төмөр замаар заримдаа хүрч ирдэг байлаа.

Тэрбээр өнөөдөр та нарын гартаа барьж байгаа дэлхий даяарх үй олон хүнтэй холбогдон, санаа бодлоо солилцож болох технологийн гайхамшигт хэрэгслийг угтан хараагүй байж болно. Гэвч амьд бөгөөд хайр ивээлээр дүүрэн Бурхан болон Түүний аз жаргалын төлөвлөгөөний тухай бат бөх гэрчлэлээр хийдэг түүний охидын бас та нарын сонголтуудын үнэ цэнийг олж харсан юм.

Охиддоо болон та нарт өгсөн түүний бошиглолын сүнслэг нөлөө бүхий зөвлөгөөг авч үзье.

Энэ нь өнөө орой та нарт өгөх миний захиасын гол сэдэв юм. Тэрбээр уг захиасаа дэлхий даяарх Бурханы охидод чуулган болж буй энэ газраас ердөө ганцхан километр зайтай байсан гэрээсээ хэлэхдээ: “Үнэний тухай амьд гэрчлэлтэй болох тулгамдсан хэрэгцээ Израилын залуу охидод бий”² гэжээ.

Тэгээд тэрбээр эдүгээ Их Эзэний Сүмд бидний нэрлэдгээр “Залуу Эмэгтэйчүүд” гэдэг байгууллагыг бий болгосон юм. Нэгэн ням гарагийн орой гэрийнхээ амралтын өрөөндөө түүний хийсэн сонголтын гайхамшигт үр нөлөөг та нар өнөө орой энд мэдэрч байгаа.

Дэлхий даяарх Израилын охид 100 гаруй жилийн дараа үнэний тухай амьд гэрчлэлтэй болох хүслээр дүүрэн байна. Та нарыг эдүгээ болон амьдралын тань турш хүчирхэгжүүлж, мөнх амьдралд хүрэх замыг тань удирдах амьд бөгөөд үргэлж өсөн дэвжих гэрчлэл та нарт хэрэгтэй. Та нар ийм гэрчлэлтэйгээр Христийн Гэрлийг үеэс үед дэлхий даяарх ах, эгч нар дээрээ тусгаж чадна.

Гэрчлэл гэж юу болохыг та нар хувийн туршлагаасаа мэднэ. “Гэрчлэл бол үнэнийг даруухнаар эрэлхийлдэг хүнд илчлэлтээр өгөгддөг итгүүлэн үнэмшүүлэгч мэдлэг юм” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заажээ. Тэрбээр илчлэлтийг авчирдаг гэрчлэл болон Ариун Сүнсний тухай: “Энэ бол Сүнс ярьсан үед оюун ухаанд аливаа эргэлзээ үлддэггүй тийм агуу итгүүлэн үнэмшүүлэгч хүч мөн. Энэ бол Есүс бол Христ, түүний сайн мэдээ үнэн гэдгийг мэдэх цорын ганц арга зам мөн”³ гэжээ.

Энэхүү сүнсний удирдамжийг та нар өөрсдөө мэдэрсэн байгаа. Энэ нь сайн мэдээний нэгэн хэсгийг өнөө орой надад баталж өгсөн шиг та нарт ч мөн адил баталсан байх. Би Итгэлийн Тунхагийн 13-т гардаг “шударга, үнэнч, ариун явдалтай, энэрэлтэй” байх тухай үгсийг сонсох бүрдээ эдгээр үгсийг Их Эзэн надад болон тэдгээр залуу эмэгтэйчүүдэд хандан хэлж буй Түүний зан чанар болохыг дахин мэдэрдэг. Иосеф Смит Түүний бошиглогч байсныг би мэдэрсэн. Иймээс дээрх үгс миний хувьд зүгээр нэг ердийн үгс биш юм.

v32

Би оюун бодолдоо Иудейн тоост замууд болон Гетсеманий Цэцэрлэгийг харсан. Нью-Йоркт байдаг ойн цоорхойд Иосеф өвдөг сөгдөн залбирахдаа, Эцэг Хүү хоёрын өмнө ямар байдалтай байсныг би зүрх сэтгэлээрээ мэдэрсэн. Үд дундын нарнаас илүү хурц тэр гэрлийг би оюуны мэлмийгээрээ харж чадаагүй ч, элгэн халуун гэрчлэлийн гайхамшгийг мэдэрсэн билээ.

Гэрчлэл нь Есүс Христийн сайн мэдээний бүрэн дүүрэн үнэний хэсгүүд болон та нарт ирж, батлагдах болно. Жишээ нь, Мормоны Номыг уншиж, тунгаан бодоход өмнө нь уншсан шүлгүүд чинь та нарт шинэ санаа, ойлголтуудыг авчрах болно. Тэдгээр санаа, ойлголтууд үнэн гэдгийг Ариун Сүнс батлах үед гэрчлэл чинь улам гүнзгийрэн батлагдан, суралцаж, залбиран, судруудыг тунгаан бодсоноор амьд гэрчлэл тань өсөн хөгжих болно.

Хэрхэн амьд гэрчлэлтэй болж, түүнтэй хэрхэн хамт байхыг өмнө нь дурдсан билээ. Үүнийг Мормоны Номон дахь Алмагийн 32-р бүлэгт хамгийн сайнаар дүрсэлсэн байдаг. Та нар энэ бүлгийг магадгүй олон дахин уншсан байх л даа. Би энэ бүлгийг унших бүрдээ шинэ гэрлийг олж хардаг. Энэ бүлгийн заадаг сургамжийг өнөө орой дахин нэг эргэж харцгаая.

Итгэлийн төлөөх эрэл хайгуулаа “итгэлийн жижиг хэсгүүд” болон үүнийг өсгөн нэмэгдүүлэх хүслээр эхлэхийг сүнслэг нөлөө бүхий хэсгүүд бидэнд заадаг⁴. Өнөө орой та нар Аврагчийн нинжин сэтгэл, шударга зан чанар, Түүний зарлигууд болон Цагаатгалаар бидэнд боломжтой болсон цэвэр ариун байдлын тухай сэтгэл догдлом үгсийг сонсоод итгэл, хүсэл эрмэлзлийг мэдэрсэн байгаа.

Иймээс итгэлийн үр та нарын зүрх сэтгэлд аль хэдийн суулгагдсан. Мөн Алмад амлагдсан итгэлийн өсөлтийг та нар зүрх сэтгэлээрээ мэдэрсэн биз ээ. Би үүнийг мэдэрсэн.

Гэвч итгэл чинь ургаж байгаа ургамал шиг тэжээгдэж байх ёстой эс бөгөөс хатаж хорчийх болно. Итгэлээр өдөөгдсөн чин сэтгэлийн тогтмол залбирал бол шийдвэрлэх ач холбогдолтой амин чухал тэжээл мөн. Хүлээн авсан үнэндээ дуулгавартай байх нь гэрчлэлийг амьд байлгаж, улам бат бөх болгоно. Зарлигуудад дуулгавартай байх нь гэрчлэлийг тань өсгөн хөгжүүлэх тэжээлийн чухал хэсэг мөн.

Аврагчийн дараах амлалтыг та нар санаж байгаа:

“Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал, тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү эсвэл Би өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ.”⁵

Энэ нь надад тохиолдсон бас та нарт ч тохиолдох болно. Миний багадаа заалгасан сайн мэдээний сургаалуудын нэг нь Бурханы бэлгүүдээс хамгийн агуу нь мөнх амьдрал гэсэн сургаал байлаа.⁶ Мөнх амьдралын нэг хэсэг нь гэр бүлүүд хайраар хамтдаа мөнхөд амьдрах явдал мөн гэдгийг би мэдсэн юм.

Эдгээр үнэнүүдийг анх сонссон цагаас хойш эдгээр нь зүрх сэтгэлд минь гүн шингэж, сонголт бүрдээ гэр бүл дотроо зөрчил сөргөлдөөнөөс зайлсхийж, амар амгаланг тогтоохын төлөө үүрэг хүлээх ёстойг мэдэрдэг болсон билээ.

Бүх адислалуудаас хамгийн агуу нь болох мөнх амьдралыг би зөвхөн энэ амьдралын дараа олж авч чадна. Гэвч энэ амьдралын сорилтууд дунд тэнгэр дэх гэр бүлийнхээ тухай зэрвэсхэн төсөөлөн харах боломж надад бий. Ариун сүмүүдэд хийдэг лацдалтын хүчний үнэн бодит байдлаар миний гэрчлэл улам өсч бэхэжсээр байна.

Хоёр охиноо ариун сүмд өвөг дээдсийнхээ өмнөөс баптисм хийлгэхийг хараад миний зүрх сэтгэл охиддоо болон нэрсийг нь тодруулсан өвөг дээдэстээ улам ойртон дотносож билээ. Гэр бүлийн гишүүдийн зүрх сэтгэл бие бие уруугаа эргэх тухай Елиагийн амлалт бидэнд өгөгдсөн юм⁷. Тиймээс Алмагийн номонд бидэнд амлагдсанчлан, итгэл нь миний хувьд тодорхой мэдлэг болсон юм.

Аврагч мөнх бус үйлчлэлийнхээ дараа сүнсний ертөнцөд хүрч очиход миний өвөг дээдэст тохиосон тэрхүү баяр хөөрийг би бага зэрэг ч гэсэн мэдэрсэн юм. Уг үйл явдлыг Сургаал ба Гэрээнд ийн дүрсэлжээ:

“Мөн гэгээнтнүүд гэтэлгэлдээ баясан, мөн Бурханы Хүүг өөрсдийнхөө гэтэлгэгч, мөн үхлээс хийгээд тамын гинжнээс Чөлөөлөгч хэмээн өвдөг сөгдөж, хүлээн зөвшөөрч байлаа.

Тэдний төрх байдал гялалзан мөн Их Эзэний оршихуйн хурц тод нь тэдэн дээр байлаа, мөн тэд түүний ариун нэрэнд магтуу дуулж байв.”⁸

Мөнх амьдралын тухай Их Эзэний амлалт үнэн бодитойг гэрчлэлийнхээ дагуу үйлдсэнээр өвөг дээдсийнхээ баяр хөөрийг би мэдэрсэн юм. Энэхүү гэрчлэл нь Аврагчийн амлалт биелэгдэх болно гэсэн итгэлээр үйлдэхийг сонгосноор улам хүчирхэгжин бэхэжсэн билээ.

Бид дуулгавартай байхаар сонгохоос гадна үнэний тухай гэрчлэлийг залбирлаар хүсэх ёстойг Тэрбээр бидэнд бас заасан юм. Их Эзэн Мормоны Номын талаар залбирч үзэх тухай зарлигтаа үүнийг бидэнд заасан билээ. Тэрбээр бошиглогч Моронайгаар дамжуулан айлдсан нь:

“Болгоогтун, та нар эдгээр зүйлийг уншихдаа хэрэв та нар тэдгээрийг унших нь Бурханы мэргэн ухаанд нийцэх аваас, Адам бүтээгдсэнээс бүр та нар эдгээр зүйлийг хүлээн авах тэр цагийг хүртэл Их Эзэн хүмүүний үрсэд хэчнээн нигүүлсэнгүй байсаар буйг та нар санан мөн үүнийг зүрх сэтгэлдээ тунгаахыг та нарт ухуулья би.

Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулья би, мөн

хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас Тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно.

Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно.”⁹

Та бүхэн энэхүү амлалтыг нотолсон байгаа эсвэл удахгүй нотлох болно гэдэгт би итгэлтэй байна. Хариулт нь ганц удаагийн хүчтэй сүнслэг туршлагаар ирэхгүй. Эхний удаа хариулт минь нам гүмхэн ирсэн. Харин Мормоны Номыг уншиж, залбирах бүрд улам илүү хүчтэйгээр мэдрэгдэх болсон билээ.

Би өнгөрсөн үйл явдлуудад найдаж амьдардаггүй. Би Мормоны Номын тухай амьд гэрчлэлээ байнга бат бөх байлгаж, бэхжүүлэхийн тулд Моронайн амлалтыг олонтаа хүлээн авдаг. Гэрчлэлээс ирдэг адислал бол байнгын эрх мэт дархлагдсан зүйл гэж би боддоггүй.

Гэрчлэл нь итгэлийн залбирлаар, судрууд дахь Бурханы үгээр цангах явдлаар түүнчлэн бидний хүлээн авсан үнэнд дуулгавартай байх үйлдлээр тэжээгдэн тэтгэгдэж байх ёстой. Залбирлыг үл тоомсорлох нь аюултай юм. Судруудыг судлах болон уншихад хайхрамжгүй хандах нь гэрчлэлд аюул учруулна. Залбирал болон судар судлах нь бидний гэрчлэлийн чухал тэжээл юм.

Алмагийн хэлсэн сэрэмжлүүлгийг та нар санаж байгаа:

“Гэвч хэрэв та нар уг модонд хайнга хандаж, мөн үүний арчилгааны талаар эс бодвоос, болгоогтун, энэ нь үндэслэхгүй байх болно; мөн нарны илч тусаж, мөн түүнийг шарж төөнөхөд, үндэсгүйн учир хатан хувхайрч, мөн та нар үүнийг сугалж, тэгээд үүнийг хаях болно.

Эдүгээ, энэ нь сайн үр бус эсвээс үүний жимс нь дур булаам бус байснаас болсон юм биш; харин энэ нь газрын чинь үржил шимгүйнх мөн та нар модыг арчлаагүйнх юм, тиймийн тул та нар үүний жимсийг авч чадахгүй.”¹⁰

Бурханы үгээр найрлах болон чин сэтгэлийн залбирал, Их Эзэний зарлигуудад дуулгавартай байснаар та нарын гэрчлэл байнга өсч хөгжин, бэхжих болно. Судар судлах тогтсон хэвшлийг тасалдуулах үе заримдаа бидэнд тохиолддог. Заримдаа

залбирахгүй байх шалтаг ч бидэнд тохиолдож мэднэ. Зарлигуудыг түр хугацаагаар сахихгүй байх үе ч бас тохиолдож мэдэх юм.

Хэрэв та нар Алма дахь дараах сэрэмжлүүлэг болон амлалтыг мартвал амьд гэрчлэлтэй болох хүсэл эрмэлзэл бий болохгүй:

“Мөн тийн, хэрэв үүний жимсийг итгэлийн нүдээр хүсэн хүлээж, та нар үгийг арчлахгүй аваас та нар хэзээ ч амьдралын модны жимснээс түүж чадахгүй.

Гэвч хэрэв та нар үгийг арчилбал, тийм ээ, үүнийг ургаж эхлэхэд модыг арчилж, өөрийн агуу шаргуу итгэл хийгээд тэвчээрээр үүнийг хүсэн хүлээх аваас энэ нь үндэслэх болно; мөн болгоогтун энэ нь үүрдийн амьдралд хүргэх мод байх болно.

Мөн энэ нь та нарын дотор үндэслэж болохын тулд та нар үгийг арчлахдаа зориулсан шаргуу байдал хийгээд та нарын итгэл, түүнчлэн та нарын тэвчээрийн учир, болгоогтун, удахгүй та нар үүний жимсийг, хамгийн эрхэм, амтат бүхнээс дээд амтат, мөн цагаан бүхнээс цагаан түүнийг тийм ээ, цэвэр бүхнээс цэвэр түүнийг түүх болно мөн та нар цадталаа, та нар өлсөхгүй бас цангахгүй болтлоо энэ жимсэн дээр найрлах болно.

Тэгээд ... уг мод та нар жимс өгөхийг хүлээж байх зуур гаргасан итгэлийнхээ мөн мөн шаргуу байдлынхаа мөн тэвчээрийнхээ мөн тэсвэрийнхээ шагналыг та нар хадаж авах болно.”¹¹

“Үүний жимсийг хүсэн хүлээ” гэсэн судрын үгсээр өнөө орой та нарын хүлээн авах мэргэн сургаал удирдагдсан болно. Ийм учраас та нарын анхаарал ариун сүмийн лацдан холболтын өрөөнд болох ирээдүйн тэр нэгэн өдөр дээр төвлөрсөн байгаа. Чухам иймээс Бурханы ариун сүмд та нарын гэрлэх лацдан холболтын өрөөнүүд дэх толинууд дээр харагддаг төгсгөлгүй гинжин хэлхээг харуулахад та нарт өнөө орой тусалсан билээ.

Хэрэв та нар гэрчлэлийнхээ дагуу хүсэл эрмэлзэлтэйгээр тэр өдрийг хүсэн хүлээвэл дэлхийн уруу таталтуудыг эсэргүүцэх хүч чадалтай байх болно. Аврагчтай илүү адилхан амьдрахаар хичээхийг сонгох бүрд гэрчлэл чинь улам бэхжих болно. Тэр бол Дэлхийн Гэрэл мөн гэдгийг та нар өөрсдөө мэдрэх цаг ирэх болно.

Амьдралд тань энэ гэрэл улам өсөн нэмэгдэхийг та нар мэдрэх болно. Энэхүү гэрэл хүч чармайлтгүйгээр ирдэггүй. Харин энэ нь гэрчлэл чинь өсч хөгжихийн хэрээр гэрчлэлээ арчилж тордохын хэрээр энэ гэрэл ирэх болно. Сургаал ба Гэрээнээс нэг амлалтыг энд дурдъя:

“Бурханаас буй тэр нь гэрэл болой; мөн гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг.”¹²

Та нар гэрчлэлээ бусадтай хуваалцсанаар дэлхийд гэрэл болж амьдралдаа буй Христийн Гэрлийг бусдад тусгаж чадна. Энэхүү гэрэл таны хайртай хүмүүст нөлөөлөх арга замуудыг Их Эзэн олох болно. Бурхан Өөрийн охидын нэгдмэл итгэл, гэрчлэлээр дамжуулан Өөрийн гэрлээр хаант улсынхаа сая сая хүний амьдралд болон дэлхийд нөлөөлөх болно.

Та нарын гэрчлэл болон сонголтуудад “Ирж, Намайг дага” гэсэн Их Эзэний урилгыг сонсож, хүлээн авах талаар Сүмийн болон та нарын үлгэр жишээг дагах хойч үеийнхний итгэл найдвар оршдог билээ. Их Эзэн та нарыг таньдаг, та нарыг хайрладаг.

Хайр болон гэрчлэлээ би та нарт үлдээе. Та нар бол Тэнгэр дэх энэрэл хайраар дүүрэн, амьд Эцэгийн охид билээ. Түүний амилсан Хүү, Есүс Христ бол дэлхийн Аврагч бөгөөд Гэрэл гэдгийг би мэднэ. Ариун Сүнс өнөө орой та нарын зүрх сэтгэлд үнэнийг нотлохоор захиас илгээснийг би гэрчилж байна. Ерөнхийлөгч Томас С.Монсон бол Бурханы амьд бошиглогч. Үүнийг би Есүс Христийн ариун нэрээр гэрчилж байна, амен.

Эшлэл

1.

Лук 18:22.

2.

Brigham Young, in *A Century of Sisterhood: Chronological Collage, 1869–1969* (1969),

8.

3.

Жозеф Фиелдинг Смит, *Answers to Gospel Questions*, Бага Жозеф Фиелдинг Смит, 5 боть, (1957–1966), 3:31.

4.

Алма 32:27-г үз.

5.

Иохан 7:17.

6.

Сургаал ба Гэрээ 14:7-г үз.

7.

Малахи 4:5–6; Иосеф Смит—Түүх 1:38–39-ийг үз.

8.

Сургаал ба Гэрээ 138:23-24.

9.

Моронай 10:3-5.

10.

Алма 32:38-39.

11.

Алма 32:40-43.

12.

Сургаал ба Гэрээ 50:24.

Лиахона

2011 оны 5-р сар